# МОНГОЛ УЛС
# ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20 22 он 12 дугаар
сарын 08-ны өдөр

Дугаар ХТТ/2962

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Б.БАТТӨМӨР ТАНАА

Асуулгын хариу хүргүүлэх тухай

"Дарханы төмөрлөгийн үйлдвэр" төрийн өмчит хувьцаат компанитай холбоотой асуудлаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуулгын хариуг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас бэлтгэж ирүүлснийг Танд хүргүүлж байна.

Хүлээн авч, танилцана уу.

Хавсралт: 36 хуудастай.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга Д.АМАРБАЯСГАЛАН

000225017101

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР**

13381 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
Энхтайвны өргөн чөлөө 16, Засгийн газрын IX байр,
Утас/Факс: (976-51) 26 23 50, И-мэйл: info@pcsp.gov.mn,
Вэбсайт: www.pcsp.gov.mn

2022.12.01 № А-2/2363
танай 2022.11.19-ны № ХИ/2747-т

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА Д.АМАРБАЯСГАЛАН ТАНАА

“Дарханы төмөрлөгийн үйлдвэр” төрийн өмчит хувьцаат компанийн талаар Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөрийн асуулгын талаар хариуг холбогдох материалыг хамт хүргүүлж байна.

Асуулгын хариуг Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөрт уламжилж өгнө үү.

Хавсралт 35 хуудастай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ,
ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА Н.ГАНБОЛД

132005907

Монгол Улсын Засгийн газрын
Хэрэг эрхлэх газар

Бичиг хэрэг

Огноо 2022-12-06

16 цаг 20 минут

**Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөрийн асуулгын хариу**

**Асуулга 1.** 2014 онд Монгол Улсын Засгийн газрын тендер зарлахад БНСУ-ын "Поско" БНЭУ-ын "Мщско стийл", "Ай Си Эм", БНХАУ-ын "БаоГан", "China national Precison Machinery I/E Corporation" гэсэн дэлхийд нэр хүнд бүхий бизнесийн арвин туршлага бүхий 5 корпорцациуд өрсөлдөөд Монгол Улсын бүртгэлд бүртгүүлээд хоёрхон жил болсон, үйл ажиллагаа явуулаагүй "Кью Эс Си" компанид ялагдсан байдаг. Дээрх сонгон шалгаруулалт хэрхэн явагдсан талаарх дэлгэрэнгүй тайлан, баримт мэдээллийг гарган ирүүлэх.

Хариулт

"Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК-ийн концессын гэрээгээр хувьчлах тухай тендерийн сонгон шалгаруулалтыг Эдийн засгийн хөгжлийн яам /тухайн үеийн/ зохион байгуулсан тул Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт материал байхгүй болно.

**Асуулга 2.** "Дарханы төмөрлөгийн үйлдвэр"-ийг төр мэдэлдээ авч Засгийн газар, Авлигатай тэмцэх газар, Үндэсний Аудитын газар, МХЕГ-аас шалгалт хийж шалгалтаар маш олон зөрчил илэрсэн. Дээрх байгууллагуудын шалгалт дуусаад нэлээдгүй хугацаа өнгөрсөн боловч шалгалтын тайлан үр дүнгийн талаар одоо болтол яагаад албан ёсны мэдээлэл олон нийтэд өгөхгүй байгаа талаар мэдээлэл

Хариулт

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны "Концессын гэрээ цуцлах тухай" 148 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК-ийн удирдлагын эрх болон хөрөнгийг "Кью Эс СИ" ХХК-аас буцаан шилжүүлэн авах тухай" 123 дугаар тогтоолоор "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК-ийн концессыг хүчингүйд тооцож төрийн өмчид хүлээн авах шийдвэр гарсан.

Мөн Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдааны тэмдэглэлээр өгөгдсөн үүргийн дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын баталсан удирдамжаар Сангийн яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газартай хамтран "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" хувьцаат компанийн 2014-2021 оны үйл ажиллагаанд 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдрөөс ажлын 25 хоногийн хугацаатай хяналт шалгалт хийлээ.

Шалгалтын дүнг Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдаанд танилцуулсан болно.

**Асуулга 3.** "Кью Эс Си" ХХК-тай холбоотой маш олон санхүүгийн зөрчлүүд илрээд байгаа. Тухайлбал 2014 онд концессын гэрээ байгуулсныхаа дараа хуульд байхгүй, концессын гэрээнд тусгагдаагүй "Менежментийн үйлчилгээний төлбөр" гэсэн төлбөрийг жил бүр 10.0 сая доллар нийтдээ 120 тэрбум төгрөгийг "Дарханы төмөрлөгийн үйлдвэр"-ээс авсан нь баримтаар нотлогдсон. Засгийн газраас дээрх шалгалтуудын хүрээнд уг асуудлыг шалгасан эсэх талаарх мэдээлэл

Хариулт

Дээрх шалгалтын тайлангаар Менежментийн төлбөртэй холбоотой учирсан хохирлын дүнг тооцон гаргаж Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдаанд танилцуулсан. Мөн Авлигатай тэмцэх газраас эрүүгийн хэрэг үүсгэн

“Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-д учирсан хохирлын дүнг тогтоохоор ажиллаж байгаа ба менежментийн төлбөртэй холбоотой асуудлыг багцлан авч үзэж байгаа болно. /тайланг хавсаргав/

**Асуулга 4**. “Кью Эс Си” ХХК-нь 2014 онд байгуулсан концессын гэрээний 6 дугаар бүлгийн 6 дах хэсгийн 6.33-т “Концесс эзэмшигч нь энэхүү гэрээг хэрэгжүүлэхэд ногдох албан татвар, төлбөр хураамж болон концессын зүйлийг ашиглах, эзэмших үйл ажиллагаа явуулахтай холбогдон гарсан аливаа зардал, төлбөрийг өөрөө бүрэн хариуцан” гэсэн үүргээ зөрчиж 123 тэрбум төгрөгийн татварын өртэй байна. Энэ асуудлыг шалгаж өрийг төлүүлэх талаар авсан арга хэмжээний тухай дэлгэрэнгүй мэдээлэл

Хариулт

Шалгалтаар татварын өр төлбөртэй холбоотой учирсан хохирлын дүнг тооцон гаргаж, “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-т үүссэн албан **татварын хуримтлагдсан өр** төлбөр болох **122,724,328,183.78** /нэг зуун хорин хоёр тэрбум, долоон зуун хорин дөрвөн сая гурван зуун хорин найман мянга нэг зуун наян гурван төгрөг далан найман мөнгө/ төгрөгийг гаргуулах тухай асуудлыг Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд 2022 оны 09 дүгээр сарын 14-ний өдөр нэхэмжлэл гаргасан. 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 181/ШЗ2022/14657 дугаартай албадан ирүүлэх захирамж гарсан нэхэмжлэлийг гардаж аваагүй байна.

Мөн Авлигатай тэмцэх газраас эрүүгийн хэрэг үүсгэн “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-д учирсан хохирлын дүнг тогтоон ажиллаж байгаа ба татварын өр төлбөртэй холбоотой асуудлыг багцлан авч үзэж байгаа болно.

**Асуулга 5**. Концессын хугацаанд “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-ийн үйлдвэрийн тоног төхөөрөмж, эд хөрөнгө, эрх, газар, гэх мэт барьцаалж болох бүхнийг банкуудад барьцаалж, үндсэн зээлийн 10 гэрээ, барьцааны гэрээ, нийт 50 гаруй гэрээгээр авсан зээлээс 160 гаруй удаагийн гүйлгээгээр нийт 168.4 тэрбум төгрөг, 69.9 сая ам.доллар буюу нийт 230 гаруй тэрбум төгрөгийг “Кью Эс Си” ХХК руу шилжүүлсэн байна. Өөрөөр хэлбэл Төмөрлөгийн үйлдвэрээр зээл авахуулаад тэр мөнгийг нь өөрсдөө тэр өдөртөө шууд “Кью Эс Си” ХХК-ийн данс уруу шилжүүлэн авсан. Үүний хүүгийн авлага 74.3 тэрбум төгрөг, 21.9 са ам.доллар ХХБ-нд төлсөн байна. “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-ийн үйл ажиллагаанд ийм зээл авах, шаардлагагүй байхад “Кью Эс Си” ХХК нь зээл авч, ХХБ-д 540 гаруй тэрбум төгрөгийн өрөнд оруулсан. Энэ асуудлыг шалгаж тогтоосон талаарх мэдээлэл

Хариулт

Дээрх шалгалтын тайлангаар “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК нь Худалдаа Хөгжлийн банкнаас зээл авч улмаар “Кью Эс Си” ХХК шилжүүлэн авсантай холбоотой учирсан хохирлын дүнг тооцон гаргаж, Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн шүүхэд дараах нэхэмжлэлийг гаргаад байна Үүнд 1.“Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК болон “Худалдаа хөгжлийн банк” (Улаанбаатар хотын банк) ХХК нарын хоорондБайгуулагдсан зээлийн гэрээнүүд Үүнд:

I. 2015 оны 12 сарын 18-ны өдөр байгуулагдсан №ЗШЭНГ9101/151218 тоот Зээлийн шугамын эрх нээх гэрээ, №ЗБГ9103/151218 тоот Зээлийн барьцааны гэрээ, №ЗШЭННГ9101/160129(1) тоот Зээлийн шугамын эрх нээх гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай гэрээ;

II. 2016 оны 05 дугаар сарын 18-ны өдөр байгуулсан №ЗШЭНГ9101/160518 тоот Зээлийн шугамын эрх нээх гэрээ, №ЗБГ9101/160518 тоот Зээлийн барьцааны гэрээ,

ЗШЭНГНГ9101/171002(1) тоот Зээлийн шугамын эрх нээх гэрээний нэмэлт гэрээ, ЗШЭНГНГ9101/180201(2) тоот Зээлийн шугамын эрх нээх гэрээний нэмэлт гэрээ, №ЗШЭНГНГ9101/180518 (3) тоот Зээлийн шугамын эрх нээх гэрээний нэмэлт гэрээ, №ЗБНГ9101/180518 (I) тоот Зээлийн барьцааны гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай гэрээ;

III. 2017 оны 05 сарын 04-ний өдөр байгуулсан №ЗГ9101/170504 тоот Зээлийн гэрээ, №ЗБГ9101/170504 тоот Зээлийн барьцааны гэрээ, №ЗНГ9101/180504(1) тоот Зээлийн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай гэрээ, №ЗБНГ9101/180504(1) тоот Зээлийн барьцааны гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай гэрээ, №ЗБНГ9102/181214(2) тоот Зээлийн барьцааны гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай гэрээ;

IV. 2018 оны 06 сарын 04-ний өдөр байгуулсан №ЗГ9101/180604 тоот Зээлийн гэрээ, №ЗБГ9101/180604 тоот Зээлийн барьцааны гэрээ;

Y. 2018 оны 12 сарын 03-ны өдөр байгуулсан №ЗШЭНГ9101/181203 тоот Зээлийн шугамын эрх нээх гэрээ, №ЗБГ9101/181203 тоот Зээлийн барьцааны гэрээ, ЗШЭННГ9102/190521 (1) тоот Зээлийн шугамын эрх нээх гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай гэрээ, ЗБНГ9103/190521 (1) тоот Зээлийн барьцааны гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай гэрээ;

YI. 2020 оны 08 сарын 31-ний өдөр байгуулсан №ЗЭНГ/СС200831011-16 тоот Зээлийн эрх нээх нэмэлт гэрээ, №Ф/СС200831011-16-4 тоот Эд хөрөнгө өмчлөлд шилжүүлэх /Фидуци/ гэрээ, №ЗБ/СС200831011-16-31 тоот Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны гэрээ, №ЗБ/СС200831011-16-41 тоот Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны гэрээ, №ЗЭНГ/СС200831011-16-1 тоот Зээлийн эрх нээх нэмэлт гэрээ, №ЗЭНГ/СС200831011-16-2 тоот Зээлийн эрх нээх нэмэлт гэрээ, №ЗЭНГ/СС200831011-16-3 тоот Зээлийн эрх нээх нэмэлт гэрээ, №ЗЭНГ/СС200831011-16-4 тоот Зээлийн эрх нээх нэмэлт гэрээ,

YII. 2020 оны 10 сарын 09-ний өдөр байгуулсан №ЗГ/СС201009020-17 тоот Зээлийн гэрээ, №Ф/СС201009020-17-1 тоот Эд хөрөнгө өмчлөлд шилжүүлэх /Фидуци/ гэрээ, №ЗБ/СС201009020-17-41 Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны гэрээ, №ЗБ/СС201009020-17-49 Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны гэрээ, №Ф/СС201009020-13-64 тоот Эд хөрөнгө өмчлөлд шилжүүлэх /Фидуци/ гэрээ;

YIII. 2020 оны 08 сарын 31-ний өдөр байгуулсан №ЗЭНГ/СС200831011-15 тоот Зээлийн эрх нээх гэрээ, №ЗБ/СС200831011-15-41 тоот Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны гэрээ, №ЗЭНГ/СС200831011-15-1 тоот Зээлийн эрх нээх нэмэлт гэрээ, №ЗЭНГ/СС200831011-15-2 тоот Зээлийн эрх нээх нэмэлт гэрээ;

IX. 2017 оны 05 сарын 16-ны өдөр байгуулсан №ЗШЭНГ9101/170516 тоот Зээлийн шугамын эрх нээх гэрээ, №ЗБГ9101/170516 тоот Зээлийн барьцааны гэрээ, №ЗШЭННГ9102/190516(1) тоот Зээлийн шугамын эрх нээх гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай гэрээ, №ЗБНГ9101/190516(1) тоот Зээлийн барьцааны гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай гэрээ, №ЗШЭННГ9101/200515(2) тоот Зээлийн шугамын эрх нээх гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай гэрээ, №ЗБНГ9101/200515(2) тоот Зээлийн барьцааны гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай гэрээ, №ЗЭНГ/СС210205003-7 тоот Зээлийн эрх нээх гэрээ, №ЗЭНГ/СС210205003-7-21 тоот Зээлийн эрх нээх гэрээ, №ЗЭНГ/СС210205003-7-01 тоот Зээлийн эрх нээх гэрээ;

X. 2017 оны 12 сарын 27-ны өдөр байгуулсан №ЗГ/СС210205003-11 тоот Зээлийн гэрээ, №ЗБ/СС171227003-11-29 тоот Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны гэрээ, №ЗГ/СС171227003-11-01 тоот Зээлийн гэрээ, №ЗГ/СС171227003-11-02 тоот Зээлийн гэрээ, №ЗГ/СС171227003-11-03 тоот Зээлийн гэрээ, №ЗГ/СС171227003-11-04 тоот Зээлийн гэрээ, ХХБ-ны №ЗГ/СС171227003-11-05 тоот Зээлийн гэрээ,

№ЗГ/СС171227003-11-06 тоот Зээлийн гэрээ-г тус тус хүчин төгөлдөр бус байх хэлцэл болохыг тогтоолгож, хүчин төгөлдөр бус хэлцлийн үр дагаврыг арилгаж, Барьцааны зүйл болох үл хөдлөх болон хөдлөх хөрөнгүүдийг барьцаанаас чөлөөлүүлж, Улаанбаатар хотын банк, Худалдаа хөгжлийн банктай байгуулсан зээлийн гэрээний хүүнд төлсөн 18,947,994,907 (арван найман тэрбум есөн зуун дөчин долоон мянга есөн зуун ерэн дөрвөн мянга есөн зуун долоон) төгрөг болон 20,571,904.88 (хорин сая таван зуун далан нэгэн мянга есөн зуун дөрвөн мянган доллар наян найман цент) ам.долларыг тус тус "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК зээлийн өглөгийн үлдэгдлээс хасаж тооцуулах;

2. "Кью Эс Си" ХХК-иас "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК-ийн дансаар дамжуулан, үндэслэлгүйгээр авсан 168,395,282,221.00 (нэг зуун жаран найман тэрбум гурван зуун ерэн тав сая хоёр зуун наян хоёр мянга хоёр зуун хорин нэгэн мянга) төгрөг болон 69,947,308 (жаран есөн сая есөн зуун дөчин долоон мянга гурван зуун найм)-н ам.доллар буюу 226,261,355,079 (Хоёр зуун хорин зургаан тэрбум хоёр зуун жаран нэгэн сая гурван зуун тавин таван мянга далан ес) төгрөгийг гаргуулан "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК-д олгох;

3. "КуалитиСтийл Корпорейшн" ХХК-иас "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК-ийн дансаар дамжуулж, үндэслэлгүйгээр авсан 16,290,560,000 /арван зургаан тэрбум хоёр зуун ерэн сая таван зуун жаран мянга/ төгрөгийг гаргуулан "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК-д олгох тухай нэхэмжлэлийг тус тус Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд тус тус гаргаад байна

**Асуулга 6.** 2017 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр "Кью Эс Си" ХХК, "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК-тай "Мэргэжлийн зөвлөгөө болон техникийн туслалцаа үзүүлэх гэрээ" буюу Менежментийн гэрээ байгуулж Металлургийн цогцолбор байгуулах төслийг хэрэгжүүлэх явцад болон Дарханы төмөрлөгийн үйлдвэрийн өдөр тутмын үйл ажиллагаанд "Кью Эс Си" ХХК-иас Монгол улсын болон олон улсын стандартын шаардлагад нийцүүлэн холбогдох хууль тогтоомжийн хүрээнд мэргэжлийн өндөр түвшинд нийт 12+1 чиглэлээр 50 ажил үйлчилгээ үзүүлэх, үйлчилгээтэй холбоотой харилцааг зохицуулахаар байгуулж менежментийн төлбөрт 2017-2021 оны 129,883,079,739.50 төгрөгийг Дарханы төмөрлөгийн үйлдвэрийн дансаар 11 удаагийн гүйлгээ хийсэн нь баримтаар нотлогдож байна. Засгийн газраас энэ асуудлыг шалгасан талаарх мэдээлэл

Хариулт

2017 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр "Кью Эс Си" ХХК болон "Дарханы Төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн хооронд байгуулсан №QSC17/01 тоот "Мэргэжлийн зөвлөгөө болон техникийн туслалцаа үзүүлэх гэрээ", **2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн "Мэргэжлийн зөвлөгөө болон техникийн туслалцаа үзүүлэх гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" гэрээг тус тус хүчин төгөлдөр бус байх хэлцэлд тооцуулж, хүчин төгөлдөр бус хэлцлийн** үр дагаврыг арилгаж "Кью Эс Си" ХХК-иас нийт **129,883,079,739.50** /нэг зуун хорин есөн тэрбум найман зуун наян гурван сая далан есөн мянга долоон зуун гучин есөн төгрөг тавин мөнгө/ төгрөгийг гаргуулах нэхэмжлэлийг Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд 2022 оны 09 сарын 22-ний өдөр нэхэмжлэл гаргаад байна. Хэрэг шүүхийн шатанд байгаа болно.

Мөн Авлигатай тэмцэх газраас эрүүгийн хэрэг үүсгэн "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК-д учирсан хохирлын дүнг тогтоохоор ажиллаж байгаа ба менежментийн төлбөртэй холбоотой асуудлыг багцлан авч үзэж байгаа болно.

**Асуулга 7.** Засгийн газраас “Кью Эс Си” ХХК-ийн эзэмшиж байсан “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” концессын гэрээг цуцлах шийдвэр гарсны дараа “Дарханы төмөрлөгийн үйлдвэр”-т даргаар ТӨБЗГ-ын Бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ц.Шинэхүүг түр орлон гүйцэтгэгчээр томилж байсан юм. Өнгөрсөн 4 дүгээр сард ТӨБЗГ-ын дэд даргаар ажиллаж байсан А.Ариунболдыг тус компанийн гүйцэтгэх захирлаар томилсон. Гэтэл 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдөр ТӨБЗГ-ын дарга Б.Цэнгэлийн тушаалаар “Дарханы төмөрлөгийн үйлдвэр”-ийн захирал А.Ариунболдыг чөлөөлж, Г.Дугаржавыг томилжээ. Энэ томилгоо ямар үндэслэлээр хэний зааврааар чиглэлийн дагуу хийгдсэн талаарх албан ёсны хариуг ирүүлэх, Г.Дугаржав нь концесс эзэмшигчидтэй ашиг сонирхол нэгтэй, шүүхэд нөлөөлөх замаар концессыг сэргээх алсын зорилготой ажил болж байгаа талаар мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээгээр цацагдаж байгаа мэдээллүүд үнэн бодитой эсэхийг шалгасан эсэх, дээрх мэдээллүүдэд албан ёсны тайлбар хариу ирүүлэх

Хариулт

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал болон захирлыг Авлигатай тэмцэх газрын албан бичгийг үндэслэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанд танилцуулж, хуралдаанаас гарсан тогтоолыг Төлөөлөн удирдах зөвлөлд удирдамж хүргүүлж Төлөөлөн удирдах зөвлөл шийдвэрлэдэг болно.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 124 дүгээр тогтоолоор “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-ийн гүйцэтгэх захирлыг эрх бүхий этгээд томилох хүртэл хугацаанд Төрийн өмчийн удирдлага зохицуулалтын төлөвлөлт, хөрөнгө оруулалтын албаны дарга Ц.Шинэхүүг Төрийн өмчийн төлөөлөгчөөр томилсон.

Мөн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 136 дугаар тогтоолоор “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгчээр А.Ариунболдыг томилсон.

Мөн тус компанийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан А.Ариунболд нь өөр ажилд шилжин ажиллах болсон тул Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6, 21 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 65 дугаар зүйл, Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.1.3 дахь заалт, Авлигатай тэмцэх газрын 2022 оны 05/13339 дүгээр албан бичгээр ирүүлсэн дүгнэлтийг тус тус үндэслэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 435 дугаар тогтоолоор ”Дарханы төмөрлөгийн үйлдвэр” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд тус компанийн гүйцэтгэх захирлаар Г.Дугаржавыг хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэхийг төрийн төлөөлөл хэрэгжүүлж байгаа гишүүдэд “Удирдамж болгох тухай” тогтоолыг хүргүүлсэн болно.

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

# ГАРЧИГ

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ ..... 2

1.1. ӨМНӨХ ШАЛГАЛТЫН ТАЛААР ..... 3

1.2. ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЛААР ..... 4

1.3. КОМПАНИЙН НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, САНХҮҮГИЙН ТООЦООЛЛЫН ТАЛААР ..... 4

ХОЁР. КОМПАНИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА ..... 5

ГУРАВ. КОМПАНИЙН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ, ГАЗАР ЭЗЭМШИХ, АШИГЛАХ ЭРХИЙН ТАЛААР ..... 7

ДӨРӨВ. САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ..... 10

ТАВ. БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ, БОРЛУУЛАЛТЫН ТАЛААР ..... 14

ЗУРГАА. УУЛ ГЕОЛОГИЙН АЖЛЫН ТАЛААР ..... 24

ДОЛОО. КОНЦЕССЫН ЗҮЙЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ..... 29

НАЙМ. МӨНГӨН ХӨРӨНГӨ ХАРИЛЦАХ ДАНСДЫН ТАЛААР ..... 43

ЕС. АВЛАГА, ӨГЛӨГ, УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ТООЦООНЫ ТАЛААР ..... 46

АРАВ. БАНКНЫ ЗЭЭЛИЙН ТАЛААР ..... 49

АРВАН НЭГ. БАРАА МАТЕРИАЛЫН ТАЛААР ..... 51

АРВАН ХОЁР. ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ТАЛААР ..... 56

АРВАН ГУРАВ. ТАТВАРЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР ..... 58

АРВАН ДӨРӨВ. ГААЛИЙН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР ..... 63

АРВАН ТАВ. ХӨРӨНГИЙН ТҮРЭЭСИЙН ТАЛААР ..... 68

АРВАН ЗУРГАА. ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ ДУТАГДЛЫН ТАЛААР ..... 77

АРВАН ДОЛОО. ДҮГНЭЛТ ..... 91

АРВАН НАЙМ. ЦААШИД АНХААРАХ АСУУДЛААР ..... 92





# "ДАРХАНЫ ТӨМӨРЛӨГИЙН ҮЙЛДВЭР" ХК-ИЙН 2014-2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТЭМДЭГЛЭЛ

2022 оны 07 дугаар сарын 01-ний өдөр Улаанбаатар хот

## НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдааны тэмдэглэлээр өгөгдсөн үүргийн дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын баталсан удирдамжаар "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" хувьцаат компанийн 2014-2021 оны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийлээ.

Шалгалтыг Сангийн яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газрын албан хаагчдын бүрэлдэхүүнтэй баг 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдрөөс ажлын 25 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэлээ.

Шалгалтын ажлын хэсэг 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдөр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын баталсан удирдамжийг "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн удирдлага, холбогдох ажилтнуудад танилцуулан, шалгалтад шаардагдах баримтын жагсаалтыг хүргүүлэн ажиллалаа.

Шалгалтын баримтыг 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдрөөс файлаар авч эхэлсэн ба хяналт шалгалт явуулахад шаардлагатай баримтууд дутмаг байсныг тэмдэглэж байна. "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн зүгээс:

Концессын зүйлд хамаарах 2010-2016 онуудад хийгдсэн төсөл арга хэмжээ, ажлын тайлан, санхүүжилт, түүний гэрээ, гэрээний гүйцэтгэл, үр дүнгийн талаарх материал, Хувьцаа эзэмшигч, Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол шийдвэр, банкны барьцааны гэрээ зэрэг материалыг Концесс эзэмшигчийн зүгээс Эрх бүхий этгээд болон "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-д хүлээлгэж өгөөгүй, зарим гэрээ, магадлал, хүлээлцсэн актуудыг архив шилжүүлсэн;

2014-2021 оны нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтууд, хууль эрхийн акт гэрээ, бусад холбоотой баримтыг Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн байсан тул 2022 оны 5 дугаар сарын 30-ны өдөр баримтын зарим хэсгийг, шалгалтын хугацаа дуусахын өмнө буюу 2022 оны 06 дугаар сарын 23-ны өдөр үлдсэн баримтыг ирүүлсэн.

Ажлын хэсэг хяналт шалгалт явуулахад шаардлагатай материал ирүүлэхийг хүссэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2022 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн А-1/1167 тоот "Хамтран ажиллах тухай" албан бичгийг концесс эзэмшигч "Кьюэ Эс Си" ХХК-д хүргүүлсэн.

Мөн нэмэлт тодруулга мэдээлэл авахаар Авлигатай тэмцэх газарт 2022 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн А-1/1277 дугаартай албан бичиг, Дархан уул аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст 2022 оны 5 дугаар сарын 24-ны өдрийн А-6/1046 дугаартай албан бичиг, 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн А-6/1325 дугаартай албан бичгийг тус тус хүргүүлсэн.

Шалгалтын ажлын хэсэг "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-иас 420 гаруй файл, 2014-2021 оны банкны харилцах дансны болон касс, дараа тайлангийн баримтууд, гадаад, дотоод худалдааны гэрээнүүд /зарим гэрээ байхгүй, дутуу/, үндсэн хөрөнгө, худалдан авалтын баримтууд, сэлбэг, бараа материалын орлого, зарлагын баримтууд, түүхий эд материалын орлогын баримтууд, санхүүгийн тайланд хийсэн Аудитын дүгнэлтүүд, гүйцэтгэх удирдлагаас гаргасан тушаал, шийдвэр, уул геологийн ажлын тайлан, төсөв, төлөвлөгөө, гүйцэтгэл, 2014-2021 онд импортоор оруулсан барааны баримтууд зэрэг 2500 гаруй хавтаст материалыг хамруулан шалгалаа.

Шалгалтын хугацаанд "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн Төмөртэй болон Төмөртолгойн төмрийн хүдрийн уурхайд 2 өдөр ажиллаж уурхайн үйл ажиллагаатай, гангийн үйлдвэрлэл, хаягдал төмөр боловсруулах, бэлдэц, цувимал үйлдвэрлэх үйлдвэрт 1 өдөр ажиллаж төмрийн үйлдвэрлэл, үйл ажиллагаатай танилцлаа. Мөн хугацаанд 2014-2021 онд хийгдсэн хөрөнгө оруулалт, уурхайн хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтын байдалтай танилцан, төмрийн хүдрийн баяжмалын овоолгод хэсэгчилсэн үзлэг тооллогыг явууллаа.

Компани санхүүгийн үйл ажиллагаандаа "Даймонд" программыг 2013 оноос эхлэн ашиглаж байна. Шалгагдах хугацааны компанийн санхүү, бүртгэлийн үйл ажиллагаа хангалтгүй, санхүүгийн тайланг НББ-ын олон улсын стандартын дагуу хөтөлж явуулдаггүй, анхан шатны бичиг баримтын бүрдэл шаардлагын хэмжээнд хийгдээгүй байлаа.

## 1.1. ӨМНӨХ ШАЛГАЛТЫН ТАЛААР

"Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн 2014-2017 оныг дуусталх хугацааны албан татварын ногдуулалт, төлөлтийн байдалд Татварын байгууллагаас 2018 онд хяналт шалгалт хийж, 2018 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 210297780 тоот шийтгэлийн хуудсаар нийт 19,874.1 сая төгрөгийн зөрчил илрүүлэн, 313.3 сая төгрөгийн нөхөн татвар, 1,167.6 сая төгрөгийн торгууль, 649.0 сая төгрөгийн алданги, **нийт 2,129.9 сая** төгрөгийн төлбөрийн акт үйлдсэн байна.

Дээрх төлбөрийн актаас 313.3 сая төгрөгийн нөхөн татварыгбарагдуулсан бол 1,167.6 сая төгрөгийн торгуулийн төлбөрөөс 250.0 сая төгрөгийг төлж, 917.6 сая төгрөгийн, 649.0 сая төгрөгийн алдангийн төлбөрөөс
610.0 сая төгрөгийг төлж 39.0 сая төгрөгийн дутуу төлөлттэй байна.

"Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр" ХК-ийн 2014.01.01-2017.12.31 дуустал албан татварын ногдуулалт, төлөлтийн байдалд "Татварын хяналт шалгалт хийх томилолт", "Татварын хяналт шалгалт хийх ерөнхий удирдамж", Хянан шалгах хэлтэс, дотоод зурвас 88, "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" хүсэлт тоот албан бичиг(хүсэлт)-ийн дагуу Хувь хүн, хуулийн этгээдээс амаар болон бичгээр ирүүлсэн мэдээлэл, хүсэлт, өргөдөл, гомдлоор-Хэсэгчилсэн шалгалтыг 2019 оны 09 дүгээр сарын 11 өдрөөс 2019 оны 12 дугаар сарын 18 өдрийг хүртэл хийж татварын Улсын байцаагчийн 210015303 тоот акт үйлдсэн байна.

Татварын хяналт шалгалтаар нийт 129,011.0 сая төгрөгийн зөрчилд илүү тайлагнасан нөхөн төлбөр 5,969.5 сая төгрөгөөс төлүүлэхээр тогтоосон ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн 43.5 сая төгрөг, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 767.9 сая төгрөгийг хасаж тооцон үлдэх илүү тайлагнасан 5,158.0 сая төгрөгийн төлбөрөөс торгууль 967.8 сая төгрөг, алданги 521.5 сая төгрөгийг тус тус суутган тооцож нийт илүү тайлагнасан 3,668.7 сая





төгрөгийн төлбөрийг өмнөх татварын хяналт шалгалтын өрийн үлдэгдэлд суутган тооцуулах татварын Улсын байцаагчийн 210015303 тоот актын хавсралт 8-д даалгасан боловч тус компани нь суутган тооцуулах тухай хүсэлт өгөөгүй учир 967.8 сая төгрөгийн торгууль, 521.5 сая төгрөгийн алдангийн төлбөрийн үлдэгдэлтэй байна.

"Дарханы Төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн 2014-2015 он, 2017-2020 онуудын санхүүгийн тайланд "Нью Проспект Аудит" ХХК, 2016 оны тайланд "Эрнст энд Янг Монголиа Аудит" ХХК аудит хийж тухайн жилүүдийн санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээг СТОУС-ын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн болохыг батламжилсан байна.

Харин 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийгдээгүй байна.

## 1.2. ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЛААР

Монгол Улсын Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2 дахь заалтуудыг хэрэгжүүлэх, аж ахуйн нэгж байгууллагын хэмжээнд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын хэрэгжилтийг шалгалаа.

"Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн гүйцэтгэх захирлын тушаалаар дотоод хяналтын аудиторыг, тус компанид мөрдөгдөх "Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ыг тус тус баталсны дагуу дотоод хяналтын алба 4 хүний орон тоотой ажиллаж байна.

Компанийн дотоод хяналт нэр төдий, байнгын ажиллагаа хангалтгүй, зөвхөн санхүүгийн гүйлгээнд хяналт тавих ажлаар хязгаарлагддаг байна.

## 1.3. КОМПАНИЙН НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, САНХҮҮГИЙН ТООЦООЛЛЫН ТАЛААР

"Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн 2014-2021 оны санхүү, нягтлан бодох бүртгэл хөтлөлт, тайлагнал дараах байдалтай байна. Шалгалтын явцад компаниас ирүүлсэн 2014-2020 оны Аудитын тайлан, дүгнэлттэй танилцлаа.

Компани 2014-2016 онуудын санхүүгийн тайланд борлуулалтын орлогыг өссөн дүнгээр 12.4 тэрбум төгрөгөөр, бусад орлогыг 713.4 сая төгрөгөөр дутуу, өртгийн зардлыг 2.4 тэрбум төгрөгөөр илүү тайлагнасан. Борлуулалт маркетингийн зардлыг 24.5 тэрбум төгрөгөөр, бусад зардлыг 2.7 тэрбум төгрөгөөр илүү тайлагнасныг Аудитын зөвлөмжийн дагуу залруулсан байна. Энэ нь компанийн хэмжээнд нягтлан бодох бүртгэл хөтлөлт, тооцооллын асуудалд анхаарах, орлогыг бууруулах, зардлыг өсгөх, ашгийг бууруулах замаар татвар, хураамжаас зайлсхийх, төсвийн төлбөрийг бууруулахад нөлөөлсөн байна.

/Аудитын тайлангаар гарсан зөрүүнүүдийг хүснэгтээр харуулав/.

| Үзүүлэлт | 2014 онд | | Зөрүү | 2015 онд | | Зөрүү | 2016 онд | | Зөрүү | Нийт зөрүү |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Балансаар | Дахин тайлагнасан | | Балансаар | Дахин тайлагнасан | | Балансаар | Дахин тайлагнасан | | |
| Борлуулалтын орлого | 86,249,951.0 | 90,659,816.0 | 4,409,865.0 | 69,389,416.0 | 70,331,126.0 | 941,710.0 | 91,810,530.0 | 98,883,597.0 | 7,073,067.0 | 12,424,642.0 |
| ББӨ | (75,612,594.0) | (75,612,594.0) | - | (44,470,060.0) | (44,029,351.0) | 440,709.0 | (40,533,617.0) | (43,344,675.0) | (2,811,058.0) | (2,370,349.0) |
| Ашигт малтмалын нөөц ашиг-ны төлбөр | (1,241,379.0) | (2,301,534.0) | (1,060,155.0) | (2,227,037.0) | - | 2,227,037.0 | - | (3,320,801.0) | (3,320,801.0) | (2,153,919.0) |
| Үйл ажиллагааны ашиг/алдагдал | 9,395,976.0 | 12,745,688.0 | 3,349,710.0 | 22,892,319.0 | 26,301,775.0 | 3,409,456.0 | 51,276,913.0 | 52,218,121.0 | 941,203.0 | 7,900,374.0 |
| Борлуулалт удирдлагын зардал | (7,211,637.0) | (7,793,621.0) | (581,984.0) | (30,309,579.0) | (4,804,528.0) | 25,505,051.0 | (4,185,542.0) | (53,611,151.0) | (49,425,609.0) | (24,502,542.0) |
| Бусад орлого | 4,726,726.0 | 6,673,239.0 | 1,946,513.0 | 5,182,060.0 | 10,997,481.0 | 5,815,421.0 | 12,811,892.0 | 5,763,315.0 | (7,048,577.0) | 713,357.0 |
| Бусад зардал | (7,024,644.0) | (8,226,148.0) | (1,201,504.0) | (5,622,655.0) | (21,331,329.0) | (15,708,674.0) | (26,552,207.0) | (12,364,810.0) | 14,187,397.0 | (2,722,781.0) |
| Бусад орлого ашиг алдагдал | (9,509,555.0) | (9,346,530.0) | 163,025.0 | (30,750,174.0) | (15,138,376.0) | 15,611,798.0 | (17,925,857.0) | (60,212,646.0) | (42,286,789.0) | (26,511,966.0) |
| ҮАБүс ашиг/алдагдал | (113,577.0) | 3,399,158.0 | 3,512,735.0 | (8,057,855.0) | 11,163,399.0 | (19,221,254.0) | 33,351,058.0 | (7,994,525.0) | (41,345,581.0) | (57,054,100.0) |
| Санхүүгийн орлого | 323,050.0 | 323,050.0 | - | 57,137.0 | - | - | - | 3,180.0 | 3,180.0 | 3,180.0 |
| Санхүүгийн зардал | (3,039,989.0) | (2,914,411.0) | 125,578.0 | (5,137,914.0) | (24,517,302.0) | (19,379,388.0) | (48,823,969.0) | (3,466,941.0) | 45,356,028.0 | 26,101,218.0 |
| ТТӨАшиг | (2,830,516.0) | 997,797.0 | 3,638,313.0 | (13,138,632.0) | (13,353,903.0) | 215,271.0 | (15,472,913.0) | (11,460,286.0) | 4,012,627.0 | 7,856,311.0 |
| Орлогын албан татвар | (7,869.0) | (1,264,736.0) | (1,256,867.0) | (5,714.0) | (5,714.0) | - | (389.0) | (389.0) | - | (1,256,867.0) |
| Нийт үр дүн | (2,838,385.0) | (656,939.0) | 2,381,446.0 | (13,144,346.0) | (13,359,617.0) | 215,271.0 | (15,473,302.0) | (11,460,675.0) | 4,012,627.0 | 6,603,344.0 |

Мөн санхүүгийн тайлангийн бараа материал, уул уурхайн хөрөнгө, үндсэн хөрөнгийг бүртгэхтэй холбоотой залруулгууд хийгдсэн ба 2016 онд өгсөн зөвлөмжийн дагуу 2019 онд залруулга хийсэн байна.

Тайлангийн хугацаанд үүссэн өр, авлагыг санхүүгийн тайланд тусгахдаа хэзээ үүссэн, юуны төлбөр болохыг анхан шатны баримт үндэслэж тооцоо хийж баталгаажуулдаггүй, тооцооны дансыг ерөнхий нэршлээр тодорхойгүй байдлаар бүртгэж санхүүгийн тайлан тэнцэлд тусгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4 "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 13.5."Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно",13.6."Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна",13.7."Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Цаашид компанийн хэмжээнд нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах, мэдээлэл боловсруулалтыг анхан шатны баримтад тулгуурлан үнэн зөв гаргах, санхүүгийн тайлангийн программ хангамжид шинэчлэл, сайжруулалт, хөгжүүлэлт хийх шаардлага байгаа нь шалгалтын явцад компаниас ирүүлсэн баримт, мэдээллээс харагдаж байна.

## ХОЁР. КОМПАНИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

"Дарханы төмөрлөгийн үйлдвэр" төрийн өмчит хувьцаат компани нь Монгол Улсын Засгийн газрын 1990 оны 160 дугаар тогтоол, Монгол Улс, Япон Улсын Засгийн газар хоорондын гэрээний дагуу жилд 100 мянган тонн цувимал бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадал бүхий төмөрлөгийн үйлдвэрийг байгуулахаар эхэлж, 1993 онд анхны ган хайлалт хийж, 1994 оны 07 дугаар сарын





04-ний өдөр үйлдвэрийг Улсын комисс хүлээн авснаар бүрэн ашиглалтад орсон байна.

- Компани нь 3 орд газар бүхий ил уурхай, 5 баяжуулах үйлдвэртэй.

Дархан-Сэлэнгийн бүсэд орших Төмөртэй, Төмөртолгой, Хуст уулын төмрийн хүдрийн ордын ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлийг эзэмшиж, 2009оноос Төмөр толгойн орд, 2011 оноос Төмөртэйн ордын ил уурхайгаас төмрийн хүдэр олборлож эхэлсэн ба төмрийн хүдрийг хуурай соронзон аргаар баяжуулж, үйлдвэрлэсэн баяжмалыг экспортод гаргах, дотоодын зах зээлд худалдах үйл ажиллагаа явуулж байна.

- Төмрийн үйлдвэрт хагас бэлэн бүтээгдэхүүн ган бэлдэц, төрөл бүрийн цувимал, ган туйван зэрэг бүтээгдэхүүн үйлдвэрлэж дотоодын зах зээлд борлуулж байна.

Төмөртэйн орд нь Дархан хотоос зүүн хойш 130 км зайд Сэлэнгэ аймгийн Хүдэр сумд байрладаг ба 2008 оны 02 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн 30 жилийн хугацаатайгаар лицензийг эзэмшиж эхэлсэн. Нийт батлагдсан геологийн нөөцийн хэмжээ нь 229.3 сая тн, талбайн хэмжээ 1200 га.

Төмөртолгойн орд нь Дархан хотоос зүүн урагш 30 км зайд Хонгор сумын нутаг дэвсгэрт байрладаг. Батлагдсан геологийн нөөцийн хэмжээ нь 17.2 сая тн. Үлдэгдэл нөөц 6.0 сая тн.

Хуст-Уулын төмрийн хүдрийн орд нь Сэлэнгэ аймгийн Ерөө сумын төвөөс зүүн урагш 25 км-т, Улаанбаатар хотоос хойд зүгт 330 км-т, Дархан хотоос зүүн хойд зүгт 110 км-т оршино. Батлагдсан геологийн нөөцийн хэмжээ 12.6 сая тн.

Одоогийн байдлаар "Уул уурхай металлургийн цогцолбор байгуулах төсөл"-ийн хүрээнд хийгдсэн Төмөртолгойн уурхайд жилд 2.0 сая тонн хүдэр баяжуулах, хуурай соронзон баяжуулах үйлдвэр, Төмөртэйн ордод жилд 3.0 сая тонн хүдэр баяжуулах хуурайн соронзон баяжуулах үйлдвэр, Дархан хотод жилд 1.0 сая тонн хүдрийг нойтон аргаар баяжуулах үйлдвэр ажиллуулж байна.

Уурхай энэ хүчин чадлаараа ашиглавал Төмөртолгойн ордын хүдрийн уурхай 3 жилийн нөөцтэй, Төмөртэйн уурхай 100 жилийн нөөцтэй байна. Харин Хуст-Уулын ордыг ашиглаж эхлээгүй байна.

/Ордын байршил, нөөц, хүчин чадал/

| Д/д | Уурхайн нэр | Байршил | Төмрийн хүдрийн нөөц /сая тонн/ | Хүчин чадал /сая тонн/ |
|---|---|---|---|---|
| 1 | Төмөртолгой хүдрийн уурхай | Дархан-Уул аймаг, Хонгор сум | 25.00 | 2.00 |
| 2 | Төмөртэй хүдрийн уурхай | Сэлэнгэ аймаг, Хүдэр сум | 229.30 | 3.00 |
| 3 | Хуст-уулын орд | Сэлэнгэ аймаг, Ерөө сум | 12.60 | |
| | Нийт: | | 266.90 | 5.00 |

**2.1. Төслийн хөрөнгө оруулалтын талаар:** "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн хуурай соронзон баяжуулах үйлдвэр 2010 онд ашиглалтад орсноор "Уул уурхай, металлургийн цогцолбор" төсөл хэрэгжиж эхэлсэн ба энэ үеэс Төрийн өмчийн хороо /тухайн үеийн нэрээр/, "Дарханы төмөрлөгийн

үйлдвэр" ТӨХК болон "Кью Эс Си" ХХК-ийн хооронд төслийн хөрөнгө оруулалтын гэрээ байгуулагджээ.

Төслийн хүрээнд 180 мянган тонн шууд ангижруулсан төмөр боловсруулах металлургийн цогцолбор барих, төмөрлөгийн үйлдвэрийг өргөтгөн техник, технологийн шинэчлэл хийж үйлдвэрийн хүчин чадлыг жилд 180 мянган тонн цувимал бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг болгох, бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах ажил хийхээр төлөвлөсөн.

Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн "Концессын гэрээ байгуулах эрх олгох тухай" 69 дүгээр тогтоолын дагуу Эдийн засгийн хөгжлийн яам болон "Кью эс Си" ХХК-ийн хооронд 2014 оны 04 дүгээр сарын 04-ны өдөр "Уул уурхай металлургийн цогцолбор байгуулах төслийг хэрэгжүүлэх Концессын гэрээ"-г байгуулсан байна.

Гэрээнд Хуст уул, Төмөртолгой, Төмөртэй ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулж жилд 3.0 сая тонноос доошгүй хүдэр олборлох, 1.5 саяас доошгүй тонн баяжмал үйлдвэрлэх үйлдвэр, жилд 500.0 мянгаас доошгүй хүчин чадал бүхий ангижруулсан төмрийн үйлдвэр, "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн хүчин чадлыг жилийн 300 мянган тоннд хүргэх өргөтгөл, шинэчлэл хийх /төмрийн хүдэр боловсруулж эцсийн бүтээгдэхүүн гаргах/, "Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд орших Төмөртэйн ордоос Хандгайт өртөө (Баянгол төмөр зам) чиглэлийн 33.4 км 1520 мм царигтай төмөр зам, ачиж буулгах терминал барих", "Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд орших Төмөртэйн ордоос Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумаас Улаанбаатар чиглэлийн олон улсын авто замын Дулаанхааны дөрвөн замын уулзвар хүртэл 95 км хүнд даацын хатуу хучилттай авто зам, "Сэлэнгэ аймгийн Ерөө сумаас Хүдэр сумын Төмөртэйн уурхай хүртэл 110 кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, /50 км/, өргөтгөл, дэд станц барих ажлуудыг тусгасан байна.

Концессын гэрээг "Шинэчлэн сайжруулах-барих-ашиглах-шилжүүлэх", "Барих-шилжүүлэх" гэсэн 2 төрлөөр байгуулсан ба Концессын зүйлийг барьж ашиглалтад оруулах хугацааг 4 жилээр тогтоож гэрээнд тусгажээ.

Концессын гэрээний дагуу 2014 онд Нойтон соронзон баяжуулах үйлдвэр, Төмөртэйн хуурай соронзон баяжуулах үйлдвэр, Дарханы терминал, Ган бөмбөлгийн үйлдвэрүүд тус тус ашиглалтад орсон байна.

2016 онд Төмөртэй-Хандгайт чиглэлийн төмөр замыг тавьж, ачих буулгах терминал, өртөө, 2017 онд ШАТ-ийн үйлдвэрийн үндсэн инженерингийн дизайн, 2018 онд 25 тн багтаамжтай Шанаган зуух, 2019 онд дахин халаах зуухны шинэчлэл хийгдэж, цахилгаан соронзон холигч, хэлбэлзүүлэгч ширээ, талсжуулагчийг тус тус ашиглалтад оруулсан байна.

2017 онд "Уул уурхай, металлургийн цогцолбор" төслийн нарийвчилсан ТЭЗҮ, Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ, 2020 онд CDE төсөл, 2021 онд Булт шрёдер төсөл хэрэгжиж "Монгол Ган Цогцолбор I" төслийн ТЭЗҮ тус тус хийгдсэн байна.

## ГУРАВ. КОМПАНИЙН УДИРДЛАГЫН ЭРХ, ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ, ГАЗАР ЭЗЭМШИХ, АШИГЛАХ ЭРХИЙН ТАЛААР

**3.1. Компанийн удирдлагын эрхийн талаар:** Монгол Улсын Засгийн Газрын 2014 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн "Концессын гэрээ байгуулах эрх олгох тухай" 69 дүгээр тогтоолыг үндэслэн Эдийн засгийн хөгжлийн яам болон





"Кью эс Си" ХХК-ийн хооронд 2014-04-04-ны өдөр "Уул уурхай металлургийн цогцолбор байгуулах төслийг хэрэгжүүлэх Концессын гэрээ"-г байгуулснаар Төрийн өмчийн хорооноос 2012 оны 4 дүгээр сарын 24-ны өдрийн 207 дугаар тогтоолоор "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК-ийн удирдлагын эрх болон хөрөнгийг "Кью Эс Си" ХХК-д шилжүүлэн өгсөн байна.

Концессын тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд төр хувийн хэвшлийн түншлэл, концессын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг 2010-2012 онд Төрийн өмчийн хороо, 2012-2014 онд Эдийн засгийн хөгжлийн яам, 2014 оны 10 дугаар сараас 2015 он хүртэл Сангийн яам, 2015 оноос 2016 оны 8 дугаар сар хүртэл Хөрөнгө оруулалтын газар, 2016 оны 8 дугаар сараас 2020 оны 12 сар хүртэл Үндэсний хөгжлийн газар, 2021 оноос Эдийн засгийн хөгжлийн яам хэрэгжүүлж байна.

Харин Концессын гэрээг цуцалснаар компанийн хувьцаа эзэмшигчийн эрхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар хэрэгжүүлэн ажиллаж байна.

Төрийн өмчийн хорооны 2014 оны 407 дугаар тогтоолоор "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн удирдлагын эрх болон мөнгөн хөрөнгийг тогтоол гарсан өдрөөр, хөрөнгийг 2014 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөр шилжүүлж, Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүдийг 2014 оны 4 дүгээр сарын 15-ны өдрөөр тус тус тасалбар болгон үүрэгт ажлаас чөлөөлсөн байна.

"Кью Эс Си" ХХК нь 2015 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн дүрмийг шинэчлэн баталсан байна. Компанийн дүрмийн: 14.2-т Компани нь дүрмийн 14.1.1-14.1.11-т заасан баримт бичгийг өөрийн үйл ажиллагаа эрхлэн явуулах газарт хадгална гэж тусгасан байна.

Гэвч Хяналт шалгалт явуулахад шаардлагатай Компанийн хувьцаа эзэмшигч, Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан тогтоол, шийдвэр, компанийн хөрөнгө барьцаалан авсан зээлийн гэрээ компанийн архивт хадгалагдаагүй, Концесс эзэмшигч "Кью Эс Си" ХХК-иас албан ёсоор хүлээлгэн өгөөгүй байна.

1.4-т "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч нь /Концессын гэрээний дагуу/ "Кью Эс Си" ХХК байна.

6.1-д Компанийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчийн хурал байх бөгөөд түүнийг концесс эзэмшигч "Кью Эс Си" ХХК дангаар хэрэгжүүлнэ.

6.2.13-т Хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхэд Төлөөлөн удирдах зөвлөлийн саналыг үндэслэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах гэж заасан байна.

**3.2. Тусгай зөвшөөрлийн талаар:** "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-д 13319А, 10738А, 13851А дугаар, 1663 гектар талбай бүхий, 3 тусгай зөвшөөрлийг Ашигт малтмал, газрын тосны газраас 2005, 2008 онд ашигт малтмал ашиглах (төмрийн хүдэр олборлох) зөвшөөрлийг 30 жилийн хугацаатайгаар олгосон байна.

Сэлэнгэ аймаг, Хүдэр сум, Төмөртэйн ордод 1200 гектар талбайд ашигт малтмал төмрийн хүдэр олборлох, 13319А дугаар тусгай зөвшөөрлийн төлбөрт жилд 26.10 сая төгрөгийг, 2022 оны байдлаар 15 дахь жилдээ тусгайзөвшөөрлийн төлбөрийг төлж байна. Дархан-Уул аймаг, Хонгор сум,

Төмөртолгойн ордод 424 гектар талбайд ашигт малтмал төмрийн хүдэр олборлох, 10738А дугаар тусгай зөвшөөрлийн төлбөрт жилд 9.22 сая төгрөгийг, 2022 оны байдлаар 17 дахь жилдээ тусгай зөвшөөрлийн төлбөрийг төлж байна.

Сэлэнгэ аймаг, Ерөө сум, Хуст-Уулын ордод 39 гектар талбайд ашигт малтмал олборлодоггүй ба 13851А дугаар тусгай зөвшөөрлийн төлбөрт жилд 0.85 сая төгрөгийг, 2022 оны байдлаар 17 дахь жилдээ тусгай зөвшөөрлийн төлбөрийг төлж байна.

/Компанийн тусгай зөвшөөрлийн жагсаалт/.

| Д/д | Тусгай зөвшөөрлийн байршил | Тусгай зөвшөөрлийн олгосон эрх бүхий албан тушаалтан, огноо | дугаар | Нийт ашиглах талбай /гектар/ | Ашиглах жил | Тусгай зөвшөөрөл анх олгосон огноо | Тусгай зөвшөөрлийн төлбөр /жилд/ |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Сэлэнгэ аймаг, Хүдэр сум, Төмөртэйн орд | Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газрын дарга, 2008.02.28 | 13319А | 1200 | 30 | 2008.02.28 | 26,096,520.00 |
| 2 | Дархан-Уул аймаг, Хонгор сум, Төмөр толгойн орд | Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газрын дарга, 2007.03.01 | 10738А | 424 | 30 | 2005.10.28 | 9,223,957.50 |
| 3 | Сэлэнгэ аймаг, Ерөө сум, Хуст-Уулын орд | Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газрын дарга, 2008.06.27 | 13851А | 39 | 30 | 2008.06.27 | 849,120.00 |
| | Нийт дүн | | | 1663 | | | 36,169,597.50 |

**3.3. Газар эзэмших, ашиглах эрхийн талаар:** "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК нь 3,419.75 га талбай бүхий нийт 31 эзэмших, ашиглах эрхийн газартай бөгөөд уурхайн газар, үйлдвэрлэлийн барилга, байгууламж бусад газар, автомашины гараашь, амралтын газар, хогийн цэг, авто тээврийн хэрэгслийн талбай, цахилгааны дэд станц, аж ахуй, уурхайн ажилчдын тосгон, нойтон соронзон баяжуулах, тохижилт зэрэг зориулалтаар эзэмшиж, ашиглаж байна.

Дээрх газруудаас Дархан-Уул аймагт 1,042.76 га талбай бүхий 21 эзэмших, ашиглах эрхийн газар, Сэлэнгэ аймагт 2,375.23 га талбай бүхий 9 эзэмших, ашиглах эрхийн газар, Улаанбаатар хотод 1.76 га талбай бүхий 1 эзэмших, ашиглах эрхийн газартай байна.

Хяналт шалгалтын явцад Дархан-Уул аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газруудаас тус компанийн Дархан-Уул аймагт байрлах газар эзэмших, ашиглах эрхийн талаарх мэдээллийг гаргуулан авахад Улсын бүртгэлийн хэлтсээс 13 эзэмших, ашиглах эрхийн газартай, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас 15 эзэмших, ашиглах эрхийн газартай гэсэн мэдээлэл ирүүлсэн байна.

Иймд Монгол Улсын Засгийн газрын 2015 оны "Концессын гэрээ байгуулах тухай" 69 дүгээр тогтоолыг, 2022 оны 148 дугаар тогтоолоор хүчингүй болгож, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 123 дугаар тогтоолын дагуу "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК нь төрийн өмчит хувьцаат компани болсонтой холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 2022 онд зохион байгуулан, гүйцэтгэж буй "Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллого"-ын дагуу дээрх эзэмших, ашиглах эрхийн газрын мэдээллийг холбогдох байгууллагуудаас гаргуулан авч, зөрүүтэй мэдээллийг залруулах, Засгийн газрын 2020 оны "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай" 10 дугаар тогтоолын дагуу эзэмших, ашиглах эрхийн газрыг үнэлж, 2022 оны санхүүгийн тайланд тусгах ажлыг зохион байгуулах нь зүйтэй.





## ДӨРӨВ. САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

**4.1. Санхүүгийн үзүүлэлт, үр дүнгийн талаар:** "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн хамгийн сүүлийн буюу 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгээс харахад мөнгөн хөрөнгө оны эхэнд 10.9 сая төгрөг байсан бол 383.2 сая төгрөг болж 372.5 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Дансны авлага 15,426.4 сая төгрөг болж 5,104.1 сая төгрөгөөр, бусад авлага 71,383,5 сая төгрөгөөр буурсан бол Татвар нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 334.1 сая төгрөгөөр өссөн, урьдчилж төлсөн зардлын тооцоо данс 205,861.0 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Өр төлбөрийн эхний үлдэгдэл 2020 оны жилийн эцсийн балансаар 491,596.4 сая байсан бол тайлангийн эцэст 630,931.6 сая төгрөг болж нийт өр төлбөр 139,335.2 сая төгрөгөөр нэмэгдсэн ба өр төлбөрийн 38.1 хувийг урт хугацаат өр, 61.9 хувийг богино хугацаат өр төлбөр эзэлж байна.

2021 онд цалингийн өглөг 2,045.6 сая төгрөгөөр, татварын өр 44, 077.4 сая төгрөгөөр, НДШ-ийн өглөг 280.9 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн, богино хугацаат зээл 21,856.5 сая төгрөгөөр өссөн, урьдчилж орсон орлого 70,424.5 сая төгрөгөөр нэмэгдсэн, хүүгийн өглөг 1,370.2 сая төгрөгөөр, урт хугацаат өр төлбөр нийт дүнгээрээ 18,735.2 сая төгрөгөөр тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Нийт өглөгийн 178.7 тэрбум төгрөг нь Худалдаа хөгжлийн банканд өгөх зээлийн өглөг байна.

Урьдчилж орсон орлого 104.5 тэрбум төгрөг үлдэгдэлтэй байгаагийн 103.5 тэрбум төгрөг нь гадаад, дотоодын 41 компанийн 644.0 мянган тонн төмрийн баяжмалын төлбөрийг урьдчилж авсантай холбоотой байна.

Урьдчилж төлсөн зардалд 213.1 тэрбум төгрөг тусгасны 154.4 тэрбумтөгрөг нь "Кью Эс Си" ХХК-д төлсөн менежментийн төлбөр, 50.4 тэрбум төгрөг нь"Төмөр замын зураг төслийн институт" ХХК-д төлсөн вагоны түрээсийн төлбөртэй холбоотой, үлдсэн нь бусад байгууллагад төлсөн төлбөрүүд байна.

/2014-2021 оны санхүүгийн тайлангийн үзүүлэлт, сая төгрөгөөр/.

| Санхүүгийн үзүүлэлтүүд | 2013-12-31 | 2014-12-31 | 2015-12-31 | 2016-12-31 | 2017-12-31 | 2018-12-31 | 2019-12-31 | 2020-12-31 | 2021-12-31 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Мөнгө, адилтгах зүйлс | 1,138,124.00 | 52,564.00 | 9,863.00 | 379,194.00 | 17,979.00 | 12,720.00 | 51,851.00 | 10,871.00 | 383,221.87 |
| Дансны болон бусад авлага | 5,245,086.00 | 7,667,138.00 | 6,819,538.00 | 6,382,079.00 | 132,161,718.00 | 153,418,530.00 | 152,498,066.00 | 174,298,995.00 | 97,811,413.43 |
| Татварын авлага | 17,166.00 | 92,131.00 | 65,953.00 | 92,839.00 | 68,003.00 | 58,254.00 | - | 1,672,049.00 | 2,006,129.60 |
| Бараа материал | 65,434,012.00 | 87,793,711.00 | 74,492,763.00 | 62,125,599.00 | 88,214,195.00 | 91,187,447.00 | 106,467,255.00 | 130,979,648.00 | 168,411,559.43 |
| УТЗардал | 12,165,938.00 | 4,825,508.00 | 10,267,539.00 | 2,430,271.00 | 7,117,678.00 | 6,025,339.00 | 7,315,913.00 | 7,227,425.00 | 213,088,387.48 |
| Эргэлтийн хөрөнгийн дүн | 84,000,326.00 | 100,431,052.00 | 91,655,856.00 | 71,409,982.00 | 227,579,573.00 | 250,702,290.00 | 268,333,085.00 | 314,188,988.00 | 481,700,711.80 |
| Үндсэн хөрөнгө | 85,036,228.00 | 89,341,905.00 | 87,992,981.00 | 93,053,753.00 | 95,906,850.00 | 94,452,484.00 | 98,142,126.00 | 107,087,452.00 | 121,970,519.78 |
| Биет бус хөрөнгө | 5,851,894.00 | 4,884,884.00 | 67,076.00 | 49,118.00 | 42,875.00 | 36,540.00 | 31,735.00 | 23,681.00 | 365,342.92 |
| Уурхайн хөрөнгө | - | - | 19,883,645.00 | 19,802,282.00 | 19,448,898.00 | 19,355,814.00 | 18,884,769.00 | 21,825,496.00 | 17,829,203.46 |
| Хойшлогдсон татварын хөрөнгө | | | | | | | 530,625.00 | 3,076,757.00 | 3,444,264.87 |
| Эргэлтийн бус хөрөнгийн дүн | 90,888,122.00 | 94,226,789.00 | 107,943,702.00 | 112,905,153.00 | 115,398,623.00 | 113,844,838.00 | 117,589,275.00 | 132,013,386.00 | 143,609,331.03 |
| НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН: | 174,888,448.00 | 194,657,841.00 | 199,599,358.00 | 184,315,135.00 | 342,978,196.00 | 364,547,128.00 | 385,922,360.00 | 446,202,374.00 | 625,310,042.83 |
| Дансны өглөг ба бусад өглөг | 15,956,311.00 | 16,910,378.00 | 25,935,307.00 | 26,868,807.00 | 40,523,960.00 | 71,878,924.00 | 67,993,563.00 | 50,912,104.00 | 40,239,486.70 |
| Татвар шимтгэлийн өглөг | 4,346,272.00 | 4,752,757.00 | 11,378,549.00 | 14,651,212.00 | 18,583,332.00 | 28,721,358.00 | 46,232,525.00 | 73,831,264.00 | 121,642,920.14 |
| Банкны богино хугацаат зээл | 105.00 | 30,641,413.00 | 32,646,515.00 | 5,270,765.00 | 24,535,924.00 | 78,742,444.00 | 54,747,431.00 | 70,366,969.00 | 92,223,526.76 |
| Хайгуулын ажлын нөхөн төлбөрийн өглөг | - | - | 2,233,581.00 | | 1,965,975.00 | 4,175,814.00 | 4,537,644.00 | 2,137,133.00 | 2,561,184.81 |
| Урьдчилж орсон орлого | 5,249,012.00 | 1,202,218.00 | 9,555,061.00 | 15,300,288.00 | 7,799,371.00 | 1,672,828.00 | 67,440,174.00 | 34,112,410.00 | 104,537,335.50 |
| Нөөц ба өр төлбөр | - | | - | 141,314.00 | 417,818.00 | 705,992.00 | 894,082.00 | 908,391.00 | 776,307.86 |
| Хүүгийн өглөг | | | - | | | | | | 26,357,946.06 |
| Богино хугацаат өр төлбөр | 26,5[illegible]1,700.00 | 53,506,764.00 | 81,749,013.00 | 62,232,384.00 | 93,928,380.00 | 186,697,360.00 | 241,845,419.00 | 232,265,291.00 | 390,338,707.87 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Урт хугацаат зээл | 16,783,080.00 | 12,939,278.00 | - | 7,551,469.00 | 137,408,945.00 | 90,371,913.00 | 57,934,131.00 | 79,622,373.00 | 66,911,963.62 |
| Хөрөнгө оруулалтын өглөг | 87,562,951.00 | 82,348,709.00 | 90,021,839.00 | 90,021,839.00 | 90,021,839.00 | 90,021,839.00 | 90,021,839.00 | 165,499,180.00 | 162,898,479.30 |
| Хайгуулын ажлын нөхөн төлбөрийн өглөг | 7,057,959.00 | 7,466,034.00 | 5,669,502.00 | 10,254,473.00 | 8,031,470.00 | 6,551,903.00 | 4,507,683.00 | 2,561,823.00 | |
| Нөхөн сэргээлтийн нөөц | - | - | 2,796,468.00 | 0 | - | - | | | |
| Урт хугацаат нөөц ба өр төлбөр | - | - | 1,848,714.00 | 5,395,202.00 | 6,436,434.00 | 7,353,893.00 | 10,037,834.00 | 11,644,765.00 | 10,782,492.55 |
| Урт хугацаат өр төлбөр | 111,413,990.00 | 102,754,021.00 | 100,336,523.00 | 113,222,983.00 | 241,898,688.00 | 194,289,553.00 | 182,501,487.00 | 259,328,141.00 | 240,592,935.46 |
| Нийт өр төлбөрийн дүн | 136,965,690.00 | 156,260,785.00 | 182,065,536.00 | 175,455,367.00 | 335,725,068.00 | 379,996,913.00 | 404,346,906.00 | 491,596,432.00 | 630,931,643.33 |
| Хувьцаат капитал | 21,091,048.00 | 20,987,274.00 | 21,353,312.00 | 21,353,312.00 | 21,353,312.00 | 21,353,312.00 | 21,353,312.00 | 21,353,312.00 | 21,353,312.48 |
| Дахин үнэлгээний нөөц | 875,415.00 | 613,443.00 | - | - | - | - | - | - | - |
| Хуримтлагдсан ашиг | 15,956,295.00 | 16,796,339.00 | (3,839,490.00) | (12,493,544.00) | (14,100,184.00) | (36,803,097.00) | (39,777,858.00) | (66,747,370.00) | (26,974,912.98) |
| Өмчийн дүн: | 37,922,768.00 | 38,397,056.00 | 17,513,822.00 | 8,869,768.00 | 7,253,128.00 | (15,449,785.00) | (18,424,546.00) | (45,394,058.00) | (5,621,600.50) |
| Өр төлбөр, эзэмшигчийн өмч дүн: | 174,888,448.00 | 194,657,841.00 | 199,599,358.00 | 184,318,135.00 | 342,978,196.00 | 364,547,128.00 | 385,922,368.00 | 446,202,374.00 | 625,310,042.83 |
| Өсөлт(+), бууралт(-) | - | 19,769,393.00 | 4,941,517.00 | (15,284,223.00) | 158,663,061.00 | 21,568,932.00 | 21,375,232.00 | 60,280,014.00 | 179,107,668.83 |

Компанийн 2014 оноос хойших санхүүгийн тайлангийн үзүүлэлтийг 2021 оны дүнтэй харьцуулахад өнгөрсөн 8 жилийн хугацаад нийт хөрөнгийн хэмжээ 450.4 сая төгрөгөөр өссөн боловч, өр төлбөр 494.0 тэрбум төгрөгөөр, үүнээс богино хугацаат өр төлбөр 73.8 хувиар буюу 364.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хөрөнгийн өсөлтийн дийлэнх буюу 200.9 сая төгрөг урьдчилж төлсөн зардал эзэлж байгаа нь хөрөнгө, өр төлбөрийн зохист харьцаа алдагдсаныг харуулж байна.

Компани өнгөрсөн хугацаанд үйл ажиллагаагаа явуулахдаа гадны зээлийн эх үүсвэрийг ашигласан ба зээлийн эх үүсвэрийн дийлэнх хувийг гадаад валютаар авсан зээл эзэлж байгаа нь компанийн санхүүгийн байдалд дарамт үүсгэж байна.

Өнгөрсөн хугацаанд 121.6 тэрбум төгрөгийн татварын өр төлбөрийн үлдэгдэлтэй байгаа нь компани хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй, Төсвийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлээгүй байгааг харуулж байна.

**4.2. Эдийн засгийн үзүүлэлтийн талаар:** Тус компанийн 2010-2021 оны эдийн засгийн гол үзүүлэлт болох бүтээгдэхүүн үйлдвэрлэл, уурхайн олборлолт, хүдэр олборлолт, боловсруулалт, нийт орлого, зарлагын хэмжээг графикаар харьцуулж үзвэл:

1. ДТҮ-ийн үйлдвэрлэлийн хэмжээ График-1








2. ДТҮ-ийн Уурхайн олборлолт, баяжуулалтын хэмжээ График-2




Дээрх графикаас харахад концессын гэрээ хэрэгжиж эхэлсэн 2014 оноос "Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр" ХК-ийн хаягдал төмөр худалдан авалт, боловсруулалт, бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээ эрс буурч 2010 оныг 2021 оныг харьцуулахад дунджаар 2.1 дахин буурсан үзүүлэлттэй.

Уурхайн олборлолтын хэмжээ 2010 оныг 2021 онтой харьцуулахад дунджаар 2.5 дахин өссөн, мөн нийт борлуулалтын орлого 2014 оны 2021 онтой харьцуулахад дунжаар 4.5 дахин өссөн үзүүлэлттэй байна.

ДТҮ-ийн үйлдвэрлэлийн нийт орлого, зарлагын хэмжээ График-3




"Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК нь 2014-2021 оны хугацаанд үндсэн үйл ажиллагаанаас 1 их наяд 595.1 тэрбум төгрөгийн, үндсэн бус үйл ажиллагаанаас 47.0 тэрбум төгрөгийн орлого олж, борлуулалтын өртөгт 698.7 тэрбум төгрөгийн, АМНАТөлбөрт 39.7 тэрбум төгрөгийн, үндсэн бус үйл ажиллагаанд 799.6 тэрбум төгрөгийн зардал зарцуулан, татварын дараах байдлаар 34.9 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна.

Компани 2014-2018 оны хооронд жил бүр алдагдалтай ажилласан Тухайлбал, 2014 онд 456.9 сая төгрөгийн, 2015 онд 13.4 тэрбум төгрөгийн 2016 онд 11.5 тэрбум төгрөгийн 2017 онд 5.1 тэрбум төгрөгийн, 2018 онд 22.7 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Харин 2019 онд 6.6 тэрбум төгрөгийн, 2020 онд 41.6 тэрбум төгрөгийн, 2021 онд 39.8 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна.

"Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн 2014-2021 оны орлого үр дүнгийн байдалд урд онтой харьцуулан шинжилгээ хийж үзэхэд борлуулалтын орлого 2015 онд буурсан харин бусад онуудад тогтмол өссөн үзүүлэлттэй байна.

Борлуулалтын өртгийг тайлант оны борлуулалтын орлогод эзэлж байгаа хувиар үзэхэд 2014 онд нийт борлуулалтын орлогын 88.0 %, 2015 онд 64.0%-ийг тус тус өртгийн зардал эзэлж байсан бол 2016-2021 онуудад орлогын 30%-50%-ийг өртгийн зардал эзэлж байна.

Борлуулалт маркетингийн зардал бусад онуудтай харьцуулахад 2016 онд 46%, 2018 онд 37%-ийг эзэлж байсан бол бусад онуудад 8-29 хувьтай байна.

Ерөнхий ба удирдлагын зардал нь тайлант онуудад дунджаар нийт зардлын 10-20 хувийг эзэлж байсан бол 2021 онд 30% болж өссөн нь тайлант онд найдваргүй авлагын хасагдуулга тооцсоноос шалтгаалсан найдваргүй авлагын хасагдуулгын зардлаар бүртгэсэн дүнгээс 77,845.9 сая төгрөг нь "Кью Эс Си" ХХК-тай холбоотой авлага байна.

Компанийн нийт орлогын 2014 онд 68.0 хувийг, 2015 онд 59.6 хувийг, 2016 онд 24.8 хувийг, 2017 онд 47.4 хувийг, 2018 онд 33.5 хувийг, 2019 онд 10.9 хувийг, 2020 онд 5.6 хувийг, 2021 онд 21.5 хувийг үйлдвэрийн борлуулалт эзэлж байна.

Уурхайн орлого 2014 онд нийт орлогын 32 хувийг, 2015 онд 40.4 хувийг, 2016 онд 75.2 хувийг, 2017 онд 52.6 хувийг, 2018 онд 66.5 хувийг, 2019 онд 89.1 хувийг 2020 онд 94.4 хувийг, 2021 онд 78.5 хувийг тус тус эзэлж байна.

Сүүлийн 2014-2015 онд орлогын ихэнх хувийг үйлдвэрийн орлого эзэлж байсан бол 2018-2021 онд уурхайн орлого дийлэнх хувийг эзэлж байна.

/2014-2021 оны орлогын дэлгэрэнгүй тайлан/.

| Балансын үзүүлэлтүүд | 2014 онд | 2015 онд | 2016 онд | 2017 онд | 2018 онд | 2019 онд | 2020 онд | 2021 онд |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Борлуулалтын орлого | 90,659,816.0 | 70,331,126.0 | 98,883,597.0 | 131,795,768.0 | 160,162,654.0 | 213,229,128.0 | 304,232,383.0 | 432,375,481.2 |
| Борлуулалтын өртөг | (75,612,594.0) | (44,029,351.0) | (43,344,675.0) | (58,349,776.0) | (80,368,166.0) | (92,797,247.0) | (102,835,850.0) | (129,528,285.6) |
| Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр | (2,301,534.0) | | (3,320,801.0) | (2,084,168.0) | (6,661,962.0) | (8,920,273.0) | (14,262,353.0) | - |
| Үйл ажиллагааны ашиг/алдагдал | 12,745,688.0 | 26,301,775.0 | 52,218,121.0 | 71,361,824.0 | 73,132,526.0 | 111,511,608.0 | 187,134,180.0 | 302,847,195.6 |
| Борлуулалт удирдлагын зардал | (7,793,621.0) | (4,804,528.0) | (53,611,151.0) | (66,558,324.0) | (84,797,113.0) | (86,418,849.0) | (101,533,488.0) | (188,759,715.1) |
| Бусад орлого | 6,673,239.0 | 10,997,481.0 | 5,763,315.0 | 4,451,102.0 | 11,586,866.0 | 5,525,434.0 | 1,028,152.0 | 421,289.4 |
| Бусад зардал | (8,226,148.0) | (21,331,329.0) | (12,364,810.0) | (10,325,656.0) | (18,451,553.0) | (9,977,447.0) | (20,452,545.0) | (169,844.3) |
| Үйл ажиллагааны бус ашиг/алдагдал | (9,346,530.0) | (15,138,376.0) | (60,212,646.0) | (72,432,878.0) | (91,661,800.0) | (90,870,862.0) | (120,957,881.0) | (188,508,270.0) |
| Санхүүгийн орлого | 323,050.0 | - | 3,180.0 | 19,046.0 | 54,583.0 | 19,225.0 | 1,341.0 | - |
| Санхүүгийн зардал | (2,914,411.0) | (24,517,302.0) | (3,468,941.0) | (3,174,045.0) | (4,262,793.0) | (12,665,478.0) | (7,160,829.0) | (35,977,936.4) |
| ТТӨА | 807,797.0 | (13,353,903.0) | (11,460,286.0) | (4,226,053.0) | (22,737,484.0) | 7,994,493.0 | 59,016,811.0 | 78,360,989.3 |
| Орлогын албан татвар | (1,264,736.0) | (5,714.0) | (389.0) | (880,237.0) | (5,458.0) | (1,401,093.0) | (17,409,120.0) | (38,574,285.6) |
| Татварын дараах ашиг/алдагдал | (456,939.0) | (13,359,617.0) | (11,460,675.0) | (5,106,290.0) | (22,742,942.0) | 6,593,400.0 | 41,607,691.0 | 39,786,703.7 |





## ТАВ. БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ, БОРЛУУЛАЛТЫН ТАЛААР

**5.1. Үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын талаар:** Үйлдвэрийн хөдөлмөрийн дотоод журмын 3.1-д "Гүйцэтгэх захирал нь компанийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар хууль тогтоомжид нийцүүлэн тушаал гаргана" гэснийг болон Төлөөлөн удирдах зөвлөл, захирлын зөвлөлийн шийдвэрийг үндэслэн үйлдвэрийн захирлын тушаалаар хаягдал төмөр худалдан авах үнийг тогтоож байна.

/Хаягдал төмөр худалдан авах үнэ, төгрөгөөр/

| Д/д | Тушаал | | Хэрэгжиж эхлэх хугацаа | Хаягдал төмөр | | Хаягдал ширэм | | НӨАТ |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Огноо | Дугаар | | УБ хотод | Дарханд | УБ хотод | Дарханд | |
| 1 | 2013.03.27 | А/35 | 2013.03.26 | 270,000.0 | 300,000.0 | | | Тооцсон. |
| 2 | 2013.06.05 | А/57 | 2013.06.06 | 245,000.0 | 275,000.0 | | | Тооцсон. |
| 3 | 2015.05.01 | А/99 | 2015.05.04 | 230,000.0 | 250,000.0 | | | Тооцсон. |
| 4 | 2015.06.15 | А/141 | 2015.06.22 | 200,000.0 | 220,000.0 | 80,000.0 | 100,000.0 | Тооцсон. |
| 5 | 2016.11.30 | А/149 | 2016.12.01 | 160,000.0 | 180,000.0 | 80,000.0 | 100,000.0 | Тооцсон. |
| 6 | 2018.01.04 | А/1 | 2018.01.04 | 220,000.0 | 240,000.0 | | | Тооцоогүй. |
| 7 | 2018.04.25 | А/112 | 2018.04.25 | 220,000.0 | 240,000.0 | 80,000.0 | 100,000.0 | Тооцоогүй. |

"Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК нь 2014-2021 онуудад үйлдвэр дээрээ шууд худалдан авалтаар 140,248.29 тн хаягдал төмрийг 32,175.9 сая төгрөгөөр, Улаанбаатар төмөр бэлтгэх төвөөрөө дамжуулан 106,501.89 тн хаягдал төмрийг 24,214.8 сая төгрөгөөр, нийт 246,750.18 тн хаягдал төмрийг 56,390.8 сая төгрөгөөр худалдан авсан байна. 2014-2021 онд хаягдал төмөр худалдан авахтай холбоотой нийт 6,471.7 сая төгрөгийн нэмэлт зардал гарсан байна.

2021 онд хаягдал төмөр худалдан авахтай холбоотой зардал бусад оноос өндөр байгаа шалтгаан нь 3 аж ахуйн нэгж байгууллагатай "Хаягдал төмөр худалдах, худалдан авах гэрээ" байгуулж гэрээний 3.3-т "Батлагдсан графикийн дагуу тогтмол нийлүүлэх, 3.2-т заасан тоо хэмжээний 90 хувьд хүрсэн тохиолдолд нийлүүлсэн хаягдал төмрийн үнийн дүнгийн 20 хувиар урамшуулна, тоо хэмжээг улирлаар тооцон дүгнэж урамшууллыг олгоно" гэж заасны дагуу "Хангайн цуурай" ХХК-д 259.8 сая төгрөгийн, "Эвсэл эрч хүч" ХХК-д 456.9 сая төгрөгийн, "Эм Эс Эм Ти трейд" ХХК-д 463.3 сая төгрөгийн урамшууллыг тус тус олгосонтой холбоотой байна.

/Хаягдал төмрийн худалдан авалтын тоо, мөнгөн дүнг хүснэгтээр харуулав/.

| Он | Худалдан авсан хаягдал төмөр | | | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо хэмжээ /тонн/ | Дундаж нэгж үнэ /төгрөг/ | Нийт үнэ /мян.төг/ | Гарсан зардал /мян төг/ | Нийт зардлын дүн /мян.төг/ |
| 2014 | 64,465.85 | 252,940.90 | 16,306,051.70 | 472,939.70 | 16,778,991.30 |
| 2015 | 26,491.71 | 248,361.31 | 6,579,515.90 | 426,476.80 | 7,005,992.70 |
| 2016 | 13,674.88 | 142,636.45 | 1,950,536.40 | 105,490.00 | 2,056,026.40 |
| 2017 | 31,082.96 | 169,707.07 | 5,274,998.80 | 440,720.20 | 5,715,719.00 |
| 2018 | 24,111.28 | 222,100.94 | 5,355,138.30 | 988,180.10 | 6,343,318.30 |
| 2019 | 23,279.50 | 224,314.86 | 5,221,938.90 | 930,973.70 | 6,152,912.60 |
| 2020 | 37,379.90 | 224,235.95 | 8,381,918.00 | 964,011.00 | 9,345,929.00 |
| 2021 | 26,264.07 | 278,733.53 | 7,320,677.70 | 2,142,936.60 | 9,463,614.30 |
| Дүн | 246,750.17 | 228,533.89 | 56,390,775.70 | 6,471,728.20 | 62,862,503.80 |

Компани 2014-2021 оны хугацаанд нийт 246.8 мянган тонн хаягдал төмөр худалдан авч 257.9 мянган тонныг боловсруулалтад оруулж 2021 оны жилийн эцсийн байдлаар 24.5 мянган тонны үлдэгдэлтэй байна. 2016 оноос хаягдал

төмрийн худалдан авалтыг нэмэгдүүлэх, нөөцийг тогтмол хэмжээнд барих, түүхий эдийн тасалдлыг арилгах зорилгоор 2018 оноос хаягдал төмөр худалдан авах гэрээнд бартер, зээлийн борлуулалтыг хориглох, урьдчилгаа төлбөрөө100% барагдуулсан бол нийт үнийн дүнгээс 5%-ийн хөнгөлөлт үзүүлэх, 2020 онд500-999 тн төмөр нийлүүлсэн тохиолдолд нийт үнийн дүнгийн -2%, 1000-2000 тн - 3%, 2000 тн-с дээш бол -5% хөнгөлөлт олгох заалтыг нэмж оруулсан байна.

/Хаягдал төмрийн үлдэгдэл, хаягдал төмрөөс ялган авсан үнэт металлын орлого/

| Он | Хаягдал төмрийн үлдэгдэл | | | Өсөлт/+/, бууралт/-/, тоо хэмжээнд | Хаягдал төмрөөс гарган авсан үнэт металл | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо хэмжээ /тонн/ | Дундаж үнэ /төгрөг/ | Нийт үнэ /мян.төг/ | | Тоо хэмжээ /тонн/ | Дундаж үнэ /төгрөг/ | Нийт үнэ /мян.төг/ |
| 2014 | 7,000.40 | 250,572.50 | 1,754,099.40 | | 2,680.10 | 1 | 2.7 |
| 2015 | 8,380.40 | 243,574.60 | 2,041,249.40 | 1,380.00 | 11,507.30 | 9,212.40 | 106,009.80 |
| 2016 | 4,200.70 | 188,160.40 | 790,412.00 | -4,179.70 | 3,267.30 | 12,777.10 | 41,747.20 |
| 2017 | 3,997.60 | 131,613.30 | 526,138.90 | -203.10 | 1,354.90 | 1 | 1.4 |
| 2018 | 11,778.60 | 159,216.70 | 1,875,347.00 | 7,781.00 | 1,497.30 | 2,503.90 | 3,749.20 |
| 2019 | 10,578.30 | 193,494.90 | 2,046,838.90 | -1,200.30 | 2,318.70 | 1 | 2.3 |
| 2020 | 9,220.90 | 200,925.60 | 1,852,709.50 | -1,357.40 | 1,765.30 | 32,379.10 | 57,159.00 |
| 2021 | 24,469.00 | 212,789.30 | 5,206,738.30 | 15,248.10 | 1,482.90 | 151 | 224 |
| Нийт дүн: | 79,625.80 | 202,114.60 | 18,093,533.30 | 17,468.60 | 25,873.90 | - | 208,895.60 |

<u>Хаягдал төмөр боловсруулалтын талаар:</u> Тус үйлдвэр 2014 оны эхэнд 16,093.5 сая төгрөгийн үнэтэй 79,625.8 тн хаягдал төмрийн үлдэгдэлтэй байсан ба 2014-2021 онуудад 56,390.8 сая төгрөгийн үнэтэй 246,750.2 тн хаягдал төмөр худалдан авч 53,130.5 сая төгрөгийн үнэтэй 257,853.7 тн хаягдал төмрийг боловсруулалтад оруулсан байна.

Тухайн жилүүдэд боловсруулалтад орж байгаа хаягдал төмрийн дундаж үнэ 206.0 мянган төгрөг бол, боловсруулалтын өртөг 120.8 мянган төгрөгөөр нэмэгдэж, боловсруулалтын өртөг тооцсон нэгж үнэ 326.8 мянган төгрөг буюу 84,262.6 сая төгрөгийн 257,853.7 тн хаягдал төмөр боловсруулсан байна.

/2014-2021 онд боловсруулалтад оруулсан хаягдал төмөр/

| Он | Боловсруулалтад | | | | |
|---|---|---|---|---|---|
| | Хаягдал төмөр /тонн/ | Дундаж үнэ /мян.төг/ | Нийт үнэ /мян.төг/ | Боловсруулалтын өртөг тооцсон дүн /мян.төг/ | Боловсруулалтын нийт үнэ /мян.төг/ |
| 2014 | 65,765.90 | 243.6 | 16,018,904.40 | 319.9 | 21,039,958.30 |
| 2015 | 42,178.70 | 188.2 | 7,936,363.10 | 259.7 | 10,955,453.40 |
| 2016 | 17,145.35 | 131.6 | 2,256,556.60 | 204.6 | 3,508,247.20 |
| 2017 | 24,656.91 | 159.2 | 3,925,792.10 | 298.1 | 7,349,781.00 |
| 2018 | 26,808.95 | 193.5 | 5,187,395.60 | 358.4 | 9,607,308.90 |
| 2019 | 26,955.60 | 200.9 | 5,416,070.70 | 363.2 | 9,790,489.60 |
| 2020 | 23,897.10 | 212.8 | 5,085,048.20 | 363.7 | 8,690,395.50 |
| 2021 | 30,445.16 | 239.9 | 7,304,395.20 | 437.5 | 13,320,974.40 |
| Нийт дүн: | 257,853.67 | 206 | 53,130,525.90 | 326.8 | 84,262,608.30 |

2014-2021 онуудад боловсруулсан хаягдал төмрөөс 114,191.8 сая төгрөгийн 89,459.7 тн арматур, 148,897.8 сая төгрөгийн 139,259.7 тн ган туйван, 1,363.9 тн ган бөмбөлөг тус тус үйлдвэрлэсэн байна.





/2014-2021 онд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, тоо хэмжээ/

| Үзүүлэлт | 2014 он | 2015 он | 2016 он | 2017 он | 2018 он | 2019 он | 2020 он | 2021 он | Өссөн дүн /тонн/ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт: /тн/ | | | | | | | | | |
| Цувималын бэлдэц | 56,312 | 43,131 | 16,319 | 20,685 | 25,291 | 28,226 | 15,506 | 35,400 | 240,871.76 |
| Үүнд: Цувимал | 52,955.7 | 40,595.9 | 15,741.5 | 17,456.9 | 26,153.0 | 24,206.0 | 16,675.5 | 34,931.7 | 228,716.2 |
| Арматур | 25,995.6 | 10,882.7 | | 1,371.0 | 4,295.3 | 15,873.7 | 8,149.3 | 22,721.0 | 89,288.6 |
| Круг | 26,960.1 | 29,713.2 | 15,741.5 | 12,741.8 | 21,857.7 | 8,332.3 | 8,526.1 | 12,210.9 | 136,083.7 |
| Ган бөмбөлгийн бэлдэц | | | | 3,344.0 | - | - | - | | 3,344.0 |
| Ган бөмбөлөг | | | | 859.4 | 152.7 | 180.8 | 426.0 | - | 1,619.0 |

**5.2. Үйлдвэрийн бүтээгдэхүүн борлуулалтын талаар:** Компани 2014-2021 онд нийт 83.3 мянган тонн, 105.5 тэрбум төгрөгийн өртөгтэй төрөл бүрийн хэмжээтэй арматур, 9.5 мянган тонн, 11.6 тэрбум төгрөгийн өртөгтэй стандарт бус арматур, 1.3 мянган тонн, 4.8 тэрбум төгрөгийн өртөг бүхий ган бөмбөлөг, 127.9 мянган тонн 136.5 тэрбум төгрөгийн бөөрөнхий төмөр борлуулан нийт 380.4 тэрбум төгрөгийн орлого олсон байна.

Үйлдвэрийн бүтээгдэхүүний нийт борлуулалтын 59.8 хувийг бөөрөнхий төмөр /круг/, 34.1 хувийг төрөл бүрийн хэмжээтэй арматур, 5.1 хувийг стандарт бус арматурын борлуулалт, 0.9 хувийг ган бөмбөлгийн борлуулалт эзэлж байна. эзэлж байна.

Бүтээгдэхүүний нэгжийн өртөг буюу 1 тн арматурын үнэ 2014 онд хэмжээнээс хамааран 709,024.86 төгрөгөөс 1,466,419.1 төгрөгийн хооронд байсан бол 2021 онд 1,581,818.4-2,562,545.45 төгрөг ойролцоогоор 74.8 хувиар өссөн байна.

Компани арматурын худалдан борлуулах үнийг гүйцэтгэх захирлын тушаалаар 2021-2022 онд нийт 4 удаа, цувимал бүтээгдэхүүн борлуулах үнийг гүйцэтгэх захирлын тушаалаар 2014-2020 онд нийт 9 удаа шинээр тогтоож өгсөн байна. Үүнд, 1 тонн цувимал бүтээгдэхүүн худалдах үнийг 2014 онд марк, уртын хэмжээнээс нь хамааруулан 1,090,000.0-1,130,000.0-1,250,000.0 төгрөгөөр тогтоож байсан бол, 2017 оноос 1,485,000-2,013,000.0 төгрөгөөр, 2021 оноос 1 тонн арматурын үнийг 2,160,000.0-2,970,000.0 төгрөгөөр тогтоосон байна.

Дээрх тушаалаар 2014 онд үйлдвэрийн бүтээгдэхүүн үнийг өөрийн өртгөөс нь доогуур үнээр тогтоож шийдвэрлэснээс 140 харилцагчид, 20.4 мянган тонн бүтээгдэхүүн борлуулан энэхүү борлуулалтаас 3.1 тэрбум төгрөгийн алдагдал хүлээсэн байна.

- Тушаалаар 12м-ийн урттай, Д13, 16, 19, 22, 25, 29 маркийн, 1 тн нь 1,021,165.12-1,466,419.57 төгрөгийн өөрийн өртөгтэй бүтээгдэхүүнийг, 1,009,090.9-1,136,363.64 төгрөгөөр худалдан борлуулж тухайн ажил гүйлгээнээс 2.3 тэрбум төгрөгийн алдагдалтай борлуулалт хийсэн.
- Тушаалаар 6-11.5м-ийн урттай, Д13, 19, 22, 25, 29 маркийн, 1 тн нь 1,025,446.6-1,466,419.63 төгрөгийн өөрийн өртөгтэй бүтээгдэхүүнийг, 1,000,000.0-1,136,363.64 төгрөгөөр худалдан борлуулж тухайн ажил гүйлгээнээс 749.5 сая төгрөгийн алдагдалтай борлуулалт хийсэн.
- Тушаалаар 6-11.5м-ийн урттай, Д19, 22, 25 маркийн, 1 тн нь 1,008,591.12-1,400,590.55 төгрөгийн өөрийн өртөгтэй бүтээгдэхүүнийг, 1,000,000.0-

1,118,181.81 төгрөгөөр худалдан борлуулж тухайн ажил гүйлгээнээс 22.6 сая төгрөгийн алдагдалтай борлуулалт хийсэн.

- Тушаалгүйгээр 125.8 мянган тонн арматурыг өөрийн өртгөөс нь доогуур үнээр худалдан 16.3 сая төгрөгийн алдагдалтай борлуулалт хийсэн.
- Тушаалаар тогтоосон үнээс доогуур 177.3 тонн арматурыг өөрийн өртгөөс нь доогуур үнээр худалдан 23.7 сая төгрөгийн алдагдалтай борлуулалт хийсэн.

/2014-2021 оны үйлдвэрийн бэлэн бүтээгдэхүүний борлуулалтын мэдээллийг хүснэгтээр харуулав./

| Үйлдвэрийн бэлэн бүтээгдэхүүний төрөл | Зарлагын тоо /тонн/ | ББӨ /төгрөг/ | Нийт өртөг /төгрөг/ | Борлуулал-тын нэгж өртөг /төгрөг/ | Борлуулалтын нийт дүн /НӨАТ-гүй/, /төгрөг/ |
|---|---|---|---|---|---|
| **2014 он** | **51,849.44** | **1,099,146.81** | **57,100,060,377.95** | **1,158,873.86** | **60,202,846,796.09** |
| Арматур /төрөл бүрийн хэмжээтэй/ | 24,560.99 | 1,145,021.82 | 28,122,870,503.94 | 1,039,863.98 | 25,540,089,859.71 |
| Арматур барак | 99.31 | 1,092,690.67 | 108,519,481.53 | 919,171.52 | 91,286,600.01 |
| Бөөрөнхий төмөр | 27,272.63 | 1,058,233.53 | 28,860,811,463.59 | 1,267,129.98 | 34,557,967,063.64 |
| Оваль | 16.50 | 476,183.28 | 7,858,928.89 | 818,181.82 | 13,503,272.73 |
| **2015 он** | **29,438.14** | **942,542.81** | **27,746,710,851.10** | **1,396,405.38** | **41,107,582,516.43** |
| Арматур /төрөл бүрийн/ | 9,909.41 | 959,413.03 | 9,507,215,955.60 | 1,140,065.86 | 11,297,378,652.75 |
| Арматур барак | 0.93 | 1,089,246.74 | 1,007,553.23 | 990,909.09 | 916,590.91 |
| Бөөрөнхий төмөр | 19,521.26 | 934,126.98 | 18,235,335,562.97 | 1,526,742.03 | 29,803,928,181.85 |
| Оваль | 6.55 | 481,187.68 | 3,151,779.30 | 818,181.82 | 5,359,090.92 |
| **2016 он** | **15,555.02** | **841,824.18** | **13,094,591,743.38** | **1,574,293.18** | **24,488,161,519.98** |
| Арматур /төрөл бүрийн/ | 1,692.17 | 833,835.08 | 1,410,990,713.15 | 1,141,680.77 | 1,931,917,954.55 |
| Бөөрөнхий төмөр | 13,857.04 | 842,951.01 | 11,680,804,848.62 | 1,627,439.27 | 22,551,489,110.89 |
| Оваль | 5.81 | 481,187.68 | 2,796,181.61 | 818,181.82 | 4,754,454.54 |
| **2017 он** | **31,903.59** | **974,396.80** | **31,086,756,830.63** | **1,958,023.54** | **62,467,981,727.52** |
| Арматур /төрөл бүрийн/ | 1,705.87 | 1,003,743.26 | 1,712,250,597.38 | 1,286,056.33 | 2,193,838,610.00 |
| Бөөрөнхий төмөр | 29,843.25 | 941,861.82 | 28,108,214,118.01 | 1,993,370.01 | 59,488,631,709.10 |
| Ган бөмбөлөг стандарт бус | 5.78 | 1,656,292.39 | 9,570,885.59 | 2,401,225.91 | 13,875,483.92 |
| Ган бөмбөлөг ф120 | 307.22 | 4,026,276.78 | 1,236,933,023.26 | 2,401,225.83 | 737,692,833.60 |
| Оваль | 41.49 | 476,985.16 | 19,788,206.39 | 818,181.82 | 33,943,090.90 |
| **2018 он** | **26,501.14** | **1,327,117.43** | **35,170,127,341.84** | **2,003,074.17** | **53,083,753,136.21** |
| Арматур /төрөл бүрийн/ | 3,885.90 | 1,288,157.51 | 5,005,653,968.26 | 1,552,424.78 | 6,032,570,714.57 |
| Бөөрөнхий төмөр | 22,147.60 | 1,278,049.61 | 28,305,731,638.83 | 2,070,000.00 | 45,845,532,000.00 |
| Ган бөмбөлөг ф125 | 443.79 | 4,162,444.17 | 1,847,267,333.31 | 2,672,727.27 | 1,186,140,059.99 |
| Оваль | 23.85 | 481,187.68 | 11,474,401.44 | 818,181.82 | 19,510,363.65 |
| **2019 он** | **13,259.43** | **1,290,671.46** | **17,113,571,704.30** | **1,742,853.25** | **23,109,245,935.35** |
| Арматур /төрөл бүрийн/ | 8,709.05 | 1,357,060.11 | 11,818,705,741.17 | 1,573,019.73 | 13,699,509,071.71 |
| Арматур стандарт бус | 4,542.75 | 1,164,755.61 | 5,291,193,538.74 | 2,070,000.00 | 9,403,492,500.00 |
| Бөөрөнхий төмөр | 7.63 | 481,187.68 | 3,672,424.39 | 818,181.82 | 6,244,363.64 |
| **2020 он** | **9,392.61** | **1,395,379.23** | **13,106,246,742.78** | **1,799,953.77** | **16,906,255,845.02** |
| Арматур /төрөл бүрийн/ | 4570.6216 | 1,511,492.17 | 6,908,458,740.57 | 1,514,764.26 | 6,923,414,233.20 |
| Бөөрөнхий төмөр | 4819.38 | 1,283,834.52 | 6,187,286,417.16 | 2,069,951.29 | 9,975,881,830.00 |
| Ган бөмбөлөг ф100 | 2.604 | 4,032,866.76 | 10,501,585.05 | 2,672,727.27 | 6,959,781.82 |
| **2021 он** | **44,164.05** | **1,451,431.48** | **64,101,097,851.08** | **2,241,632.73** | **98,999,588,546.35** |
| Арматур /төрөл бүрийн/ | 28,244.65 | 1,453,384.37 | 41,050,325,508.02 | 2,203,137.93 | 62,226,848,856.33 |
| Арматур стандарт бус | 42.57 | 1,069,595.47 | 45,531,609.38 | 1,653,489.76 | 70,387,405.46 |
| Бөөрөнхий төмөр | 15,314.15 | 1,393,069.60 | 21,333,675,467.13 | 2,298,091.64 | 35,193,317,866.38 |
| Ган бөмбөлөг стандарт бус | 7.26 | 1,068,692.85 | 7,761,702.46 | 2,681,818.18 | 19,477,509.09 |
| Ган бөмбөлөг ф100 | 555.43 | 2,995,534.19 | 1,663,803,564.09 | 2,681,818.18 | 1,489,556,909.09 |
| **2022-I улирал** | **12,637.61** | **1,564,598.87** | **19,772,757,876.19** | **2,532,857.33** | **32,009,251,464.50** |
| Арматур /төрөл бүрийн/ | 7,687.74 | 1,551,667.70 | 11,928,815,389.24 | 2,574,963.63 | 19,795,646,778.13 |
| Арматур барак | 70.76 | 1,087,001.14 | 76,919,461.83 | 1,300,000.00 | 91,991,900.00 |
| Арматур стандарт бус | 132.43 | 1,206,194.81 | 159,735,171.89 | 1,310,629.85 | 173,565,400.00 |
| Бөөрөнхий төмөр | 4,746.68 | 1,602,656.14 | 7,607,287,853.23 | 2,517,140.40 | 11,948,047,386.37 |
| **Нийт дүн** | **234,801.03** | **1,185,224.43** | **278,291,921,319.25** | **1,756,272.80** | **412,374,667,489.45** |

**5.3. Уурхайн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн талаар:** Компани 2014-2021 онд Төмөртолгой, Төмөртэйн ордуудаас төмрийн хүдэр олборлож төмрийн хүдрийг баяжуулан эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж бүтээгдэхүүнийг экспортод гаргах, худалдан борлуулах үйл ажиллагаа явуулсан байна.





2014 оны эхэнд компани 2.5 сая тонн, 25.4 тэрбум төгрөгийн төмрийн хүдрийн үлдэгдэлтэй байсан бол 2014 онд 2.2 сая тонн, 2015 онд 18.9 мянган тонн, 2016 онд 539.4 мянган тонн, 2017 онд 2.6 сая тонн, 2018 онд 1.6 сая тонн, 2019 онд 2.5 сая тонн, 2020 онд 3.7 сая тонн, 2021 онд 3.0 сая тонн нийт 16.1 сая тонн төмрийн хүдэр олборлосон байна.

Төмрийн хүдэр олборлолтын төлөвлөгөө 2014, 2015 онуудад тасарсан нь компанийн үйл ажиллагааг гүйцэтгэх захирлын шийдвэрээр зогсоосон үйлдвэрт Консерваци явуулах ажиллагаатай холбоотой байна.

/Төмрийн хүдрийн олборлолт, боловсруулалт, үлдэгдлийг оноор харуулав/.

| Он | Хүдэр олборлолт | | Боловсруулалт, Үйлдвэрлэлд зарцуулсан | | Үлдэгдэл | |
|---|---|---|---|---|---|---|
| | Тоо хэмжээ /тн/ | Нийт үнэ /төгрөгөөр/ | Тоо хэмжээ /тн/ | Нийт үнэ /төгрөгөөр/ | Тоо хэмжээ /тн/ | Нийт үнэ /төгрөгөөр/ |
| 2014-01-01 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 2,524,820.00 | 25,358,318,028.96 |
| 2014 онд | 2,178,862.22 | 35,957,784,048.78 | 1,706,251.00 | 26,224,822,879.35 | 2,997,431.22 | 35,091,279,198.39 |
| 2015 онд | 18,850.00 | 877,644,957.14 | 863,635.00 | 10,054,856,153.88 | 2,152,646.22 | 25,914,068,001.65 |
| 2016 онд | 539,413.75 | 8,779,434,565.22 | 1,845,452.11 | 24,101,387,210.35 | 846,607.87 | 10,592,115,356.52 |
| 2017 онд | 2,563,389.01 | 45,693,651,961.90 | 2,932,967.52 | 47,881,384,116.98 | 477,029.36 | 8,404,383,201.44 |
| 2018 онд | 1,566,855.81 | 41,085,044,761.68 | 1,989,133.35 | 47,507,853,151.27 | 54,751.82 | -1,981,574,811.85 |
| 2019 онд | 2,523,077.79 | 48,420,812,688.23 | 2,408,337.51 | 45,105,856,279.32 | 169,492.10 | 5,296,531,220.76 |
| 2020 онд | 3,724,776.55 | 65,448,695,954.45 | 3,471,906.59 | 62,210,791,721.80 | 422,362.06 | 8,534,435,453.41 |
| 2021 онд | 3,010,191.31 | 71,480,513,865.27 | 3,004,264.91 | 66,058,739,382.18 | 428,288.46 | 13,956,209,936.50 |
| 2022-03-31 | | 0.00 | 0.00 | 0.00 | 428,288.46 | 13,956,209,936.50 |
| **Дүн** | **16,125,416.45** | **317,743,682,802.67** | **18,221,947.99** | **329,145,690,895.13** | **10,501,717.57** | **149,086,125,146.98** |
| Олборлолтоос гадуурхи төмрийн хүдрийн орлого, зарцуулалт /худалдсан, данс шилжүүлсэн/ | | | | | | |
| Он | Хүдрийн бусад орлого | | Бусад зарцуулалт | | Үлдэгдэл /Нийт дүнгээр/ | |
| | Тоо хэмжээ /тн/ | Нийт үнэ /төгрөгөөр/ | Тоо хэмжээ /тн/ | Нийт үнэ /төгрөгөөр/ | Тоо хэмжээ /тн/ | Нийт үнэ /төгрөгөөр/ |
| 2014 онд | 0.00 | 0.00 | 57.22 | 956,034.13 | 2,997,374.00 | 35,090,323,164.26 |
| 2015 онд | 0.00 | 0.00 | | | 2,152,646.22 | 25,914,068,001.65 |
| 2016 онд | 0.00 | 0.00 | | | 846,607.87 | 10,592,115,356.52 |
| 2017 онд | 46,749.55 | 51,902,752.90 | | | 523,778.91 | 8,456,285,954.34 |
| 2018 онд | 55,757.99 | 55,757.99 | | | 110,509.81 | 1,981,630,569.84 |
| 2019 онд | 0.00 | 0.00 | | | 169,492.10 | 5,296,531,220.76 |
| 2020 онд | 0.00 | 0.00 | | | 422,362.06 | 8,534,435,453.41 |
| 2021 онд | 0.00 | 0.00 | | | 428,288.46 | 13,956,209,936.50 |
| 2022-03-31 | 0.00 | 0.00 | 530,738.78 | 14,007,212,413.31 | -102,450.32 | -51,002,476.81 |
| **Дүн** | **102,507.54** | **51,958,510.89** | **530,796.00** | **14,008,168,447.44** | **0.00** | **0.00** |
| **Нийт дүн:** | **16,227,923.99** | **317,795,641,313.56** | **18,752,743.99** | **343,153,859,342.57** | **0.00** | **0.00** |

Компани 2014-2022 оны 1 дүгээр улирлын хугацаанд олборлолтоос гадуур 102.5 мянган тонн 51.9 сая төгрөгийн төмрийн хүдрийг бэлэн бүтээгдэхүүнээр бүртгэн авсан байна.

Компани олборлосон төмрийн хүдрээс 2014-2022 оны 1 дүгээр улирлын хугацаанд 18.7 сая тонн, 336.8 тэрбум төгрөгийн өртөг бүхий төмрийн хүдрийг баяжуулах цехийн боловсруулалтад оруулан, 57.2 тонн төмрийн хүдрийг худалдан борлуулсан байна.

2022 оны 1 дүгээр улирлын байдлаар 530.7 мянган тонн, 14.0 тэрбум төгрөгийн төмрийн хүдрийн нөөцийн үлдэгдэлтэй байна.

2014-2021 онд төмрийн хүдрийн боловсруулалт төлөвлөсөн тоо хэмжээнд хүрээгүй ба Төмөртэйн уурхайд өссөн дүнгээр 90 хувийн гүйцэтгэлтэй, Төмөртолгойн уурхайд 66.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

/Төмрийн хүдэр боловсруулалт, баяжмал гаргалт/

| Он | Төмөртэй уурхай | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Хүдэр боловсруулалт, тн | | | Бүтээгдэхүүн гаргалт /тн/ | | | | | | Хаягдал үйлдвэрлэл, тн | | |
| | | | | Нийт баяжмал | | | Нийт зээсрийн бүтээгдэхүүн | | | Нийт хаягдал | | |
| | Төл | Гүйц | Гүйц хувь | Төл | Гүйц | Гүйц хувь | Төл | Гүйц | Гүйц хувь | Төл | Гүйц | Гүйц хувь |
| 2014 онд | - | 472,988.0 | 0% | - | 314,342.0 | 0% | | | | - | 158,646.0 | 0% |
| 2015 онд | 1,008,000.0 | 862,755.0 | 86% | 282,634.0 | 547,533.3 | 194% | | | | 725,366.0 | 315,221.7 | 43% |
| 2016 онд | 1,739,500.0 | 1,845,452.1 | 106% | 1,137,048.0 | 1,141,082.3 | 100% | 170,322.0 | 174,790.9 | 103% | 432,130.0 | 529,579.0 | 123% |
| 2017 онд | 1,995,900.0 | 2,019,937.9 | 101% | 1,188,435.3 | 1,177,854.7 | 99% | 403,687.0 | 606,072.0 | 150% | 403,777.8 | 236,011.3 | 58% |
| 2018 онд | 1,961,860.0 | 1,181,995.4 | 60% | 1,449,417.0 | 563,850.3 | 39% | 103,331.0 | 507,778.9 | 491% | 409,747.0 | 110,356.2 | 27% |
| 2019 онд | 1,688,450.0 | 1,351,266.8 | 80% | 1,021,079.0 | 747,896.2 | 73% | 206,8[illegible] | 361,041.7 | 175% | 395,237.0 | 242,328.9 | 61% |
| 2020 онд | 2,014,000.0 | 2,017,880.7 | 100% | 1,152,431.0 | 1,231,714.7 | 107% | 444,819.2 | 464,619.2 | 104% | 416,749.8 | 321,546.9 | 77% |
| 2021 онд | 2,005,000.0 | 1,429,093.6 | 71% | 1,201,200.0 | 773,307.3 | 64% | 411,000.0 | 500,280.4 | 122% | 392,800.0 | 155,505.9 | 40% |
| 2022 он I ул | 99,450.0 | 41,587.4 | 42% | 59,670.0 | 30,159.8 | 51% | 34,807.5 | 4,118.7 | 12% | 4,972.5 | 7,308.9 | 147% |
| **Дүн:** | **12,532,170.0** | **11,222,957.0** | **90%** | **7,491,914.3** | **6,627,740.5** | **87%** | **1,774,792.7** | **2,618,701.7** | **148%** | **3,160,780.0** | **2,078,514.9** | **65%** |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Төмөртолгой уурхай | | | | | | | | | | | |
| 2014 онд | 1,200,000.0 | 1,233,263.0 | 103% | 816,000.0 | 816,622.7 | 100% | | | 0% | 816,000.0 | 416,640.0 | 51% |
| 2015 онд | 1,500,000.0 | 880.0 | 0% | - | 618.2 | 0% | | | 0% | - | 261.8 | 0% |
| 2016 онд | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 2017 онд | 1,323,840.0 | 913,030.2 | 69% | 832,050.4 | 603,999.9 | 73% | 63,811.6 | 64,446.8 | 101% | 427,978.0 | 244,583.5 | 57% |
| 2018 онд | 2,000,560.0 | 807,137.9 | 40% | 1,202,240.8 | 395,424.0 | 33% | 178,987.9 | 199,413.5 | 111% | 619,331.3 | 212,300.5 | 34% |
| 2019 онд | 1,488,000.0 | 1,057,070.7 | 71% | 867,920.0 | 471,448.6 | 54% | 248,480.0 | 289,814.3 | 117% | 371,600.0 | 295,807.8 | 80% |
| 2020 онд | 1,531,060.0 | 1,453,936.0 | 95% | 774,646.8 | 762,816.2 | 98% | 382,852.4 | 405,472.3 | 106% | 373,560.6 | 285,847.5 | 77% |
| 2021 онд | 1,553,000.0 | 1,392,299.6 | 90% | 807,560.0 | 697,188.4 | 86% | 388,250.0 | 476,839.8 | 123% | 357,190.0 | 218,470.6 | 61% |
| | 342,000.0 | 182,871.7 | 53% | 205,200.0 | 93,763.7 | 46% | - | 25,487.0 | 0% | 136,800.0 | 63,621.0 | 47% |
| 2022 он I ул | 316,810.0 | 304,414.1 | 96% | 171,076.2 | 192,292.5 | 112% | 104,547.1 | 74,058.6 | 71% | 41,186.7 | 38,063.1 | 92% |
| | 123,480.0 | 121,109.8 | 98% | 74,977.2 | 75,824.9 | 101% | - | 10,513.8 | 0% | 48,502.8 | 34,771.1 | 72% |
| Дүн: | 11,376,750.0 | 7,468,012.9 | 66% | 5,761,671.4 | 4,109,800.0 | 71% | 1,368,929.0 | 1,545,845.9 | 113% | 3,192,149.6 | 1,810,366.8 | 57% |
| Нойтон баяжуулах үйлдвэр | | | | | | | | | | | | |
| 2019 онд | 180,180.0 | 72,495.1 | 40% | 117,117.0 | 52,369.7 | 45% | | | | | 20,125.0 | |
| 2020 онд | 197,700.0 | 130,943.2 | 66% | 120,985.0 | 95,911.1 | 79% | | | | | 35,032.0 | |
| 2021 онд | 202,160.0 | 184,361.4 | 91% | 279,480.0 | 122,151.2 | 44% | | | | | 62,210.0 | |
| | 580,040.0 | 387,799.7 | 67% | 517,582.0 | 270,432.0 | 52% | - | - | - | - | 117,367.0 | - |
| Угаах шугам | | | | | | | | | | | | |
| 2020 онд | 38,860.0 | 39,151.0 | 101% | 33,031.0 | 34,321.0 | 104% | | | | | 34,320.0 | |
| 2021 онд | 147,960.0 | 114,055.9 | 77% | 125,766.0 | 91,350.7 | 73% | | | | | 91,350.0 | |
| | 186,820.0 | 153,206.9 | 82% | 158,797.0 | 125,671.7 | 79% | - | - | - | - | 125,670.0 | - |

Төмрийн хүдрийг баяжуулах цехэд боловсруулан бэлэн бүтээгдэхүүн гарган авч байна. 2014-2022 оны 1 дүгээр улирлын хугацаанд нийтдээ 18.7 сая тонн төмрийн хүдрийг баяжуулан боловсруулж, 10.6 сая тонн экспортын баяжмал, 4.2 сая тонн завсрын бүтээгдэхүүн гарган авсан байна.

Төмрийн хүдрийн балансаар 2014 оноос хойш нийт 3.9 тэрбум төгрөгийн хаягдлыг 2020 оноос эхлэн санхүүгийн тайланд бүртгэж нийт 2.3 сая тонн хаягдлыг бүртгэсэн байна. Зөрүү 1.6 сая тонн хаягдал санхүүгийн тайланд бүртгэгдээгүй байна.

/2014-2022 оны 1 дүгээр улирлын хугацаанд орлого авсан хаягдал/

| Хаягдлын орлого, оноор | Төмөртолгой уурхай | | Төмөртэй уурхай | | Нийт хаягдлын орлого | |
|---|---|---|---|---|---|---|
| | Тоо хэмжээ /тонн/ | Нийт өртөг /төгрөг/ | Тоо хэмжээ /тонн/ | Нийт өртөг /төгрөг/ | Тоо хэмжээ /тонн/ | Нийт өртөг /төгрөг/ |
| 2020 он | 1,060,121.80 | 1,060,121.80 | 682,611.30 | 682,611.30 | 1,742,733.10 | 1,742,733.10 |
| 2021 он | 262,621.96 | 262,621.96 | 180,250.75 | 180,250.75 | 442,872.71 | 442,872.71 |
| 2022-I он | 66,788.05 | 66,788.05 | 4,607.44 | 4,607.44 | 71,395.49 | 71,395.49 |
| Нийт дүн: | 1,389,531.81 | 1,389,531.81 | 867,469.49 | 867,469.49 | 2,257,001.30 | 2,257,001.30 |

Компани 2014-2022 оны 1 дүгээр улирлын хугацаанд 17.7 сая тонн, 533.4 тэрбум төгрөгийн баяжмалын орлого авснаас 15.9 сая тонн, 507.5 тэрбум төгрөгийн төмрийн хүдрийн баяжмалыг үйлдвэрлэсэн байна.

309.5 мянган тонн, 309.5 мянган төгрөгийн баяжмалыг үйлдвэрлэлийн бус хэлбэрээр орлогод авсан, 1.5 сая тонн, 24.8 тэрбум төгрөгийн баяжмалыг бүтээгдэхүүний ангилал хооронд шилжүүлэн бүртгэсэн байна.

Нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 37.4 хувийг Төмөртолгойн уурхайгаас, 62.6 хувийг Төмөртэйн уурхайгаас гаргасан бүтээгдэхүүн эзэлж байна.

Үйлдвэрлэлтийн дунд бий болсон бүтээгдэхүүний 66.9 хувь буюу 10.7 сая тонн нь экспортын баяжмал, 26.3 хувь буюу 4.2 сая тонн нь завсрын баяжмал, 6.7 хувь буюу 1.1 сая тонн нь угаасан, шигшсэн, нойтон баяжмал эзэлж байна.

Уурхайн эдийн засгийн үзүүлэлтээс харахад Концессын гэрээний хугацаанд "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн уурхайн үйл ажиллагаанд тодорхой ахиц гараагүй, үйлдвэрлэл, техникийн нөхцөл гэрээнд заасан хэмжээнд хүрээгүй байна. Тухайлбал, Төмөртолгойн уурхай нь жилд 2 сая тонн төмрийн хүдэр боловсруулах хүчин чадалтай боловч 2014-2021 оны 1 дүгээр улирлын хугацаанд нийт хүчин чадлынхаа 31.2 хувийг, Төмөртэйн уурхай жилд 3 сая тонн хүдэр боловсруулах хүчин чадалтай боловч нийт хүчин чадлынхаа 41.5 хувийг ашигласан, уул геологийн ажил төлөвлөсөн тоо хэмжээнд хүрээгүй байна.





/2014-2022 оны 1 дүгээр улирлын хугацааны бэлэн бүтээгдэхүүн гаргалтыг уурхай, бүтээгдэхүүний төрлөөр/.

| Баяжмалын ангилал, он | Төмөртолгой уурхай | | | Төмөртэй уурхай | | | Нийт уурхайн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн гаргалт | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо хэмжээ /тонн/ | Нэгж өртөг /төгрөг/ | Нийт өртөг /төгрөг/ | Тоо хэмжээ /тонн/ | Нэгж өртөг /төгрөг/ | Нийт өртөг /төгрөг/ | Тоо хэмжээ /тонн/ | Нэгж өртөг /төгрөг/ | Нийт өртөг /төгрөг/ |
| 2014 он | 816,622.63 | 29,819.3 | 24,351,144,738.67 | 314,342.00 | 22,148.3 | 6,962,469,415.41 | 1,130,964.6 | 27,487.5 | 31,313,613,154.1 |
| 1.Баяжмал бүхэл | 519,708.38 | 30,435.5 | 15,817,606,850.80 | 179,274.00 | 22,110.5 | 3,963,831,252.24 | 698,982.4 | 28,300.3 | 19,781,438,103.0 |
| 2.Баяжмал нунтаг | 296,914.25 | 28,740.7 | 8,533,537,887.87 | 135,068.00 | 22,200.9 | 2,998,637,163.17 | 431,982.3 | 26,695.9 | 11,532,175,051.0 |
| 2015 он | 618.20 | 213,773.0 | 132,154,470.86 | 794,810.89 | 27,831.3 | 21,874,187,414.23 | 795,429.1 | 27,666.0 | 22,006,361,855.1 |
| 1.Баяжмал бүхэл | 442.20 | 213,773.0 | 94,530,422.07 | 401,682.52 | 27,820.6 | 11,175,067,667.16 | 402,124.7 | 28,025.1 | 11,269,598,089.2 |
| 2.Баяжмал нунтаг | 176.00 | 213,773.0 | 37,624,048.79 | 145,850.80 | 27,845.3 | 4,061,260,547.72 | 146,026.8 | 28,069.4 | 4,098,884,596.5 |
| 4.Баяжмал шигшсэн | - | - | - | 247,277.57 | 26,843.8 | 6,637,869,199.35 | 247,277.6 | 26,843.8 | 6,637,869,199.4 |
| 2016 он | - | - | - | 1,746,923.96 | 24,624.6 | 42,842,507,205.80 | 1,746,924.0 | 24,624.6 | 42,842,507,205.8 |
| 1.Баяжмал бүхэл | - | - | - | 688,501.62 | 24,763.0 | 17,049,356,914.74 | 688,501.6 | 24,763.0 | 17,049,356,914.7 |
| 2.Баяжмал нунтаг | - | - | - | 452,580.91 | 26,117.2 | 11,820,128,740.61 | 452,580.9 | 26,117.2 | 11,820,128,740.6 |
| 4.Баяжмал шигшсэн | - | - | - | 431,050.59 | 26,976.2 | 11,628,116,666.12 | 431,050.6 | 26,976.2 | 11,628,116,666.1 |
| 5.Завсрын бүтээгдэхүүн | - | - | - | 174,790.84 | 13,415.5 | 2,344,904,884.33 | 174,790.8 | 13,415.5 | 2,344,904,884.3 |
| 2017 он | 673,049.11 | 28,888.4 | 19,444,009,220.03 | 1,783,926.56 | 23,288.4 | 41,541,191,813.80 | 2,456,975.7 | 24,821.2 | 60,985,201,033.6 |
| 1.Баяжмал бүхэл | 458,121.87 | 30,410.1 | 13,931,546,138.66 | 776,613.38 | 26,950.2 | 20,929,898,893.88 | 1,234,735.3 | 28,233.9 | 34,861,445,032.7 |
| 2.Баяжмал нунтаг | 145,878.00 | 32,234.4 | 4,702,288,640.78 | 401,241.00 | 27,656.9 | 11,097,081,816.40 | 547,119.0 | 28,877.4 | 15,799,370,457.2 |
| 5.Завсрын бүтээгдэхүүн | 69,049.24 | 11,733.3 | 810,174,440.39 | 606,072.18 | 15,698.1 | 9,514,211,103.34 | 675,121.4 | 15,292.6 | 10,324,385,543.7 |
| 2018 он | 593,930.08 | 37,840.6 | 22,474,689,830.27 | 1,071,629.84 | 35,633.7 | 38,186,099,403.43 | 1,665,559.9 | 36,430.7 | 60,660,789,233.7 |
| 1.Баяжмал бүхэл | 277,850.56 | 39,647.5 | 11,016,079,957.79 | 375,030.60 | 41,255.2 | 15,471,945,661.05 | 652,881.2 | 40,571.0 | 26,488,025,618.8 |
| 2.Баяжмал нунтаг | 116,666.05 | 39,390.8 | 4,595,572,758.50 | 188,819.79 | 48,899.1 | 9,233,124,028.91 | 305,485.8 | 45,267.9 | 13,828,696,787.4 |
| 5.Завсрын бүтээгдэхүүн | 199,413.47 | 34,416.1 | 6,863,038,113.98 | 507,779.45 | 26,549.0 | 13,481,029,713.47 | 707,192.9 | 28,767.3 | 20,344,065,827.5 |
| 2019 он | 813,642.66 | 38,067.6 | 31,778,955,509.19 | 1,108,937.88 | 32,032.8 | 35,672,612,702.69 | 1,922,580.4 | 35,005.8 | 67,301,468,210.9 |
| 1.Баяжмал бүхэл | 349,058.03 | 37,780.7 | 13,187,647,580.34 | 397,372.77 | 36,047.3 | 14,324,215,934.37 | 746,430.8 | 36,857.9 | 27,511,863,514.7 |
| 2.Баяжмал нунтаг | 122,390.55 | 38,809.2 | 4,749,880,145.51 | 350,523.45 | 37,616.8 | 13,185,555,303.07 | 472,914.0 | 37,925.4 | 17,935,435,448.6 |
| 5.Завсрын бүтээгдэхүүн | 289,824.27 | 32,090.3 | 9,300,538,147.19 | 361,041.66 | 22,193.4 | 8,012,741,465.25 | 650,865.9 | 26,600.4 | 17,313,279,612.4 |
| 6.Баяжмал нойтон | 52,369.70 | 86,706.3 | 4,540,889,635.15 | - | - | - | 52,369.7 | 86,706.3 | 4,540,889,635.2 |
| 2020 он | 1,263,999.77 | 30,433.5 | 38,467,917,450.22 | 1,730,653.89 | 30,430.5 | 52,673,865,566.06 | 2,994,653.7 | 30,434.3 | 91,141,783,009.3 |
| 1.Баяжмал бүхэл | 525,853.95 | 29,128.4 | 15,317,257,962.06 | 862,291.08 | 34,741.1 | 29,956,966,824.01 | 1,388,145.0 | 32,614.9 | 45,274,224,806.1 |
| 2.Баяжмал нунтаг | 236,762.26 | 29,503.6 | 6,985,375,197.22 | 353,110.58 | 34,443.9 | 12,162,499,955.21 | 589,872.8 | 32,461.0 | 19,147,875,152.4 |
| 5.Завсрын бүтээгдэхүүн | 405,472.30 | 22,388.6 | 9,078,039,539.92 | 480,932.23 | 20,994.2 | 10,096,769,091.59 | 886,404.5 | 21,632.1 | 19,174,808,631.5 |
| 6.Баяжмал нойтон | 95,911.26 | 73,893.8 | 7,087,244,731.00 | - | - | - | 95,911.3 | 73,893.8 | 7,087,244,731.0 |
| 7.Баяжмал угаасан | - | - | - | 34,320.00 | 13,334.2 | 457,629,684.25 | 34,320.0 | 13,334.2 | 457,629,684.3 |
| 2021 он | 1,434,700.82 | 44,989.1 | 64,645,897,731.48 | 1,376,631.00 | 36,883.6 | 50,771,385,977.38 | 2,811,331.8 | 41,020.2 | 115,317,283,709.9 |
| 1.Баяжмал бүхэл | 491,424.25 | 44,299.4 | 21,769,794,546.12 | 560,058.20 | 45,039.1 | 25,224,491,681.94 | 1,051,482.5 | 44,693.4 | 46,994,286,228.1 |
| 2.Баяжмал нунтаг | 318,998.35 | 48,438.5 | 15,451,799,705.07 | 218,068.42 | 44,967.7 | 9,806,045,826.81 | 537,066.8 | 47,029.2 | 25,257,845,531.9 |
| 5.Завсрын бүтээгдэхүүн | 502,126.60 | 30,521.3 | 15,325,576,044.25 | 507,053.72 | 26,816.0 | 13,597,151,314.03 | 1,009,180.3 | 28,659.6 | 28,922,727,358.3 |
| 6.Баяжмал нойтон | 122,151.32 | 98,228.4 | 11,998,727,436.04 | - | - | - | 122,151.3 | 98,228.4 | 11,998,727,436.0 |
| 7.Баяжмал угаасан | - | - | - | 91,350.66 | 23,466.7 | 2,143,697,154.60 | 91,350.7 | 23,466.7 | 2,143,697,154.6 |
| 2022-I улирал | 361,437.30 | 34,742.7 | 12,557,300,999.12 | 34,278.49 | 98,209.2 | 3,366,465,786.63 | 395,715.8 | 40,240.4 | 15,923,764,785.8 |
| 1.Баяжмал бүхэл | 187,238.45 | 36,949.5 | 6,918,361,112.60 | 17,629.05 | 104,885.4 | 1,849,030,807.10 | 204,867.5 | 42,795.4 | 8,767,391,919.7 |
| 2.Баяжмал нунтаг | 89,626.50 | 38,608.4 | 3,460,338,974.29 | 13,166.52 | 107,648.5 | 1,417,356,494.64 | 102,793.0 | 47,451.6 | 4,877,695,468.9 |
| 5.Завсрын бүтээгдэхүүн | 84,572.35 | 25,760.2 | 2,178,600,912.23 | 3,482.92 | 28,733.5 | 100,076,484.89 | 88,055.3 | 25,877.8 | 2,278,677,397.1 |
| Нийт дүн | 5,960,000.16 | 35,874.5 | 213,753,060,948.84 | 9,912,334.61 | 29,488.0 | 290,740,687,274.23 | 16,320,334.7 | 31,077.8 | 507,492,751,223.1 |

/2014-2022 оны 1 дүгээр улирлын хугацаанд үйлдвэрлэлийн бусаар орлого авсан баяжмал/

| Баяжмалын ангилал, он | Төмөртолгой уурхай | | Төмөртэй уурхай | | Олборлолтоос гадуур бүртгэлд тусгасан баяжмал | | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо хэмжээ /тонн/ | Нийт өртөг /төгрөг/ | Тоо хэмжээ /тонн/ | Нийт өртөг /төгрөг/ | Тоо хэмжээ /тонн/ | Нийт өртөг /төгрөг/ | |
| 2016 он | | | 31,978.77 | 31,978.77 | 31,978.77 | 31,978.77 | Тооллого, хэмжилтийн зөрүү, овоолгын сийрэгжилтын зөрүү |
| 1.Баяжмал бүхэл | | | 29,054.89 | 29,054.89 | 29,054.89 | 29,054.89 | |
| 2.Баяжмал нунтаг | | | 2,923.88 | 2,923.88 | 2,923.88 | 2,923.88 | |
| 2018 он | | | 364.97 | 364.97 | 364.97 | 364.97 | |
| 5.Завсрын бүтээгдэхүүн | | | 364.97 | 364.97 | 364.97 | 364.97 | |
| 2019 он | 46,000.59 | 46,000.59 | 231,185.70 | 231,185.70 | 277,186.29 | 277,186.29 | |
| 1.Баяжмал бүхэл | 56.49 | 56.49 | 65,508.42 | 65,508.42 | 65,564.91 | 65,564.91 | |
| 2.Баяжмал нунтаг | | | 67,380.64 | 67,380.64 | 67,380.64 | 67,380.64 | |
| 4.Баяжмал шигшсэн | | | 20,489.47 | 20,489.47 | 20,489.47 | 20,489.47 | |
| 5.Завсрын бүтээгдэхүүн | 45,944.10 | 45,944.10 | 77,807.17 | 77,807.17 | 123,751.27 | 123,751.27 | |
| 2020 он | 8.60 | 8.60 | | | 8.60 | 8.60 | |
| 5.Завсрын бүтээгдэхүүн | 8.60 | 8.60 | | | 8.60 | 8.60 | |
| Нийт дүн | 46,009.19 | 46,009.19 | 263,529.44 | 263,529.44 | 309,538.63 | 309,538.63 | - |

Баяжмалын өөрийн өртгийг үйлдвэрлэлийн үе шатны аргаар тооцдог ба нэгж бүтээгдэхүүний өртөг анхдагч төмрийн хүдрийн өртөг, баяжуулах цех хүртэлх тээвэр, боловсруулалтын зардлаар тооцогдож байна.

**5.4. Уурхайн бүтээгдэхүүн борлуулалтын талаар:** "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК нь Төмөртолгой болон Төмөртэйн хүдрийн уурхайгаас олборлон баяжуулалт хийсэн төмрийн хүдэр, баяжмалыг дотоодын болон гадаадын компаниудад худалдан борлуулж байна.

2014-2021 оны компанийн тайлан мэдээгээр нийт 11,841.2 мянган тонн төмрийн хүдэр болон баяжмал худалдан борлуулж 1,132.0 тэрбум төгрөгийн орлого олсон байна.

Борлуулалтын тоо хэмжээг өмнөх онуудтай нь харьцуулбал 2017 онд 77.5 мянган тонн буюу 7.3 хувиар, 2021 онд өмнөх оноос 657.6 мянган тонн буюу 23.1 хувиар буурсан, бусад онуудад өссөн үзүүлэлттэй.

Борлуулалтын нэгжийн дундаж өртгийг өмнөх онуудтай харьцуулбал 2015 онд 41.2 хувь буюу 35.7 мянган төгрөгөөр буурсан хэдий ч 2016 онд 28.3 хувь, 2017 онд 11.8 хувь, 2018 онд 11.1 хувь, 2019 онд 4.7 хувь, 2020 онд 17.4 хувь, 2021 онд 54.1 хувиар өссөн нь борлуулалтын орлогын өсөлтөд нөлөөлсөн байна.

"Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК нь хүдрийн баяжмалыг төмрийн агуулгаас нь хамааруулан дийлэнх тохиолдолд 58%-с дээш агуулгатай баяжмалыг экспортод гаргадаг, 30-55% хүртэл агуулгатайг завсрын бүтээгдэхүүн, 30-аас доош агуулгатайг бага агуулгатай гэж ангилан дотоодын компаниудад худалдан борлуулж байна. Завсрын бүтээгдэхүүнийг нойтон баяжуулах үйлдвэрт боловсруулан агуулгыг өндөрсгөн илүү үнэ хүргэн борлуулдаг байна.

"Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК нь 2021 онд нийт 2,286.6 мянган тонн хүдэр 342.5 тэрбум төгрөгөөр борлуулснаар тайлагнасан байна.

2021 онд БНХАУ-ын 27 компанид 1,765.7 мянган тонныг 303.7 тэрбум төгрөгөөр, дотоодын 12 компанид 520.5 мянган тонныг 38.8 тэрбум төгрөгөөр борлуулснаас харахад экспортод гаргаж буй бүтээгдэхүүнийг тонн тутам дунджаар 172 мянган төгрөгөөр, дотоодод 74.6 мянган төгрөгөөр борлуулсан байна. Энэ нь экспортод гаргаж буй бүтээгдэхүүнд агуулагдах төмрийн хэмжээ 58 хувиас дээш, харин дотоодод борлуулж буй төмрийн хүдрийн агууламж 15-50 хувь байгаатай холбоотой байна.

"Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК нь дотоодын аж ахуйн нэгжүүдэд төмрийн хүдрийг худалдах, худалдан авах гэрээний дагуу борлуулж 2014 онд 21,030.7 сая төгрөгийн, 2015 онд 3,861.9 сая төгрөгийн, 2016 онд 118.9 сая төгрөгийн, 2017 онд 34,315.4 сая төгрөгийн, 2018 онд 6,357.5 сая төгрөгийн, 2019 онд 25,525.1 сая төгрөгийн, 2020 онд 18,687.1 сая төгрөгийн, 2021 онд 35,295.4 сая төгрөгийн /НӨАТ-гүй дүн/ борлуулалт хийсэн байна.

/2014-2022 оны 1 улирлын хугацаанд худалдан борлуулсан баяжмал/.

| Баяжмалын төрөл, он | Баяжмал борлуулалт | | | | | Тоо хэмжээнд | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо хэмжээ /тонн/ | Дундаж өртөг /төгрөг/ | Борлуулсан бүтээгдэхүүний өртөг /төгрөг/ | Борлуулсан нэгж үнэ /төгрөг/ | Нийт борлуулалтын орлого /төгрөг/ | Эзлэх хувь | Өсөлт /+/, бууралт /-/ |
| 2014 он | 532,740.96 | 28,190.09 | 15,526,963,528.87 | 45,759.60 | 24,310,140,850.66 | 2.2% | |
| 1.Баяжмал бүхэл | 374,884.90 | 30,673.42 | 11,499,002,377.90 | 48,908.84 | 18,335,184,323.78 | 75.4% | |
| 2.Баяжмал нунтаг | 157,856.06 | 25,516.67 | 4,027,961,150.97 | 37,850.66 | 5,974,956,526.88 | 24.6% | |





| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2015 он | 543,375.30 | 27,323.36 | 14,846,838,825.23 | 51,022.01 | 27,724,099,327.94 | 2.5% | 10,634.34 |
| 1.Баяжмал бүхэл | 90,385.55 | 29,591.79 | 2,674,669,958.77 | 27,883.07 | 2,520,226,617.45 | 9.1% | |
| 2.Баяжмал нунтаг | 271,904.84 | 26,914.32 | 7,318,132,753.50 | 49,623.98 | 13,493,000,613.02 | 48.7% | |
| 4.Баяжмал шигшсэн | 181,084.91 | 26,805.30 | 4,854,036,112.96 | 64,670.61 | 11,710,872,097.47 | 42.2% | |
| 2016 он | 1,059,528.70 | 25,618.52 | 27,037,554,425.78 | 65,450.86 | 69,340,930,451.85 | 6.2% | 516,151.40 |
| 1.Баяжмал бүхэл | 344,763.21 | 24,265.03 | 8,365,690,917.78 | 66,843.69 | 23,045,245,622.57 | 33.2% | |
| 2.Баяжмал нунтаг | 442,934.44 | 25,853.59 | 11,451,446,679.25 | 65,942.96 | 29,208,418,024.57 | 42.1% | |
| 4.Баяжмал шигшсэн | 271,829.05 | 26,562.34 | 7,220,416,828.75 | 62,882.41 | 17,093,266,804.71 | 24.6% | |
| 2017 он | 982,066.26 | 25,742.19 | 25,280,531,429.57 | 73,145.98 | 71,834,202,916.21 | 6.4% | (77,460.44) |
| 1.Баяжмал бүхэл | 626,222.77 | 26,707.75 | 16,725,004,213.50 | 77,505.13 | 48,535,476,275.11 | 67.6% | |
| 2.Баяжмал нунтаг | 281,562.09 | 26,850.66 | 6,123,252,848.99 | 78,914.06 | 22,219,206,804.52 | 30.9% | |
| 4.Баяжмал шигшсэн | 30.00 | 27,467.36 | 824,020.79 | 45,454.55 | 1,363,636.36 | 0.0% | |
| 5.Завсрын бүтээгдэхүүн | 74,251.40 | 5,810.67 | 431,450,346.29 | 14,520.35 | 1,078,156,202.22 | 1.5% | |
| 2018 он | 1,344,510.42 | 32,814.85 | 44,119,909,880.74 | 81,238.06 | 109,225,415,188.19 | 9.7% | 362,444.16 |
| 1.Баяжмал бүхэл | 817,625.01 | 33,267.61 | 27,200,428,722.40 | 93,429.31 | 76,390,136,646.35 | 69.9% | |
| 2.Баяжмал нунтаг | 306,352.22 | 35,899.26 | 10,997,818,452.91 | 87,018.03 | 26,658,167,285.73 | 24.4% | |
| 5.Завсрын бүтээгдэхүүн | 220,533.19 | 26,851.57 | 5,921,662,705.43 | 28,009.89 | 6,177,111,256.11 | 5.7% | |
| 2019 он | 2,242,906.60 | 33,607.16 | 75,377,715,405.72 | 85,026.55 | 190,706,611,644.48 | 17.0% | 898,396.18 |
| 1.Баяжмал бүхэл | 929,057.93 | 36,096.78 | 33,536,003,082.13 | 96,928.62 | 90,052,299,743.87 | 47.2% | |
| 2.Баяжмал нунтаг | 741,249.26 | 33,601.21 | 24,906,872,469.15 | 102,967.31 | 76,324,442,975.65 | 40.0% | |
| 5.Завсрын бүтээгдэхүүн | 524,145.96 | 24,280.12 | 12,726,324,442.41 | 35,064.45 | 18,378,887,959.54 | 9.6% | |
| 6.Баяжмал нойтон | 48,453.45 | 86,856.88 | 4,208,515,412.03 | 122,816.52 | 5,950,980,965.42 | 3.1% | |
| 2020 он | 2,849,876.63 | 30,595.99 | 87,194,782,885.37 | 99,847.72 | 284,653,678,885.87 | 25.3% | 606,970.03 |
| 1.Баяжмал бүхэл | 1,344,974.96 | 33,744.53 | 45,385,544,586.03 | 119,459.21 | 160,669,639,974.93 | 56.5% | |
| 2.Баяжмал нунтаг | 526,313.31 | 35,001.63 | 18,421,826,113.56 | 111,894.68 | 58,891,764,663.38 | 20.7% | |
| 5.Завсрын бүтээгдэхүүн | 923,048.46 | 21,371.41 | 19,726,847,747.12 | 62,819.41 | 57,985,364,077.09 | 20.4% | |
| 6.Баяжмал нойтон | 55,539.90 | 65,908.73 | 3,660,564,438.66 | 126,159.93 | 7,006,910,170.47 | 2.5% | |
| 2021 он | 2,192,313.38 | 187,457.01 | 69,394,641,491.41 | 153,914.39 | 337,428,576,150.43 | 100% | (657,563.25) |
| 1.Баяжмал бүхэл | 891,732.57 | 35,730.68 | 31,862,207,144.62 | 190,355.95 | 169,746,602,321.66 | 50.3% | |
| 2.Баяжмал нунтаг | 353,973.94 | 37,778.38 | 13,372,560,380.73 | 211,692.22 | 74,933,529,130.52 | 22.2% | |
| 5.Завсрын бүтээгдэхүүн | 851,319.40 | 17,594.58 | 14,978,603,608.39 | 83,060.75 | 70,711,227,147.11 | 21.0% | |
| 6.Баяжмал нойтон | 95,287.47 | 96,353.39 | 9,181,270,357.67 | 231,270.87 | 22,037,216,551.14 | 6.5% | |
| 2022-I улирал | 97,314.32 | 28,604.75 | 2,783,651,587.73 | 93,448.17 | 9,093,845,403.80 | 0.8% | |
| 1.Баяжмал бүхэл | 36,547.57 | 43,670.46 | 1,596,049,180.24 | 179,915.77 | 6,575,484,271.20 | 72.3% | |
| 5.Завсрын бүтээгдэхүүн | 60,766.75 | 19,543.62 | 1,187,602,407.49 | 41,443.06 | 2,518,361,132.60 | 27.7% | |
| Нийт борлуулалтын дүн: | 11,844,630.57 | 30,626.44 | 361,862,889,460.42 | 94,914.19 | 1,124,223,499,821.43 | 100% | |

Компанийн гүйцэтгэх захирлын 2014-04-30-ны А/63 дугаар тушаалаар зах зээлд төмрийн хүдрийн баяжмалын үнэ унасантай холбоотойгоор Төмөртолгойн уурхайн төмрийн хүдрийн бүхэл баяжмалын худалдан борлуулан үнийг 38 ам доллароор үйлдвэр нөхцөлтэйгөөр, төмрийн хүдрийн хаягдлын үнийг 3 ам доллароор /НӨАТ орсон/;

2014-06-23-ны А/115 дугаар тушаалаар зах зээлд төмрийн хүдрийн баяжмалын үнэ буурсантай холбоотойгоор Төмөртолгойн уурхайн бүхэл баяжмалын худалдан борлуулан үнийг 30 ам доллараар, нунтаг баяжмалын үнийг 29 ам доллароор, төмрийн хүдрийн хаягдлын үнийг 3 ам доллароор үйлдвэрийн нөхцөлөөр /НӨАТ орсон/ тус тус тогтоосон байна.

Дотоодын аж ахуйн нэгж байгууллагад борлуулсан баяжмалын үнийг тодруулахад дараах байдалтай байна. Үүнд:

Бүхэл 40%-45%-ийн хүхэртэй баяжмалыг хамгийн өндөр үнээр "Ган бөмбөлөг үндраа" ХХК-д 158100,91 нэгж үнээр, "Херо хүдэр" ХХК-д хамгийн бага 24634,84 нэгж үнээр, "Ган бөмбөлөг үндраа" ХХК-д дундаж үнээр 49299,64 нэгж үнээр борлуулсан байна.

Бүхэл баяжмал 58%-ийн хүхэртэй баяжмалыг хамгийн өндөр үнээр "Монгол металл бирж" ХХК-д 214,465.71 нэгж үнээр, Дундаж үнээр "Монгол металл бирж" ХХК-д 178,337.08 нэгж үнээр борлуулсан байна.

Бүхэл 40%-50%-ийн хүхэртэй баяжмалыг хамгийн өндөр үнээр "Си Эй И ресоурсес" ХХК-д 105,862.84 нэгж үнээр, "Херо хүдэр" ХХК-д хамгийн бага 26,242.75 нэгж үнээр, "Си Эй И ресоурсес" ХХК-д 61,819.64 нэгж үнээр борлуулсан байна.

Бүхэл 50%-54%-ийн хүхэртэй баяжмалыг хамгийн өндөр үнээр "Дархан талын шанд" ХХК-д 141,514.1 нэгж үнээр, "Цемент шохой" ХХК-д хамгийн бага 57,511.82 нэгж үнээр, "Ган хүдэр орд" ХХК-д 73,892.21 нэгж үнээр 2021 онд тус тус борлуулсан байна.

Компани 2014-2020 онуудад 19 харилцагчид, 548.3 мянган тонн жинтэй, баяжмалыг өөрийн өртгөөс нь 2.8 тэрбум төгрөгөөр доогуур үнээр борлуулж тайлант жилийн ашгийн үзүүлэлтийг мөн хэмжээгээр бууруулсан байна.

/Өөрийн өртгөөс доогуур үнээр борлуулсан төмрийн хүдрийн баяжмал/

| Он, харилцагчаар | Тоо хэмжээ /тонн/ | Борлуулсан барааны өртөг /төгрөгөөр/ | Борлуулсан дүн /төгрөгөөр/ | Зөрүү /төгрөгөөр/ |
|---|---|---|---|---|
| **2014 он** | **156,398.01** | **4,161,410,800.44** | **3,131,245,416.11** | **(1,030,165,384.33)** |
| Канетик ХХК | 99,472.82 | 2,897,617,820.22 | 2,179,288,280.07 | (718,329,540.15) |
| Кью Эс Си ХХК /хүдэр/ | 56,925.19 | 1,263,792,980.22 | 951,957,136.04 | (311,835,844.18) |
| **2015 он** | **187,433.20** | **5,569,720,575.39** | **4,517,280,828.89** | **(1,052,439,746.50)** |
| Гэрэлт хос болор | 32,989.65 | 1,008,997,555.54 | 717,048,835.33 | (291,948,720.21) |
| Канетик ХХК | 42,397.60 | 1,267,579,778.28 | 950,348,690.77 | (317,231,087.51) |
| Ньюсиян ХХК | 19,747.40 | 583,846,914.45 | 416,998,060.97 | (166,848,853.48) |
| Эйч Эс Эм Жи ХХК | 92,298.55 | 2,709,296,327.12 | 2,432,885,241.82 | (276,411,085.30) |
| **2017 он** | **69,672.50** | **2,538,523,554.34** | **2,229,816,941.91** | **(308,706,612.43)** |
| Баялаг хүдэр ХХК | 805.40 | 32,210,026.31 | 27,967,518.74 | (4,242,507.57) |
| Нисээч интернэшнл ХХК | 30,461.40 | 1,214,070,935.31 | 936,104,681.64 | (277,966,253.67) |
| Эйч Эс Эм Жи ХХК | 38,405.70 | 1,292,242,592.72 | 1,265,744,741.53 | (26,497,851.19) |
| **2018 он** | **122,472.13** | **4,124,909,411.33** | **3,808,812,159.02** | **(316,097,252.31)** |
| Баян их үйлс ХХК | 19,459.65 | 697,221,944.69 | 598,118,878.65 | (99,103,066.04) |
| Ган эрдэс хүдэр ХХК | 44,319.45 | 1,522,390,002.80 | 1,485,640,341.53 | (36,749,661.27) |
| Майн Тек Инженеринг ХХК | 41,314.90 | 1,325,439,595.85 | 1,175,746,936.00 | (149,692,659.85) |
| Мон маг ХХК | 536.80 | 18,276,469.88 | 16,499,280.00 | (1,777,189.88) |
| Нисээч интернэшнл ХХК | 12,994.15 | 432,819,973.40 | 406,747,144.97 | (26,072,828.43) |
| Хайрхан Тоб ХХК | 1,000.70 | 34,070,908.00 | 32,890,580.87 | (1,180,327.13) |
| Херо Транс ХХК | 2,773.30 | 91,991,990.48 | 90,507,906.09 | (1,484,084.39) |
| Хөтөл ЦШХК | 73.18 | 2,698,526.23 | 2,661,090.91 | (37,435.32) |
| **2019 он** | **5,950.50** | **183,002,648.01** | **165,598,868.74** | **(17,403,779.27)** |
| Нисээч интернэшнл ХХК | 5,950.50 | 183,002,648.01 | 165,598,868.74 | (17,403,779.27) |
| **2020 он** | **6,394.80** | **543,807,115.15** | **488,015,906.07** | **(55,791,209.08)** |
| Их уул менежмент ХХК | 6,394.80 | 543,807,115.15 | 488,015,906.07 | (55,791,209.08) |
| **Нийт дүн:** | **548,321.14** | **17,121,374,104.66** | **14,340,770,120.74** | **(2,780,603,983.92)** |

2014 оноос 2021 оны 1 дүгээр улирлын хугацаанд 11.9 сая тонн жинтэй, 361.6 тэрбум төгрөгийн өртөг бүхий баяжмалыг 1 их наяд 125.8 тэрбум төгрөгөөр худалдан борлуулснаас гэрээнд заасны дагуу агуулга чийгшлийн зөрүүгээр 17.5 тэрбум төгрөгийн бууралт тооцож хассан байна.

2015- оны 01 дүгээр сарын 01-ний санхүүгийн тайлангаар бүхэл баяжмалын үлдэгдэл 2014 оны жилийн эцсийн үлдэгдлээс 9135.99 тн, 273.1 сая төгрөгийн бүхэл баяжмалаар зөрүүтэй байгааг тодруулахад 2015 онд бэлэн бүтээгдэхүүний код өөрчлөхдөө түүхий эд материалын дансанд бүртгэсэн ба дээрх баяжмалыг "Канетик" ХХК-д өөрийн өртгөөс нь 7916.0 төгрөгөөр доогуур үнээр борлуулан тухайн ажил гүйлгээнээс 72.3 сая төгрөгийн алдагдал хүлээсэн байна.





Компани төмрийн хүдрийн баяжмал борлуулалтад 2014-2017 онд нийт 3.4 тэрбум төгрөгийн борлуулалтын хөнгөлөлт тооцсон боловч зарим хөнгөлөлтийг үндэслэлгүй, компанийн үйл ажиллагаанд илт хохирол учруулсан байдлаар үзүүлсэн байна. Тухайлбал 2014 онд "Кью Эс Си" ХХК-нд нунтаг баяжмалыг өөрийн өртгөөс доогуур үнээр худалдан борлуулсан атлаа тухайн борлуулалтад 597.6 сая төгрөгийн үнийн зөрүүний хөнгөлөлт тооцсон, мөн ханшийн зөрүүнээс үүссэн 41.6 сая төгрөгөөр "Кью Эс Си" ХХК-иас авах авлагыг бууруулсан байна.

/Борлуулалтын хөнгөлөлт үзүүлсэн компани/

| Он | Харилцагчийн нэр | Борлуулалтын хөнгөлөлт /төгрөг/ | Тайлбар |
|---|---|---|---|
| 2014 | "Канетик" ХХК | 99,522,099.99 | Үнийн зөрүү |
| | "Кью Эс Си" ХХК | 597,604,658.15 | Үнийн зөрүү |
| | | 41,568,588.63 | |
| | Нобль Ресоурсес Интернэйшнл ПТИ лимитед | 924,509.30 | Гэрээний заалтын дагуу үнийн хөнгөлөлт |
| 2015 | "Канетик" ХХК | 13,308,501.74 | |
| | Central energy AG | 37,207,642.01 | Гэрээний дагуу чийг хасаж тооцсон ,бусад гэрээн заасан үзүүлэлтүүд зэр бичилт хийв |
| | "Канетик" ХХК | 250,869,988.30 | Баяжмалын үнийн зөрүү |
| | Нобль Ресоурсес Интернейшнл ПТИ лимитед | 776,679,656.71 | Чийгшил гэрээний дагуу 2 хувийн хөнгөлөлт |
| | | 264,917,119.78 | |
| 2016 | Siberian energy trading INC | 307,846,222.72 | Гэрээний дагуу чийгшлийн хөнгөлөлт |
| | Siberian energy trading INC | 396,592,269.40 | Баяжмалын гарцын зөрүүг тооцов |
| 2017 | Ганвор ХХК | 648,239,280.77 | Чийгшил болон хөнгөлөлтийг хассан. |
| | **Нийт дүн:** | **3,435,280,637.60** | |

## ЗУРГАА. КОМПАНИЙН УУЛ ГЕОЛОГИЙН АЖЛЫН ТАЛААР

**6.1. Төмөртэйн төмрийн хүдрийн уурхайн техник эдийн засгийн** үндэслэлийг 2011 онд ШУТИС-ийн дэргэдэх Уул уурхайн төсөл судалгааны төв боловсруулсан ба 2014 онд "Пауэр Опен Пит" ХХК биетийг ил аргаар ашиглах зорилгоор техник эдийн засгийн үндэслэлийг тодотгосон ба геологийн нөөцөөр нийт 18,230.10 мянган тонн төмрийн хүдрийн нөөцтэй байгаагаас, 2011-2014 он хүртэл 5,404.10 мянган тонн төмрийн хүдэр олборлосноор, 12,826.00 мянган тонн төмрийн хүдрийн үлдэгдэл нөөцтэй болохыг тогтоосон байна.

**Тодотгох болсон шалтгаан нь:** Уурхайн хүчин чадлыг 3.0 сая тн/жил болгон нэмэгдүүлэх, Төмөртэй ордыг түшиглэн хуурай соронзон баяжуулах үйлдвэр барих, Төмөртэйн ордын хүдрийг баяжуулан бүхэллэг баяжмалыг экспортлох, нунтаг баяжмалыг "Дарханы Төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн дэргэдэх нойтон баяжуулах үйлдвэрт нийлүүлэх, хүдрийн ил уурхайн ашиглалтыг бүрэн хэмжээгээр, баяжуулах технологийн хувьд хуурай соронзон сепараторын аргаар баяжуулах үндсэн зорилготой байна.

/2014-2018 оны тодотгосон техник эдийн засгийн үндэслэлээрх уулын ажлын тоо хэмжээ/.

| Ашиглалтын жил | Уулын цул, м3 | ХХКоэф | Херо хуулалт, м3 | Төмрийн хүдэр олборлолт, тн |
|---|---|---|---|---|
| 2014 | 1,594,894.00 | 1.29 | 1,345,588.00 | 1,039,907.00 |
| 2015 | 3,199,520.00 | 1.14 | 2,649,479.00 | 2,332,963.00 |
| 2016 | 4,756,103.00 | 1.32 | 4,041,199.00 | 3,050,580.00 |
| 2017 | 4,149,456.00 | 1.06 | 3,392,432.00 | 3,186,854.00 |
| 2018 | 1,160,496.00 | 0.35 | 693,199.00 | 2,003,264.00 |
| **Нийт** | **14,862,469.00** | **1.03** | **12,121,897.00** | **11,613,568.00** |

"Кью Эс Си" ХХК нь "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн Төмөртэйн төмрийн хүдрийн уурхайн ТЭЗҮ-д 2014 оноос хойш тодотгол хийлгээгүй байгаа нь Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын 2012 оны 74 дүгээр тушаалаар баталсан

"Ашигт малтмалын баялгийг урьдчилсан үнэлгээ, ашигт малтмалын ордын нөөцийг ашиглах боломжийн урьдчилсан үнэлгээ, уул уурхайн төслийн Техник, эдийн засгийн үндэслэлд тавигдах үндсэн шалгуурууд ба техник, эдийн засгийн үндэслэл хүлээн авах журам"-ын 7.3-т "Уул уурхайн төсөлд хүчин чадал, тоног төхөөрөмжийн өөрчлөлт орсон, уг техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулснаас хойш ашиглалт явуулаагүй 3-с дээш жилийн хугацаа өнгөрсөн, ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч өөрчлөгдсөн тохиолдолд болон ***тухайн техник, эдийн засгийн үндэслэлийг хүлээн авснаас хойш 5 жил тутамд төсөл хэрэгжүүлэгч байгууллага техник, эдийн засгийн үндэслэлийг тодотгох, шинэчлэх буюу шинээр боловсруулах үүргийг хүлээнэ***" гэж заасантай нийцээгүй байна.

**6.2. Төмөр толгойн төмрийн хүдрийн уурхайн техник эдийн засгийн үндэслэлийг** 2010 онд ШУТИС-ийн дэргэдэх Уул уурхайн төсөл судалгааны төв боловсруулсан ба 2018 онд "Жеммери" ХХК техник эдийн засгийн үндэслэлийн нэмэлт тодотголыг боловсруулан мөрдөн, ажиллаж байна. 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаарх геологийн нөөцөөр 11,963.1 мянган тонн төмрийн хүдрийн нөөц байгааг тогтоосон байна.

**Тодотгох болсон шалтгаан:** Эрдэс баялгийн сайдын 2012 оны 74 дүгээр тушаалын 7.3-д заасны дагуу, Төмөртолгойн төмрийн хүдрийн ордын баруун хүдрийн биетэд 2014-2015 онд гүйцэтгэсэн ашиглалтын үеийн нэмэлт хайгуулын ажлын үр дүнгийн тайланг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар 2017 онд хэлэлцүүлэн баталгаажуулснаар уурхайн ТЭЗҮ-д нэмэлт тодотгол оруулсан байна.

/Тодотгосон ТЭЗҮ-ээр, 2017-2022 оны уулын ажлын тоо хэмжээ/

| Ашиглалтын жил | Хөрс хуулалт, м3 | Төмрийн хүдэр олборлолт, тн | ХХКоэф, м3/тн |
|---|---|---|---|
| 2017 | 4,000,000.00 | 1,000,000.00 | 4.00 |
| 2018 | 4,500,000.00 | 2,000,000.00 | 2.25 |
| 2019 | 4,500,000.00 | 2,000,000.00 | 2.25 |
| 2020 | 1,500,000.00 | 2,000,000.00 | 0.75 |
| 2021 | 450,000.00 | 2,000,000.00 | 0.23 |
| 2022 | 177,700.00 | 779,800.00 | 0.23 |
| Нийт | 15,127,700.00 | 9,779,800.00 | 1.62 |

**6.3. Уулын ажлын гүйцэтгэл-Төмөртэйн төмрийн хүдрийн уурхай:** "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК нь тухайн оны эхэнд Ашигт малтмал газрын тосны газраар уулын ажлын төлөвлөгөөг батлуулан ажилладаг хэдий ч дээрх төлөвлөгөө, компанийн батлагдсан бизнес төлөвлөгөө болон тодотгосон төлөвлөгөөтэй уялдаагүй байна.

Компани уулын цулын хэмжээг тооцоолохдоо "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн гүйцэтгэх захирлын тушаалаар баталсан коэффициентын дагуу тухайн онд олборлосон хүдрийн тонн хэмжээг эзлэхүүн буюу м3-рүү шилжүүлж байна.

2014 онд уулын ажлын гүйцэтгэлээр 3,238.55 мян.м3 уулын цул хөдөлгөж, 2,810.68 мян.м3 хөрс хуулан, 941.31 мян.тн хүдэр олборлож, хөрс хуулалтын 2.66 м3/тонн коэффициенттой ажилласан байна.

Дээрх үзүүлэлтийг төлөвлөгөөтэй /бизнес/ харьцуулахад уулын цул авалт 89%, хөрс хуулалт 88%, хүдэр олборлолт 94%-тай байна.

Ашигт малтмал газрын тосны газраар батлуулсан төлөвлөгөөтэй харьцуулахад хөрс хуулалт 72.86%, хүдэр олборлолт 88.91%-тай байна.





2015 онд уулын ажлын гүйцэтгэлээр 189.24 мян.м3 уулын цул хөдөлгөж, 189.24 мян.м3 хөрс хуулсан боловч хүдэр олборлоогүй байна.

Дээрх үзүүлэлтийг төлөвлөгөөтэй Ашигт малтмал газрын тосны газраар батлуулсан уулын ажлын төлөвлөгөөтэй харьцуулахад хөрс хуулалт 7.14%-тай байна. Бизнес төлөвлөгөөнд уулын ажлын төлөвлөгөө тусгагдаагүй.

2016 онд уулын ажлын гүйцэтгэлээр 1,254.53 мян.м3 уулын цул хөдөлгөж, 1,118.09 мян.м3 хөрс хуулан, 539.41 мян.тн хүдэр олборлож, хөрс хуулалтын 1.75 м3/тонн коэффициенттэй ажилласан байна.

Дээрх үзүүлэлтийг төлөвлөгөө /бизнес/ харьцуулахад уулын цулыг 69%, хөрс хуулалтыг 76%, хүдэр олборлолтыг 69%-тай тус тус гүйцэтгэсэн байна. Ашигт малтмал газрын тосны газраар батлуулсан төлөвлөгөөтэй харьцуулахад хөрс хуулалт 42.19%, хүдэр олборлолт 26.97%-тай байна.

2017 онд уулын ажлын гүйцэтгэлээр 3,946.35 мян.м3 уулын цул хөдөлгөж, 3,178.90 мян.м3 хөрс хуулан, 1,688.40 мян.тн хүдэр олборлож, хөрс хуулалтын 1.65 м3/тонн коэффициенттой ажилласан байна.

Дээрх үзүүлэлтийг төлөвлөгөө /бизнес/ харьцуулахад уулын цулыг 72%, хөрс хуулалтыг 64%, хүдэр олборлолтыг 85%-тай тус тус гүйцэтгэсэн байна. Ашигт малтмал газрын тосны газраар батлуулсан төлөвлөгөөтэй харьцуулахад хөрс хуулалт 71.92%, хүдэр олборлолт 59.60%-тай байна.

2018 онд уулын ажлын гүйцэтгэлээр 2,820.67 мян.м3 уулын цул хөдөлгөж, 2,498.23 мян.м3 хөрс хуулан, 755.18 мян.тн хүдэр олборлож, хөрс хуулалтын 3.10 м3/тонн коэффициенттой ажилласан байна.

Дээрх үзүүлэлтийг төлөвлөгөө /бизнес/ харьцуулахад уулын цулыг 59%, хөрс хуулалтыг 59%, хүдэр олборлолтыг 41%-тай тус тус гүйцэтгэсэн байна. Ашигт малтмал газрын тосны газраар батлуулсан төлөвлөгөөтэй харьцуулахад хөрс хуулалт 59.48%, хүдэр олборлолт 34.48%-тай байна.

2019 онд уулын ажлын гүйцэтгэлээр 2,956.82 мян.м3 уулын цул хөдөлгөж, 2,362.40 мян.м3 хөрс хуулан, 1,426.61 мян.тн хүдэр олборлож, хөрс хуулалтын 1.96 м3/тонн коэффициенттой ажилласан байна.

Дээрх үзүүлэлтийг төлөвлөгөө /бизнес/ харьцуулахад уулын цулыг 76%, хөрс хуулалтыг 71%, хүдэр олборлолтыг 79%-тай тус тус гүйцэтгэсэн байна. Ашигт малтмал газрын тосны газраар батлуулсан төлөвлөгөөтэй харьцуулахад хөрс хуулалт 76.98%, хүдэр олборлолт 84.13%-тай байна.

2020 онд уулын ажлын гүйцэтгэлээр 5,225.86 мян.м3 уулын цул хөдөлгөж, 4,487.76 мян.м3 хөрс хуулан, 2,039.44 мян.тн хүдэр олборлож, хөрс хуулалтын 2.31 м3/тонн коэффициенттой ажилласан байна.

Дээрх үзүүлэлтийг төлөвлөгөө /бизнес/ харьцуулахад уулын цулыг 83%, хөрс хуулалтыг 82%, хүдэр олборлолтыг 95%-тай тус тус гүйцэтгэсэн байна. Ашигт малтмал газрын тосны газраар батлуулсан төлөвлөгөөтэй харьцуулахад хөрс хуулалт 115.48%, хүдэр олборлолт 116.17%-тай байна.

2021 онд уулын ажлын гүйцэтгэлээр 4,297.63 мян.м3 уулын цул хөдөлгөж, 3,771.05 мян.м3 хөрс хуулан, 1,579.73 мян.тн хүдэр олборлож, хөрс хуулалтын 2.17 м3/тонн коэффициенттой ажилласан байна.

Дээрх үзүүлэлтийг төлөвлөгөө /бизнес/ харьцуулахад уулын цулыг 84%, хөрс хуулалтыг 82%, хүдэр олборлолтыг 75%-тай тус тус гүйцэтгэсэн байна. Ашигт малтмал газрын тосны газраар батлуулсан төлөвлөгөөтэй харьцуулахад хөрс хуулалт 94.28%, хүдэр олборлолт 79.65%-тай байна.

2022 оны эхний 4 сарын уулын ажлын гүйцэтгэлээр 849.38 мян.м3 уулын цул хөдөлгөж, 774.63 мян.м3 хөрс хуулан, 224.24 мян.тн хүдэр олборлож, хөрс хуулалтын 3.45 м3/тонн коэффициенттой ажилласан байна.

Дээрх үзүүлэлтийг төлөвлөгөө /бизнес/ харьцуулахад уулын цулыг 69%, хөрс хуулалтыг 74%, хүдэр олборлолтыг 43%-тай тус тус гүйцэтгэсэн байна. Ашигт малтмал газрын тосны газраар батлуулсан төлөвлөгөөтэй харьцуулахад хөрс хуулалт 16.84%, хүдэр олборлолт 10.54%-тай байна.

Төмөртэйн төмрийн хүдрийн уурхайн 2014-2022.04 сар хүртэлх уулын ажлын төлөвлөгөө гүйцэтгэл/.

| Он | Хүдэр олборлолт /тонноор/ | | | | Хөрс хуулалт /м3/ | | | Уулын цул /м3/ | | | Хөрс хуулалтын коэффициент /м3/тн/ | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Биелэлт /хувиар/ | М3-р | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Биелэлт /хувиар/ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Биелэлт /хувиар/ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Биелэлт /хувиар/ |
| 2014 | 1,000,000.00 | 941,310.00 | 94.1% | 2.20 | 3,180,000.00 | 2,810,684.00 | 88.4% | 3,634,544.70 | 3,238,552.30 | 89.1% | 3.25 | 2.66 | 81.8% |
| 2015 | - | - | 0.0% | | 0.00 | 189,237.00 | 0.0% | 0.00 | 189,237.00 | 0.0% | - | - | 0.0% |
| 2016 | 782,237.60 | 539,413.76 | 69.0% | 3.84 | 1,464,813.00 | 1,118,086.27 | 76.3% | 1,810,281.60 | 1,254,531.00 | 69.3% | 1.20 | 1.75 | 145.7% |
| 2017 | 1,978,000.00 | 1,688,395.60 | 85.4% | 2.20 | 4,930,000.00 | 3,178,895.00 | 64.5% | 5,450,526.30 | 3,946,347.00 | 72.4% | 2.10 | 1.65 | 78.9% |
| 2018 | 1,860,000.00 | 755,182.10 | 40.6% | 2.40 | 4,260,000.00 | 2,498,228.00 | 58.6% | 4,749,475.00 | 2,820,671.00 | 59.4% | 2.05 | 3.10 | 151.4% |
| 2019 | 1,814,939.00 | 1,426,606.50 | 78.6% | 2.40 | 3,307,000.00 | 2,362,402.47 | 71.4% | 3,905,361.00 | 2,956,822.00 | 75.7% | 2.11 | 1.96 | 92.7% |
| 2020 | 2,150,000.00 | 2,039,439.52 | 94.9% | 2.75 | 5,500,000.00 | 4,487,761.03 | 81.6% | 6,273,333.00 | 5,225,860.00 | 83.3% | 2.53 | 2.31 | 91.4% |
| 2021 | 2,100,000.00 | 1,579,732.80 | 75.2% | 3.00 | 4,600,000.00 | 3,771,049.02 | 82.0% | 5,125,000.00 | 4,297,625.79 | 83.9% | 2.27 | 2.17 | 95.6% |
| 2022 он 04 сар | 520,000.00 | 224,244.04 | 43.1% | 3.00 | 1,040,600.00 | 774,629.59 | 74.4% | 1,223,400.00 | 849,377.60 | 69.4% | 2.02 | 3.45 | 171.2% |
| Нийт дүн | 12,205,176.60 | 9,194,324.32 | 64.5% | 2.72 | 28,282,413.00 | 21,190,972.38 | 66.4% | 32,171,921.60 | 24,779,023.86 | 66.9% | 1.85 | 2.12 | 101.0% |

"Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК нь Төмөртэйн төмрийн хүдрийн уурхайгаас 2014-2022 оны эхний 4 сарын байдлаар нийт 24,779.02 мян.м3 уулын цул хөдөлгөн, 21,190.97 мян.м3 хөрс хуулан, 9,194.32 мян.тн хүдэр олборлож, хөрс хуулалтын 2.12 м3/тонн коэффициенттой ажилласан байна.

**6.4. Уулын ажлын гүйцэтгэл-Төмөртолгойн төмрийн хүдрийн уурхай:** "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК нь тухайн оны эхэнд Ашигт малтмал газрын тосны газраар уулын ажлын төлөвлөгөөг батлуулан ажилладаг боловч компанийн батлагдсан бизнес төлөвлөгөө, тодотгосон төлөвлөгөөний дагуу уулын ажлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг гаргаж, Ашигт малтмал газрын тосны газарт тайлагнаж байна.

2014 онд уулын ажлын гүйцэтгэлээр 4,885.79 мян.м3 уулын цул хөдөлгөж, 4,357.36 мян.м3 хөрс хуулан, 1,239.55 мян.тн хүдэр олборлож, хөрс хуулалтын 3.5 м3/тонн коэффициенттэй ажилласан байна.

Дээрх үзүүлэлтийг төлөвлөгөө /бизнес/ харьцуулахад уулын цулыг 108.44%, хөрс хуулалтыг 110.03%, хүдэр олборлолтыг 103.30%-тай гүйцэтгэсэн байна.

2015 онд уулын ажлын гүйцэтгэлээр 106.14 мян.м3 уулын цул хөдөлгөж, 97.57 мян.м3 хөрс хуулан, 18.85 мян.тн хүдэр олборлож, хөрс хуулалтын 1.70 м3/тонн коэффициенттой ажилласан байна.

Дээрх үзүүлэлтийг төлөвлөгөө /бизнес/ харьцуулахад уулын цулыг 28.17%, хөрс хуулалтыг 31.21%, хүдэр олборлолтыг 13.37%-тай тус тус гүйцэтгэсэн байна. Ашигт малтмал газрын тосны газраар батлуулсан төлөвлөгөөтэй харьцуулахад хөрс хуулалт 2.75%, хүдэр олборлолт 1.89%-тай байна.



"Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн 2014-2021 оны үйл ажиллагаанд хийсэн шалгалтын тайлан

2016 онд Төмөртолгойн төмрийн хүдрийн уурхай ажиллаагүй.

2017 онд уулын ажлын гүйцэтгэлээр 2,171.25 мян.м3 уулын цул хөдөлгөж, 1,788.07 мян.м3 хөрс хуулан, 874.99 мян.тн хүдэр олборлож, хөрс хуулалтын 1.91 м3/тонн коэффициенттой ажилласан байна. Дээрх үзүүлэлтийг төлөвлөгөө /бизнес/ харьцуулахад уулын цулыг 63.44%, хөрс хуулалтыг 66.22%, хүдэр олборлолтыг 55.03%-тай тус тус гүйцэтгэсэн байна.

2018 онд уулын ажлын гүйцэтгэлээр 2,216.15 мян.м3 уулын цул хөдөлгөж, 1,941.31 мян.м3 хөрс хуулан, 835.40 мян.тн хүдэр олборлож, хөрс хуулалтын 3.87 м3/тонн коэффициенттой ажилласан байна.

Дээрх үзүүлэлтийг төлөвлөгөө /бизнес/ харьцуулахад уулын цулыг 47.78%, хөрс хуулалтыг 50.55%, хүдэр олборлолтыг 41.98%-тай тус тус гүйцэтгэсэн байна. Ашигт малтмал газрын тосны газраар батлуулсан төлөвлөгөөтэй харьцуулахад хөрс хуулалт 43.14%, хүдэр олборлолт 41.77%-тай байна.

2019 онд уулын ажлын гүйцэтгэлээр 2,506.64 мян.м3 уулын цул хөдөлгөж, 2,049.78 мян.м3 хөрс хуулан, 1,096.47 мян.тн хүдэр олборлож, хөрс хуулалтын 2.12 м3/тонн коэффициенттой ажилласан байна.

Дээрх үзүүлэлтийг төлөвлөгөө /бизнес/ харьцуулахад уулын цулыг 71.14%, хөрс хуулалтыг 70.32%, хүдэр олборлолтыг 75.10%-тай тус тус гүйцэтгэсэн байна. Ашигт малтмал газрын тосны газраар батлуулсан төлөвлөгөөтэй харьцуулахад хөрс хуулалт 45.53%, хүдэр олборлолт 54.28%-тай байна.

2020 онд уулын ажлын гүйцэтгэлээр 3,412.53 мян.м3 уулын цул хөдөлгөж, 2,747.45 мян.м3 хөрс хуулан, 1,685.34 мян.тн хүдэр олборлож, хөрс хуулалтын 1.77 м3/тонн коэффициенттой ажилласан байна.

Дээрх үзүүлэлтийг төлөвлөгөө /бизнес/ харьцуулахад уулын цулыг 83%, хөрс хуулалтыг 82%, хүдэр олборлолтыг 95%-тай тус тус гүйцэтгэсэн байна. Ашигт малтмал газрын тосны газраар батлуулсан төлөвлөгөөтэй харьцуулахад хөрс хуулалт 61.35%, хүдэр олборлолт 86.64%-тай байна.

2021 онд уулын ажлын гүйцэтгэлээр 3,321.32 мян.м3 уулын цул хөдөлгөж, 2,850.49 мян.м3 хөрс хуулан, 1,430.46 мян.тн хүдэр олборлож, хөрс хуулалтын 0.92 м3/тонн коэффициенттой ажилласан байна.

Дээрх үзүүлэлтийг төлөвлөгөө /бизнес/-тэй харьцуулахад уулын цулыг 88.88%, хөрс хуулалтыг 86.38%, хүдэр олборлолтыг 89.40%-тай тус тус гүйцэтгэсэн байна. Ашигт малтмал газрын тосны газраар батлуулсан төлөвлөгөөтэй харьцуулахад хөрс хуулалт 83.08%, хүдэр олборлолт 67.33%-тай байна.

2022 оны эхний 4 сарын уулын ажлын гүйцэтгэлээр 525.17 мян.м3 уулын цул хөдөлгөж, 361.08 мян.м3 хөрс хуулан, 470.64 мян.тн хүдэр олборлож, хөрс хуулалтын 1.12 м3/тонн коэффициенттой ажилласан байна.

Дээрх үзүүлэлтийг төлөвлөгөө /бизнес/ харьцуулахад уулын цулыг 54%, хөрс хуулалтыг 47.51%, хүдэр олборлолтыг 55.37%-тай тус тус гүйцэтгэсэн байна. Ашигт малтмал газрын тосны газраар батлуулсан төлөвлөгөөтэй харьцуулахад хөрс хуулалт 11.28%, хүдэр олборлолт 29.42%-тай байна.

Төмөртолгойн төмрийн хүдрийн уурхайн 2014-2022.04 сар хүртэлх уулын ажлын төлөвлөгөө гүйцэтгэл/.

| Он | Хүдэр олборлолт /тонноор/ | | | | Хөрс хуулалт /м3/ | | | Уулын цул /м3/ | | | Хөрс хуулалтын коэффициент /м3/тн/ | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Биелэлт /хувиар/ | М3-р | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Биелэлт /хувиар/ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Биелэлт /хувиар/ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Биелэлт /хувиар/ |
| 2014 | 1,200,000.0 | 1,239,552.22 | 103.30% | 2.62 | 3,960,000.00 | 4,357,357.00 | 110.03% | 4,505,456.00 | 4,885,792.00 | 108.44% | 3.32 | 3.50 | 105.55% |
| 2015 | 141,000.0 | 18,850.00 | 13.37% | 2.20 | 312,643.00 | 97,570.00 | 31.21% | 376,734.00 | 106,138.00 | 28.17% | 1.49 | 1.70 | 114.27% |
| 2016 | Төмөртолгойн төмрийн хүдрийн уурхай 2016 онд ажиллаагүй | | | | | | | | | | | | |
| 2017 | 1,590,000.0 | 874,993.71 | 55.03% | 2.13 | 2,700,000.00 | 1,788,069.60 | 66.22% | 3,422,727.27 | 2,171,251.28 | 63.44% | 1.53 | 1.91 | 124.36% |
| 2018 | 1,990,000.0 | 835,403.53 | 41.98% | 3.47 | 3,840,000.00 | 1,941,308.15 | 50.55% | 4,638,345.30 | 2,216,149.54 | 47.78% | 1.99 | 3.87 | 194.37% |
| 2019 | 1,460,000.0 | 1,096,471.55 | 75.10% | 2.40 | 2,915,000.00 | 2,049,779.08 | 70.32% | 3,523,333.60 | 2,506,642.20 | 71.14% | 2.00 | 2.12 | 106.14% |
| 2020 | 1,560,000.0 | 1,685,336.65 | 108.03% | 2.55 | 3,475,000.00 | 2,747,451.26 | 79.06% | 4,067,083.40 | 3,412,525.70 | 83.91% | 2.25 | 1.77 | 78.64% |
| 2021 | 1,600,000.0 | 1,430,458.11 | 89.40% | 3.67 | 3,300,000.00 | 2,850,488.04 | 86.38% | 3,736,666.67 | 3,321,318.45 | 88.88% | 2.03 | 0.92 | 45.40% |
| 2022 он 04 сар | 850,000.0 | 470,843.30 | 55.37% | 2.85 | 760,000.00 | 361,079.00 | 47.51% | 972,500.00 | 525,167.10 | 54.00% | 0.93 | 1.12 | 120.85% |
| Нийт дүн | 10,391,000.0 | 7,651,709.37 | 73.64% | 2.74 | 21,262,643.00 | 16,193,102.11 | 76.16% | 25,242,846.24 | 19,144,984.27 | 75.84% | 1.94 | 2.11 | 108.88% |

"Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК нь Төмөртолгойн төмрийн хүдрийн уурхайгаас 2014-2022 оны эхний 4 сарын байдлаар нийт 19,144.98 мян.м3 уулын цул хөдөлгөн, 16,193.10 мян.м3 хөрс хуулан, 7,651.71 мян.тн хүдэр олборлож, хөрс хуулалтын 2.11 м3/тонн коэффициенттой ажилласан байна.

## ДОЛОО. КОНЦЕССЫН ЗҮЙЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

### 7.1. Концессын хөрөнгө оруулалтын талаар:

#### 7.1.1. Хуст уул, Төмөртолгой, Төмөртэй ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулж, жилдээ 3,0 сая тонн төмрийн хүдэр олборлох, жилд 1.5 сая тонноос доошгүй тонн төмрийн хүдрийн хуурай болон нойтон аргын баяжмал үйлдвэрлэх үйлдвэр

"Уул уурхай металлургийн цогцолбор байгуулах төслийг хэрэгжүүлэх Концессын гэрээ"-ний 2.1.1-д "Хуст уул, Төмөртолгой, Төмөртэй ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулж, жилдээ 3,0 сая тонн төмрийн хүдэр олборлох, жилд 1.5 сая тонноос доошгүй тонн төмрийн хүдрийн хуурай болон нойтон аргын баяжмал үйлдвэрлэх үйлдвэр" төслийг барих-ашиглах-шилжүүлэх төрлөөр хэрэгжүүлэхээр туссан.

Концесс эзэмшигч нь тухайн концессын зүйлийн хүрээнд нийт 152.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн гэж тайлагнасан байна.

/Уурхайн олборлох хүчин чадлыг нэмэгдүүлэх хөрөнгө оруулалт/

| Д/д | Төсөл арга хэмжээний нэр | Хөрөнгө оруулалт /сая төгрөгөөр/ |
|---|---|---|
| 1 | Төмөртэй уурхайн тоног төхөөрөмж, хөрөнгө оруулалт | 81,200.70 |
| 2 | Төмөртэйн уурхайд 750 тн\ц соронзон баяжуулах үйлдвэр | 10,850.10 |
| 3 | Төмөртэй уурхайн ажилчдын амрах, хооллох кэмп | 1,613.40 |
| 4 | Төмөртэйн уурхайн засварын төв, оффиссын барилга | 2,237.70 |
| 5 | Төмөртолгой уурхайн тоног төхөөрөмж, хөрөнгө оруулалт | 27,121.40 |
| 6 | Төмөртолгой уурхайд 750 тн\цаг соронзон баяжуулах үйлдвэр | 12,640.50 |
| 7 | ДТҮ-ын төмөр замын терминал төсөл | 3,771.20 |
| 8 | ДТҮ-ийн 1 сая тонн хүдрийг нойтон баяжуулах үйлдвэр | 11,611.20 |
| 9 | Судалгаа техник үндэслэл | 1,649.20 |
| | ТӨСЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ: | 152,695.40 |

Концессын зүйлийн хүрээнд хуурай болон нойтон баяжуулах үйлдвэрүүдийг уурхайнуудад 2010-2019 оны хооронд барьж ашиглалтад оруулж, уурхайн хүдэр боловсруулах үйл ажиллагаанд ашиглаж байгаа бол уул уурхайн бусад тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт нь тодорхой бус түрээсийн хэлбэрээр ашиглаж байна.





#### 7.1.2. Жилд 500.0 мянгаас доошгүй тонн хүчин чадал бүхий шууд ангижруулах төмрийн үйлдвэр

"Уул уурхай металлургийн цогцолбор байгуулах төслийг хэрэгжүүлэх Концессын гэрээ"-ний 2.1.2-д "Жилд 500.0 мянгаас доошгүй тонн хүчин чадал бүхий шууд ангижруулах төмрийн үйлдвэр" төслийг барих-ашиглах-шилжүүлэх төрлөөр хэрэгжүүлэхээр туссан.

Концесс эзэмшигч 2016 онд Финлянд улсын Outotec GmbH & Co.KG компанитай төмрийн хүдрийн шууд ангижруулах үйлдвэрийн техник эдийн засгийн үндэслэл, инженерийн зураг төсөл боловсруулах гэрээ байгуулж гүйцэтгүүлж, 2017 онд жилд 600 мянган/тонн хүдрийг шууд ангижруулах хүчин чадал бүхий төмрийн үйлдвэрийн техник эдийн засгийн үндэслэл, инженерийн зураг төсөл хүлээн авсан.

Техник эдийн засгийн үндэслэлийн тооцоогоор жилд 600 мянган/тонн хүдрийг шууд ангижруулах төмрийн үйлдвэрийн байгуулахад 150-170 МВА-ын цахилгаан эрчим хүч шаардлагатай гэсэн тооцоо гарсан боловч Монгол Улсын хэмжээнд эрчим хүчний эх үүсвэр дутагдалтай, Дархан, Сэлэнгийн бүсийн цахилгаан дамжуулах сүлжээний хүчин чадал хүрэлцэхгүй тул концесс эзэмшигч тухайн концессын зүйлд хөрөнгө оруулалт хийж, хэрэгжүүлээгүй байна.

#### 7.1.3. "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн хүчин чадлыг жилийн 300.0 мянган тоннд хүргэх өргөтгөл, шинэчлэл хийх, Төмрийн хүдэр боловсруулж эцсийн бүтээгдэхүүн гаргах.

"Уул уурхай металлургийн цогцолбор байгуулах төслийг хэрэгжүүлэх Концессын гэрээ"-ний 2.1.3-д Дарханы төмөрлөгийн үйлдвэр ТӨХК-ийн хүчин чадлыг жилийн 300.0 мянган тоннд хүргэх өргөтгөл, шинэчлэл хийх\Төмрийн хүдэр боловсруулж эцсийн бүтээгдэхүүн гаргах" төслийг барих-ашиглах-шилжүүлэх төрлөөр хэрэгжүүлэхээр туссан.

"Дархан Төмөрлөгийн Үйлдвэр" ХК-ийн боловсруулах үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх хүрээнд 2017 онд "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК нь 26.8 тэрбум төгрөгийн өөрийн хөрөнгө оруулалтаар 100-140 мм диаметртэй ган бөмбөлгийн давтах аргын үйлдвэр, шанаган зуух, цахилгаан соронзон холигч, үйлдвэрийн барилга, дэд бүтцийг ашиглалтад оруулсан байна.

Тус гангийн үйлдвэр 2019 онд хаягдал төмрийн түүхий эд, техникийн дотоод нөөцөө ашиглан 100 мм диаметр хэмжээтэй давтах аргын 600 тонн ган бөмбөлөг үйлдвэрлэж "Эрдэнэт" ТӨҮГ-т нийлүүлсэн боловч тухайн байгууллагын үндсэн шаардлагад нийцээгүй тул ган бөмбөлгийн үйлдвэр 2019 оноос үйл ажиллагаа явуулаагүй зогсонги байна.

Ган бөмбөлгийн үйлдвэр нь зөвхөн хаягдал төмөр боловсруулах технологид үндэслэсэн тул цаашид хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломж хязгаарлагдмал байна.

#### 7.1.4. "Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд Төмрийн хүдэр баяжуулах үйлдвэрийг цахилгаан эрчим хүчээр хангах "Төмөртэй" 110 кВ-ын дэд станц, 110 кВ-ын 50 км цахилгаан дамжуулах агаарын шугам барих төсөл"

2011 оны "дэд бүтэц байгуулах төсөл"-ийг хамтран хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын гэрээний 1.2.3-д "Дархан хотоос 110 квт хүчин чадал бүхий 140 км өндөр хүчдэлийн шугам татаж Төмөртэйн уурхайг цахилгаанаар хангах", гэж 2014 онд байгуулсан "Уул Уурхай, металлургийн цогцолбор байгуулах төслийг хэрэгжүүлэх концессын гэрээ"-ний 2.1.6-д "Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд

Төмрийн хүдэр баяжуулах үйлдвэрийг цахилгаан эрчим хүчээр хангах "Төмөртэй" 110 кВ-ын дэд станц, 110 кВ-ын 50 км цахилгаан дамжуулах агаарын шугам барихад төсөл"-ийг барих-шилжүүлэх төрлөөр хэрэгжүүлэхээр туссан.

Хөрөнгө оруулагч "Кью Эс Си" ХХК 2012 од "Монцахэр" ХХК-тай тус цахилгаан дамжуулах агаарын шугамын ажлын зураг төсөл, төсвийг гүйцэтгүүлж, 2012 оны 647/2012 дугаартай магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажуулсан.

Батлагдсан төсөвт өртгийг үндэслэн 2012 онд хөрөнгө оруулагч "Кью Эс Си" ХХК, захиалагч "Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр" ХК, гүйцэтгэгч "Юнайтед Энержи Систем" ХХК-ийн хооронд 12,576,151,011 төгрөгийн төсөвт өртөг бүхий ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, 2014 онд Эрчим хүчний барилга, байгууламжийг ашиглалтад оруулах улсын комиссын 11/2014 дугаартай актаар байнгын ашиглалтад хүлээлгэн өгч, Төмөртэйн уурхайн үйл ажиллагаанд ашиглаж байна.

2016 онд байгуулсан "Уул Уурхай, металлургийн цогцолбор байгуулах төслийг хэрэгжүүлэх концессын гэрээ"-ний 2.1.6-д заасны дагуу 2016 онд концессын зүйлийн төлбөрөөр 12.5 тэрбум төгрөгийг Улсын төсвөөс буцаан авсан боловч тухайн хөрөнгийг төр, орон нутгийн өмчлөлд өнөөг хүртэл шилжүүлээгүй байна.

**7.1.5. "Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд орших Төмөртэйн ордоос Хандгайт өртөө чиглэлийн 33.4 км, 1520 мм царигтай төмөр зам, ачиж буулгах терминал төсөл"**

2011 оны "Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төсөл"-ийн хүрээнд шаардлагатай "дэд бүтэц байгуулах төсөл"-ийг хамтран хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын гэрээний 1.2.2-т "Болд Төмөр Ерөө гол" ХХК-ийн төмөр замаас Төмөртэйн уурхай хүртэлх 22 км төмөр зам тавих" гэж 2014 оны "Уул уурхай металлургийн цогцолбор байгуулах төслийг хэрэгжүүлэх Концессын гэрээ"-ний 2.1.4-т "Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд орших Төмөртэйн ордоос Хандгайт өртөө чиглэлийн 33.4 км, 1520 мм царигтай төмөр зам, ачиж буулгах терминал төсөл"-ыг барих-ашиглах-шилжүүлэх төрлөөр хэрэгжүүлэхээр туссан.

Төмөр замын зураг төсөл, төсвийг 2012 онд хөрөнгө оруулагч "Кью Эс Си" ХХК, захиалагч "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК, гүйцэтгэгч "Юнайтед Энержи Системс" ХХК-ийн хооронд байгуулсан АГГ/2012/01 тоот гэрээ мөн 2012 онд "Максимал" ХХК-ийн хооронд байгуулсан АГГ/2012/03 дугаартай гэрээний дагуу төмөр замын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах гэрээг байгуулж гүйцэтгүүлсэн байна.

Төмөр зам, терминалын барилгын ажлыг "Кью Эс Си" ХХК нь "Монголиан Рэйлвэй корпорэйшн" ХХК-тай 2014 онд 106.8 сая ам.долларын үнийн дүнтэй "Төмөр замын ажил захиалгаар гүйцэтгэх гэрээ"-г байгуулж Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд орших Төмөртэйн ордоос Хандгайт өртөө чиглэлийн төмөр зам барих ажлыг гүйцэтгүүлж, 2015 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 02/18/15 дугаартай барилга байгууламжийг ашиглалтад оруулах Улсын комиссын актаар төмөр замыг ашиглалтад хүлээж авсан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 9 дүгээр сарын 07-ны өдрийн "Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай" 364 дүгээр тогтоолоор "Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд орших Төмөртэйн ордоос Ерөө суманд орших "Болд төмөр Ерөө гол" ХХК-ийн төмөр замын хандгайт өртөө хүртэлх 33.4 км төмөр замыг ачиж





буулгах терминалын хамт барих" концессыг "барих-шилжүүлэх" төрлөөр хэрэгжүүлсүгэй" гэж тусгасны дагуу 2015 оны 10 дугаар сарын 02-ны өдөр "Уул уурхай металлургийн цогцолбор байгуулах төсөл"-д концессын нэмэлт гэрээгээр концессын төрлийг өөрчилж, концессын төлбөрийг Улсын төсөвт суулган, концесс эзэмшигчид нөхөн төлөх хуваарийг оруулсан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 77 дугаар тогтоолоор тус төмөр замыг "Монголын Төмөр Зам" ТӨХК-д шилжүүлэхээр болсонтой холбогдуулан, Сангийн сайдын 2016 оны 72 дугаар тушаалаар төмөр замын концессын төлбөр гүйцэтгэх акт үйлдэж 90.1 сая долларыг жилийн 14.9 хувийн хүүтэй шилжих вексель Сангийн яамнаас гаргаж концесс эзэмшигчид төмөр замын бүтээн байгуулалтын ажлын санхүүжилтийг олгосон байна. Сангийн яамны шилжих векселийг дараах байдлаар санхүүжүүлсэн байна.

/Төмөр замын векселийн төлбөрийн санхүүжилт, төгрөгөөр/

| Д/д | Вексель эзэмшигчийн нэр | Векселийн үндсэн төлбөр /төгрөг/ | Векселийн хүүгийн төлбөр /төгрөг/ | Нийт төлбөр /төгрөг/ |
|---|---|---|---|---|
| 1 | Хөгжлийн банк | 113,608,605,210 | 16,927,756,877 | 130,536,362,088 |
| 2 | Төрийн банк | 70,000,000,000 | 10,430,046,027 | 80,430,046,027 |
| | Нийт дүн: | 183,608,605,210 | 27,357,802,904 | 210,966,408,114 |

Засгийн газрын тогтоолоор концессын гэрээний төрөлд өөрчлөлт оруулснаар концессын төлбөр, хүүгийн төлбөрт Улсын төсвөөс нийт 210.9 тэрбум төгрөгийг төлсөн байна.

**7.1.6. Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд орших Төмөртэйн ордоос Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумаас Улаанбаатар чиглэлийн олон улсын авто зам Дулаан хааны дөрвөн замын уулзвар хүртэл 95 км хүнд даацын хатуу хучилттай авто зам:**

Монгол Улсын Эдийн засгийн хөгжлийн яам болон "Кью Эс Си" ХХК-ийн хооронд 2014 онд байгуулсан "Уул уурхай металлургийн цогцолбор байгуулах төслийг хэрэгжүүлэх Концессын гэрээ"-ний 2.1.5-д "Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд орших Төмөртэйн ордоос Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумаас Улаанбаатар чиглэлийн олон улсын авто зам Дулаанхааны дөрвөн замын уулзвар хүртэл 95 км хүнд даацын хатуу хучилттай авто зам" төслийг барих-ашиглах-шилжүүлэх төрлөөр хэрэгжүүлэхээр туссан.

Зам, тээврийн яамны 2015 оны 25/15 дугаартай ажлын даалгавраар "Сэлэнгэ аймгийн Дулаан хааны 4-н замын уулзвар-Ерөө-Хүдэр чиглэлийн хатуу хучилттай авто замын ТЭЗҮ болон инженерийн нарийвчилсан зураг төсөл, ажлын тоо хэмжээг "Даваа зам" ХХК, авто замын зураг төсвийг "Кью Эс Си" ХХК-ийн захиалгаар "Арвай Нутгийн Зам" ХХК гүйцэтгэж, 2018 оны 01/2018 тоот магадлалын дүгнэлтээр баталгаажуулсан байна.

Авто замыг ажлыг 2014 онд хөрөнгө оруулагч "Кью Эс Си" ХХК, үндсэн гүйцэтгэгч "Пик Девлопмент" ХХК, туслан гүйцэтгэгч "Мотор Сервис" ХХК-ийн хооронд байгуулсан гэрээний дагуу 2014-2017 онд 95.3 тэрбум төгрөгийн санхүүжилтээр гүйцэтгэж, 2017 оны 07/10/17 тоот барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлтээр ашиглалтад оруулсан.

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны "Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай" 364 дүгээр тогтоолоор концессын төрлийг "барих-шилжүүлэх"

төрлөөр хэрэгжүүлсүгэй" гэж тусгасны дагуу 2015 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн концессын нэмэлт гэрээгээр концессын төрлийг "барих-шилжүүлэх" болгон мөн "хүнд даацын" гэх тодотголыг хасаж байгуулснаар 2016 онд Улсын төсвөөс 57.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг буцаан авсан байна.

"Уул уурхай металлургийн цогцолбор байгуулах төслийг хэрэгжүүлэх Концессын гэрээ"-ний 2.1.5-д тус авто зам нь Төмөртэйн ордоос хүдэр тээвэрлэх, хүнд даацын авто зам байхаар тусгасан боловч тухайн зам нь Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын төвийн чиглэлд, орон нутгийн шинж чанартай байхаар төлөвлөгдөж баригдсан байгаа нь концессын гэрээнд "Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төсөл"-д хамааралгүй авто замын төслийг тусган хэрэгжүүлж, улмаар Улсын төсвөөс санхүүжилтийг нь олгосон байна.

**7.2. Концессын хөрөнгө оруулалт, хэрэгжилтийн талаар:** "Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр" ХК-ийн ажиллагаа, техник технологийг бүрэн шинэчилж, Хуст уул, Төмөртолгой, Төмөртэйн ордыг эдийн засгийн эргэлтэд оруулж хүдрийг шууд ангижруулах замаар ган бүтээгдэхүүн үйлдвэрлэх, Монгол Улсын гангийн дотоодын хэрэгцээг бүрэн хангах зорилтын хүрээнд 2014 онд Эдийн засгийн хөгжлийн яам, "Кью эс си" ХХК-ийн хооронд "Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төслийг хэрэгжүүлэх концессын гэрээ"-г "шинэчлэн сайжруулах-барих-ашиглах-шилжүүлэх" төрлөөр, дэд бүтцийн 3, үйлдвэрлэл, уурхай 3, нийт үндсэн 6 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусган гэрээ байгуулсан.

Энэ хүрээнд концесс эзэмшигч нийт 630.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийж "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн үйл ажиллагааг өргөжүүлэх замаар концессын гэрээний үндсэн зорилт болох ган боловсруулах, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх концессын зүйлийг амжилттай хэрэгжүүлж байгаа талаар эрх бүхий байгууллагад ирүүлсэн тайланд дурдсан байна.

Үүнээс авто зам, төмөр зам, цахилгаан эрчим хүчний салбарт хийсэн 320.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг Улсын төсвөөс буцаан авсан боловч Засгийн газрын тогтоолоор Улсын төсөвт буцаан төвлөрүүлэх шийдвэр гарсан. Харин үйлдвэрлэл, уурхайн хүчин чадлыг сайжруулах чиглэлд хийсэн 310.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн нь тайлан балансаар баталгаажаагүй, "Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр" ХК-ийн өөрийн хөрөнгөөр хийсэн байх тул мөн концесс эзэмшигчийн зүгээс концессын гэрээний хүрээнд 2010-2021 оны хооронд "Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр" ХК-д хийсэн гэх 630.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаас 2010-2013 онд хийсэн 81.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт */2014 концессын гэрээгээр хөрөнгө оруулалтад тооцож бүртгэсэн/*-аас бусад хөрөнгө оруулалтыг концесс эзэмшигчээс концессын зүйлд оруулсан хөрөнгө оруулалтад тооцох боломжгүй. Харин 81.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын үр ашгийг тооцож холбогдох шийдвэр гаргах шаардлагатай байна.

/Концессын зүйлийн хэрэгжилтийг хүснэгтээр харуулав, 2014-2021 он/

| Д/д | Хөрөнгө оруулалтын нэр | Хөрөнгө оруулалт /сая төгрөгөөр/ | Хөрөнгө оруулалтад тооцох эсэх тухай тайлбар | Хангалттай |
|---|---|---|---|---|
| 1 | Хуст уул, Төмөртолгой, Төмөртэй ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулж, жилдээ 3,0 сая тонн төмрийн хүдэр олборлох, жилд 1.5 сая тонноос доошгүй тонн төмрийн хүдрийн хуурай болон нойтон аргын баяжмал үйлдвэрлэх үйлдвэр | 152,695.00 | Ямар тоног төхөөрөмж нийлүүлсэн нь тодорхой бус гэрээ, хүлээлцсэн акт байхгүй, ДТҮ-ын хөрөнгийн бүртгэлд байх тул хөрөнгө оруулалтад тооцох боломжгүй. | Хангалтгүй. |
| 2 | Жилд 500.0 мянгаас доошгүй тонн хүчин чадал бүхий шууд ангижруулах төмрийн үйлдвэр | 3,168.20 | Концессын гэрээний 6.37- заасныар концесс эзэмшигч өөрийн хөрөнгөөр хийх үүрэгтэй тул хөрөнгө оруулалтад тооцох боломжгүй. | Хэрэгжүүлээгүй. |





| Д/д | Хөрөнгө оруулалтын нэр | Хөрөнгө оруулалт /сая төгрөгөөр/ | Хөрөнгө оруулалтад тооцох эсэх тухай тайлбар | Хангалттай |
|---|---|---|---|---|
| 3 | Дархан төмөрлөгийн үйлдвэр ТӨХК-ийн хүчин чадлыг жилийн 300.0 мянган тоннд хүргэх өргөтгөл, шинэчлэл хийх\Төмрийн хүдэр боловсруулж эцсийн бүтээгдэхүүн гаргах | 26,895.30 | 2014-2019 онд "ДТҮ" ТӨХК өөрийн 26.9 тэрбум төгрөгийн хөрөнгөөр хийсэн төсөл арга хэмжээ тул хөрөнгө оруулалтад тооцох боломжгүй. | ДТҮ-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн. |
| 4 | Сэлэнгэ аймгийн Хүдэр сумынд орших Төмөртэйн ордоос Хандгайт өртөө\Баянгол төмөр зам\ чиглэлийн 33.4 км 1520 мм царигтай төмөр зам, ачиж буулгах терминал | 212,788.30 | Тус төмөр замын төсөл нь үр ашигтүй, концесс эзэмшигч өөрийн хөрөнгө оруулалтаар хийх үүрэгтэй төсөл арга хэмжээ тул хөрөнгө оруулалтад тооцох боломжгүй. Тус авто замын Улсын төсвөөс авсан санхүүжилтийг төсөвт буцаан төвлөрүүлэх 2018 оны 6 дугаар тогтоол гарсан. | Хэрэгжүүлсэн. Санхүүжилтээ Улсын төсвөөс буцаан авсан. |
| 5 | Сэлэнгэ аймгийн Хүдэр сумынд орших Төмөртэйн ордоос Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумаас Улаанбаатар чиглэлийн олон улсын авто зам Дулаанханы дөрвөн замын уулзвар хүртэл 95 км хүнд даацын хатуу хучилттай авто зам | 95,272.20 | Тус авто зам нь концессын зүйлд хамааралгүй төсөл арга хэмжээ тул хөрөнгө оруулалт тооцох боломжгүй. Тус авто замын Улсын төсвөөс авсан санхүүжилтийг төсөвт буцаан төвлөрүүлэх 2018 оны 6 дугаар тогтоол гарсан. | Хэрэгжүүлсэн. Санхүүжилтээ Улсын төсвөөс буцаан авсан. |
| 6 | Сэлэнгэ аймгийн Ерөө сумаас Хүдэр сумын Төмөртэйн уурхай хүртэл 110 кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, 50 км, өргөтгөл, дэд станц | 12,576.20 | Концессын гэрээний 2.5- заасны дагуу улсын төсвөөс санхүүжилтээ 2016 онд санхүүжилтийг буцаан авса хөрөнгө оруулалтад тооцох боломжгүй. | Хэрэгжүүлсэн. Санхүүжилтээ Улсын төсвөөс буцаан авсан. |
| 7 | Концессын төлбөрт улсын төсөвт төвлөрүүлсэн. | 31,900.00 | Концессын гэрээний 2.12-т заасны дагуу концесс эзэмшигч төлөх үүрэгтэй тул хөрөнгө оруулалтад тооцох боломжгүй. | Хэрэгжүүлсэн. Санхүүжилтээ Улсын төсвөөс буцаан авсан. |
| 8 | Төслийн санхүүжилтийн зардалд зарцуулсан | 95,546.10 | Ямар төслийн хүрээнд хэдэн төгрөг зарцуулсан талаар "ДТҮ" ТӨХК-д ямарч мэдээлэл, хөрөнгийн бүртгэл байхгүй тул хөрөнгө оруулалтад тооцох боломжгүй. | Хэрэгжүүлсэн. Санхүүжилтээ Улсын төсвөөс буцаан авсан. |
| | НИЙТ ДҮН: | 630,841.30 | | |

Товч дүгнэвэл "Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төсөл"-ийн концессын зүйлийн төсөл арга хэмжээнээс 1 төсөл арга хэмжээ "Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр" ХК өөрийн хөрөнгөөр, 3 төсөл арга хэмжээ Улсын төсвөөс санхүүжилтээ авсан, 1 төсөл арга хэмжээ хэрэгжээгүй, 1 төсөл арга хэмжээ хангалтгүй хэрэгжсэн байна.

**7.3. "Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төсөл"-ийн үр дүнгийн талаар:**

7.3.1. Концесс эзэмшигч нь "Хуст уул, Төмөртолгой, Төмөртэй ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулж, жилдээ 3,0 сая тонн төмрийн хүдэр олборлох, жилд 1.5 сая тонноос доошгүй тонн төмрийн хүдрийн хуурай болон нойтон аргын баяжмал үйлдвэрлэх үйлдвэр" төслийн хүрээнд 2010-2019 онд нийт 152.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн гэж тайлагнасан боловч аль уурхайд хэдий хэмжээний тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт хийсэн нь тодорхой бус, "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн тайлан баланс, өмчид бүртгэлгүй, 2014 оноос хойш уурхайд хөрөнгө оруулалтаар авсан тоног төхөөрөмжөө "Кью Эс Си" ХХК-аас "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-д түрээсийн хэлбэрээр ашиглуулж байна.

7.3.2. Концесс эзэмшигч нь "Жилд 500.0 мянгаас доошгүй тонн хүчин чадал бүхий шууд ангижруулах төмрийн үйлдвэр" төслийн хүрээнд 2017 онд жилд 600 мянган/тонн хүдрийг шууд ангижруулах хүчин чадал бүхий төмрийн үйлдвэрийн техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулсан, үйлдвэрт концесс эзэмшигч хөрөнгө оруулалт хийж, хэрэгжүүлээгүй.

7.3.3. Концесс эзэмшигч нь "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн хүчин чадлыг жилийн 300.0 мянган тоннд хүргэх өргөтгөл, шинэчлэл хийх/Төмрийн хүдэр боловсруулж эцсийн бүтээгдэхүүн гаргах төсөл"-ийн хүрээнд 2017 онд "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК нь 26.8 тэрбум төгрөгийн өөрийн хөрөнгө оруулалтаар ган бөмбөлгийн давтах аргын үйлдвэрийн барилга, шаардлагатай

дэд бүтцийн хамт ашиглалтад оруулсан, бүтээгдэхүүн нь хэрэглэгчийн шаардлага хангахгүй байгаа тул 2019 оноос ажиллаагүй байна.

7.3.4. Концесс эзэмшигч нь "Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд орших Төмөртэйн ордоос Хандгайт өртөө чиглэлийн 33.4 км, 1520 мм царигтай төмөр зам, ачиж буулгах терминал төсөл"-ийн хүрээнд дээрх чиглэлийн 33.4 км төмөр зам, терминалыг 2015 онд ашиглалтад оруулж, 2016 онд концессын төрөлд өөрчлөлт оруулж, улсын төсвөөс 183.6 тэрбум төгрөгийг буцаан авсан нь төсвийн хөрөнгийг төлөвлөлтгүй, үр ашиггүй зарцуулах, төмөр зам ашигласны нэмэлт зардал гарах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

7.3.5. Концесс эзэмшигч нь "Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд орших Төмөртэйн ордоос Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумаас Улаанбаатар чиглэлийн олон улсын авто зам Дулаан хааны дөрвөн замын уулзвар хүртэл 95 км хүнд даацын хатуу хучилттай авто зам" төлийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Хүдэр сумаас Дулаанхааны 4 замын уулзвар чиглэлийн 95 км авто замыг гүйцэтгэж 2017 онд ашиглалтад оруулж, 2016 онд концессын төрөлд өөрчлөлт оруулж, улсын төсвөөс 57.2 тэрбум төгрөгийг буцаан авсан нь концессын зорилгод хамаарахгүйзүйлийг концессын гэрээнд тусгаж, төсвийн хөрөнгийг төлөвлөлтгүй, үр ашиггүй зарцуулах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

7.3.6. Концесс эзэмшигч нь "Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд Төмрийн хүдэр баяжуулах үйлдвэрийг цахилгаан эрчим хүчээр хангах "Төмөртэй" 110 кВ-ын дэд станц, 110 кВ-ын 50 км цахилгаан дамжуулах агаарын шугам барих төсөл"-ийн хүрээнд 2012 онд барьж, 2014 онд ашиглалтад оруулсан. "Уул Уурхай, металлургийн цогцолбор байгуулах төслийг хэрэгжүүлэх концессын гэрээ"-ний дагуу 2016 онд улсын төсвөөс 12.5 тэрбум төгрөгийг буцаан авсан болович тухайн хөрөнгийг төр, орон нутгийн эзэмшилд өнөөг хүртэл шилжүүлээгүй концесс эзэмшигчийн өмчлөлд байна.

Концессын зүйлийн хөрөнгө оруулалт, хэрэгжилтийн нөхцөл байдлаас үзэхэд концесс эзэмшигч "Кью Эс Си" ХХК нь харин төмрийн хүдэр боловсруулах, гангийн үйлдвэрлэл хөгжүүлэх, эцсийн бүтээгдэхүүн гаргах төсөлд ямар ч хөрөнгө оруулалт хийж, хэрэгжүүлээгүй, зөвхөн уул уурхайн салбар хүдэр баяжуулах үйлдвэрлэлд тоног төхөөрөмжийн хэлбэрээр хөрөнгө оруулалт хийж олборлосон түүхий эд, баяжуулсан баяжмалаа шууд экспортод гаргах бодлого баримталж ажилласан нь концессын гэрээ үр дүнгүй хэрэгжсэн гэж үзэхээр байна.

**7.4. Хөрөнгө оруулалтын талаар /89,567,293,568.61/:** ТӨХ-ны 2013 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн 471 дүгээр тогтоолоор Кью Эс Си ХХК-ийн хөрөнгө оруулалтыг 81,301,393,800.4 төгрөгөөр баталгаажуулж (ам.доллароор биш төгрөгөөр) хөрөнгө оруулалтыг хүлээн зөвшөөрсөн байна. ТӨХ-ны 2013 оны тогтоол гарснаас хойш нийт 8.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт нэмж хийснээр хүлээн зөвшөөрч 2022 оны 1 дүгээр улирлын санхүүгийн тайланд Хөрөнгө оруулалтыг 89,567,293,568.61 төгрөгөөр тусгасан болович холбогдох баримтаар баталгаажуулж тооцоо нийлсэн акт үйлдээгүй байна.

Иймд 2014 оны 4 сараас хойш хийгдсэн гэх 8,720,445,222.74 төгрөгийн хөрөнгө оруулалтын зардал баримтаар нотлогдохгүй байгаа тул хийгдсэн хөрөнгө оруулалтын жагсаалтыг гарган, хөрөнгө тус бүрээр нь тулган шалгаж баталгаажуулах шаардлагатай гэж үзэж байна.

**7.5. Хөрөнгө оруулалтын санхүүжилтийн талаар:** "Дархан төмөрлөгийн үйлдвэр" ХК болон "Кью Эс Си" ХХК-ийн хооронд 2010 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр байгуулагдсан "Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төсөл"-ийг хэрэгжүүлэхэд хөрөнгө оруулагчаас 48.0 сая.ам доллароос доошгүй хэмжээний санхүүжилт хийхээр, 2011 оны 12 дугаар сарын 23-ны өдөр





байгуулсан "Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төсөл"-ийн хүрээнд шаардлагатай "Дэд бүтэц байгуулах төсөл"-ийг хамтран хэрэгжүүлэхэд төсөл хэрэгжүүлэгчээс 49.0 сая.ам.доллараас доошгүй хэмжээний санхүүжилт хийхээр тохиролцсон.

Энэхүү төслийг хэрэгжүүлэх концессын гэрээний ашиглалт, төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн /630.8 тэрбум төгрөг/ тайланг холбогдох байгууллагад хүргүүлж тайлагнасан байна.

Концессийн гэрээний 2.1.1-2.1.5 дахь заалтыг "Шинэчлэн сайжруулах-барих-ашиглах-шилжүүлэх, 2.1.6 дахь заалтыг "Барих-шилжүүлэх" төрлөөр хэрэгжүүлэхээр гэрээ байгуулсан хэдий ч 2.1.4- 2.1.5 дахь заалт "Барих-шилжүүлэх" төрөл болж өөрчлөгдсөн.

Төслийн хүрээнд хийгдсэн концессын зүйлүүдийн хэрэгжилтийг бүлэглэн товч авч үзлээ.

***Концессийн гэрээний "Шинэчлэн сайжруулах-барих-ашиглах-шилжүүлэх төрлийн хүрээнд:***

2.1.1. Хуст уул, Төмөртолгой, Төмөртэй ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулж, жилдээ 3,0 сая тонн төмрийн хүдэр олборлох, жилд 1.5 сая тонноос доошгүй тонн төмрийн хүдрийн хуурай болон нойтон аргын баяжмал үйлдвэрлэх үйлдвэр байгуулах;

Энэхүү төслийн хүрээнд концесс эзэмшигч жилд 150 тн/цаг, 250 тн/ц, 750 тн/ц хүдэр боловсруулах хүчин чадал бүхий хуурай соронзон баяжуулах үйлдвэр болон төмрийн хүдрийг угаах аргаар баяжуулж шаврын агуулгыг бууруулж баяжмал дахь төмрийн агуулга өсгөх замаар баяжуулалт хийдэг угаах шугамын үйлдвэрийг ашиглалтад оруулснаар тайлагнасан байна.

"Дархан төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн дүнгээр компанийн машин тоног төхөөрөмж дансанд 4 ширхэг баяжуулах үйлдвэр бүртгэлтэй байна.

/Баяжуулах үйлдвэрүүдийн мэдээлэл/

| Баяжуулах үйлдвэрийн нэр | Үйлдвэрүүдийн балансын үнэ /сая.төг/ 2021.12.31 | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Хөрөнгийн нэр | Бүртгэсэн огноо | Анхны өртөг | Балансын үнэ | Балансын элэгдэл | Хөрөнгийн тоо |
| Төмөртолгой уурхай жилд цагт 150 тн\цаг хүдэр боловсруулах хүчин чадал бүхий хуурай аргын соронзон баяжуулах үйлдвэр | үйлдвэрийн тоног/төх | 2010.10.01 | 1,354.36 | 1,542.78 | 1,542.78 | 1 |
| | эрчим хүчний тоног/төх | 2017/12/31 | 16.95 | 16.95 | 6.78 | 2 |
| ДҮН /Хуурай соронзон баяжуулах үйлдвэр -1/ | | | 1,371.31 | 1,559.73 | 1,549.56 | 3 |
| Төмөртолгой уурхай жилд цагт 250 тн\цаг хүдэр боловсруулах хүчин чадал бүхий хуурай аргын соронзон баяжуулах үйлдвэр | үйлдвэрийн тоног/төх | 2015/11/03 | 1,730.79 | 1,798.29 | 1,111.40 | 13 |
| | эрчим хүчний тоног/төх | 2021/09/01 | 409.01 | 409.01 | 13.61 | 4 |
| ДҮН /Хуурай соронзон баяжуулах үйлдвэр -2/ | | | 2,139.80 | 2,207.30 | 1,125.01 | 17 |
| Төмөртэйн уурхайд 750 тн\ц хүдэр боловсруулах хүчин чадал бүхий АНУ-ын TROI,EREIZ брэндийн хуурай соронзон аргаар баяжуулах үйлдвэр | үйлдвэр | 2014/07/01 | 10,850.10 | 11,963.81 | 8,916.20 | 1 |
| | үйлдвэрийн тоног/төх | 2019/12/01 | 6,690.15 | 6,891.37 | 1,473.89 | 34 |
| | эрчим хүчний тоног/төх | 2019/12/01 | 625.71 | 625.71 | 211.06 | 4 |
| ДҮН /Хуурай соронзон баяжуулах үйлдвэр-3/ | | | 18,165.96 | 19,480.89 | 10,601.15 | 39 |
| Дарханы төмөрлөгийн үйлдвэрийн гангийн үйлдвэрийн дэргэд жилийн 1 сая тн боловсруулах хүчин чадалтай Нойтон баяжуулах үйлдвэр | үйлдвэрийн тоног/төх | 2014/03/25 - 2021/12/31 | 6,184.22 | 7,392.62 | 1,738.33 | 58 |
| | эрчим хүчний тоног/төх | 2021/10/01 | 1,322.22 | 1,322.22 | 338.89 | 2 |
| | Хаягдлын далан тоног/төх | 2015/02/01 | 3,166.52 | 3,171.20 | 1,194.42 | 1 |
| ДҮН /Нойтон баяжуулах үйлдвэр/ | | | 10,672.97 | 11,886.04 | 3,271.64 | 61 |
| Төмөртэйн уурхайд Угаах шугамын хөрөнгө оруулалт /CDE/ | Тоног төхөөрөмж | 2020/08/31 | 2,511.94 | 2,705.51 | 344.39 | 6 |
| ДҮН Угаах шугам | | | 2,511.94 | 2,705.51 | 344.39 | 6 |
| НИЙТ ДҮН | | | 34,861.97 | 37,838.46 | 16,891.76 | 126.00 |

Баяжуулах үйлдвэрүүдийн 2010-2020 онуудад 37,839.5 сая төгрөгийн балансын үнэтэй 126 ширхэг тоног төхөөрөмж бүртгэлтэй байна.

Эдгээр үйлдвэрүүдийн талаар хөрөнгө оруулалтын эх үүсвэр, ашиглалтын байдлын талаар товч танилцуулбал:

1. Төмөртолгой уурхайн 150 тн/цаг хүчин чадалтай баяжуулах шугамын тоног төхөөрөмжийг 2010 оны 10-р сарын 27-ний өдрийн А/175 тоот тушаалаар НӨАТ-ын дүнг хасаж 1,354.3 төгрөгөөр үндсэн хөрөнгөд бүртгэж авсан байна. Концесс эзэмшигчийн тайланд 2,332.8 сая төгрөгөөр тусгасан хэдий ч санхүүжилт хийсэн хөрөнгө оруулалтын гүйлгээ хийгдээгүй байна. Иймд хөрөнгө оруулалтын тайлангийн дүнгээс хасагдаж байна. "Дархан төмөрлөгийн үйлдвэр" ХК нь өөрийн хөрөнгийн эх үүсвэрээр худалдан авсан баримт гаргаж өгсөн/

Тус үйлдвэр 2015 оны төмрийн хүдрийн үнийн уналтаас шалтгаалж уурхай зогссонтой холбогдуулан хадгалалтын горимд орсноос хойш огт ажиллаагүй хэдий ч үндсэн хөрөнгөд элэгдэж тооцож ирсэн бүртгэлтэй байна.

2. Төмөртолгой уурхайн 250 тн/цаг хүчин чадалтай баяжуулах шугамын тоног төхөөрөмжийг "Кью Эс Си" ХХК-ийн хөрөнгө оруулалтаар 2010 оны 12-р сарын 30-ны №033 тоот худалдах, худалдан авах 3 талт /ДТҮ, Ти И Эн, Кью Эс Си/ гэрээний дагуу 1.800.000$ + 2011 оны 10-р сарын 25-ны XX-2011-297 тоот гурвалсан гэрээний дагуу нэмэлт тоног төхөөрөмж 480.000$-аар худалдан авч үндсэн хөрөнгөд 2207.3 сая төгрөгөөр бүртгэлтэй байна. Концесс эзэмшигчийн тайланд 4,147.2 сая төгрөгөөр тусгасан байна.

Уг баяжуулах үйлдвэр 2011 оноос ашиглаж байгаад, 2015 онд тоног төхөөхөмжийг дахин үнэлж салган 1,730.8 тэрбум төгрөгөөр үндсэн хөрөнгөд бүртгэсэн бөгөөд 2015 оны төмрийн хүдрийн үнийн уналтаас шалтгаалж уурхай зогссонтой холбогдуулан хадгалалтын горимд орсноос хойш огт ажиллаагүй байна.

Компаниас гаргаж өгсөн мэдээллээр баяжуулах 1, 2 үйлдвэр 2010-2014 онуудад нийтдээ 2.9 сая тонн баяжмал үйлдвэрлээд өнөөдрийг хүртэл ажиллаагүй байна.

/Баяжуулах 1, 2 үйлдвэрийн үйлдвэрлэлийн хэмжээ/

| Огноо | | хүдэр боловсруулалт /тн/ | бүхэл баяжмал /тн/ | нунтаг баяжмал /тн/ | Нийт баяжмал /тн/ |
|---|---|---|---|---|---|
| Төмөртолгой | 2010 | 252,359.00 | 47,805.00 | 80,322.90 | 128,127.90 |
| | 2011 | 978,715.00 | 271,651.95 | 203,081.96 | 474,733.91 |
| | 2012 | 1,091,270.00 | 389,838.07 | 259,572.63 | 649,410.70 |
| | 2013 | 1,237,701.39 | 455,630.63 | 389,142.53 | 844,773.16 |
| | 2014 | 1,233,263.00 | 519,708.48 | 296,914.47 | 816,622.95 |
| НИЙТ | | 4,793,308.39 | 1,684,634.13 | 1,229,034.49 | 2,913,668.62 |

3. Төмөртэй уурхайн хуурай соронзон баяжуулах үйлдвэрийн үндсэн тоног төхөөрөмж нь АНУ-ын ТРИО брэндийн тоног төхөөрөмж, соронзон ангилагчууд нь Эрэйз Магнетикс-ын сепараторууд бөгөөд "Кью Эс Си" ХХК-ийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэн 10,850.1 сая төгрөгөөр 2014 онд үндсэн хөрөнгөд бүртгэсэн байна.

Баяжмалын төмрийн агуулга, гарцыг нэмэгдүүлэх зорилгоор БНХАУ-ын SANME брэндийн 29 нэр төрлийн 6,865,430,307.37 төгрөгийн тоног төхөөрөмжөөр 2019 онд өргөтгөсөн нь хүдрийн чийгтэй байдлаас шалтгаалж үр дүнд хүрээгүй тул өргөтгөлөөр суурилуулсан тоног төхөөрөмжийг цаашид ашиглах шаардлагагүй болж байна. */Баяжуулах үйлдвэрийн хэлтсээс өгсөн тайлбар/*

4. Нойтон соронзон баяжуулах үйлдвэрийн угсралтын ажлыг 2012 онд эхлүүлж 2014 оны 12 сард ашиглалтанд орсон. Анхны хүчин чадал нь 1 сая.тн/жил боловсруулах хүчин чадалтайгаар баригдсан. Нойтон соронзон баяжуулах үйлдвэрийн дэргэд 565мян.м3 багтаамжтай геомембран





доторлогоотой хаягдлын даланг мөн адил 2014 онд ашиглалтанд оруулсан. "Кью Эс Си" ХХК-ийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэсэн тоног төхөөрөмж нь 11,886.04 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгөд бүртгэлтэй байна Концесс эзэмшигчийн тайланд 11,611.2 сая төгрөгөөр тусгасан байна.

Дэлхийн зах зээл дээрх төмрийн хүдрийн үнийн уналтаас шалтгаалсан Төмөртолгойн уурхайн 2015-2017 он хүртэлх зогсолт, соронзон сепаратор мушгиа ангилагч зэрэг тоног төхөөрөмжийн хүчин чадлын зөрүү, баяжмалын чанараас үүдэн технологийн өөрчлөлт хийх шаардлага үүссэн зэргээс хамаарч 2017-2019 он хүртэл нийт 5 жилийн хугацаанд ашиглалтгүй зогссон байна.

Шаардлагатай туршилт судалгаа технологийн өөрчлөлтийг 2019 онд "Соёолон Интернэшнл" ХХК-тай хамтран хэрэгжүүлж ашиглаж эхэлсэн. 2019-2021 оны хугацаанд өвлийн улирал далангийн хөлдөлт, тэжээлийн дутагдал зэргээс хамаарч ажиллахгүй зогсож ирсэн бөгөөд дулааны улирал ажилласан ба 387.8 мян.тн нунтаг завсрын бүтээгдэхүүнийг боловсруулж 270.4 мян.тн нойтон баяжмал үйлдвэрлэсэн байна.

Анхны тоног төхөөрмжүүдээс 907.5 сая төгрөгийн мушгиа ангилуур болон соронзон сепараторуудыг ашиглаглахгүй тул сэлбэг материал руу, 1,046.9 сая төгрөгийг ашиглалтанд ороогүй үндсэн хөрөнгөд аудитын залруулгаар 2019 онд шилжүүлсэн байна.

/Нойтон баяжуулах үйлдвэрийн зардал/

| Зардлын төрөл | Хэмжих нэгж | 2019-2021 | | | 2022.01-04 сар | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Зогсон хугацааны зардал | Ажилласан хугацааны зардал | Тайлбар | Зардлын дүн | Тайлбар |
| Түүхий эд материал | төг | - | 11,278,478,782 | Нунтаг завсрын баяжмал | | |
| Цалингийн зардал, НДШ | төг | 483,366,624 | 2,245,958,096 | | 161,899,393 | |
| Хөдөлмөр хамгаалалын зардал | төг | 37,049,634 | 104,788,509 | | 3,698,741 | |
| Засвар үйлчилгээний зардал | төг | 745,219,104 | 1,628,482,690 | Зогссон хугацаанд засвар үйлчилгээ хийгддэг | 712,803,522 | Үйлдвэрийн тоног төхөөрөмжүүдийн суурын гайк боолт 2020 оноос муудаж засварлаж |
| Шатах тослох мариалын зардал | төг | 27,350,962 | 240,425,086 | | 18,611,270 | жиллуулж |
| Цахилгааны зардал | төг | 46,187,333 | 1,670,021,301 | | 11,842,206 | байгаад 2022 оны |
| Элэгдлийн зардал | төг | 1,258,446,679 | 2,483,935,263 | | 545,393,980 | 1- сараас бүрэн |
| Түрээсийн зардал | төг | 44,000,000 | 169,778,620 | QSC автоачигч | 30,800,000 | буулгаж засварлах |
| Тээврийн зардал | төг | 6,714,523 | 1,873,347,783 | ТЭМ тээвэрлэлт | | шаардлага гарсан |
| Татвар хураамж | төг | 78,105,289 | 49,422,103 | | 1,151,872 | тул 2022 оны 1-р |
| Дулааны зардал | төг | 24,055,154 | 37,208,930 | | 41,129,594 | сараас өдийг |
| Усны зардал | төг | 56,461,746 | 319,871,519 | | 5,351,818 | хүртэл үйлдвэр |
| Бичиг хэргийн зардал | төг | 774,330 | 2,256,461 | | 505,263 | зогссон. |
| Шинжилгээний зардал | төг | 390,090 | 236,268,242 | | | |
| Сургалтын зардал | төг | - | 4,000,000 | | | |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал | төг | 27,712,582 | 138,582,255 | | 48,400 | |
| Бусад зардал | төг | 46,246,434 | 184,676,289 | Хоол, ахуун тохижилт, шуудан холбоо | 15,395,506 | |
| НИЙТ | төг | 2,882,080,486 | 22,667,501,930 | | 1,548,831,556 | |

Тус үйлдвэр 2019-2021 оны хугацаанд сул зогсох үедээ 2,882.0 тэрбум, ажилласан хугацаанд 22,667.5 сая төгрөгийн зардал гаргаж ажиллаж байна.

"Кью Эс Си" ХХК-ийн тайланад Төмөртолгой уурхай жилд цагт 500 тн\цаг хүдэр боловсруулах хүчин чадал бүхий хуурай аргын соронзон баяжуулах үйлдвэрийг 6,160.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалт оруулсан гэж тайлагнасан

хэдий ч уг үйлдвэрийг "Дархан төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн үндсэн хөрөнгөд бүртгэзгүй түрээслүүлэн ашиглуулж түрээсийн орлого олж ажиллан концессийн гэрээний үүргийг зөрчсөн байна.

Мөн нойтон баяжуулах үйлдвэртэй холбогдон дархан терминалийн 3,771.2 сая төгрөгийн хөрөнгийг 2015 онд дуусаагүй барилга данснаас шилжүүлэн үндсэн хөрөнгөд бүртгэж хөрөнгө оруулалтын өглөгийн дүнг нэмэгдүүлсэн.

**2.1.2.** Шууд ангижруулсан төмрийн үйлдвэр байгуулах төсөл хэрэгжээгүй байна. Талбайн инженер геологийн судалгааны ажлыг хийж, үйлдвэрийн ТЭЗҮ боловсруулах ажлыг хийсэн.

**2.1.3.** Дархан төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн хүчин чадлыг жилийн 300 мянган тоннд хүргэх өргөтгөлш шинэчлэл хийх;

Энэ төслийг "Кью Эс Си" ХХК-ийн **менежмент дор** 2014-2019 онд гангийн үйлдвэрт дараах төслүүдийг "Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр" ХК-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн байна. Үүнд:

1. Ган бөмбөлгийн давтах аргын үйлдвэр байгуулах төсөл
2. Төвийн төвлөрсөн дулааны шугамд холбогдох төсөл
3. Пресс хайч суурилуулах төсөл
4. Шанаган зуух суурилуулах төсөл
5. Усан хөргөлтийн цамхаг суурилуулах төсөл
6. Цахилгаан соронзон холигч, хэлбэлзүүлэгч ширээ суурилуулах төсөл
7. Дахин халаах зуухыг дизель түлшинд шилжүүлэх төсөл
8. Шреддерийн тоног төхөөрөмж суурилуулах

Эдгээр төслүүдээс ган бөмбөлгийн төсөл болон Шреддерийн төсөлд зарим асуудал үүссэн байна. Тухайлбал:

-Шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, дотоодын зах зээлийг хангах зорилгоор 25 000 тн/жил хүчин чадал бүхий Ганбөөренцөг үйлдвэрлэх цех 2017 оны 1-р сарын 28-ны өдөр ашиглалтанд оруулсан. Үйлдвэр ашиглалтанд орсон хэдийч компанийн үйлдвэрлэсэн бэлдэцээс чанарын шаардлага хангасан ган бөөренцөг үйлдвэрлэж чадаагүй зогсонги байдалтай байна. Үйлдвэрлэлт явагдахгүй байгаатай холбогдуулан элэгдлийн зардал сар бүр 137 370 912 төгрөг гарч жилд 1,6 тэр бум төгрөг сул зогсолтын зардлаар бүртгэгдэж ашгийн үзүүлэлтийг бууруулж байна.

-Вагон тээврийн даац ашиглалтыг нэмэгдүүлж тээврийн зардлыг бууруулах, хаягдал төмөр боловсруулалтын өртөг зардлыг бууруулах зорилгоор төсөл хэрэгжүүлсэн шреддер 2021 оны 7-р сараас эхлэн боловсруулалт хийж эхэлсэн боловч технологийн үйл ажиллагаанаас шалтгаалан бүтээл бага, үйл ажиллагаа доголдолтой байна.

Шреддерт орох нөөц төмөр бэлдэх талбай байхгүй, ачилт хийх базагч 15-20 минут ажиллаад мотор халж 5-15 минут хөргөлт хийж зогсдог, эвдрэл гарч байгаа нь ажлын цагийн 50%-д сул зогсож байна. Шреддерт 1 удаа орсон төмөр урт, овор ихтэй гарч дахин ачаалалт хийх зэрэг шалтгаануудаас ажлын бүтээл маш бага гарч байна. Гүйцэтгэлийн хувь:

| Д/д | Үзүүлэлтүүд | Төслөөр | Гүйцэтгэл | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|
| 1 | Вагоны даац ашиглалт /тн/ | 65 | 27 | 41% |
| 2 | Цагийн бүтээл /тн/ | 15 | 5.9 | 39% |
| 3 | Бүтээлтэй хугацаа /цаг/ | 6 | 3.78 | 63% |





Концессын гэрээний "Барих-шилжүүлэх" төрлийн хүрээнд: **2.1.4, 2.1.5, 2.1.6.** Дэд бүтцийн төслийн хүрээнд дор дурдсан концессыг хэрэгжүүлсэн байна.

/Барих-шилжүүлэх төрлөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээ, сая төгрөгөөр/

| Д/д | "Кью Эс Си" ХХК-иас хийсэн хөрөнгө оруулалтын нэр | Концессын аль зүйлд хамаарах эсэх | Хүчин чадал | Ашиглалтад хүлээж авсан актын огноо, дугаар | Хөрөнгө оруулагчийн тайлагнасан дүн /сая төг | "Кью Эс Си" ХХК-д Улсын төсвөөс олгосон дүн /сая.төг/ |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Сэлэнгэ аймгийн Ерөө сумаас Хүдэр сумын Төмөртэйн уурхай хүртлэх 110 кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугам\50 км\ өргөтгөл, дэд станц бүхий төсөл | 2.1.6 Цахилгаан | 110 кВт, 50 км | 2014.03.17 №11/2014 | 12,576.20 | 12,576.20 |
| 2 | Сэлэнгэ аймгаар дамжин өнгөрөх олон улсын авто замтай холбох 95 км авто замын төсөл | 2.1.5 Авто зам | 95 км хатуу хучилттай авто зам | 2016.07.06 №07/07/16, 2017.07.31 №07/10/17, 2017.12.19 №07/17/17 | 95,272.20 | 57,163.30 |
| 3 | Төмөртэйн ордоос Хандгайт өртөө\Сэлэнгэ аймгийн Хүдэр сум\ чиглэлийн 1520 мм царигтай төмөр зам, өртөө, ачиж буулгах терминал бүхий төсөл | 2.1.4 Төмөр зам | Жилд 7-8 сая тонн ачаа тээвэрлэх | 2015.12.28 №02/18/15 | 212,788.30 | 183,608.60. |
| | ДҮН | | | | 320,636.70 | 253,348.10 |

Хөрөнгө оруулагч дээрх хүснэгтэд дурдсан төслийг хэрэгжүүлж барилга байгууламжийг улсын комиссын актаар ашиглалтад хүлээн авсан байна.

Төслийн хэрэгжилтийн явцад Эдийн засгийн хөгжлийн яам /хуучин нэрээр/ болон "Кью Эс Си" ХХК нь 2014 онд Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төслийг концессын "Шинэчлэн сайжруулах-барих-ашиглах-шилжүүлэх" төрлөөр байгуулсан боловч Засгийн газрын 2015 оны 9 дүгээр сарын 07-ны өдрийн 364 дүгээр тогтоолоор "Барих-шилжүүлэх" гэж өөрчлөн концессын гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд орших Төмөртэйн ордоос Хандгайт өртөө чиглэлийн 33.4 км, 1520 мм царигтай төмөр зам, ачиж буулгах терминал төслийн эргэн төлөлтөд 2016 онд 183.6 тэрбум төгрөг, Сэлэнгэ аймгаар дамжин өнгөрөх олон улсын автозамтай холбох 95 км-ын автозамын ажлын санхүүжилтэд 57.1 тэрбум төгрөг, Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд Төмрийн хүдэр баяжуулах үйлдвэрийг цахилгаан эрчим хүчээр хангах "Төмөртэй" 110 кВ-ын дэд станц, 110 кВ-ын 50 км цахилгаан дамжуулах агаарын шугам барихад 12.6 тэрбум төгрөг нийт 253.4 тэрбум төгрөгийг улсын төсвөөс олгосон бөгөөд эдгээр төслийн хөрөнгө төрийн өмчлөлд бүртгэлгүй байна.

Засгийн газрын 2018 оны 1 дүгээр сарын 04-ний өдрийн 06 дугаар тогтоолоор дээрх төмөр зам болон авто замыг барих төслийн концессын "барих-шилжүүлэх" төрлөөр байгуулсан нэмэлт гэрээг цуцлахыг Үндэсний хөгжлийн газарт даалгаж, улсын төсвөөс олгосон хөрөнгийг Улсын төсөвт буцаан төвлөрүүлэхийг Сангийн сайд, Зам тээвэр хөгжлийн сайд, Үндэсний хөгжлийн газарт тус тус даалгаж, Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоолын хавсралтаар баталсан барих шилжүүлэх төрлийг хүчингүй болгосон байна.

Төмөр зам, ачиж буулгах терминалын хөрөнгө оруулалтын санхүүжилтийг Зам, тээвэр хөгжлийн яамны хөрөнгө оруулалтын дансаар дамжуулан гаргаж бусад эргэлтийн хөрөнгө дансанд "Төмөртэйн ордоос Хандгайт өртөө хүртэл тавигдсан" гэх нэртэйгээр 183,608,605,200 төгрөгөөр тайлагнасан бөгөөд Сангийн яамны 2018.03.29-ний өдрийн 12/-1/1593 бичгээр концессийн гэрээний"барих-шилжүүлэх" нөхцлийг хүчингүй болгосонтой холбогдуулан бий болсон хөрөнгийг аль байгууллага хүлээн авч бүртгэх нь тодорхойгүй тул журмын дагуу төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд хэвээр үлдээж УСНББОУС-14 буюу "Тайлагналын үеийн дараах үйл явдал" стандартын дагуу тайландаа тусгах явах шаардлагатайг зөвлөсөн байна.

**Хөрөнгө оруулалтын санхүүжилтийн өглөгийн талаар:** "Кьюү Эс Си" ХХК өөрийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн тооцоог дараах байдлаар тайлагнаж "Дархан төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн хөрөнгө оруулалтын өглөгт тусгаж тооцоо нийлсэн акт үйлдсэн байна.

/Хөрөнгө оруулалтын зардлын товчоо, төгрөг, ам доллар/

| ОН | Хөрөнгө оруулалтын дүн 2012.12.31-ны байдлаар | | | |
|---|---|---|---|---|
| | гэрээний дүн | | төлбөр хийсэн дүн | |
| | доллар | төгрөг | доллар | төгрөг |
| 2010 | 7,976,364.00 | 2,347,833,178.00 | 7,017,075.40 | 3,688,002,950.50 |
| 2011 | 25,256,978.00 | 15,414,140,069.00 | 33,388,478.00 | 7,284,715,028.00 |
| | Машин ТТ-ийн гааль, НӨТ-ын санхүүжилт | | | 248,275,000.00 |
| | Тээврийн зардлын санхүүжилт | | 10,120.00 | |
| 2012 | 2,944,125.89 | 26,804,649,275.00 | 6,365,000.00 | 8,015,477,400.00 |
| | Хүдэр сумын Сум хөгжүүлэх сан ЗДТГ | 30,000,000.00 | 100,000.00 | 30,100,000.00 |
| ДҮН | 36,177,467.89 | 44,596,622,522.00 | 46,880,673.40 | 19,266,570,378.50 |
| Хөрөнгө оруулалтын дүн | | | 80,244,134,213.25 | |
| Хөрөнгө оруулагчийн гаргасан зардал | | | 1,057,259,581.15 | |

"Дархан төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн 2012 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангын аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн "Би Энд Си аудит" ХХК-ийн дүгнэлтээр 2010.10.01-ний өдрөөс 2012.12.31-ний өдрийн хооронд хөрөнгө оруулагч 81,275.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийснийг урт хугацаат өглөгөөр бүртгэснийг баталгаажуулсан байна.

"Дархан төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн хөрөнгө оруулалтын 81,275.9 сая төгрөгийн өглөгийг Төрийн өмчийн хороо /хуучин нэрээр/-ны 2013 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 471 дүгээр тогтоолоор хүлээн зөвшөөрчээ.

Компанийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд бүртгэлтэй 90,021.8 сая төгрөгийн урт хугацаат өглөгийн задаргаа тодорхойгүй байлаа. Хөрөнгө оруулалтын санхүүжилтийн 98 орчим хувь нь 2010-2014 онуудад хийгдсэн бөгөөд ажлын хэсэг 2014-2021 оны санхүүгийн үйл ажиллагааг шалгах удирдамжтай тул тухайн хугацааны хөрөнгө оруулалтын санхүүжилтийн зарцуулалтын үр дүнг шалгах боломжгүй байлаа.

Тиймээ хөрөнгө оруулалтын гэрээний бүртгэлээрх болон хөрөнгө оруулалтын өглөгийн гүйлгээний дүнгээрх хөрөнгө оруулалтын санхүүжилтийн задаргааний түүврийг "Дархан төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн санхүүгийн албанаас гаргуулж, тулгах байдлаар ажилласан дүнг тайланд товчлон танилцуулж байна.





/Хөрөнгө оруулалтын өглөгийн 2012-2016 оны гүйлгээ, мян.төг,ам.доллар/

| Он | Хөрөнгө оруулалтын өглөг | | | |
|---|---|---|---|---|
| | Дебет | | Кредит | |
| | төгрөг | доллар | төгрөг | доллар |
| 2010 | - | - | 10,901,004.60 | 7,654.80 |
| 2011 | 1,611,814.40 | 750.2 | 54,122,805.40 | 33,511.10 |
| 2012 | - | - | 17,864,053.50 | 6,815.00 |
| 2013 | - | - | 6,286,902.00 | 1,310.50 |
| 2014 | - | - | 7,361,957.50 | 55.7 |
| 2015 | 13,151,628.80 | - | 7,794,013.80 | 806.1 |
| 2020 | - | - | 454,545.50 | - |
| Нийт дүн | 14,763,443.20 | 750.2 | 104,785,282.20 | 50,153.20 |
| Буцаалтын дүн | | | -14,763,443.20 | -750.2 |
| Хөрөнгө оруулалтын өглөгийн цэвэр дүн | | | 90,021,839.00 | 49,403.00 |

Хүснэгтээс харахад 104,785.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын өглөг үүсч 14,763.4 сая төгрөгийн буцаалт хийгдэж 2020 оны жилийн эцсийн байдлаар 49,4 сая доллар буюу 90,021.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

"Кьюү Эс Си" ХХК-ийн хөрөнгө оруулалт нь мөнгөн хөрөнгөөр, худалдан авсан хөрөнгөөр хийгдсэнээс гадна хөрөнгө оруулагчийн болон бусд зардал хэлбэрээр гарч тооцоо хийгдсэн байна.

/Хөрөнгө оруулалтын санхүүжилтийн хэлбэр, мян.төг,ам.доллар/

| Тайлант он | Санхүүжилтийн төрөл | | | | Нийт дүн | |
|---|---|---|---|---|---|---|
| | мөнгөөр | | хөрөнгөөр | зардал | | |
| | төгрөг | доллар | төгрөг | төгрөг | төгрөг | доллар |
| 2010 | 199,233.20 | 6,904.60 | 973,063.60 | 105,197.30 | 1,277,494.10 | 6,904.60 |
| 2011 | 7,172,695.00 | 33,511.10 | 2,559,411.30 | 363,452.70 | 10,095,559.00 | 33,511.10 |
| 2012 | 8,405,597.40 | 6,815.00 | - | 219,111.70 | 8,624,709.10 | 6,815.00 |
| 2013 | 4,013,988.50 | 1,310.50 | 211,151.90 | 21,600.00 | 4,246,740.40 | 1,310.50 |
| 2014 | 1,393,542.50 | 910.5 | 4,029,003.50 | 212,189.50 | 5,634,735.40 | 910.5 |
| 2015 | 2,338,271.60 | 219.5 | 4,880,313.40 | - | 7,218,585.00 | 219.5 |
| | - | - | 454,545.50 | - | 454,545.50 | - |
| Нийт дүн | 23,523,328.20 | 49,671.20 | 13,107,489.10 | 921,551.10 | 37,552,368.40 | 49,671.20 |

Хөрөнгө оруулагчаас 23,523.3 сая төгрөг , 49.6 сая долларыг мөнгөн хэлбэрээр санхүүжүүлж, хөрөнгө хэлбэрээр 13,107.5 сая төгрөг /28% нь тээврийн хэрэгсэл, 68% нь тоног төхөөрөмж, 4% нь ТЭЗҮ, байгаль орчны үнэлгээ/-ийн хөрөнгө оруулалт хийсэн бол зардалд 921.5 сая төгрөгийг санхүүжүүлж хөрөнгө оруулалтын өглөгт тусгасан байна.

Санхүүжилтийн нийт 49.67 сая ам.долларын дүн нь хөрөнгө оруулалтын өглөгийн үлдэгдэл 49.4 сая долларын дүнгээс 0.27 мянган ам.доллараар зөрүүтэй байгаа нь доллараар санхүүжилт хийсэн ч худалдан авалтын төлбөрийг төгрөгөөр хийсэн, төгрөгөөр хийсэн ч доллараар хийсэн зэргэтэй холбоотой нэг талдаа нэмэгдэж нөгөө талдаа хасагдсан дүнгээр зөрүүтэй харагдаж байгаа болно.

"Кьюү Эс Си ХХК"-ийн хөрөнгө оруулалтыг урт хугацаат өр төлбөрт бүртгэснийг компанийн 2012 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд "Би Энд Си Аудит" ХХК, 2013-2015 онуудын жилийн эцсийн санхүүгийн тайланд "Нью Проспект Аудит" ХХК-ийн хийсэн аудитын дүгнэлтээр тус тус баталгаажуулсан байна.

/Хөрөнгө оруулалтын аудитлагдсан дүн, мян.төг/

| Үзүүлэлт | 2012.12.31 | 2013.12.31 | 2014.12.31 | 2014.12.31 /шинээр тайлагнасан/ | 2015.12.31 |
|---|---|---|---|---|---|
| Хөрөнгө оруулалтын өглөг /төгрөг/ | 20,140,928 | 24,049,767 | 31,312,423 | 18,736,223 | 24,724,811 |
| Хөрөнгө оруулалтын өглөг /ам.доллар/ | 61,160,466 | 63,513,184 | 63,612,486 | 63,612,486 | 65,297,028 |
| ДҮН | 81,301,394 | 87,562,951 | 94,924,909 | 82,348,709 | 90,021,839 |

Аудитын залруулгаар хөрөнгө оруулагчийн 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангын үлдэгдлээрх 94,924,909.0 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтын өглөгийн дүн 82.348,709.0 мянган төгрөг болгож шинээр тайлагнасан нь ЭЗИТБТТайланд 12,576.2 сая төгрөгийн Төмөртэйн дэд станц, 110 квВ-ын агаарын шугамын хөрөнгийг хасч тайлагнасан дүнгээр бууруулсантай холбоотой байна.

Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020.12.31-ний өдрийн 20/23 дугаар тогтоолын дагуу "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн ерөнхий захирлын 2020.12.31-ний өдрийн тушаалаар хөрөнгө оруулалтын гэрээний дагуу хийгдсэн санхүүжилт болох урт хугацаат өглөг 49,403,008.94 ам. долларт 2020.12.31-ний өдрийн ханшаар ханшийн тэгшитгэл хийж тооцоо нийлэхийг зөвшөөрсөн байна.

Мөн 2020.12.31-ний өдөр 165,449.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг мөнгөөр буцаан барагдуулах талаарх QSC 20/23 дугаартай "Хөрөнгө оруулалтын санхүүжилтийг барагдуулах гэрээ"-г нэг талаас хөрөнгө оруулагч компанийн гүйцэтгэх захирал Э.Шижир, ерөнхий нягтлан бодогч Д.Энхтунгалаг нар, нөгөө талаас тус компанийн ерөнхий захирал М.Отгонбаяр, санхүү эдийн засаг хариуцсан дэд захирал Ч.Очирхам, ерөнхий нягтлан С.Сарантуяа, ахлах хуульч Б.Цогтбаяр нар гарын үсэг зурж тэмдэгээр баталгаажуулан байгуулжээ.

Дээрх шийдвэрийн дагуу 2020.12.31-ний өдрөөр ам.доллараар илэрхийлсэн хөрөнгө оруулалтын өглөгийн дүнд ханшийн тэгшитгэл хийж, үр дүнг хамаарах тайлант жилүүдийн ашиг, алдагдалд хуваарилсан байна.

"Кьюо Эс Си" ХХК 2010-2012 онд хийсэн өөрийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн тооцооны тайлан гаргаж "Дархан төмөрлөгийн үйлдвэр" ХК тооцоо нийлж акт үйлдсэн, мөн "Кью Эс Си ХХК", Төрийн өмчийн хороо /хуучин нэрээр/-ны 2013 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 471 дүгээр тогтоолоор "Кью Эс Си ХХК"-ийн хөрөнгө оруулалтын өглөгийг 81,275.9 сая төгрөгөөр тооцож хүлээн зөвшөөрч баталгаажуулсан атал "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК нь 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд ханшийн тэгшитгэлийн 75,477.3 сая төгрөгийг тусгаж хөрөнгө оруулалтын өглөгийг 165,499.2 сая төгрөгөөр тайлагнасан шийдвэр нь хүчин төгөлдөр бус байна.

Иймд хөрөнгө оруулалтын өглөгийн дүнгээс 2022 оны санхүүгийн тайланд ханшийн тэгшитгэлийг хасаж залруулах арга хэмжээ авах шаардлагатай.

## НАЙМ. МӨНГӨН ХӨРӨНГӨ ХАРИЛЦАХ ДАНСДЫН ТАЛААР

"Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК нь 2014-2021 онуудад нийт төгрөгийн 25, валютын 21 данс ашиглаж байсан бөгөөд 2022 оны байдлаар банкны 10 харилцах дансанд төгрөг болон валютын үлдэгдэлтэй байна. Шалгалтад хамрагдах 2014-2021 онуудад зарим банкны дансыг ашиглахгүйгээр хаасан





байна. Тайлангийн хугацаанд мөнгөн орлогын дүн 454,996.6 сая төгрөгөөр нэмэгдэж, 473,229.5 сая төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдсэн нь өмнөх оны мөн үеийн үзүүлэлттэй харьцуулахад мөнгөн орлогын дүн 166,685.2 сая төгрөгөөр нэмэгдсэн, зарлагын гүйцэтгэл 3,944.2 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

/2021 оны жилийн эцсийн байдлаар хаагдаагүй дансдын үлдэгдэл/

| Д/д | Дансны нэр, зориулалт | Банкны дансны дугаар | Валютын төрөл | Үлдэгдэл 2021.12.31 |
|---|---|---|---|---|
| 1 | Дархан Худалдаа хөгжлийн банкан дахь төгрөгийн харилцах | 403001064 | MNT | 1,206,866.05 |
| 2 | Улаанбаатар банкны төгрөгийн харилцах | 2600005810 | MNT | 286,331.45 |
| 3 | УБ хотын банкны төгрөгийн харилцах | 26000062642 | MNT | - |
| 4 | Харилцах дансан дахь бэлэн мөнгө | 499247109 | MNT | - |
| 5 | УБ хотын банкин дахь төгрөгийн харилцах | 2600082173 | MNT | 1,100.00 |
| 6 | Худалдаан хөгжлийн банкан дахь төгрөгийн харилцах | 499247109 | MNT | 88,692.02 |
| | Төгрөгийн дансны үлдэгдэл | | | 1,582,989.52 |
| 1 | Дархан Худалдаа хөгжлийн банкан дахь валютын харилцах | 403006493 | USD | 133,668.06 |
| | | | | 380,793,569.33 |
| 2 | УБ хотын банкны валютын харилцах | 2600062653 | USD | 17.55 |
| | | | | 49,996.44 |
| 3 | Худалдаа хөгжлийн банкны Зээлийн валютын харилцах | 499247110 | USD | 10.07 |
| | | | | 28,687.42 |
| 4 | Худалдаа хөгжлийн банкны валютын харилцах | 403197498 | USD | 19.65 |
| | | | | 55,978.92 |
| | Валютын дансны үлдэгдэл | | USD | 133,715.33 |
| | | | төгрөг | 380,928,232.11 |
| | НИЙТ ДҮН: | | төгрөг | 382,511,221.63 |

Нийт мөнгөн орлогын 97,3 хувийг бараа, бэлэн бүтээгдэхүүн борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого, 2,7 хувийг бусад мөнгөн орлого эзэлж байна. Мөнгөн гүйлгээний тайлангийн үр дүнгээс харахад Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн 18,232.9 сая төгрөг, Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн 25,792.7 сая төгрөг, Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн 44,398.0 сая төгрөгийн үзүүлэлттэй байна.

**8.1. "Кью Эс Си" ХХК-тай холбоотой хийгдсэн ажил гүйлгээний талаар:** "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-иас Худалдаа Хөгжлийн банкан дах 403197498 долларын дансаараа дамжуулан "Кью Эс Си" ХХК-д 2021 оны 06 дугаар сарын 14-ний өдрөөс 2021 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийг хүртэлх хугацаанд 21,063.0 мянган ам доллар буюу 58,700.1 сая төгрөг, "Куалити стийл корпорейшн" ХХК-д 2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдрөөс 2021 оны 05 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд нийт 24,174.0 мянган ам.доллар буюу 68,885.9 сая төгрөгийг тус тус шилжүүлж зарлагын гүйлгээ хийсэн боловч энэ нь ямар ажил үйлчилгээний төлбөр болох нь тодорхойгүй, хоорондын тооцоо нэрээр их хэмжээний мөнгийг байгууллага хооронд шилжүүлж байгаа ч тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй байна.

"Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн Худалдаа Хөгжлийн банкан дах 403001064 тоот дансаар дамжуулан 2021 онд "Кью Эс Си" ХХК-д 8,893.7 сая төгрөгийн орлогын, 146,256.8 сая зарлагын гүйлгээг хоорондын тооцоогоор бичилт хийж 137,363.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй, "Куалитистийл корпорэйшн" ХХК-д 4,711.0 сая төгрөгийн орлогын 106,820.9 сая төгрөгийн зарлагын гүйлгээ хийж 102,109.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаагаар тайлагнаж хоорондын тооцоогоор **нийт 239,472.9** сая төгрөгийн тооцоо үүсгэсэн боловч ажил гүйлгээг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4. "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.2."бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 14.4.3." бүх өр төлбөр" гэсэн заалтыг зөрчсөн байна.

/"Кьюо Эс Си" ХХК-тай холбоотой мөнгөн хөрөнгийн гүйлгээний товчоо/

| Он | Дебет | | Кредит | |
|---|---|---|---|---|
| | USD /ам доллар/ | Төгрөг /мянган төгрөг/ | USD /ам доллар/ | Төгрөг /мянган төгрөг/ |
| 2014 | 1,236,333.10 | 6,637,115.80 | 233,820.10 | 3,261,604.00 |
| 2015 | 86,000.00 | 5,564,111.10 | 1,504,678.20 | 5,526,220.60 |
| 2016 | 8,121,827.80 | 79,590,977.50 | 28,214,739.60 | 74,627,033.60 |
| 2017 | 669,284.40 | 18,277,397.50 | 63,795,418.00 | 192,858,350.80 |
| 2018 | 3,335,060.00 | 48,517,325.70 | 4,466,622.50 | 89,483,746.70 |
| 2019 | 14,454,160.90 | 39,883,732.70 | 29,521,910.10 | 80,817,516.20 |
| 2020 | 21,579,365.20 | 70,226,529.50 | 32,890,400.00 | 118,575,679.20 |
| 2021 | | 9,725,348.80 | 20,603,000.00 | 146,233,174.50 |
| Дүн | 49,482,031.40 | 278,422,538.60 | 181,230,588.50 | 711,383,325.60 |

/Жич: Компанийн санхүүгээс гаргаж өгсөн тайлангаар/

Дээрх хүснэгтээс харахад 2014-2021 онд "Кьюо Эс Си" ХХК-иас төгрөгөөр илэрхийлэгдсэн дүнгээр нийт 278.4 тэрбум төгрөг орсон бол "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-иас 711.4 тэрбум төгрөг шилжүүлсэн буюу зөрүү 433.0 тэрбум төгрөг шилжсэн байна.

Тухайн мөнгөний шилжүүлгүүд зөвхөн хоорондын тооцоогоор гэсэн бичиглэлтэй, санхүүгийн анхан шатны баримт тодорхой бус, чухам ямар ажил үйлчилгээний төлбөр болох нь тодорхойгүй байх тул хууль, хүчний байгууллагаас нэг бүрчлэн тодруулан шалгах нь зүйтэй байна.

"Кьюо Эс Си ХХК"-д шилжүүлсэн 711.4 тэрбум төгрөгийн 312.4 тэрбум төгрөгийг Улаанбаатар хотын банк болон Худалдаа хөгжлийн банкнаас зээлсэн зээлээр, үлдэх хэсгийг борлуулалтын орлогоос төлсөн/шилжүүлсэн байна.

**8.2. Ханшийн тэгшитгэлийн талаар:** "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн ерөнхий захирлын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн "Тооцоо нийлэх тухай" А/152 тоот тушаалаар Хөрөнгө оруулалтын гэрээний дагуу хийгдсэн санхүүжилт болох урт хугацаат өглөгийн 49,403,008.94 ам долларт ханшийн тэгшитгэл хийж тооцоо нийлэхийг Ерөнхий нягтлан бодогч С. Сарантуяад зөвшөөрсний дагуу улирал жилийн тайлангийн хугацаанд ханшийн тэгшитгэл хийж санхүүгийн тайланд тусгасан боловч анхан шатны холбогдох баримтаар баталгаажуулж тооцоо нийлсэн акт үйлдээгүй байна.

Ханшийн тэгшитгэлийн зөрүүг тооцохдоо гадаад валютаар авсан зээл, дансны өглөгийн үлдэгдлийн түүхэн ханш болон хаалтын ханшийн зөрүүнээс үүссэн түр зөрүү, хойшлогдсон татварын хөрөнгө болон бусдаас авах авлагын үлдэгдлийг тооцож баталгаажуулаагүй, үндсэн хөрөнгийн элэгдлийн тооцоолол нь санхүүгийн болон татварын хуулийн дагуу элэгдэл тооцох аргачлалын зөрүүнээс түр зөрүү үүссэн эсэх зэрэг ханшийн өөрчлөлт, өсөлт бууралтын холбогдох тооцоог нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу тооцож данс бүртгэлд үнэн зөв тусгаагүй байна.

"Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 20/253 тоот тогтоол, Ерөнхий захирлын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/152 тоот тушаалын дагуу Хөрөнгө





оруулалтын гэрээний дагуу хийгдсэн санхүүжилт болох урт хугацаат өглөгийн 49,403,008,94 ам долларт 2020.12.31-ний өдрийн ханшаар ханшийн тэгшитгэл хийснээс гарсан ханшийн тэгшитгэлийн 75,477,340,428.77 төгрөгийг буцааж хөрөнгө оруулалтын өглөгөөс хасаж ханшийн тэгшитгэлээр бууруулан бүртгэх шаардлагатай гэж үзэж байна.

Тус үйлдвэрийн 2022 оны 1-р улирлын санхүүгийн тайланд "Кьюо Эс Си" ХХК-ийн хөрөнгө оруулалтыг 170,196,911,572.02 төгрөгөөр бүртгэснийг задалж үзвэл ханшийн тэгшилтгэлд **80,629,618,003.41** төгрөгийг тооцож оруулсан байна.

Энэ нь Төрийн өмчийн хорооны 2013 оны 471 дүгээр тогтоолоор "Кьюо Эс Си" ХХК-ийн хөрөнгө оруулалтын зардлыг **81,301,393,800.4** төгрөгөөр баталгаажуулж (ам.доллараар биш төгрөгөөр) хүлээн зөвшөөрсөн байхад энэ тооцоог ам.долларт шилжүүлэн тооцож ханшийн зөрүү бодсон нь үндэслэлгүй байна.

## ЕС. АВЛАГА, ӨГЛӨГ, УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ТООЦООНЫ ТАЛААР

"Кьюо Эс Си" ХХК-тай хийсэн тооцоогоор /2021оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 164,740,079,038.53 төгрөгийн авлагатай, 167,202,592,279.12 төгрөгийн өглөгтэй байгаагаар тайлагнасан байна. Урьдчилж төлсөн тооцоо дансанд Менежментийн гэрээний урьдчилгаа төлбөрт оны эхэнд 185,815,345,099.28 төгрөг тооцогдсоноос тайлангийн хугацаанд 31,401,920,000.00 төгрөгийг зардлаар хүлээн зөвшөөрч 154,413,425,099.28 төгрөгийн авлагатай байна.

Тайлангийн эцэст холбоотой талын бусад авлага данс 10,098,833,703.87 төгрөгийн, Худалдаа хөгжлийн банканд төлөх зээлийн хүүгийн авлагын данс 3,544,943.03 төгрөгийн үлдэгдэлтэй байгаагаар тусгагдсан байна.

Нийт өглөг оны эхэнд 165,499,179,451.92 төгрөг байсан бол тайлангийн хугацаанд Ашиглалтын үеийн хайгуулын ажлын 1,703,412,827.20 төгрөгийн өглөг үүсгэж бүртгэснээр тайлангийн эцэст 167,202,592,279.12 төгрөгийн үлдэгдэлтэй болсон байна.

"Кьюо Эс Си" ХХК-тай хийсэн тооцоогоор 2022 оны 1 дүгээр улирлын байдлаар Холбоотой талын авлага төгрөгөөр 150,713,375,420.66, доллароор 10,438,439,246.13, Банкны зээлийн хүүгийн авлага 3,544,943.03 төгрөг, Урьдчилж төлсөн тооцоо 154,413,425,099.28 төгрөг нийт 315,565,239,766.07 төгрөгийн авлагатай.

Бусад өглөг дансанд Ашиглалтын үеийн хайгуулын ажлын 1,703,412,827.20 төгрөг, Дотоодын байгууллагад өгөх өглөгийн 2,893,220,901.16 төгрөг, Бусад урт хугацаат өглөг / ХО/ төгрөгөөр 20,668,611,447.30 доллароор 139,102,899,379.84, бусад 48,816,427.87 төгрөг нийт 164,368,144,555.50 өглөгтэй байгаагаар тайлагнасан байна

Холбоотой талын авлага дансанд ТТ-ийн ДТҮ-QCS-Т Актын дагуу Куалити стийлийн авлагын 94 763 195 171 төгрөг , ХХБ зээлийн 13 сая $, ба 38 сая $-ийн төлбөрийн үлдэгдэл болох авлагын 50 668 865 182 төгрөгийн зөрүү - 9 209 184 981 / данснаас шилжүүлж авсан авлага/ төгрөгийн тус тус тооцож хаасан байна.

**9.1. "Кьюо Эс Си" ХХК-ийн холбоотой талуудын зарим ажил үйлчилгээний талаар буюу "Нэйшнл Ньюс Корпорэйшн" ХХК-тай холбоотой үүссэн тооцооны талаар:** Мөн "Дархан Төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн төлөөлөн

удирдах зөвлөлийн 2021 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 21\12 тоот хурлын тогтоолын үндэслэн "Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төсөл"-ийн зорилго "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн үйл ажиллагаанд шууд нөлөөгүй Улаанбаатар хотын Блью Скай Тауэрын 8 давхарт байрлах 1455.75 м.кв барилгыг Худалдаа Хөгжлийн банк, Улаанбаатар хотын банк хувьцаа эзэмшдэг, хамаарал бүхий Нэйшнл Ньюс Корпорэйшн ХХК-аас 1 м.кв-ыг нь 7,650.0 мянган төгрөгт тооцож нийт 11,136.5 сая төгрөгөөр худалдах худалдан авах гэрээг байгуулсан байна.

Банкны зээлийн эх үүсвэрээр компанид хэрэгцээгүй байрыг оффисын зориулалтаар худалдан авсан асуудал нь зээлийн хүүг өсгөж шаардлагагүй санхүүжилт хийснээр зардлыг нэмэгдүүлэх үндэслэл болсон байна. Мөн худалдан авсан байрны ашиглалтын тооцоог хийж өөрсдөө байрлаж үйл ажиллагаа явуулж байгаагаас бусад сул чөлөөтэй талбайг түрээслүүлж олсон орлогоос зээлийн хүүг барагдуулах бодит боломжийг ашиглаагүй, компаниас гаргуулж байгаа зарим төлбөрийг бууруулах зэрэг үр ашгийн тооцоог хийгээгүй байхад гаргасан энэ шийдвэр нь компанийн үйл ажиллагаанд хохирол учруулах сөрөг үр дагаврыг бий болгосон байна.

**9.2.Мэргэжлийн зөвлөгөө болон техникийн туслалцаа үзүүлэх гэрээний хэрэгжилтийн талаар:** "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн ерөнхий захирал Т.Отгонбаяр, "Кью Эс Си" ХХК-ийн гүйцэтгэх захирал Э.Шижир нар 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдөр байгуулсан дугааргүй гэрээгээр тус 2 байгууллагын хооронд 2017 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр байгуулсан QSC17/01 дугаартай "Мэргэжлийн зөвлөгөө өгөх болон техникийн туслалцаа үзүүлэх гэрээний 7 дугаар зүйлийн 7-ын 2 дах хэсэг, 17 дугаар зүйлийн 7-ын 2 дах хэсэг болон холбогдох бусад хууль тогтоомжийг үндэслэн 2018 онд борлуулалт, ачилт, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа төмөр замын нөхцөл байдлаас шалтгаалан буурсан гэсэн үндэслэлээр гэрээний дүнг бууруулж 2018 онд 21,172,934,750 төгрөгөөр тооцсон байна.

"Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК, "Кью Эс Си" ХХК-ийн хооронд 2017.01.02-нд байгуулсан "Мэргэжлийн зөвлөгөө өгөх болон техникийн туслалцаа үзүүлэх гэрээ"-г 2021.01.12-ний өдрийн гэрээний дүнг баталгаажуулах акт үйлдэж 12 үзүүлэлтийг хангалттай гэж 2 тал дүгнэсэн боловч мэргэжлийн зөвлөгөө болон техникийн туслалцаа үзүүлэх ажлын хүрээнд ямар үйлчилгээ үзүүлсэн нь тодорхойгүй, гэрээгээр хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэл үр дүнг тоон үзүүлэлт, мөнгөн дүнгээр илэрхийлж тооцоогүй, их хэмжээний төлбөр авч үзүүлсэн мэргэжлийн зөвлөгөө, техникийн туслалцааны бодит үр дүн байхгүй, гэрээний дагуу ямар ажил гүйцэтгэснийг тодруулж, баримтаар нотлох шаардлагатай байна) бөгөөд хий хоосон гэрээ байгуулж төлбөр авсан гэж үзэж байна.

Мэргэжлийн зөвлөгөө болон техникийн туслалцаа үзүүлэх гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 2020.10.01-ний өдрийн /дугааргүй/ нэмэлт өөрчлөлтийн 9.2.3 дах заалтыг үндэслэн хийгдсэн 2021-2027 оныг дуусталх хугацааны төлбөрийг 9.2.2-д" энэхүү гэрээний төлбөрийг төлөх хугацаанаас 6 сараас дээш хугацааны өмнө урьдчилан төлсөн тохиолдолд тухайн төлбөр төлөх үеийн Монгол банкнаас зарласан бодлогын хүүгийн хувь хэмжээгээр төлбөрийг бууруулан тооцож төлнө" гэсний дагуу "Кью Эс Си" ХХК-аас авах авлагаас бууруулан тооцож урьдчилж төлсөн тооцоо дансанд 185,815,345,099.28 төгрөгийн бичилт хийсэн байна.





9.2.3-д" Энэхүү гэрээ хүчин төгөлдөр болсны дараа "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК нь 2021-2027 оныг дуусталх хугацааны төлбөрийг 2021 оны эхний улиралд багтаан урьдчилан төлөх бөгөөд 2022-2027 оны төлбөрийг уг гэрээний 9.2.2-т заасны дагуу хямдруулан тооцож төлнө" гэсний дагуу менежментийн нэмэлт гэрээний зохицуулалтаар 1 жилийн төлбөрт НӨАТ-гүй дүнгээр 28,547,200,000,00 төгрөг, НӨАТ-тай дүнгээр 31,401,920,000,00 төгрөг төлөх тооцоо хийж 2021-2027 онд нийт 219,813,440,000.00 /НӨАТ-гүй / төгрөгийг урьдчилан төлөх тооцоо хийж хөнгөлөлт тооцсон дүнгээр 185,815,345,099.28 төгрөг төлөхөөр тусгасан байна.

Дээрх тооцоогоор гаргасан 185,815,345,099.28 төгрөгөөс 2021 оны зардалд 31,401,920,000 төгрөгийг хасаж үлдэх 154,413,425,099.28 төгрөгийг авлагаар тооцож бүртгэсэн боловч 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд найдваргүй авлагын хасагдуулгаар бүртгэж хаасан байсныг дахин тооцож 154,641,245,334,66 төгрөгийг "Кью Эс Си" ХХК-аас буцаан авах авлагаар бүртгэсэн боловч тооцоо хийлж актаар баталгаажуулаагүй байна.

9.2.4-д" Энэхүү гэрээний 9.2.3-т заасан төлбөрийн 30% хүртэлх төлбөрийг талууд харилцан тохиролцсон тохиолдолд 2021.12.31-ний дотор багтаан төмрийн хүдэр, төмрийн хүдрийн баяжмал, арматур, ган бөөрөнцгийн бэлдэц болон бусад үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээр төлж болно гэсэн өөрчлөлтийг оруулсан байна.

"Кью Эс Си" ХХК-ийн 2021 онд хийлгэж байсан ашиглалтын үеийн хайгуулын ажлын төлбөр болох 1,709,280,565.3 төгрөгийн өглөгийн ажил нь зогссон мөн холбогдох бичиг баримтыг дуусгавар болгон хүлээлгэн өгөөгүй байгаа учир өглөгөөс хасаж тооцоо хийх шаардлагатай гэж үзэж байна.

**9.3. Найдваргүй авлагын хасагдуулга тооцсон талаар:** Үйлдвэрийн найдваргүй авлагын хасагдуулга дансны үзүүлэлтийг үүссэн хугацаанаас хамааруулан авч үзвэл 2014-2016 он ба түүнээс өмнөх жилүүдэд үүссэн найдваргүй авлагын хасагдуулгын нийт дүнг санхүүгийн тайланд тусгахдаа 2016 оны өссөн дүнгээр 2,008.4 сая төгрөг буюу 100 хувийн үзүүлэлттэй гэж суурь тооцоолол болгон авч үзсэн бөгөөд түүнээс хойших жилүүдэд хасагдуулга тооцох хувь хэмжээг бууруулан 2017 онд 50% буюу 6.9 сая, 2018 онд 50% буюу 172.6 сая, 2019 онд 25% буюу 176.2 сая, 2020 онд 10% буюу 102.6 сая төгрөгөөр тус тус тооцсон бөгөөд 2021 оны жилийн эцсийн байдлаар нийт 2,366.8 сая төгрөг болж нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Найдваргүй авлагын хасагдуулга дансны үзүүлэлтийг зардлын нэр төрлөөр авч үзвэл Хувь хүмүүсээс авах авлага, Дараа тайлангийн тооцооны данс, Ажлаас халагдсан ажилтан албан хаагчдаас авах авлага, Дотоодын болон гадаадын байгууллагаас авах валютын авлага, холбоотой талын ажил үйлчилгээ гэсэн ерөнхий ангилалд хамааруулан тайлагнажээ.

Үйлдвэрийн найдваргүй авлагын хасагдуулга дансны үзүүлэлтийг үүссэн хугацаанаас хамааруулан авч үзвэл 2016 ба түүнээс өмнөх жилд 100%-ийн үзүүлэлттэй 2,008.4 сая, 2017 онд 50% буюу 6.9 сая, 2018 онд 50% буюу 172.6 сая, 2019 онд 25% буюу 176.2 сая, 2020 онд 10% буюу 102.6 сая төгрөг байгаа бөгөөд 2021 оны жилийн эцсийн байдлаар нийт 2,366.8 сая төгрөг болж нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Уурхайн найдваргүй авлагын хасагдуулга дансны үзүүлэлтийг үүссэн хугацаанаас хамааруулан авч үзвэл 2014-2016 он ба түүнээс өмнөх жилүүдэд үүссэн найдваргүй авлагын хасагдуулгын нийт дүнг 2016 оны өссөн дүнгээр 160.2 сая төгрөг буюу 100%-гэж суурь тооцоолол болгон авч үзсэн бөгөөд түүнээс хойших жилүүдэд хасагдуулга тооцох хувь хэмжээг бууруулан 2017 онд 50% буюу 0.57 сая, 2018 онд 50% буюу 0.4 сая, 2019 онд 25% буюу 74.8 сая, 2020 онд 10% буюу 54.2 сая, 2021 оны жилийн эцсийн байдлаар нийт 2,366.8 сая төгрөгийн хуримтлагдсан үзүүлэлттэй байна.

Найдваргүй авлагын хасагдуулга дансны үзүүлэлтийг зардлын нэр төрлөөр авч үзвэл Ажлаас халагдсан болон ажилтан албан хаагчдаас авах авлага, гадаад болон дотоодын байгууллагаас авах валютын болон төгрөгийн авлага, дараа тайлангийн тооцоогоор үүссэн авлага байна. Холбоотой талын дансны авлагын эхний үлдэгдэл 4,254.2 сая төгрөг байсан бол тайлангийн хугацаанд 2021 оны жилийн эцсийн байдлаар 82,370.0 сая болж өссөн бөгөөд нийт зардлын 164,752.7 сая төгрөг нь дангаараа "Кьюү Эс Си" ХХК-тай холбогдох тооцоо байна.

## АРАВ. БАНКНЫ ЗЭЭЛИЙН ТАЛААР

"Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК нь 2021 оны жилийн эцсийн байдлаар Худалдаа хөгжлийн банканд 49,091.1 мянган ам.долларын 5 үндсэнзээл, 10,507.7 сая төгрөгийн 3 үндсэн зээл, 9,383.7 мянган ам.долларын зээлийнхүү, 1,622.9 сая төгрөгийн зээлийн хүүгийн, нийт 178,745.2 сая төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. /ам долларыг 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн Монгол банкны ханшаар тооцов/.

2022 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 43,037.2 мянган ам.долларын 5 үндсэн зээлийн, 14,849.8 сая төгрөгийн 3 үндсэн зээлийн, 9,431.0 мянган ам.долларын зээлийн хүүгийн, 1,700.7 сая төгрөгийн зээлийн хүүгийн, нийт 180,295.5 сая төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. /Ам долларыг 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн Монгол банкны ханшаар тооцов/.

/Банкны зээлийн үлдэгдлийг хүснэгтээр харуулав, ам доллар, төгрөгөөр/.

| Үзүүлэлт | | Үлдэгдэл 2021-12-31 | Үлдэгдэл 2022-05-31 |
|---|---|---|---|
| Төгрөгийн | Үндсэн зээл | 10,507,566,672.00 | 14,849,785,056.85 |
| | Зээлийн хүү | 1,622,958,509.61 | 1,700,730,020.06 |
| Дүн | | 12,130,625,181.61 | 16,550,515,076.91 |
| Ам долларын | Үндсэн зээл | $49,091,056.41 | $43,037,216.66 |
| | Зээлийн хүү | $9,383,742.82 | $9,431,017.75 |
| Дүн | | $58,474,801.23 | $52,468,234.41 |
| Ханш 2021/12/31, 2022/05/31 | | 2,849.34 | 3,120.84 |
| Төгрөгт шилжүүлсэн дүн | | 166,614,590,136.69 | 163,744,964,676.10 |
| Нийт дүн: | | 178,745,215,318.30 | 180,295,479,753.01 |

"Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК нь 2014-2022 оны 05 дугаар сарын 31-ний байдлаар банкнаас авсан нийт зээлийн эх үүсвэрээс 780,559.6 сая төгрөгийг зарцуулсныг зориулалтаар нь авч үзвэл:

"Кьюү Эс Си ХХК"-д 312,393.2 сая, "Куалитистийл корпорэйшн" ХХК-д 50,509.6 сая, цалин, нийгмийн даатгалын шимтгэлд 64,066.3 сая, өрөмдлөг, тэсэлгээ, хайгуул, нөхөн сэргээлтэд 7,265.8 сая, хоол унаанд 873.5 сая, хаягдал төмөр худалдан авахад 950.6 сая, тээвэр, шинжилгээнд 72,243.2 сая, түрээсийн төлбөрт 492.3 сая, гаалийн татвар хураамжид 5,702.1 сая, татвар, даатгалд 7,474.4 сая, бараа материалд 68,929.4 сая, үндсэн хөрөнгө худалдан авахад 21,100.5 сая, шатах тослох материал, шатахууны зардалд 11,051.9 сая,





ашиглалтын зардалд 11,025.9 сая, хөдөлмөр хамгаалал, бичиг хэрэг, хангамжийн материал худалдан авахад 169.4 сая, зээлийн эрсдэлийн шимтгэлд 656.7 сая, зээл, зээлийн хүүгийн төлбөрт 119,658.4 сая, бусад зардалд 25,996.2 сая төгрөгийг банкны зээлийн эх үүсвэрээс тус тус санхүүжүүлэн зарцуулсан байна.

/Банкны зээлийн зарцуулалтыг зориулалтаар харуулав/.

| Банкны зээлийн зарцуулалт | 2014 он | 2015 он | 2016 он | 2017 он | 2018 он | 2019 он | 2020 он | 2021 он | 5/31/2022 | Дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Цалин, НДШ | 11,093.50 | | 11,414.90 | 19,180.30 | 3,281.10 | 433.6 | 3,283.10 | 12,770.70 | 2,609.10 | 64,066.30 |
| Өрөмдлөг тэсэлгээ, хайгуул, нөх.сэргээлт | 1,300.00 | | 37.8 | 4,845.20 | 1,082.80 | | | | | 7,265.80 |
| Хоол | | | | | | 188.1 | 121.2 | 564.2 | | 873.5 |
| "Кьюү Эс Си" ХХК-д | 2,797.80 | 1,151.00 | 9,240.40 | 136,208.30 | 54,180.00 | 50 | 20,024.00 | 88,321.70 | 420 | 312,393.20 |
| "Куалити стийл корпорейшн" ХХК | | | | | | | | 48,859.80 | 1,650.00 | 50,509.60 |
| Хаягдал төмөр | | | | | | | | 785.8 | 164.8 | 950.6 |
| Тээвэр, шинжилгээ | 558 | 1,106.60 | 26,953.70 | 27,772.90 | 8,088.80 | 2,742.50 | 1,046.50 | 3,946.80 | 27.4 | 72,243.20 |
| Түрээс | | | | | | | 45 | 447.4 | | 492.4 |
| Гаалийн татвар хураамж | 688.1 | 60 | 1,489.50 | 2,089.30 | 707.4 | 0.5 | 261.9 | 405.1 | 0.4 | 5,702.10 |
| Татвар, даатгал | 208.3 | | 1,005.40 | 438.6 | 169.8 | 122.6 | 2,420.40 | 3,109.30 | | 7,474.40 |
| Бараа материал | 15,646.40 | 3,599.90 | 10,099.30 | 19,337.50 | 4,059.40 | 1,888.70 | 2,738.70 | 10,686.70 | 872.8 | 68,929.50 |
| Үндсэн хөрөнгө | 1,369.00 | 3,063.50 | 2,680.70 | 5,722.00 | 336.2 | 63.6 | 1,827.40 | 5,992.10 | 45.9 | 21,100.50 |
| Шатах тослох материал шатахуун | | | | 10,163.60 | | 9.5 | 163.6 | 692.5 | 22.6 | 11,051.90 |
| Ашиглалтын зардал | 1,458.80 | | 2,689.70 | 2,954.20 | 1,474.50 | 0.9 | 611.8 | 900.5 | 935.6 | 11,026.00 |
| Хөд хам, бичиг хэрэг, хангамж.мат | | | | | | | 36.3 | 119.5 | 13.6 | 169.4 |
| Зээлийн эрсдлийн шимтгэл | | | | | | | | 656.7 | | 656.7 |
| Зээл, зээлийн хүү | 4,741.60 | 6,744.40 | 11,413.90 | 18,306.90 | 17,040.70 | | 1,477.10 | 59,360.00 | 573.8 | 119,658.40 |
| Бусад | 422 | 9.5 | 597.4 | 2,909.60 | 1,082.30 | 5.6 | 20,209.20 | 667.8 | 92.9 | 25,996.20 |
| Нийт дүн: | 40,283.30 | 15,735.00 | 77,622.70 | 249,928.40 | 91,503.60 | 5,505.70 | 54,266.00 | 238,286.40 | 7,429.10 | 780,559.60 |

2022 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Худалдаа хөгжлийн банканд төлөх зээл, хүүгийн барьцаанд нийт худалдах, худалдан авах гэрээний дагуу орж ирэх орлого болон ирээдүйд орж ирэх мөнгөн хөрөнгө, түүний үр шим, авлага түүний үр шим, банкнууд дахь харилцах дансны орлого, үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийг 13,000.0 мянган ам.доллар, 494,428.2 сая төгрөгөөр үнэлсэн барьцааны гэрээтэй байна.

/Банкны барьцаа-биет болон биет бус хөрөнгө давхар барьцаалсан дүн, сая төгрөг, ам доллар/

| Үлдэгдэлтэй зээлүүд | Үлдэгдэл /сая төгрөг, ам доллараар/ | | Хөдлөх эд хөрөнгийн барьцаа | Үл хөдлөх хөрөнгийн барьцаа | Фидуцийн гэрээ | Дүн |
|---|---|---|---|---|---|---|
| 27.3 тэрбумын эрхтэй шугаман зээл /төг, валют/ | 2,234.60 | 28.3 | 132,174.90 | 364.9 | 1,771.40 | 137,266.50 |
| | $3,987,878.39 | $83,035.00 | | | 2,955.30 | |
| 20.0 тэрбумын эрхтэй шугаман зээл /төгрөг, валютын эрхтэй | 2,167.90 | 1,218.20 | 165,941.90 | 364.9 | 1,771.40 | 171,033.50 |
| | $8,260,575.20 | $125,458.30 | | | 2,955.30 | |
| $38,000,000 | $15,019,762.10 | $6,947,543.40 | 153,000.00 | | | 153,000.00 |
| $13,000,000 | $13,000,000 | $2,274,981.00 | $13,000,000 | | | $13,000,000 |
| $2,769,000 | $ 2,769,000.00 | | 11,618.20 | 364.9 | 1,771.40 | 18,200.60 |
| | | | | | 4,446.00 | |
| ₮ 10,870.0 | 10,447.30 | 454.2 | 8,151.00 | 6,776.60 | | 14,927.60 |
| Нийт дүн | 14,849.80 | 1,700.70 | 470,888.20 | 7,871.60 | 18,870.80 | 494,428.20 |
| | $43,037,216.70 | $9,431,017.70 | $13,000,000 | | | $13,000,000 |

## АРВАН НЭГ. БАРАА МАТЕРИАЛЫН ТАЛААР

"Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК нь 2021 оны 1 дүгээр улирлын байдлаар 176.7 тэрбум төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна. Бараа материал нийт хөрөнгийн 32.9 хувийг, эргэлтийн хөрөнгийн 65.0 хувийг эзэлж байна.

Бараа материалыг зориулалтаар нь уурхайн болон үйлдвэрийн бараа материалаар ангилан бүртгэсэн ба 86.7 хувь буюу 153.2 тэрбум төгрөгийн бараа материалыг төмрийн хүдэр олборлон боловсруулахтай холбоотой үйл ажиллагаа буюу уурхайн хэсэгт, 13.3 хувь буюу 23.5 тэрбум төгрөгийн бараа материалыг хаягдал төмөр худалдан авч боловсруулахтай холбоотой үйл ажиллагаа буюу үйлдвэрийн хэсэгт ангилан бүртгэжээ.

Бараа материалын дансны ангилал, эзлэх хувийн жинг хамгийн сүүлийн хугацаагаар авч үзэхэд 64.4 хувь буюу 113.7 тэрбум төгрөгийг бэлэн бүтээгдэхүүн, 27.5 хувь буюу 48.6 тэрбум төгрөгийг түүхий эд материал, 10.0 хувь буюу 17.7 тэрбум төгрөгийг сэлбэг хэрэгсэл, 1.1 хувь буюу 1.9 тэрбум төгрөгийг дуусаагүй үйлдвэрлэлийн хөрөнгө, 0.9 хувь буюу 1.3 тэрбум төгрөгийг шатах тослох материал, 1.0 хувь буюу 1.7 тэрбум төгрөгийг ашиглалтад ороогүй үндсэн хөрөнгө эзэлж байна.

/Дарханы төмөрлөгийн үйлдвэрийн балансад бүртгэлтэй бараа материалыг төрөл, үлдэгдлээр харуулав/.

| Д/д | Бараа материалын дансны төрөл | Бараа материалын үлдэгдэл, он, /сая төгрөгөөр/ | | | | | | | | | | Эзлэх хувийн жин, 2022 I ул |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2014-01-01 | 2014 он | 2015 он | 2016 он | 2017 он | 2018 он | 2019 он | 2020 он | 2021 он | 2022-03-31 | |
| 1 | Бэлэн бүтээгдэхүүн | 26,380.39 | 51,328.23 | 42,437.28 | 32,031.02 | 66,359.35 | 76,465.55 | 63,093.45 | 66,702.25 | 111,478.76 | 110,611.73 | 72.2% |
| 2 | ДҮ-н нэгтгэл зардал | 1,411.57 | 5,260.52 | 405.54 | 405.54 | 3,496.38 | 1,073.63 | 210.90 | 271.40 | 20.57 | 1,234.14 | 0.8% |
| 3 | Түүхий эд материал | 3,492.47 | 3,575.21 | - | - | - | - | 1,269.98 | 563.53 | 10,782.65 | 31,717.55 | 20.7% |
| 4 | Сэлбэг хэрэгсэл | 13,473.04 | 11,763.04 | 3,440.83 | 5,143.15 | 4,164.69 | 3,598.73 | 6,452.30 | 8,765.25 | 10,374.13 | 9,974.65 | 6.5% |
| 5 | Шатах тослох материал | 885.79 | 638.23 | 194.65 | 262.79 | 279.03 | 348.77 | 534.88 | 747.08 | 899.80 | 959.81 | 0.6% |
| 6 | Хангамжийн материал | 1,753.30 | 1,187.66 | 43.32 | 34.46 | 58.77 | 78.34 | 480.64 | 1,770.47 | 1,017.00 | 572.48 | 0.4% |
| 7 | БМ-ын үнэлгээний хасагдуулга | - | - | - | (73.27) | (1,093.81) | (1,014.86) | (1,461.08) | (1,819.72) | (2,231.24) | (2,231.24) | -1.5% |
| 8 | Ашиглалтад ороогүй үндсэн хөрөнгө | 180.64 | 1,387.96 | - | - | - | - | 1,046.96 | 380.79 | 380.79 | 380.79 | 0.2% |
| | Уурхайн дүн: | 47,577.20 | 75,140.86 | 46,521.62 | 37,803.70 | 73,264.42 | 80,550.15 | 71,648.03 | 77,381.04 | 132,722.46 | 153,219.90 | 86.7% |
| 1 | Бэлэн бүтээгдэхүүн | 7,738.41 | 9,763.77 | 16,288.58 | 16,517.36 | 3,052.74 | 1,795.23 | 18,042.53 | 26,753.72 | 17,936.64 | 3,124.22 | 13.3% |
| 2 | ДҮ-н нэгтгэл зардал | - | - | 1,455.04 | 72.17 | 280.89 | - | - | - | - | 659.62 | 2.8% |
| 3 | Түүхий эд материал | 5,859.04 | 3,997.93 | 4,584.11 | 4,042.53 | 12,581.48 | 11,400.46 | 14,107.12 | 20,341.29 | 14,720.81 | 16,900.25 | 71.9% |
| 4 | Сэлбэг хэрэгсэл | 4,400.25 | 2,938.07 | 9,775.69 | 7,530.13 | 8,067.99 | 6,685.11 | 7,034.85 | 8,406.21 | 7,927.67 | 7,694.17 | 32.7% |
| 5 | Шатах тослох материал | - | - | 244.25 | 287.08 | 234.06 | 144.65 | 223.39 | 208.09 | 423.26 | 562.55 | 2.4% |
| 6 | Хангамжийн материал | 1.47 | - | 447.06 | 319.77 | 301.13 | 304.63 | 356.42 | 648.67 | 597.76 | 486.10 | 2.1% |
| 7 | БМ-ын үнэлгээний хасагдуулга | - | - | 0.00 | (601.57) | (2,953.44) | (2,987.74) | (4,304.84) | (4,119.13) | (7,276.99) | (7,276.99) | -31.0% |
| 8 | Ашиглалтад ороогүй үндсэн хөрөнгө | - | - | 1,387.96 | 1,387.96 | 1,359.75 | 1,359.75 | 1,359.75 | 1,359.75 | 1,359.75 | 1,359.75 | 5.8% |
| | Үйлдвэрийн дүн: | 17,999.18 | 16,699.77 | 34,182.70 | 29,555.43 | 22,924.62 | 18,702.10 | 36,819.22 | 53,598.81 | 35,689.10 | 23,509.66 | 13.3% |
| 1 | Бэлэн бүтээгдэхүүн | 34,118.80 | 61,092.01 | 58,725.86 | 48,548.39 | 69,412.09 | 78,260.78 | 81,135.98 | 93,455.97 | 129,415.60 | 113,735.94 | 64.4% |
| 2 | ДҮ-н нэгтгэл зардал | 1,411.57 | 5,260.52 | 1,860.58 | 477.71 | 3,777.27 | 1,073.63 | 210.90 | 271.40 | 20.57 | 1,893.75 | 1.1% |
| 3 | Түүхий эд материал | 9,351.51 | 7,573.14 | 4,584.11 | 4,042.53 | 12,581.48 | 11,400.46 | 15,397.09 | 20,904.82 | 25,503.47 | 48,617.80 | 27.5% |
| 4 | Сэлбэг хэрэгсэл | 17,873.29 | 14,701.11 | 13,216.51 | 12,673.28 | 12,232.68 | 10,283.84 | 13,487.15 | 17,171.45 | 18,301.80 | 17,668.82 | 10.0% |
| 5 | Шатах тослох материал | 885.79 | 638.23 | 438.90 | 549.87 | 513.11 | 493.42 | 758.27 | 955.17 | 1,323.06 | 1,522.36 | 0.9% |
| 6 | Хангамжийн материал | 1,754.77 | 1,187.66 | 490.40 | 354.24 | 359.90 | 382.97 | 837.06 | 2,419.14 | 1,614.76 | 1,058.58 | 0.6% |
| 7 | БМ-ын үнэлгээний хасагдуулга | 0.00 | 0.00 | 0.00 | (674.84) | (4,047.25) | (4,002.60) | (5,765.91) | (5,938.85) | (9,508.24) | (9,508.24) | -5.4% |
| 8 | Ашиглалтад ороогүй Үн.хөр | 180.64 | 1,387.96 | 1,387.96 | 1,387.96 | 1,359.75 | 1,359.75 | 2,406.71 | 1,740.54 | 1,740.54 | 1,740.54 | 1.0% |
| | НИЙТ ДҮН: | 65,576.38 | 91,840.63 | 80,704.32 | 67,359.13 | 96,189.04 | 99,252.26 | 108,467.25 | 130,979.65 | 168,411.56 | 176,729.56 | 100% |

Бараа материалд 2016 оноос хойш нийт 9.5 тэрбум төгрөгийн үнэ цэнийн бууралтыг тооцож бүртгэсэн ба үүнээс, уурхайн бараа материалд 2.2 тэрбум төгрөгийн, үйлдвэрийн бараа материалд 1.4 тэрбум төгрөгийн хасагдуулга тооцсон байна.

2022 оны 1 дүгээр улирлын байдлаарх бараа материалын үлдэгдлийг 2014 он, өмнөх онуудтай харьцуулбал уурхайн бараа материал 2014 оноос 105.6





тэрбум төгрөгөөр, үйлдвэрийн бараа материал 5.5 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

/Бараа материалын үлдэгдлийг өмнөх жилийн үлдэгдэлтэй харьцуулан харуулбал/

| Бараа материал | | Он, /сая төгрөгөөр/ | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2014-01-01 | 2014 | 2015 | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020 | 2021 | 2022-03-31 |
| Уурхайн бараа материалын үлдэгдэл | | 47,577.20 | 75,140.86 | 46,521.62 | 37,803.70 | 73,264.42 | 80,550.15 | 71,648.03 | 77,381.04 | 132,722.46 | 153,219.90 |
| Өөрчлөлт: | жил бүр | - | 27,563.66 | -28,619.24 | -8,717.92 | 35,460.72 | 7,285.73 | -8,902.12 | 5,733.00 | 55,341.42 | 20,497.44 |
| | 2013 оноос | - | - | - | - | - | - | - | - | - | 105,642.70 |
| Үйлдвэрийн бараа материалын үлдэгдэл | | 17,999.18 | 16,699.77 | 34,182.70 | 29,555.43 | 22,924.62 | 18,702.10 | 36,819.22 | 53,598.81 | 35,689.10 | 23,509.66 |
| Өөрчлөлт: | жил бүр | - | -1,299.41 | 17,482.93 | -4,627.27 | -6,630.81 | -4,222.52 | 18,117.12 | 16,779.39 | -17,909.51 | -12,179.44 |
| | 2013 оноос | - | - | - | - | - | - | - | - | - | 5,510.48 |
| Нийт бараа материалын үлдэгдэл | | 65,576.38 | 91,840.63 | 80,704.32 | 67,359.13 | 96,189.04 | 99,252.26 | 108,467.25 | 130,979.65 | 168,411.56 | 176,728.56 |
| Өөрчлөлт: | жил бүр | - | 26,284.25 | -11,136.31 | -13,345.19 | 28,829.90 | 3,063.22 | 9,215.00 | 22,512.39 | 37,431.91 | 8,318.00 |
| | 2013 оноос | - | - | - | - | - | - | - | - | - | 111,153.18 |

Компанийн бараа материалын дансанд 2014-2022 оны 1 дүгээр улирлын хугацаанд нийт 3 их наяд 65.4 тэрбум төгрөгийн нэмэгдсэн, 2 их наяд 953.1 тэрбум төгрөгийн хасагдсан хөдөлгөөн хийгдсэн байна. Үүний 938.8 тэрбум төгрөгийн нэмэгдсэн, хасагдсан хөдөлгөөн нь хөрөнгийн дотоод шилжилт буюу данс хоорондын ажил гүйлгээ, 573.5 сая төгрөгийн нэмэгдсэн, 7.8 тэрбум төгрөгийн хасагдсан хөдөлгөөн хийгдсэн нь бараа материалын үнэ цэнийн хасагдуулгыг тооцож Аудитын зөвлөмжийн дагуу залруулга хийсэн ажил гүйлгээний бичилт байна.

- **Бараа материалын цэвэр орлогыг авч үзвэл:** 2014 оноос 2022 оны 1 дүгээр улирлын хугацаанд 1 их наяд 600.6 тэрбум төгрөгийн бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн. Үүнээс уурхайд 1 их наяд 13.0 тэрбум төгрөгийн, төмөрлөгийн үйлдвэрийн хэсэгт 587.6 тэрбум төгрөгийн бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн байна.
- 416.8 тэрбум төгрөгийн бараа материалыг шинээр худалдан авснаас 217.4 тэрбум төгрөгийн бараа материалыг уурхайн, 199.4 тэрбум төгрөгийн бараа материалыг үйлдвэрийн хэрэгцээнд худалдан авсан.
- Үндсэн бус үйл ажиллагаа, 2 догч түүхий эд, бараа материалын буцаалт, бусад орлогоор 67.1 тэрбум төгрөгийн бараа материалыг хүлээн авч бүртгэсэн байна.

- **Бараа материалын цэвэр зарцуулалтыг авч үзвэл:** 2014 оноос 2022 оны 1 дүгээр улирлын хугацаанд 657.4 тэрбум төгрөгийн өртөг бүхий бэлэн бүтээгдэхүүнийг худалдан борлуулсан. Үүнээс 374.7 тэрбум төгрөгийг уурхайн, 282.7 тэрбум төгрөгийн үйлдвэрийн бэлэн бүтээгдэхүүний борлуулалт эзэлж байна.
- 1 их наяд 195.8 тэрбум төгрөгийн бараа материалыг үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд зарцуулснаас 715.1 тэрбум төгрөгийн материалыг уурхайн

хэрэгцээнд, 480.7 тэрбум төгрөгийн материалыг үйлдвэрийн хэрэгцээнд зарцуулсан байна.

- Үйлдвэрлэлийн бус үйл ажиллагааны зардалд 80.5 тэрбум төгрөгийн бараа материалыг зарцуулсан.
- Үндсэн хөрөнгийн шинж агуулсан 1.5 тэрбум төгрөгийн хөрөнгийг шилжүүлсэн. Үүнээс барилга байгууламжийн дансанд 66.4 сая төгрөгийн, тоног төхөөрөмжийн дансанд 1.3 тэрбум төгрөгийн, дуусаагүй барилгын дансанд 96.6 сая төгрөгийн бараа материалыг тус тус шилжүүлэн бүртгэсэн байна.

/Бараа материалын орлого, зарцуулалтыг төрлөөр нь харуулав, сая төгрөгөөр/.

| Он | Үйлдвэрлэсэн | Худалдан авсан | Бусад орлого | Нийт нэмэгдсэн дүн | Үйлд-вэрлэлд зарцуулсан | Борлуулсан | Бусад зарлага | Нийт хасагдсан дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| *Уурхай* | *1,013,027.23* | *217,426.65* | *57,686.01* | *1,288,062.39* | *672,200.90* | *374,736.30* | *73,568.36* | *1,120,544.58* |
| 2014 | 67,271.40 | 16,388.92 | 0.00 | 83,660.32 | 0.00 | 15,688.07 | 0.00 | 15,688.07 |
| 2015 | 22,884.00 | 8,005.61 | 1,383.30 | 32,272.91 | 20,668.29 | 16,455.07 | 3,346.63 | 40,469.99 |
| 2016 | 51,621.94 | 12,677.53 | 2,544.75 | 66,866.73 | 43,393.59 | 31,852.49 | 242.80 | 76,488.87 |
| *буцаалт* | 0.00 | 0.00 | 22.51 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 2017 | 106,678.85 | 20,504.96 | 1,317.72 | 128,501.63 | 66,723.23 | 26,982.53 | 1,405.36 | 95,111.12 |
| 2018 | 110,424.41 | 19,633.34 | 26,658.27 | 156,716.02 | 75,974.55 | 44,292.22 | 26,819.71 | 147,086.48 |
| 2019 | 140,446.72 | 38,973.45 | 13,557.83 | 192,978.00 | 98,137.47 | 76,210.12 | 27,266.50 | 201,616.13 |
| Буц | 0.00 | (4.05) | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 2020 | 221,643.86 | 42,363.43 | 5,638.09 | 269,645.37 | 161,711.00 | 90,732.89 | 10,495.99 | 262,946.05 |
| *буцаалт* | 0.00 | (8.17) | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 2021 | 252,029.70 | 51,445.26 | 5,915.35 | 309,390.31 | 180,228.74 | 69,673.40 | 3,457.58 | 253,386.53 |
| Буц | 0.00 | (26.81) | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 2022-1 | 40,026.35 | 7,434.16 | 570.70 | 48,031.21 | 25,364.03 | 2,849.50 | 533.80 | 28,747.34 |
| *Үйлдвэр* | *587,571.83* | *199,372.04* | *4,808.42* | *791,756.15* | *369,610.57* | *282,745.12* | *25,653.49* | *678,009.96* |
| 2014 | 129,492.22 | 49,802.25 | 0.00 | 179,294.47 | 0.00 | 59,449.97 | 0.00 | 59,449.97 |
| 2015 | 73,734.66 | 18,843.03 | 289.54 | 92,867.22 | 61,004.43 | 28,014.85 | 3,465.65 | 92,484.92 |
| 2016 | 27,148.20 | 8,326.97 | 163.85 | 35,641.10 | 20,507.98 | 13,267.97 | 4,511.04 | 38,286.99 |
| *хасаг-дуулга* | 0.00 | 0.00 | 2.08 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 2017 | 45,503.58 | 21,441.90 | 157.97 | 67,103.46 | 34,880.42 | 31,312.31 | 5,370.18 | 71,562.91 |
| 2018 | 69,964.43 | 21,278.91 | 111.92 | 91,355.27 | 57,563.28 | 35,777.72 | 1,921.60 | 95,262.60 |
| 2019 | 73,678.39 | 20,741.51 | 764.74 | 95,184.64 | 56,859.77 | 17,378.97 | 1,848.99 | 76,087.72 |
| 2020 | 49,437.86 | 21,291.92 | 1,272.95 | 72,002.73 | 39,912.15 | 13,358.15 | 2,137.96 | 55,408.04 |
| Буц | 0.00 | (0.78) | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 2021 | 104,268.15 | 32,253.76 | 1,973.74 | 138,495.65 | 86,804.01 | 64,326.09 | 5,686.03 | 156,816.13 |
| 2022-1 | 14,344.34 | 5,392.56 | 73.71 | 19,810.61 | 12,078.52 | 19,859.11 | 712.04 | 32,649.66 |
| Нийт дүн: | 1,600,599.05 | 416,798.69 | 62,394.43 | 2,079,817.54 | 1,041,811.46 | 657,481.42 | 99,221.84 | 1,798,554.53 |

*/*Бараа материалын орлого, зарцуулалтыг Үйлдвэр, уурхайгаар болон бараа материалын дансны ангилал тус бүрээр гаргасныг хавсралтаар оруулав/.*

Компанийн бараа материалын ашиглалтгүй хөрөнгийн дансанд үйлдвэрт ашиглаж байгаа хийн зуухыг шинэчлэх зорилгоор 2013 онд гэрээ байгуулан худалдаж авсан 1,359,754.5 мянган төгрөгийн өртөг бүхий Цэвэршүүлсэн хүйтэн хийн станцын тоног төхөөрөмж бүртгэлтэй байна. Хөрөнгийн үлдэгдэл төлбөрийг 2014 онд шилжүүлэн хөрөнгийг хүлээн авсан боловч өнөөгийн байдлаар угсралтын ажил хийгдээгүй, хөрөнгөд бараа материалын үнэлгээний хасагдуулгыг 100 хувиар тооцож бүртгэсэн байна.





**11.1. Бэлэн бүтээгдэхүүний талаар:** Бараа материалын дүнд эзлэх хувийн жингээр нийт бараа материалын 65.5 хувийг бэлэн бүтээгдэхүүн, 27.5 хувийг түүхий эд материал эзэлж байна.

2022 оны 1 дүгээр улирлын байдлаар уурхайд 110.6 тэрбум төгрөгийн, төмөрлөгийн үйлдвэрт 3.1 тэрбум төгрөгийн бэлэн бүтээгдэхүүн бүртгэлтэй байна.

/Уурхай, үйлдвэрийн бэлэн бүтээгдэхүүний үлдэгдлийг он оноор харуулав/.

| Д/д | Бэлэн бүтээгдэхүүн | ББ-ний үлдэгдэл 2014-2022 оны 1 дүгээр улирал дуустал, /сая төгрөгөөр/ | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2014 | 2015 | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020 | 2021 | 2022-03-31 |
| 1 | ББ-Уурхай | 51,328.2 | 42,437.3 | 32,031.0 | 66,359.4 | 76,465.5 | 63,093.5 | 66,702.2 | 111,478.8 | 110,611.7 |
| 2 | ББ-Үйлдвэр | 9,763.8 | 16,288.6 | 16,517.4 | 3,052.7 | 1,795.2 | 18,042.5 | 26,753.7 | 17,936.8 | 3,124.2 |
| | Нийт дүн: | 61,092.0 | 58,725.9 | 48,548.4 | 69,412.1 | 78,260.8 | 81,136.0 | 93,456.0 | 129,415.6 | 113,735.9 |

Уурхайн бэлэн бүтээгдэхүүнд Төмөртолгой, Төмөртэйн уурхайгаас олборлож, боловсруулсан төмрийн хүдэр, баяжмал, завсрын бүтээгдэхүүн, хаягдал бүртгэгдсэн ба энэ нь уурхайн бараа материалын 73.0 хувийг эзэлж байна.

Төмрийн хүдрийг уурхайн бэлэн бүтээгдэхүүнд ангилан бүртгэж байгаад 2022 оны 1 сараас түүхий эд материалын данс руу шилжүүлэн бүртгэсэн байна.

/Уурхайн бэлэн бүтээгдэхүүний дансны ангилал, үлдэгдэл/.

| Д/д | Уурхайн бэлэн бүтээгдэхүүний ангилал /төрөлжих нэршлээр/ | 2021-12-31-ний байдлаар | | | | 2022-03-31-ний байдлаар | | | | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Тоо хэмжээ /тн/ | Нийт өртөг /төгрөгөөр/ | Хувийн жин | | Тоо хэмжээ /тн/ | Нийт өртөг /төгрөгөөр/ | Хувийн жин | | |
| | | | | Тоо хэмжээ | Тэнгэн дүн | | | Тоо хэмжээ | Тэнгэн дүн | |
| 1 | Төмрийн хүдэр | 530,738.78 | 14,007,212,413.31 | 9.8% | 12.6% | - | - | - | - | 2022 оны 1 сараас Түүхий эд материалын дансанд ангилан бүртгэсэн. |
| 2 | Баяжмал /төрөл бүрийн/ | 2,863,615.54 | 97,469,507,963.97 | 52.7% | 87.4% | 3,162,017.01 | 110,609,621,161.99 | 60.0% | 99.998% | - |
| 3 | Хаягдал | 2,036,448.81 | 2,036,448.81 | 37.498% | 0.002% | 2,104,166.19 | 2,104,166.19 | 40.0% | 0.002% | 1 тн-ыг 1 төгрөгөөр үнэлэн бүртгэлд тусгасан. |
| | Нийт дүн | 5,430,803.13 | 111,478,754,820.09 | 100.0% | 100.0% | 5,266,183.20 | 110,611,725,322.18 | 100.0% | 100.0% | |

Компани 2022 оны 1 дүгээр улирлын байдлаар 5.3 сая тонн, 110.6 тэрбум төгрөгийн төмрийн хүдрийн баяжмал, завсрын бүтээгдэхүүн, хаягдал бүртгэлтэй, байгаагаас Төмөртэйн уурхайд 2.1 сая тонн, 40.3 тэрбум төгрөгийн, Төмөртолгойн уурхайд 3.1 сая тонн, 70.3 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн бүртгэлтэй байна.

Үүнээс 1.3 сая тонн экспортын баяжмалын үлдэгдэлтэй байна. 2021-12-31-ний байдлаар 48 харилцагчид, 644.0 мянган тонн, 36.3 сая ам доллар буюу 103.6 тэрбум төгрөгийн экспортын баяжмалын өглөгтэй байна.

/Экспортын баяжмалын үлдэгдлийг 2022-03-31-ний байдлаар харуулав/.

| Д/д | Баяжмалын агуулга | Овоолгын дугаар | Бүтээгдэхүүн | Баяжмалын төрөл | Төмрийн агуулга, % | Хүхрийн агуулга, % | Үлдэгдэл, тн |
|---|---|---|---|---|---|---|---|
| Хуурай баяжуулах үйлдвэрийн бэлэн бүтээгдэхүүн | | | | | | | |
| 1 | 61%-аас дээш | №4 | Бүхэл баяжмал | Хүхэр багатай | 61% < | 0.5% > | 11,818.45 |
| | | №8 | Нунтаг баяжмал | Хүхэр багатай | 61%< | 0.5% > | 26,343.90 |
| 2 | 55-61% | №6 | Нунтаг баяжмал | Хүхэртэй | 55-61% | 0.5-2.5% | 207,505.26 |
| | | №30 | | Хүхэр ихтэй | 55-61% | 2.5%< | - |
| | | №7 | | Хүхэр багатай | 55-61% | 0.5% > | 22,091.14 |
| | | №3 | Бүхэл баяжмал | Хүхэртэй | 55-61% | 0.5-2.5% | 197,560.25 |
| | | №24 | | Хүхэр ихтэй | 55-61% | 2.5%< | 288,929.75 |
| | | №5 | | Хүхэр багатай | 55-61% | 0.5% > | 15,562.50 |
| Төмөртэй уурхай, экспортын баяжмалын үлдэгдэл | | | | | | | 769,811.25 |
| 1 | 55-61% | №1 | Нунтаг баяжмал | Хүхэртэй | 55-61% | 3-5% | 131,020.20 |
| | | №2 | Бүхэл баяжмал | Хүхэртэй | 55-61% | 3-5% | 217,102.50 |
| | | №7 | Нунтаг баяжмал | Хүхэртэй | 55-61% | 3-5% | 105,753.60 |
| | | №8 | Бүхэл баяжмал | Хүхэртэй | 55-61% | 3-5% | 67,200.00 |
| Төмөртолгойн уурхай, экспортын баяжмалын үлдэгдэл | | | | | | | 521,076.30 |
| Нийт Экспортын баяжмалын үлдэгдэл: | | | | | | | 1,290,887.55 |

Үйлдвэрийн бэлэн бүтээгдэхүүн 2022 оны 1 дүгээр улирлын байдлаар 3.1 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна. Арматур, ган бөмбөлөг төмөр бэлдэц үйлдвэрлэж бүртгэдэг ба нийт бэлэн бүтээгдэхүүний 16.1 хувийг эзэлж байна.

2021 оны жилийн эцсийн байдлаар нийт 5,430.8 мянган тонн төмрийн хүдрийн үлдэгдэл бүртгэснээс 4,900.0 мянган тонн нь баяжуулсан хүдэр, үлдэх хэсэг нь баяжуулахад бэлэн хүдэр байна.

2022 оны 04 дүгээр сарын 30-ны байдлаар гаргасан тайлангаар Төмөртэй болон Төмөртолгойн уурхайн үйлдвэрлэсэн хүдрийн баяжмалын бэлэн үлдэгдэл нийт 5,526.1 мянган тонн, үүнээс экспортын баяжмалын үлдэгдэл 1,755.9 мянган тонн, бага агуулгатай 2,019.9 мянган тонн байна.

2022 оны 05 дугаар сарын 28-ны өдөр Төмөртэйн уурхайд ажиллаж төмрийн хүдрийн овоолго, техник хэрэгсэл, уулын ажлын байдалтай газар дээр очиж танилцлаа. Төмөртэй уурайд нийт 34 овоолго үүсгэн төмрийн баяжмалыг агуулгаар нь ангилан бэлтгэсэн байна. Тус ажлын хүрээнд 14 дүгээр овоолгод маркшейдерийн хэмжилт хийхэд хамгийн сүүлд хийсэн хэмжилтээр 385,306 тонн байсан бол тухайн өдрийн хэмжилтээр 389,208 тн гарсан нь 1 хувийн зөрүүтэй буюу хүлээн зөвшөөрөх хэмжээнд байна гэж үзлээ.

**Борлуулалтаас гадуурх баяжмал зарцуулалтын талаар:** Компани төмрийн хүдрийн баяжмалыг худалдан борлуулахаас гадна 2014-2022 оны 1 дүгээр улирлын хугацаанд 31.9 мянган тонн жинтэй, 875.2 сая төгрөгийн баяжмалыг борлуулалтаас гадуур захиран зарцуулсан байна.

/Үйл ажиллагааны бус зардалд зарцуулсан баяжмал/

| Баяжмалын төрөл, он | Тоо хэмжээ /тонн/ | Нэгж өртөг /төгрөгөөр/ | Нийт өртөг төгрөгөөр/ | Зарцуулалтын байдал |
|---|---|---|---|---|
| 2014 он | 11,321.61 | 29,372.45 | 332,543,387.90 | |
| Баяжмал бүхэл | 392.00 | 29,897.44 | 11,719,797.18 | Баяжмалын чийгшил |
| Баяжмал нунтаг | 10,929.61 | 29,353.62 | 320,823,590.72 | Терминалын зам талбайд |
| 2015 он | 5,849.65 | 28,360.41 | 165,898,479.70 | |
| Баяжмал бүхэл | 547.36 | 24,865.53 | 13610398.46 | Ачилтын талбайн уланд үлдсэн баяжмал |
| | 1901.39 | 29,897.44 | 56846696.86 | |
| | 0.35 | 29,897.43 | 10464.1 | Баяжмалын чийгшил хассан. |
| | 0.51 | 29,897.45 | 15247.7 | |
| | 228.06 | 29,897.44 | 6818410.58 | |
| Баяжмал нунтаг | 3,171.98 | 27,931.22 | 88,597,262.00 | Ачилтын талбайн уланд үлдсэн бүхэл баяжмал борлуулалтын зардалд |
| 2016 он | 6.87 | 30,585.28 | 210,120.85 | |
| Баяжмал бүхэл | 6.87 | 30,585.28 | 210,120.85 | Хөтөл борлуулалт чийгшил хасав |
| 2018 он | 113.56 | 28,601.85 | 3,248,025.52 | |
| Завсарын бүт-н /Бүхэл 50%-54% Хүхэртэй/ | 56.78 | 29,779.85 | 1690900.14 | Жингийн зөрүү Хөтөл |
| | 56.78 | 27,423.84 | 1557125.38 | Жингийн зөрүү Хөтөл |
| 2020 он | 1,008.00 | 27,094.79 | 27,311,547.99 | |
| Завсарын бүт-н /Нунтаг 50%-55% Хүхэргүй | 1,008.00 | 27,094.79 | 27,311,547.99 | Актаар зарлагадав. |
| 2021 он | 13,632.30 | 124,901.78 | 346,032,490.85 | |
| Завсарын бүт-н /Нунтаг 40-50% Хүхэргүй/ | 2,305.20 | 14,112.97 | 32,533,211.39 | Баяжуулах-3 Туршилтын боловсруулалтад баяжмал зарлагадав. |
| Завсарын бүт-н /Нунтаг 50%-55% Хүхэргүй/ | 851.70 | 29,514.11 | 25,137,164.94 | |
| Завсарын бүт-н /Нунтаг 45%-50% Хүхэргүй/ | 168.30 | 19,984.75 | 3,363,434.19 | |
| Завсарын бүт-н /Бүхэл 50%-55% Хүхэргүй/ | 3,743.40 | 41,587.83 | 155,679,895.84 | |
| Завсарын бүт-н /Бүхэл 45%-50% Хүхэргүй/ | 6,563.70 | 19,702.12 | 129,318,784.49 | |
| Нийт дүн: | 31,931.99 | 268,916.55 | 875,244,052.81 | |

Мөн 2014-2021 онд баяжмалын агуулга, нэр төрөлд өөрчлөлт оруулж 1 сая 452.1 мянган тн, 30,3 тэрбум төгрөгийн өртөг бүхий баяжмалыг зарлага болгож, 1 сая 452.1 мянган тонн, 24.8 тэрбум төгрөгийн баяжмалыг орлого авч бүтээгдэхүүний ангилал хооронд нягтлан бодох бүртгэлийн дансны шилжүүлэг





хийсэн. Энэ бүртгэлийн дүнгээр бүтээгдэхүүний өөрийн өртгийг 5.5 тэрбум төгрөгөөр бууруулан бүртгэлд тусгасан байна.

2019 онд 2016 оны Аудитын дүгнэлтийг үндэслэн жилийн эцсийн тайланд бараа материалтай холбоотой 16.9 тэрбум төгрөгийн залруулга хийж бэлэн бүтээгдэхүүний дансанд бүртгэлтэй 858.8 мянган тонн, 19.7 төгрөгийн нэгж үнэтэй, 16.9 тэрбум төгрөгийн завсрын бүтээгдэхүүн /Нунтаг 45%-50% Хүхэргүй/-ийг, нэгж үнийг 13.3 төгрөгөөр тооцож 11.4 тэрбум төгрөгөөр бүртгэн зөрүү 5.5 тэрбум төгрөгийг балансын эргэлтийн бус хөрөнгийн дансанд биет бус хөрөнгөөр бүртгэсэн байна.

2016 оны компанийн Аудитын тайлан Англи хэлээр бэлтгэгдсэн ба тайланд бүтээгдэхүүний ангилал хооронд хийх өөрчлөлтийг тухайн онд бус 2019 онд хэрэгжүүлсэн нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, цаг хугацаандаа байх үндсэн зарчимд нийцээгүй, хөрөнгө шамшигдсан байж болзошгүй эргэлзээг үүсгэж байна.

/2014-2022 онд бүтээгдэхүүний ангилал шилжүүлснээс үүссэн зөрүүг хүснэгтээр харуулав/.

| Он | Бүтээгдэхүүний нэр | Зарлага: Тоо хэмжээ /тонн/ | Зарлага: Нэгж үнэ /төгрөг/ | Зарлага: Нийт үнэ /төгрөг/ | Бүтээгдэхүүний нэр | Орлого: Тоо хэмжээ /тонн/ | Орлого: Нэгж үнэ /төгрөг/ | Орлого: Нийт үнэ /төгрөг/ |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2018 онд | Баяжмал бүхэл | 291,492.89 | 29,802.83 | 8,687,255,113.63 | Баяжмал Бүхэл | 143,046.34 | 32,086.53 | 4,589,860,256.88 |
| | | | | | ЗБ, Бүхэл, 50-54%, Хүхэртэй | 148,446.55 | 27,543.33 | 4,088,712,596.06 |
| | Дүн: | 291,492.89 | 29,802.83 | 8,687,255,113.83 | | 291,492.89 | 29,814.93 | 8,678,572,852.94 |
| 2019 онд | Баяжмал нунтаг | 15,649.79 | 36,884.02 | 577,227,241.69 | - | - | - | - |
| | - | - | - | | Баяжмал бүхэл | 6.43 | 30,088.90 | 193,471.61 |
| | ЗБ/Бүхэл 50%-54%, Хүхэртэй | 1,439.64 | 29,856.00 | 42,981,894.51 | ЗБ/Бүхэл 50%-54%, Хүхэртэй | 17,082.95 | 36,189.80 | 618,228,503.45 |
| | ЗБ-Нунтаг 45%-50% Хүхэргүй | 858,861.88 | 19,700.39 | 16,919,912,044.23 | ЗБ-Нунтаг 45%-50% Хүхэргүй | 858,861.88 | 13,312.12 | 11,433,270,114.30 |
| | Дүн: | 875,951.31 | 29,813.47 | 17,540,121,180.43 | | 875,951.26 | 26,530.27 | 12,051,892,089.36 |
| 2020 онд | Баяжмал бүхэл | 0.26 | 36,735.00 | 9,551.10 | Баяжмал нунтаг | 0.64 | 17,742.63 | 11,355.28 |
| | Баяжмал бүхэл Хүхэртэй 58% | 12,431.66 | 24,264.77 | 301,651,358.78 | Баяжмал бүхэл, Хүхэргүй | 17,074.58 | 24,424.71 | 417,041,629.13 |
| | Баяжмал нунтаг, Хүхэргүй 58% | 1,279.51 | 42,437.41 | 54,299,085.81 | | | | |
| | Баяжмал нунтаг Хүхэртэй, 56-58% | 1,462.75 | 23,682.04 | 34,640,897.02 | | | | |
| | ЗБ, Бүхэл 40-50% Хүхэртэй | 2,042.22 | 16,693.70 | 34,092,199.60 | | | | |
| | ЗБ, Бүхэл 50%-55% Хүхэргүй | 37,412.90 | 41,840.60 | 1,565,378,277.87 | ЗБ, Бүхэл 50%-55% Хүхэргүй | 2,025.31 | 15,774.45 | 31,948,157.80 |
| | ЗБ, Нунтаг 40%-45% Хүхэргүй | 108,187.82 | 12,194.57 | 1,319,303,608.21 | ЗБ, Нунтаг 50%-55% Хүхэргүй | 26,509.36 | 18,904.45 | 501,144,981.21 |
| | ЗБ, Нунтаг 45% доош Хүхэртэй | 121,829.41 | 6,045.39 | 736,506,296.92 | ЗБ, Нунтаг 40%-45% Хүхэртэй | 128,906.28 | 12,553.62 | 1,618,241,081.52 |
| | ЗБ, Нунтаг 45-50% Хүхэртэй | 0.15 | 32,096.33 | 4,814.45 | ЗБ, Нунтаг 45-50% Хүхэртэй | 101,951.72 | 13,188.50 | 1,344,589,875.13 |
| | ЗБ, Бүхэл 45%-50% Хүхэргүй | - | - | - | ЗБ, Бүхэл 45%-50% Хүхэргүй | 8,184.00 | 16,000.17 | 130,945,417.57 |
| | Дүн: | 284,846.88 | 23,598.98 | 4,045,886,088.78 | - | 284,651.89 | 14,406.56 | 4,043,922,497.64 |
| | Нийт дүн: | 1,452,090.88 | | 30,273,262,384.02 | | 1,452,096.04 | | 24,774,187,439.94 |
| | Зөрүү: | | | | | | | (5,499,074,944.08) |

## АРВАН ХОЁР. ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ТАЛААР

**12.1. Компанийн санхүүгийн тайланд бүртгэлтэй орон сууцны талаар:** "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2013.04.05-ны 06 дугаар тогтоолоор санхүүгийн тайланд бүртгэлтэй орон сууц хувьчлах асуудлыг Төрийн өмчийн хороонд хүргүүлсэн.

Төрийн өмчийн хорооны 2014.04.24-ний 18 дугаар тэмдэглэлээр компанийн балансад бүртгэлтэй, 41 айлын орон сууцыг одоогийн оршин сууж буй ажилтнуудад нь зохих журмын дагуу хувьчлахыг дэмжиж, Засгийн газарт тавьж шийдвэрлүүлэхийг даалгасан.

Орон сууцыг хувьчлах асуудлаар компанийн зүгээс 2006 оноос холбогдох байгууллагад хүсэлт тавьж ирсэн хэдий ч шийдвэрлэгдээгүй байж байгаад Засгийн газрын 2014 оны 69 дүгээр тогтоолын дагуу компанийн удирдлагын эрх болон хөрөнгийг концессын гэрээгээр "Кью Эс Си" ХХК-д шилжсэний дараа

Төрийн өмчийн хороонд 2015 онд 1-2/1205, 1-2/21207 албан бичгээр хүсэлтээ дахин хүргүүлсэн байна.

Төрийн өмчийн хорооны 2015 оны 02 дугаар сарын 05-ны 4/283 дугаар /2015.09.15-ны 1а/2406 дугаар/ албан бичгийг үндэслэн "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн ТУЗ-ийн 2015.03.20-ны өдрийн "Орон сууцны тухай" 15А тогтоолоор орон сууцыг эзэмшигч ажилтны өмчлөлд шилжүүлэх, худалдах шийдвэр гарган, хувьчлах ажил зохион байгуулагдсан байна.

Монголросцветмет нэгдэл нь "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-д менежментийн гэрээ хэрэгжүүлэх хугацаанд "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-д Удирдлагын багийн 2004.01.30-ны өдрийн 05 дугаар тогтоолын дагуу нэр бүхий ажилтанд хуваарилан эзэмшүүлсэн 35 орон сууцыг захирлын 2004 оны 787, 2006 оны А/16, А-74, 787, 2009 оны 143 дугаар тушаалуудыг үндэслэн 50-100% хувийн хөнгөлөлттэй нөхцөлөөр, үлдэгдэл төлбөрийг барагдуулсан ажилтнууд болон 2004 онд байр олгогдож урьдчилгаа төлбөрөө хийсэн ажилтанд орон сууцны үлдэх өртгөөр хувьчлах, 2009 оноос хойш ашиглалтад орсон 7, шүүхэд нэхэмжлэлтэй 2 нийт 9 байрыг дуудлагын худалдаагаар худалдан борлуулахаар "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн 2015.03.20-ны өдрийн 15А хурлын тогтоолоор шийдвэрлэсэн байна.

"Кью Эс Си" ХХК-ийн 2015 оны ТУЗ-ийн А/06 тогтоолоор "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн эзэмшлийн 35 орон сууцыг эзэмшигчдэд нь хувьчлах, 9 орон сууцыг дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч бүртгэлийг балансад холбогдох журмын дагуу бүртгэхээр шийдвэрлэсэн байна.

Тус компани 2014 онд 415.1 сая төгрөгийн 11 ширхэг, 2016 онд 262.2 сая төгрөгийн 6 ширхэг, 2019 онд 176.0 сая төгрөгийн 1 ширхэг нийт 853,3 сая төгрөгийн үнэтэй 17 ширхэг орон сууц шинээр худалдан авч үндсэн хөрөнгөд бүртгэж нэмэгдсэн байна. Нэг ордертой 1 байрыг хэмжилт хийн 2 салгаж засвар хийж 8.1 сая төгрөгөөр капиталжуулжээ.

2014 онд бараа материалын дансанд бүртгэлтэй 144.8 сая төгрөгийн 9 орон сууцыг үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлж, "Сонсголон хайрхан" ХХК-иас 2 ширхэг орон сууцыг 270.2 сая төгрөгөөр худалдан авч нийт 11 орон сууц нэмэгдсэн бол 2016 онд "Альфа констракшн" ХХК-иас 5 ширхэг орон сууцыг 262.2 сая төгрөгөөр худалдан авсан, 2019 онд "Эрин интернэшнл" ХК-иас 176.0 сая төгрөгөөр 1 ширхэг орон сууц худалдан авснаар нийт 853.3 сая төгрөгийн 17 орон сууц шинээр нэмэгдсэн байна.

Шинээр худалдан авсан орон сууцууд компанийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй байна.

ТУЗ-ийн шийдвэрийг үндэслэн "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн ерөнхий захирлын 2015 оны А/270, А/272 болон бусад холбогдох тушаалын дагуу хувьчлах ажлыг зохион байгуулж 2015 онд 181.1 сая төгрөгийг балансын үнэтэй 23, 2016 онд 96.6 сая төгрөгийн балансын үнэтэй 2, 2019 онд 41.3 сая төгрөгийн балансын үнэтэй 1, 2022 онд 19.5 сая төгрөгийн балансын үнэтэй 1, үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 338.5 сая төгрөгийн балансын үнэтэй 27, эргэлтийн хөрөнгөд бүртгэлтэй 104.9 сая төгрөгийн балансын үнэтэй 12 орон сууц, нийт 39 ширхэг 443,5 сая төгрөгийн орон сууцыг тус тус хувьчилж данснаас хассан байна.

/Төрийн өмчийн хорооны 2014 оны 207 дугаар тогтоолоор хүлээлгэн өгсөн орон сууц, хөдлөл өөрчлөлт/





| Он | Үзүүлэлт | | Балансын үнэ /мянган төгрөгөөр/ | Тоо /ш/ |
|---|---|---|---|---|
| Эхний үлдэгдэл /2014.04.24/ | Тогтоолын нэгдүгээр хавсралтын жагсаалт дахь орон сууцны дүн | Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй | 479,473.11 | 24 |
| | | Эргэлтийн хөрөнгөд бүртгэлтэй | 104,978.50 | 12 |
| Нэмэгдсэн /2021-2022/ | Худалдаж авч үндсэн хөрөнгөд бүртгэсэн орон сууцны дүн | | 861,405.11 | 17 |
| Хасагдсан /2014-2022/ | Эзэмшигч ажилтнуудад нь хувьчилж эргэлтийн хөрөнгийн материалын данснаас хассан | | 104,978.50 | 12 |
| | Эзэмшигч ажилтнуудад нь хувьчилж үндсэн хөрөнгийн данснаас хассан | | 181,128.39 | 23 |
| | Урьдчилгаа төлбөрөө хийсэн ажилтнуудад худалдаж үндсэн хөрөнгийн данснаас хассан | | 157,418.38 | 4 |
| Эцсийн үлдэгдэл /2022.03.31/ | Үндсэн хөрөнгийн бүртгэлээрх дүн | Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй | 1,002,331.45 | 14 |
| | | Эргэлтийн хөрөнгөд бүртгэлтэй | - | - |
| | Дуудлагын худалдаагаар худалдах шийдвэр гарсан ч зарагдаагүй болон төлбөрөө төлж дуусаагүй тул үндсэн хөрөнгөд бүртгэлтэй авлагаар бүртгэлтэй орон сууцны дүн /1 ордертой байрыг 2 салгаж 6 ширхэг/ | | 232,588.38 | 5+1 |

Хөрөнгө шилжүүлсэн тогтоолоор 24 ширхэг 479,5 сая төгрөгийн орон сууц хүлээлгэн өгсөн бол 853.3 сая төгрөгийн 17 орон сууц нэмэгдэж, үндсэн хөрөнгөөс 338.5 сая төгрөгийн 27, эргэлтийн хөрөнгөөс 104.9 сая төгрөгийн 12, нийт 443.5 сая төгрөгийн 39 орон сууц хасагдаж 2022 онд төрийн өмчид хөрөнгө хүлээж авахад **14** буюу 1 ордертой 2 орон сууцыг 2 салгаж бүртгэсэнтэй холбоотойгоор 1,004.5 сая төгрөгийн **16** орон сууц бүртгэлтэй, "Альфа констракшн" ХХК-иас худалдан авсан 1 ширхэг орон сууц бүртгэлгүй байна.

Орон сууц худалдан авахдаа тухайн байранд худалдан авсан автомашины 4 ширхэг зогсоол бусад үндсэн хөрөнгөд бүртгэлтэй байгаа бол 1 "Альфа констракшн" ХХК-иас авсан 1 ширхэг зогсоол бүртгэлгүй байна.

/Үндсэн хөрөнгөд бүртгэлгүй авто зогсоол/

| Хөрөнгийн нэр | | Ашиглалтад орсон огноо | Тоо ширхэг | Балансын үнэ /төгрөгөөр/ |
|---|---|---|---|---|
| Худалдаж авсан орон сууцны зогсоол | Сонголон хайрханы дулаан зогсоол | 2014/09/31 | 2 | 29,090,909.08 |
| | Дархан нэхийгийн 15 тоот машины зогсоол | 1/1/2011 | 2 | 7,272,728.00 |
| | 13-р баг, 10-р хороолол, Альфа хотхон 3-р байр, 46 тоотын зогсоол | 12/1/2016 | 1 | Бүртгэлгүй байгаа |
| Нийт дүн | | [redacted] | 5 | 36,363,637.08 |

Монгол Улсын "Эдийн засгийн хөгжлийн яам" болон "Кью Эс Си" ХХК-ийн хооронд байгуулсан Концессын гэрээний 4.5-д "Энэхүү гэрээний хугацаанд "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК нь төрийн өмч хэвээр байна" гэж заасан.

Гэтэл "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль"-ийн 9 дүгээр зүйлийн 9.3-т "төрийн өөрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг хувьчлалаас гадуур худалдах, шилжүүлэх тухай шийдвэр гаргах; гэж заасан Засгийн газрын бүрэн эрхийг зөрчиж концесс эзэмшигч болон түүний томилсон удирдлагын баг удирдлагын эрхээ хэтрүүлэн төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгө болох тус компанид бүртгэлтэй 443,525,268.33 төгрөгийн балансын үнэ бүхий 39 ширхэг орон сууцыг хувьчлах шийдвэр гаргасан тул нөхөн төлүүлэх шаардлагатай.

## АРВАН ГУРАВ. ТАТВАРЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР

**13.1. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын талаар:** "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайланг Том татвар төлөгчийн газарт цахимаар тайлагнадаг. Татвар төлөгчийн цахим

системд ирүүлсэн 2014-2021 оны тайлангийн дэлгэрэнгүйг хавсралтаар дэлгэрэнгүй үзүүлэв.

/ААНОАТ-ын тайлагнал, мянган төгрөгөөр/

| Огноо | Орлого | Өртөг | Үйл ажиллагааны зардал | Татвар ногдуулах орлого | Ногдуулсан татвар | Хүүгийн орлогоос суутгасан татвар | Нийт суутгасан татвар |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2014 | 92,312,972.10 | 75,612,593.70 | 10,309,230.90 | 261,173.10 | 26,117.30 | 2,215.80 | 28,333.10 |
| 2015 | 74,628,613.30 | 44,470,059.80 | 36,206,167.90 | -9,821,258.21 | 0 | 5,713.70 | 5,713.70 |
| 2016 | 110,951,268.50 | 45,115,323.50 | 64,017,269.60 | -1,760,407.64 | 0 | 335.7 | 335.7 |
| 2017 | 137,816,231.30 | 58,320,896.30 | 75,538,072.60 | -2,995,304.85 | 0 | 1,904.60 | 1,904.60 |
| 2018 | 171,767,416.60 | 79,751,097.30 | 94,789,550.60 | -15,870,327.45 | 0 | 5,458.30 | 5,458.30 |
| 2019 | 218,467,355.30 | 91,668,232.70 | 111,816,554.90 | 16,457,826.00 | 2,094,697.90 | 1,922.60 | 2,096,620.50 |
| 2020 | 305,261,876.80 | 102,153,419.90 | 123,031,044.80 | 86,379,760.10 | 19,731,961.70 | 134.1 | 19,732,095.80 |
| 2021 | 432,874,388.90 | 129,528,285.60 | 224,290,240.30 | 166,565,951.40 | 38,941,487.80 | 0 | 38,941,487.80 |
| Нийт дүн | 1,544,080,122.90 | 626,619,906.70 | 739,998,131.70 | 239,217,412.40 | 60,794,264.70 | 17,684.80 | 60,811,949.50 |

/Ногдуулалт төлөлтийг графикаар харуулбал/




Дээрх тайлагналаас харахад сүүлийн жилүүдэд борлуулалтын орлого нэмэгдсэн хэрээр компанийн татвар ногдуулах орлого өссөн ч Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн дагуу төлөх ёстой татвараа хугацаа хожимдуулж төлсөн бөгөөд 2021.12.31-ний өдрийн байдлаар 55,023.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

**13.2. Нэмэгдсэн өртгийн албан татварын талаар:** "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК нь 2014 онд Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчөөр бүртгүүлэн тайлагнаж иржээ. Шалгалтад хамруулах хугацаагаар НӨАТ-ын борлуулалт, худалдан авалт, буцаалтыг он тус бүрээр харуулбал

/НӨАТ ногдуулалт/

| Он | Борлуулалтын орлого /мянган төгрөгөөр/ | | Нийт борлуулалт /мянган төгрөгөөр/ | Ногдуулсан татвар /мянган төгрөгөөр/ |
|---|---|---|---|---|
| | Дотоодын борлуулалт | Экспортын борлуулалт | | |
| 2014 | 89,098,661.17 | 1,607,103.92 | 90,705,765.09 | 8,909,866.12 |
| 2015 | 51,459,384.75 | 22,719,344.84 | 74,178,729.58 | 5,145,938.47 |
| 2016 | 37,166,222.57 | 68,523,960.97 | 105,690,183.55 | 3,716,622.26 |
| 2017 | 71,325,994.79 | 65,666,732.82 | 136,992,727.61 | 7,132,599.48 |
| 2018 | 61,101,444.26 | 101,152,655.65 | 162,254,099.91 | 6,110,144.43 |
| 2019 | 55,334,154.64 | 155,269,952.79 | 210,604,107.43 | 5,533,415.46 |
| 2020 | 48,846,432.99 | 255,922,159.11 | 304,768,592.10 | 4,884,643.30 |
| 2021 | 135,993,397.49 | 303,672,417.65 | 439,665,815.14 | 13,599,339.75 |
| Нийт дүн | 550,325,692.67 | 974,534,327.75 | 1,524,860,020.42 | 55,032,569.27 |



/Графикаар харуулбал/




/Худалдан авалтад ногдуулсан НӨАТ/

| Огноо | Худалдан авалт /мянган төгрөгөөр | | Нийт худалдан авалт /мянган төгрөгөөр/ | Ногдуулсан татвар /мянган төгрөгөөр/ |
|---|---|---|---|---|
| | импорт | дотоодын ХА | | |
| 2014 | 12,762,488.96 | 59,371,657.91 | 72,134,146.87 | 7,213,414.69 |
| 2015 | 6,423,330.41 | 26,995,412.99 | 33,418,743.40 | 3,341,874.34 |
| 2016 | 2,622,526.88 | 22,986,241.77 | 25,608,768.66 | 2,560,876.87 |
| 2017 | 12,574,412.53 | 81,810,257.70 | 94,384,670.23 | 9,438,467.02 |
| 2018 | 9,562,479.38 | 86,679,611.78 | 96,242,091.16 | 9,624,209.12 |
| 2019 | 11,790,324.60 | 122,728,278.09 | 134,518,602.69 | 13,451,860.27 |
| 2020 | 6,248,552.87 | 150,651,592.84 | 156,900,145.70 | 15,690,014.57 |
| 2021 | 9,293,783.37 | 163,413,735.70 | 172,707,519.07 | 17,270,751.91 |
| Нийт дүн | 71,277,899.00 | 714,636,788.77 | 785,914,687.77 | 78,591,468.78 |

/Графикаар харуулбал/




/НӨАТ-ын залруулга/

| Огноо | Хасагдахгүй НӨАТ | Буцаалт /мянган төгрөгөөр/ | | Эцсийн тооцоогоор /мянган төгрөгөөр/ | |
|---|---|---|---|---|---|
| | | Бор буцаалт | ХА буцаалт | буцаан авах | төлбөл зохих |
| 2014 | 384.55 | 6191.56363 | 0 | 1,035,280.18 | 2,725,924.59 |
| 2015 | 11,236.58 | 0 | 0 | 580,891.49 | 2,398,192.21 |
| 2016 | 989,810.53 | 659.2 | 0 | 194,535.60 | 2,339,432.32 |
| 2017 | 4,320,263.06 | 0 | 0 | 1,377,464.30 | 3,391,859.82 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2018 | 5,868,541.57 | 0 | 1,145.45 | 3,310,258.94 | 954,636.60 |
| 2019 | 8,304,260.48 | 0 | - | 1,743,002.86 | 1,357,187.18 |
| 2020 | 10,404,139.15 | 0 | 4,060.72 | 522,144.04 | 919,315.44 |
| 2021 | 7,608,185.07 | 609,903.80 | 5,492.07 | 7,849,229.43 | 4,752,470.21 |
| Нийт дүн | 37,506,820.39 | 616,754.37 | 10,698.24 | 16,612,806.84 | 18,837,018.37 |

/Графикаар харуулбал/




Дээрх тайлагналаас харахад экспортын борлуулалт сүүлийн жилүүдэд тогтмол өссөн байх бөгөөд 2021 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар 8,309.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Нэмэгдсэн өртгийн албан татварын чөлөөлөгдөх борлуулалтад хувь тэнцүүлэн худалдан авалтад хасалт хийхдээ нэмэгдсэн өртгийн албан татвар ногдох дотоодын борлуулалтын дүнг нийт борлуулалтын дүнд харьцуулсан хувь хэмжээгээр худалдан авалтаас хасагдахгүй дүн буюу үндсэн хөрөнгө, сэлбэг, суудлын автомашинд төлсөн дүнг хассан худалдан авалтын нэмэгдсэн өртгийн албан татварыг үржүүлсэн хэмжээгээр хасалт хийсэн байна.

"Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК нь "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-тай 2021.03.29-ний өдрийн 2021/10-39-0134 тоот бөөрөнхий төмөр ф100 худалдах, худалдан авах гэрээний дагуу 3,037.9 тн бөөрөнхий төмөр ф100 бүтээгдэхүүн нийлүүлснээс 1,096.4 тн бүтээгдэхүүн чанарын шаардлага хангахгүй бутарсан тул 2,488.8 сая төгрөгийн, мөн 2021.03.29-ний өдрийн 2021/10-39-0135 тоот бөөрөнхий төмөр ф80 худалдах, худалдан авах гэрээний дагуу 7,975.91 тн бөөрөнхий төмөр ф80 бүтээгдэхүүн нийлүүлснээс 1,591.25 тн бүтээгдэхүүн чанарын шаардлага хангахгүй бутарсан тул 3,612.1 сая төгрөгийн, нийт 2,687.7 тн бүтээгдэхүүнийг 6,100.9 сая төгрөгийн / НӨАТ гүй дүн / дүнгээр борлуулалтын буцаалт хийснийг тус тус нэмэгдсэн өртгийн албан татварын тайландаа тайлагнасан байна.

**13.3. АМНАТ-ын тайлангийн талаар:** Шалгалтад хамруулсан хугацааны АМНАТ-ын дотоод, гадаад борлуулалтаар ногдуулсан татварыг он тус бүрээр харуулбал:

/АМНАТ-ын тайлагнал/

| Огноо | Борлуулатын үнэлгээ /мянган төгрөгөөр/ | | | Үндсэн /төгрөгөөр/ | Нэмэлт /төгрөгөөр/ | Нийт төлбөр /төгрөгөөр/ |
|---|---|---|---|---|---|---|
| | Дотоодын борлуулалт | Экспорт | Нийт | | | |
| 2014 | 22,026,022.20 | 16,680,795.73 | 38,706,817.93 | 1,935,340.90 | 398,199.72 | 2,333,540.61 |
| 2015 | 3,861,902.81 | 42,445,159.19 | 46,307,062.00 | 2,315,353.08 | 272,689.09 | 2,588,042.17 |
| 2016 | 119,234.56 | 65,335,195.51 | 65,454,430.06 | 3,272,721.46 | 10,526.34 | 3,283,247.80 |
| 2017 | 6,167,374.98 | 80,720,800.73 | 86,888,175.71 | 4,344,408.79 | - | 4,344,408.79 |





| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 2018 | 6,997,766.28 | 55,839,966.68 | 62,837,732.96 | 3,141,886.64 | - | 3,141,886.64 |
| 2019 | 29,782,857.26 | 148,619,942.90 | 178,402,800.16 | 8,920,139.99 | 58,534.47 | 8,978,674.46 |
| 2020 | 27,666,821.40 | 256,248,795.44 | 283,915,616.84 | 14,164,253.77 | 71,162.17 | 14,235,415.94 |
| 2021 | 35,295,456.84 | 299,512,554.54 | 334,808,011.37 | 16,740,400.57 | 3,555,278.05 | 20,295,678.62 |
| Нийт дүн | 131,917,436.32 | 965,403,210.72 | 1,097,320,647.04 | 54,634,505.20 | 4,366,389.83 | 59,200,895.03 |

/Графикаар/




Дээрх тайлагналаар АМНАТ-ын борлуулалт тогтмол өсөж байсан бөгөөд 2021.12.31-ний өдрийн байдлаар 43,927.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Ашигт малтмалын тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 342 дугаар, 2019 оны 465 дугаар тоот тогтоолоор баталсан журмын дагуу олон улсын худалдаанд хүлээн зөвшөөрөгдсөн тухайн сарын дунджийг тогтоох зарчмыг үндэслэн тухайн бүтээгдэхүүний олон улсын зах зээлийн үнийг баримтлан нийтэд зарласан үнээс 30 болон түүнээс дээш хувиар бага бол Ашигтмалтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулах борлуулалтын үнэлгээгээр тайлагнах зохицуулалттай боловч зарим тохиолдолд бүтээгдэхүүн худалдах худалдан авах гэрээний үнийн дүнгээр тайлагнасан асуудлыг нягтлан ажиллаж байна.

**13.4. Хувь хүний орлогын албан татварын талаар:** Тус компани нь цалин, хөдөлмөрийн хөлс тэдгээртэй адилтгах бусад орлогоос суутгасан орлогын албан татварын тайланг Дархан-Уул аймгийн татварын хэлтэст "Үйлдвэр"-ийн ажилчдын, Сэлэнгэ аймгийн татварын хэлтэст "Уурхай"-н ажилчдын цалин, хөлс тэдгээртэй адилтгах бусад орлогоос суутгасан албан татварыг тус тус суутган тайлагнадаг байна.

/ХХОАТатварын тайлан/

| Дархан-Уул аймаг | | | | Сэлэнгэ аймаг | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| Он | Ажилчдын тоо | Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах орлого | Суутгасан татвар /мянган төгрөгөөр/ | Он | Ажилчдын тоо | Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах орлого | Суутгасан татвар /мянган төгрөгөөр/ |
| 2014 | 1778 | 21,414,607.88 | 1,811,315.84 | 2014 | 71 | 801,699.41 | 66,891.01 |
| 2015 | 1575 | 11,981,489.66 | 997,941.80 | 2015 | 63 | 364,895.45 | 30,107.85 |
| 2016 | 1225 | 10,055,799.68 | 837,635.66 | 2016 | 50 | 469,291.65 | 39,164.49 |
| 2017 | 1350 | 14,762,626.61 | 1,245,653.71 | 2017 | 72 | 728,630.75 | 61,240.62 |
| 2018 | 1357 | 15,924,266.77 | 1,279,255.06 | 2018 | 68 | 695,067.79 | 54,920.74 |
| 2019 | 1333 | 18,688,593.94 | 1,428,354.38 | 2019 | 63 | 891,756.44 | 68,080.03 |
| 2020 | 2830 | 21,517,512.50 | 1,674,700.55 | 2020 | 105 | 1,860,606.99 | 145,415.37 |
| 2021 | 3095 | 28,941,199.19 | 2,321,261.60 | 2021 | 262 | 2,583,686.64 | 205,079.67 |
| Нийт дүн | | 143,286,096.23 | 11,596,118.60 | Нийт дүн | | 8,395,616.12 | 670,899.78 |

Цалин, хөдөлмөрийн хөлс тэдгээртэй адилтгах орлогын албан татварын тайлангийн төрлөөр 2021 оны 12 сарын 31-ний байдлаар 1,115.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

**13.5. Албан татвар төлөлтийн талаар:** "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК нь 2014-2021 оныг дуусталх хугацаанд Авто тээвэр, өөрөө явагч хэрэгслийн албан татварын төрлөөр 256.0 сая төгрөг, автын агаарын бохирдлын төлбөрөөр

11.1 сая төгрөг, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын төрлөөр 8,821.7 сая төгрөг, ашигт малтмалын нөөц ашигласны нэмэлт төлбөрөөр 0.2 сая төгрөг, ашигт малтмал нөөц ашигласны төлбөр- тусгай зөвшөөрөл эзэмшигчийн төрлөөр 19,672.7 сая төгрөг, ахуйн хэрэглээний ус, рашаан ашигласны төлбөрөөр 0.7 сая төгрөг, газрын төлбөрөөр 777.5 сая төгрөг, галт зэвсгийн албан татварын төрлөөр 0,03 сая, нэмэгдсэн өртгийн албан татварын төрлөөр 5,583.3 сая төгрөг, зам ашигласны төлбөрөөр 4.7 сая төгрөг, иргэний үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны орлогоос суутгасан албан татварын төрлөөр 0.07 сая төгрөг, суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан албан татварын төрлөөр 432.1 сая төгрөг, суутгагчийн хуулийн этгээдэд олгосон орлогоос суутгасан татвар 202.5 сая төгрөг, үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөрөөр 118.9 сая төгрөг, үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар 541.3 сая төгрөг, хуулийн этгээдийн үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын төрлөөр 309.5 сая төгрөг, цалин, хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах орлогоос суутгасан татварын төрлөөр 11,037.6 сая төгрөг, татварын алданги, торгуулиар 830.6 сая төгрөгийг тус тус төлж, улс, аймаг нийслэл, орон нутгийн төсөвт нийт 48,600.7 сая төгрөгийг төлсөн байна.

## АРВАН ДӨРӨВ. ГААЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР

**14.1 Импортын байдлын талаар:** "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК нь гаалийн байгууллагад 2014-2021 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар 509 гаалийн мэдүүлгээр 1954 нэр төрлийн бараанд импортын барааны гаалийн бүрдүүлэлт хийсэн байна. Дээрх гаалийн мэдүүлгүүдийг эрсдэл тооцсон байдлаар нь хяналтын төлөвөөр ангилан авч үзвэл 374 гаалийн мэдүүлгээр буюу 74.4 хувиар **"улаан"** төлөвт, 117 гаалийн мэдүүлгээр буюу 23 хувиар **"улбар шар"** төлөвт, 18 гаалийн мэдүүлгээр буюу үлдсэн 2.6 хувиар **"ногоон"** төлөвт сонгогдсон, нийт гаалийн бүрдүүлэлтийн 96.2 хувийг гаалийн үнэлгээний 1-р арга буюу хэлцлийн үнийн аргаар гаалийн бүрдүүлэлтийг хийсэн байна.

Импортын барааны гаалийн бүрдүүлэлтийн 80 гаруй хувийг БНХАУ-аас тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, түүхий эд материал зэргийг импортолсон бөгөөд Япон болон Герман улсаас мөн сэлбэг тоног төхөөрөмж, түүхий эд материал импортолсон байна.

Гаалийн газар хороодоор хийсэн бүрдүүлэлтийг ангилахад нийт бүрдүүлэлтийн 53.05 хувь буюу 270 гаалийн мэдүүлгээр Дархан уул аймаг дахь Гаалийн газраар, 18.86 хувь буюу 96 гаалийн мэдүүлгээр Замын Үүд дэх гаалийн газраар, 49 гаалийн мэдүүлгээр буюу 9.63 хувийг Улаанбаатар хот дахь гаалийн газраар, 11.2 хувь буюу 57 гаалийн мэдүүлгээр Буянт Ухаа дахь гаалийн газраар, үлдсэн 7.27 хувь Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газар болон Сэлэнгэ аймаг дах гаалийн газраар импортын барааны бүрдүүлэлтийг хийсэн байна.

Гаалийн бүрдүүлэлтийн дараах шалгалтад өмнө 2010 онд хамрагдаж байсан, ЭЗИТБДТХ-ийн дагуу татварын байгууллагад шинэчилсэн мэдүүлэг гарган өгсөн байна.





/Импортын гаалийн бүрдүүлэлт, төгрөгөөр/

| Д/д | Он | ГМэд тоо | Бичлэг тоо | Статистик дүн | Суурь үнэлгээ /MNT/ | Гааль | НӨАТ | Нийт татвар |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2014 он | 77 | 546 | 7,089,589.53 | 12,968,228,493.12 | 613,325,307.08 | 1,287,983,144.98 | 1,901,308,452.22 |
| 2 | 2015 он | 34 | 95 | 3,123,714.04 | 6,123,641,652.33 | 306,182,082.58 | 642,982,373.50 | 949,164,456.11 |
| 3 | 2016 он | 25 | 116 | 6,924,335.83 | 16,318,487,922.77 | 126,920,596.07 | 266,533,251.66 | 393,453,847.69 |
| 4 | 2017 он | 93 | 327 | 4,989,306.39 | 12,123,096,149.57 | 517,238,325.83 | 1,264,033,447.52 | 1,781,271,773.39 |
| 5 | 2018 он | 75 | 144 | 3,772,652.48 | 9,338,482,732.70 | 467,241,243.72 | 980,572,397.64 | 1,447,813,641.34 |
| 6 | 2019 он | 92 | 357 | 4,231,166.94 | 11,231,227,409.04 | 559,097,186.99 | 1,179,032,459.54 | 1,738,129,646.59 |
| 7 | 2020 он | 40 | 196 | 2,120,921.57 | 5,952,282,635.09 | 297,614,131.74 | 624,989,676.66 | 922,603,808.44 |
| 8 | 2021 он | 73 | 173 | 6,151,169.29 | 17,527,726,824.29 | 876,148,652.44 | 1,840,387,547.57 | 2,716,536,200.04 |
| Дүн | | 509 | 1954 | 38,402,856.06 | 91,583,173,818.91 | 3,763,767,526.45 | 8,086,514,299.07 | 11,850,281,825.52 |

"Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК нь 2014-2021 онуудад нийт 509 гаалийн мэдүүлгээр, 1954 нэр төрлийн 38.4 сая ам.долларын 91.5 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий бараанд 3.76 тэрбум төгрөгийн барааны гаалийн татвар, 8.08 тэрбум төгрөгийн НӨАТ, нийт 11.8 тэрбум төгрөгийн импортын барааны татварыг төлсөн байна.

**14.2. Экспортын байдлын талаар:** "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК нь гаалийн байгууллагад 2014-2021 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар 131,357 гаалийн мэдүүлгээр төмрийн хүдэр болон хүдрийн баяжмалд экспортын гаалийн бүрдүүлэлт хийснээс хяналтын төлөвийг авч үзвэл 44,451 гаалийн мэдүүлгээр буюу 33.8 хувиар **"улаан"** төлөвт, 84,337 гаалийн мэдүүлгээр буюу 64.2 хувиар **"улбар шар"** төлөвт, 2572 гаалийн мэдүүлгээр буюу үлдсэн 2 хувиар **"ногоон"** төлөвт сонгогдсон, төмрийн хүдэр болон хүдрийн баяжмалыг гаалийн үнэлгээний хэлцлийн үнийн 1-р аргаар, мөн 4-р аргаар буюу Сангийн яамнаас цахим сүлжээнд байршуулсан экспортод гаргасан ашигт малтмалын бүтээгдэхүүний олон улсын зах зээлийн үнийн мэдээллийг үндэслэн гаалийн үнийг тогтоож гаалийн бүрдүүлэлтийг хийсэн байна.

Гаалийн газар хороодоор хийсэн бүрдүүлэлтийг ангилахад нийт бүрдүүлэлтийн 99.9 хувь буюу 131,350 гаалийн мэдүүлгээр Дархан уул аймаг дахь гаалийн газраар, үлдсэн 0.1 хувийг УБГГ, БУГГ, УХШИГГ-аар гаалийн бүрдүүлэлтийг хийсэн байна.

/Экспортын барааны гаалийн бүрдүүлэлтийн мэдээлэл, төгрөгөөр/

| Он | Гад тоо | Барааны нэр | Барааны код | Гаалийн мэдүүлгийн тоо | | Статистик дүн/USD/ | | Суурь үнэлгээ/MNT/ | | Ачилагдсан тоо хэмжээ /кг/ | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2014 он | 4 | төмрийн хүдэр | 2601.11.10 | 682 | 682 | 6,726,176.34 | 6,726,176.34 | 12,653,771,050.16 | 12,653,771,050.16 | 99,506,468.32 | 99,506,468.32 |
| | | төмрийн баяжмал | 2601.11.20 | - | | - | | - | | - | |
| 2015 он | 5 | төмрийн хүдэр | 2601.11.10 | 5,583 | 5,739 | 14,777,810.12 | 15,245,540.92 | 29,228,033,105.00 | 30,159,959,141.00 | 380,064,835.82 | 389,971,657.48 |
| | | төмрийн баяжмал | 2601.11.20 | 156 | | 467,730.80 | | 931,926,036.00 | | 9,906,821.66 | |
| 2016 он | 3 | төмрийн хүдэр | 2601.11.10 | 14,905 | 16,055 | 41,970,404.72 | 45,512,164.46 | 89,576,560,356.86 | 98,232,286,567.83 | 961,065,395.34 | 1,036,078,237.64 |
| | | төмрийн баяжмал | 2601.11.20 | 1,150 | | 3,541,759.74 | | 8,655,726,210.97 | | 74,992,842.30 | |
| 2017 он | 8 | төмрийн хүдэр | 2601.11.10 | 6,972 | 10,492 | 25,285,143.26 | 40,281,250.72 | 61,823,739,388.96 | 98,321,522,348.10 | 511,301,058.01 | 738,951,827.11 |
| | | төмрийн баяжмал | 2601.11.20 | 3,520 | | 14,996,107.46 | | 36,497,782,959.14 | | 227,650,769.10 | |
| 2018 он | 6 | төмрийн хүдэр | 2601.11.10 | 12,843 | 15,893 | 35,352,249.97 | 47,794,345.75 | 87,313,294,958.54 | 117,735,571,040.70 | 881,199,323.41 | 1,094,949,153.41 |
| | | төмрийн баяжмал | 2601.11.20 | 3,050 | | 12,442,095.78 | | 30,422,276,082.16 | | 213,749,830.00 | |
| 2019 он | 16 | төмрийн хүдэр | 2601.11.10 | 17,331 | 22,407 | 70,606,599.54 | 97,752,605.76 | 188,267,457,875.79 | 260,727,740,603.71 | 1,185,843,052.95 | 1,527,814,547.67 |
| | | төмрийн баяжмал | 2601.11.20 | 5,076 | | 27,146,006.22 | | 72,460,282,727.92 | | 341,971,494.72 | |
| 2020 он | 23 | төмрийн хүдэр | 2601.11.10 | 17,903 | 34,022 | 91,322,562.63 | 185,006,731.25 | 257,159,825,689.83 | 519,932,509,972.29 | 1,209,232,445.03 | 2,305,442,171.11 |
| | | төмрийн баяжмал | 2601.11.20 | 16,119 | | 93,684,168.62 | | 262,772,684,282.46 | | 1,096,209,726.06 | |
| 2021 он | 37 | төмрийн хүдэр | 2601.11.10 | 13,184 | 26,067 | 105,430,861.00 | 241,280,649.93 | 300,403,789,887.54 | 687,476,002,174.54 | 867,313,773.97 | 1,727,447,682.24 |
| | | төмрийн баяжмал | 2601.11.20 | 12,883 | | 135,849,788.93 | | 387,072,212,287.00 | | 860,133,908.27 | |
| Нийт дүн | | төмрийн хүдэр | 2601.11.10 | 89,403 | 131,357 | 391,471,806 | 679,599,463 | 1,028,426,472,313 | 1,825,239,364,808 | 6,095,546,353 | 8,930,161,745 |
| | | төмрийн баяжмал | 2601.11.20 | 41,954 | | 288,127,658 | | 796,812,892,565 | | 2,824,615,392 | |

Тус Дарханы төмөрлөгийн үйлдвэр ТӨХК нь 2014-2021 онуудад нийт 131,357 гаалийн мэдүүлгээр, 679.6 сая ам.долларын 1 их наяд 825.2 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 8.9 сая тонн төмрийн хүдэр болон хүдрийн баяжмалд экспортын барааны гаалийн бүрдүүлэлтийг хийсэн байна.

**14.3. Импортын барааны шалгалтын талаар:** 2014 онд үйлдвэр болон уурхайн санхүүгийн бүртгэл тайланг нэгдсэн бүртгэлээр хөтлөн явуулж байсан бөгөөд 2015 оноос үйлдвэр уурхайгаар тус тусад нь салган бүртгэж санхүүгийн тайланг бэлтгэн, нэгтгэлийг улсад өгч байсан бөгөөд шалгалтын ажлын хэсэг нь 8 жилийн үйлдвэр болон уурхай гэсэн 16 гүйлгээ балансыг тулган шалгасан бөгөөд шаардлагатай тохиолдолд 2010 хүртэл санхүүгийн болон бусад баримтуудыг тулган шалгаж ажиллаж байлаа.

Санхүү бүртгэлийн гүйлгээ баланс, санхүүгийн тайлан, харилцах, кассын бүртгэл, бараа материал, түүхий эд, үндсэн хөрөнгийн бүртгэл, авлага, өглөгийн бүртгэл зэрэг холбогдох дансны бүртгэлийг тухай бүр нягтлан бодогч нараас гаргуулан авч, тайлбар тодруулга авч, анхан шатны бичиг баримттай тулган шалгаж ажилласан.

"Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК нь импортолсон барааг орлогод авахдаа гадаад харилцагчийн авлага, өглөг дансанд хуримтлуулсан төлбөр тооцоог хааж, худалдан авалтын дансанд өртгийг хуримтлуулж, орлогод авдаг. Бараа орлогод өртөг тооцож бүртгэхдээ гадаадаас худалдан авсан барааны үнэ, дотоод тээврийн зардал, гаалийн байгууллагад төлсөн гаалийн татвар, хураамж, тэдгээртэй холбогдох бусад зардлыг оруулж тооцдог байна. Өртөг тооцсон бүртгэлийн баримтыг хэвлэж, гадаад худалдааны гэрээ, барааны үнийн нэхэмжлэх, холбогдох бичиг баримтын хамт архивлаж хадгалсан байсан.

Иймд гадаадад шилжүүлсэн мөнгөний банкны хуулгыг анхан шатны баримттай тулгаж шалгасан. Гадаад харилцагч болон гадаад мөнгөн гүйлгээний бүртгэлийг шалгалтын материалд хавсаргав.

Гадаад харилцагчийн авлага, өглөгийн бүртгэлд хаалтын бичилт хийж, барааг орлогод авдаг тул гаалийн мэдүүлгийг гадаад харилцагч тус бүрээр валютын дүнгээр тулган баталгаажуулаа.

Санхүүгийн анхан шатны баримтаас үндсэн хөрөнгө, дараа тайлан, сэлбэг материал, түүхий эд материалыг орлогод авсан өртгийн дэлгэрэнгүй бүртгэлийг гаалийн байгууллагад мэдүүлсэн барааны үнэ, тоо ширхэг, гадаад харилцагчийн мэдээлэл, төлсөн татварын дүн зэрэг мэдээлэлтэй тулган шалгалаа.

2014-2021 оны үйлдвэр болон уурхайн санхүүгийн тайланд гадаад худалдаатай холбоотой дансны бүртгэл гүйлгээ балансад тусгасан байдлыг он оноор хүснэгтээр харуулбал: /Гадаад худалдааны бүртгэл, төгрөгөөр/

| Он | Ангилал | Дансны утга | Эхний үлдэгдэл Авлага | Эхний үлдэгдэл Өглөг | Гүйлгээний дебет | Гүйлгээний кредит | Эцсийн үлдэгдэл Авлага | Эцсийн үлдэгдэл Өглөг |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2014 | Үйлдвэр, уурхай нэгдсэн | Гадаадын байгууллагаас авах авлага | 116,500,483 | | 2,602,576,494 | 2,719,076,957 | - | |
| | | Гадаадын байгууллагаас авах валютын авлага | 175,491,865 | | 8,528,020,153 | 7,670,125,654 | 1,033,386,374 | |
| | | Гадаадын байгууллагад өгөх өглөг | | 1,146,363,240 | 1,579,874,678 | 572,417,661 | | 138,906,223 |
| | | Гадаадын байгууллагад өгөх өглөг /USD/ | | 2,569,123,598 | 15,635,513,359 | 15,787,085,158 | | 2,720,695,396 |
| | | Урьдчилж төлсөн тооцоо | 7,502,118,846 | | 21,562,143,315 | 23,771,599,369 | 5,312,662,791 | |
| | | Дүн | 7,794,111,174 | 3,715,486,838 | 49,828,128,006 | 50,520,304,797 | 6,346,049,165 | 2,859,601,619 |
| Он | Ангилал | Дансны утга | Эхний үлдэгдэл Авлага | Эхний үлдэгдэл Өглөг | Гүйлгээний дебет | Гүйлгээний кредит | Эцсийн үлдэгдэл Авлага | Эцсийн үлдэгдэл Өглөг |
| 2015 | Үйлдвэр | Гадаадын байгууллагаас авах авлага | | | 7,245,000 | 7,245,000 | - | |
| | | Гадаадын байгууллагаас авах валютын авлага | | | 935,163,934 | - | 935,163,934 | |
| | | Гадаадын байгууллагад өгөх өглөг | | 129,415,314 | 129,415,314 | - | | - |
| | | Гадаадын байгууллагад өгөх өглөг /USD/ | | 2,720,695,396 | 1,733,721,301 | 5,049,531,831 | | 6,036,505,926 |
| | | Урьдчилж төлсөн тооцоо | 4,269,644,633 | | 20,736,227,596 | 23,964,049,255 | 1,041,822,974 | |
| | | Урьдчилж төлсөн тооцоо USD | | | 477,594,260 | 477,594,260 | - | |
| | | Урьдчилж төлсөн тооцоо-Евро | | | 3,063,518,676 | - | 3,063,518,676 | |
| | | Дүн | 4,269,644,633 | 2,850,110,710 | 27,082,889,081 | 29,518,420,346 | 5,040,505,583 | 6,036,505,926 |
| | Уурхай | Гадаадын байгууллагаас авах авлага | | | 1,504,470 | - | 1,504,470 | |
| | | Гадаадын байгууллагаас авах валютын авлага | 1,033,386,374 | | 7,898,296,950 | 8,931,683,324 | - | |
| | | Гадаадын байгууллагад өгөх өглөг | | 9,490,909 | 21,651,709 | 12,160,800 | | - |
| | | Гадаадын байгууллагад өгөх өглөг /USD/ | | | 18,480,566,955 | 19,296,383,823 | | 815,816,868 |
| | | Урьдчилж төлсөн тооцоо | 1,054,324,933 | | 9,230,694,071 | 631,704,874 | 9,653,314,130 | |
| | | Дүн | 2,087,711,306 | 9,490,909 | 35,632,714,155 | 28,871,932,820 | 9,654,818,600 | 815,816,868 |





| Он | Ангилал | Дансны утга | Эхний үлдэгдэл Авлага | Эхний үлдэгдэл Өглөг | Гүйлгээний дебет | Гүйлгээний кредит | Эцсийн үлдэгдэл Авлага | Эцсийн үлдэгдэл Өглөг |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2016 | Үйлдвэр | Гадаадын байгууллагаас авах авлага | | | 79,029,265 | 79,029,265 | - | |
| | | Гадаадын байгууллагаас авах валютын авлага | 935,163,934 | | 703,977,115 | 447,183,959 | 1,191,957,090 | |
| | | Гадаадын байгууллагад өгөх өглөг | | | 36,685,985 | 36,685,985 | | - |
| | | Гадаадын байгууллагад өгөх өглөг /USD/ | | 6,036,505,926 | 403,291,610 | 2,185,119,024 | | 7,818,333,340 |
| | | Урьдчилж төлсөн тооцоо | 1,041,822,974 | | 21,892,749,755 | 17,229,918,310 | 5,704,654,428 | |
| | | Урьдчилж төлсөн тооцоо USD | | | 3,976,672,617 | 1,643,056,858 | 2,333,615,759 | |
| | | Урьдчилж төлсөн тооцоо-Евро | 3,063,518,676 | | 7,060,252,660 | - | 10,123,771,336 | |
| | | Дүн | 5,040,505,583 | 6,036,505,926 | [illegible] | [illegible] | 19,353,998,612 | 7,818,333,340 |
| | Уурхай | Гадаадын байгууллагаас авах авлага | 1,504,470 | | 254,363,610 | 254,363,610 | 1,504,470 | |
| | | Гадаадын байгууллагаас авах валютын авлага | - | | 11,388,140,218 | 11,388,140,218 | - | |
| | | Гадаадын байгууллагад өгөх өглөг /USD/ | | 815,816,868 | 952,715,178 | 2,367,500,485 | | 2,230,602,175 |
| | | Урьдчилж төлсөн тооцоо | 9,653,314,130 | | 9,434,136,516 | 12,302,382,239 | 6,785,068,407 | |
| | | Дүн | 9,654,818,600 | 815,816,868 | 22,029,355,523 | 26,312,386,553 | 6,786,572,877 | 2,230,602,175 |
| Он | Ангилал | Дансны утга | Эхний үлдэгдэл Авлага | Эхний үлдэгдэл Өглөг | Гүйлгээний дебет | Гүйлгээний кредит | Эцсийн үлдэгдэл Авлага | Эцсийн үлдэгдэл Өглөг |
| 2017 | Үйлдвэр | Гадаадын байгууллагаас авах авлага | | | 1,287,407,598 | 426,407,925 | 860,999,673 | |
| | | Гадаадын байгууллагаас авах валютын авлага | 1,191,957,090 | | - | 1,191,957,090 | - | |
| | | Гадаадын байгууллагад өгөх өглөг | | | 83,980,952 | 84,089,378 | | 108,426 |
| | | Гадаадын байгууллагад өгөх өглөг /USD/ | | 7,818,333,340 | 1,150,165,645 | 751,220,640 | | 7,419,388,335 |
| | | Урьдчилж төлсөн тооцоо | 5,704,654,428 | | 26,061,842,460 | 28,971,814,485 | 2,794,682,403 | |
| | | Урьдчилж төлсөн тооцоо USD | 2,333,615,759 | | 10,110,606,835 | 10,399,770,022 | 2,044,452,571 | |
| | | Урьдчилж төлсөн тооцоо-Евро | 10,123,771,336 | | 1,234,482,252 | 11,358,253,588 | - | |
| | | Дүн | 19,353,998,612 | 7,818,333,340 | 38,828,486,741 | 53,183,513,127 | 5,700,134,647 | 7,419,496,761 |
| | Уурхай | Гадаадын байгууллагаас авах авлага | 1,504,470 | | 98,856,386 | 98,856,386 | 1,504,470 | |
| | | Гадаадын байгууллагаас авах валютын авлага | - | | 22,321,276,741 | 22,320,534,192 | 742,549 | |
| | | Гадаадын байгууллагад өгөх өглөг /USD/ | | 2,230,602,175 | 3,517,614,810 | 17,872,121,063 | | 16,585,108,628 |
| | | Урьдчилж төлсөн тооцоо | 6,785,068,407 | | 14,359,525,113 | 17,608,690,706 | 3,535,902,814 | |
| | | Дүн | 6,786,572,877 | 2,230,602,175 | 40,297,372,852 | 57,830,202,348 | 3,538,149,833 | 16,585,108,628 |
| Он | Ангилал | Дансны утга | Эхний үлдэгдэл Авлага | Эхний үлдэгдэл Өглөг | Гүйлгээний дебет | Гүйлгээний кредит | Эцсийн үлдэгдэл Авлага | Эцсийн үлдэгдэл Өглөг |
| 2018 | Үйлдвэр | Гадаадын байгууллагаас авах авлага | 860,999,673 | | 1,533,155 | 1,533,155 | 860,999,673 | |
| | | Гадаадын байгууллагад өгөх өглөг | | 108,426 | 95,012,865 | 95,012,865 | | 108,426 |
| | | Гадаадын байгууллагад өгөх өглөг /USD/ | | 7,419,388,335 | 1,328,856,847 | 2,169,206,282 | | 8,259,737,771 |
| | | Урьдчилж төлсөн тооцоо | 2,794,682,403 | | 8,357,055,551 | 10,630,679,486 | 521,058,468 | - |
| | | Урьдчилж төлсөн тооцоо USD | 2,044,452,571 | | 9,290,349,611 | 8,821,330,543 | 2,513,471,638 | |
| | | Дүн | 5,700,134,647 | 7,419,496,761 | 19,072,808,028 | 21,717,762,332 | 3,895,529,779 | 8,259,846,197 |
| | Уурхай | Гадаадын байгууллагаас авах авлага | 1,504,470 | | 704,550 | 2,209,020 | - | |
| | | Гадаадын байгууллагаас авах валютын авлага | 742,549 | | 70,260,427,955 | 67,162,952,931 | 3,098,217,573 | |
| | | Гадаадын байгууллагад өгөх өглөг /USD/ | | 16,585,108,628 | 26,678,291,138 | 13,947,245,364 | | 3,854,062,854 |
| | | Урьдчилж төлсөн тооцоо | 3,535,902,814 | | 14,574,692,687 | 14,077,760,342 | 4,032,835,360 | |
| | | Дүн | 3,538,149,833 | 16,585,108,628 | 111,514,118,531 | 95,160,187,857 | 7,131,052,933 | 3,854,062,854 |
| Он | Ангилал | Дансны утга | Эхний үлдэгдэл Авлага | Эхний үлдэгдэл Өглөг | Гүйлгээний дебет | Гүйлгээний кредит | Эцсийн үлдэгдэл Авлага | Эцсийн үлдэгдэл Өглөг |
| 2019 | Үйлдвэр | Гадаадын байгууллагаас авах авлага | 860,999,673 | | 623,850,559 | 623,850,559 | 860,999,673 | |
| | | Гадаадын байгууллагаас авах валютын авлага | | | 2,574,674,178 | 2,574,674,178 | - | |
| | | Гадаадын байгууллагад өгөх өглөг | | 108,426 | 64,644,133 | 103,627,204 | | 19,091,497 |
| | | Гадаадын байгууллагад өгөх өглөг /USD/ | | 8,259,737,771 | 813,430,587 | 1,824,915,196 | | 9,271,222,380 |
| | | Урьдчилж төлсөн тооцоо | 521,058,468 | | 5,272,406,023 | 5,227,194,402 | 566,270,089 | |
| | | Урьдчилж төлсөн тооцоо USD | 2,513,471,638 | | 7,670,714,652 | 9,689,116,951 | 495,069,340 | |
| | | Урьдчилж төлсөн тооцоо ДХЗ-ний төсөл | | | 1,456,009,951 | 1,456,009,951 | - | |
| | | Дүн | 3,895,529,779 | 8,259,846,197 | 18,490,930,083 | 21,499,568,441 | 1,922,339,101 | 9,290,313,877 |
| | Уурхай | Гадаадын байгууллагаас авах валютын авлага | 3,098,217,573 | | 98,449,418,673 | 100,724,395,300 | 823,240,946 | |
| | | Гадаадын байгууллагад өгөх өглөг | | | 533,680 | 533,680 | | - |
| | | Гадаадын байгууллагад өгөх өглөг /USD/ | | 3,854,062,854 | 3,460,201,204 | 2,013,410,606 | | 2,407,272,256 |
| | | Урьдчилж төлсөн тооцоо | 4,032,835,360 | | 54,705,865,773 | 52,619,245,409 | 6,119,455,724 | |
| | | Урьдчилж төлсөн тооцоо Улаан шугамын өргөтгөл | | | 13,777,724 | - | 13,777,724 | |
| | | Дүн | 7,131,052,933 | 3,854,062,854 | 156,629,797,065 | 155,357,254,854 | 6,956,474,395 | 2,407,272,256 |
| Он | Ангилал | Дансны утга | Эхний үлдэгдэл Авлага | Эхний үлдэгдэл Өглөг | Гүйлгээний дебет | Гүйлгээний кредит | Эцсийн үлдэгдэл Авлага | Эцсийн үлдэгдэл Өглөг |
| 2020 | Үйлдвэр | Гадаадын байгууллагаас авах авлага | 860,999,672.52 | | 495,950,928.00 | 495,950,928.00 | 860,999,672.52 | |
| | | Гадаадын байгууллагаас авах валютын авлага | | | 1,047,660,385.82 | 1,038,456,183.57 | 9,204,202.25 | |
| | | Гадаадын байгууллагад өгөх өглөг | | 19,091,497.00 | 4,491,400.00 | 4,212,600.00 | | 18,812,697.00 |
| | | Гадаадын байгууллагад өгөх өглөг /USD/ | | 9,271,222,380.07 | 702,597,805.98 | 752,981,763.18 | | 9,321,606,337.27 |
| | | Урьдчилж төлсөн тооцоо USD | 495,069,339.69 | | 4,728,998,278.75 | 3,959,442,929.03 | 1,264,624,689.41 | |
| | | Урьдчилж төлсөн тооцоо ДХЗ-ний төсөл | | | 46,784,210.00 | 46,784,210.00 | | - |
| | | Дүн | 1,356,069,012.21 | 9,290,313,877.07 | 7,026,483,009.55 | 6,297,828,813.76 | 2,134,828,564.18 | 9,340,419,034.27 |
| | Уурхай | Гадаадын байгууллагаас авах авлага | | | 2,527,600.00 | 2,527,500.00 | | - |
| | | Гадаадын байгууллагаас авах валютын авлага | 823,240,946.34 | | 106,608,639,439.40 | 102,449,105,012.73 | 4,982,775,373.01 | |
| | | Гадаадын байгууллагад өгөх өглөг /USD/ | | 2,407,272,255.84 | 1,939,113,879.71 | 481,053,355.00 | | 949,211,731.13 |
| | | Урьдчилж төлсөн тооцоо | 6,119,455,724.45 | | 51,235,006,818.94 | 52,608,741,640.24 | 4,745,722,903.15 | |
| | | Дүн | 6,942,696,670.79 | 2,407,272,255.84 | 159,785,288,838.06 | 155,541,427,007.97 | 9,728,498,276.16 | 949,211,731.13 |
| Он | Ангилал | Дансны утга | Эхний үлдэгдэл Авлага | Эхний үлдэгдэл Өглөг | Гүйлгээний дебет | Гүйлгээний кредит | Эцсийн үлдэгдэл Авлага | Эцсийн үлдэгдэл Өглөг |
| 2021 | Үйлдвэр | Гадаадын байгууллагаас авах авлага | 860,999,672.52 | | 342,415,492.57 | 342,415,492.57 | 860,999,672.52 | |
| | | Гадаадын байгууллагаас авах валютын авлага | 9,204,202.25 | | 9,549,558.99 | 16,275,303.24 | 2,478,456.00 | |
| | | Гадаадын байгууллагад өгөх өглөг | | 18,812,697.00 | 18,704,271.00 | 60,122,249.40 | | 60,230,675.40 |
| | | Гадаадын байгууллагад өгөх өглөг /USD/ | | 9,321,606,337.27 | 381,066,801.60 | 364,687,349.54 | | 9,305,224,885.21 |
| | | Урьдчилж төлсөн тооцоо USD | 1,264,624,689.41 | | 2,291,328,458.16 | 3,053,303,010.76 | 502,650,136.81 | |
| | | Урьдчилж төлсөн тооцоо USD / Дамжин зуух төсөл / | | | 712,998,250.00 | | 712,998,250.00 | |
| | | Дүн | 2,134,828,564.18 | 9,340,419,034.27 | [illegible] | [illegible] | 2,078,126,515.33 | 9,365,455,560.61 |
| | Уурхай | Гадаадын байгууллагаас авах авлага | | | 934,706.38 | 934,708.38 | | - |
| | | Гадаадын байгууллагаас авах валютын авлага | 4,982,775,373.01 | | 91,596,051,380.23 | 94,129,376,066.95 | 2,451,450,686.29 | |
| | | Гадаадын байгууллагад өгөх өглөг | | | | 113,204,499.27 | | 113,204,499.27 |
| | | Гадаадын байгууллагад өгөх өглөг /USD/ | | 949,211,731.13 | 699,132,391.57 | 69,826.61 | | 250,149,166.17 |
| | | Урьдчилж төлсөн тооцоо | 4,745,722,903.15 | | 304,103,267,906.50 | 99,651,146,191.30 | 208,997,644,618.35 | |
| | | Дүн | 9,728,498,276.16 | 949,211,731.13 | 396,401,326,396.66 | 194,094,731,294.81 | 211,449,295,304.64 | 363,353,667.44 |

Бараа, материалын өдөр тутмын орлого, зарлагын бүртгэлийг хариуцсан нярав бүртгэн бүртгэлийг нягтлан бодогч хянаж бичилт хийн программд мэдээллийг оруулснаар санхүүгийн тайланг бэлтгэж байна.

Импортын барааны гадаад төлбөрийг харилцахаас гадаад валютаар шилжүүлсэн байсныг санхүүгийн харилцахын баримтаар болон мөнгөн гүйлгээний тайлангаар тулган шалгах, үндсэн хөрөнгийн бүртгэлийг гадаад харилцагчаар худалдан авалтаар гаалийн мэдүүлэгт тусгасан байдлыг он тус бүрээр тулган шалгах ажиллагаа хийв.

2019 онд "Дива цогт" ХХК-тай түүхий эд материал худалдан авах гэрээ хийсэн бөгөөд тус компани нь гэрээний дагуу импортын түүхий эд материалын гаалийн болон бусад татварыг төлж барагдуулан барааг нийлүүлэх гэрээтэй байсан. Гэвч "Дива цогт" ХХК нь гэрээний дагуу гаалийн болон бусад зардлыг төлөхгүйгээр "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-иар гаалийн бүрдүүлэлтийг хийн гаалийн болон бусад татварыг төлүүлсэн зөрчилтэй байсан тул холбогдох зөрчлийг ажлын хэсгийн татварын улсын байцаагчид шилжүүлэн шалгууллаа.

Тус компанийн импортын барааны гадаад худалдааны гэрээг санхүүгийн бүртгэлд тусгасан байдалтай шалгахад зарим бараанд үнийн дүн багатай овор хэмжээ бага барааг гэрээ хийлгүй шууд худалдан авалт хийсэн байсан.

Мөн гаалийн мэдүүлэгт гадаад харилцагчийн нэрийг буруу мэдүүлсэн байсан нь харилцагчаар тулган шалгахад хүндрэлтэй цаг хугацаа их зарцуулж байлаа. Гадаад худалдааны гэрээний гүйцэтгэлийг хянахдаа гаалийн бүрдүүлэлтийг хянадаггүйгээс гаалийн байгууллагад мэдүүлээгүй барааг орлогод авсан зөрчлүүд гарлаа.

**14.4. Экспортын барааны шалгалтын талаар:** Шалгалтад хамрагдах 2014-2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр 131,357 экспортын гаалийн бүрдүүлэлтийн мэдээллийг CAIS мэдээллийн сангаас татан авч экспортын гаалийн бүрдүүлэлтийн мэдээллийг боловсруулан барааны ангиллаар нэгтгэн ажлын хэсэгт мэдээллийг гарган өгч мэдээллээр хангаж ажилласан.

Мөн шалгалтын ажлын шаардлагаар харилцан хамаарал бүхий Кью Эс Си ХХ-ийн 2010-2022 онд хийсэн гаалийн бүрдүүлэлтийн мэдээ мэдээллийг татан авч боловсруулалт хийн шалгалтын ажлын хэсэгт мэдээ мэдээлэл гарган өгч, баазаас татан авсан мэдээллийг боловсруулан өгч ажилласан.

2020 онд Дарханы төмөрлөгийн үйлдвэр ХК нь БНХАУ-ын 25 аж ахуйн нэгжтэй төмрийн хүдэр, баяжмал нийлүүлэх 49 гадаад худалдааны гэрээний дагуу гаалийн байгууллагад 2.3 сая тн төмрийн хүдэр, баяжмалыг гаалийн статистик дүнгээр 185 сая ам.доллар буюу 519.9 тэрбум төгрөгөөр гаалийн бүрдүүлэлт хийж экспортод гаргасан байна. Гадаад худалдааны гэрээний тоо хэмжээ, үнийн дүнг гаалийн байгууллагад мэдүүлсэн тоо хэмжээ, гэрээний үнэтэй харьцуулсан байдлаар шалгахад гаалийн байгууллага экспортын барааны үнэлгээг ГТГТТХ-ийн дагуу 4-р аргаар үнэлсэн нь тус компанийн хэлцлийн үнээс 2 дахин их байсан.

2021 онд Дарханы төмөрлөгийн үйлдвэр ХК нь БНХАУ-ын 29 аж ахуйн нэгжтэй төмрийн хүдэр, баяжмал нийлүүлэх 49 гадаад худалдааны гэрээний дагуу гаалийн байгууллагад 1.7 сая тн төмрийн хүдэр, баяжмалыг гаалийн статистик дүнгээр 241.2 сая ам.доллар буюу 687.4 тэрбум төгрөгөөр гаалийн





бүрдүүлэлт хийж экспортод гаргасан байна. Гадаад худалдааны гэрээний тоо хэмжээ, үнийн дүнг гаалийн байгууллагад мэдүүлсэн тоо хэмжээ, гэрээний үнэтэй харьцуулсан байдлаар шалгахад гаалийн байгууллага экспортын барааны үнэлгээг ГТГТТХ-ийн дагуу 4-р аргаар үнэлсэн нь тус компанийн хэлцлийн үнээс 2.2 дахин их байсан.

Экспортолсон төмрийн хүдэр, баяжмалын тоо хэмжээг санхүүгийн борлуулалтын хэмжээтэй тулгаж үзэхэд гаалийн бүрдүүлэлтийн нийт жин буюу бохир жинтэй таарч байна. Гаалийн бүрдүүлэлт хийхдээ бохир жингээс гаалийн төв лабораторийн дүгнэлтээр тодорхойлсон чийгшлийн хэмжээг хасаж цэвэр жинг гаргаж мэдүүлсэн байсан. Дээрх цэвэр жинг экспортын барааны ангиллын тоо хэмжээгээр мэдүүлж байсан нь шалгалтаар тогтоогдсон. Өөрөөр хэлбэл гаалийн мэдүүлгийн бохир жин нь санхүү бүртгэл дэх борлуулалтын тоо хэмжээтэй таарсан.

"Дарханы Төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн экспортод гарсан төмрийн хүдэр, баяжмалыг гаалийн байгууллага сангийн яамны байршуулсан экспортод гаргасан ашигт малтмалын бүтээгдэхүүний олон улсын зах зээлийн үнээр үнэлж, гаалийн бүрдүүлэлт хийсэн байна.

Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд засгийн газрыг төлөөлж хариуцагчаар ажиллах ажлын хэсэгт 2010-2022 оны 1 дүгээр улирал хүртэлх Дархан-Уул аймгаас төмрийн хүдэр, баяжмалын экспорт хийсэн Аж ахуйн нэгжийн мэдээллийг гэрээний үнэ, гаалийн үнэтэй харьцуулсан судалгааг гаргаж өгсөн. Мөн ажлын хэсгийн бусад гишүүдэд төмөрлөгийн үйлдвэрийн экспортын гэрээг гаалийн бүрдүүлэлттэй харьцуулсан мэдээг боловсруулж хүргүүлсэн.

## АРВАН ТАВ. ХӨРӨНГИЙН ТҮРЭЭСИЙН ТАЛААР

**15.1. Машин механизм, тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн түрээсийн талаар:** "Кью Эс Си" ХХК нь "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-д 2014 оны 4 дүгээр сараас 10 дугаар сарын хооронд 2-3 жилийн хугацаатай, нийт 8 ширхэг /ТТТГ2014/01-ТТТГ2014/08 дугаартай/ "Техник, тоног төхөөрөмжийн түрээсийн гэрээ"-г байгуулан, 53 ширхэг, Үүний 44 ширхэг нь машин механизм, 3 ширхэг нь тээврийн хэрэгсэл, 6 ширхэг нь тоног төхөөрөмж байна. Гэрээ 2015 онд хүчин төгөлдөр байж байгаад 2016 оноос шинэчлэгдсэн тул шинэ гэрээ байгуулсан байна.

"Кью Эс Си" ХХК нь "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-д 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн, 1 жилийн хугацаатайгаар QSC16/01 дугаар "Техник, тоног төхөөрөмжийн түрээсийн гэрээ"-г байгуулан, 56 ширхэг машин механизм, тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийг, Үүнээс 45 ширхэг нь машин механизм, 5 ширхэг нь тээврийн хэрэгсэл, 6 ширхэг нь тоног төхөөрөмж байна.

"Кью Эс Си" ХХК нь 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн, 1 жилийн хугацаатай, QSC17/01 дугаартай, "Техник, тоног төхөөрөмжийн түрээсийн гэрээ"-г байгуулан, 55 ширхэг машин механизм, тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийг түрээслүүлсэн ба Үүнээс, 41 ширхэг нь машин механизм, 7 ширхэг нь тээврийн хэрэгсэл, 6 ширхэг нь тоног төхөөрөмж, 1 ширхэг нь санмэй хуурай соронзон баяжуулах үйлдвэр байна. Гэрээний хугацааг 1 жилээр тогтоосон боловч 2018 онд гэрээг сунгаж, 2019, 2020 онуудад гэрээгүйгээр дээрхх хөрөнгийг "Дарханы Төмөрлөгийн үйлдвэр" ХК-д түрээслүүлсэн байна.

"Кью Эс Си" ХХК нь 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн, 2 жилийн хугацаатайгаар QSC21/01 дугаартай, "Техник, тоног төхөөрөмжийн түрээсийн гэрээ"-г байгуулан, 45 машин механизм, тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийг түрээслүүлсэн ба, Үүнээс 33 ширхэг нь машин механизм, 7 ширхэг нь тээврийн хэрэгсэл, 5 ширхэг нь тоног төхөөрөмж байна. Гэрээ 2022 онд хүчин төгөлдөр хэрэгжиж байна.

"Кью Эс Си" ХХК нь 2020.12.31-ний өдрийн, QSC20/32 дугаар гэрээгээр, Санмэ брэндийн хуурай баяжуулах үйлдвэрийг мөн 2021.09.01-ний өдрийн, QSC21/47 дугаар гэрээгээр Ампко, Эриез брэндийн хуурай баяжуулах үйлдвэрийг "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-д 1 жилийн хугацаатайгаар түрээслэхээр гэрээ байгуулсан ба гэрээг 2022 онд 2 жилийн хугацаагаар буюу 2024 он хүртэл сунгасан байна.

Компани 2021 оноос өмнө баяжуулах үйлдвэр, түүний техник, тоног төхөөрөмжийг 1 гэрээгээр зохицуулдаг байсан бол 2021 оноос тус тусдаа гэрээтэй байхаар зохицуулалт хийж гэрээг салгасан байна.

**15.2. Түрээсийн төлбөр, тооцооны талаар:** "Кью Эс Си" ХХК нь 2014, 2015 онуудад техник, тоног төхөөрөмжөө түрээслүүлэхдээ төлбөрийг валютаар тооцдог байсан ба 2016 оноос төгрөгөөр тооцон гэрээ байгуулжээ. 2014-2017 онуудад 15 нэр төрлийн, 2018-2022 онуудад 14 нэр төрлийн техник, тоног төхөөрөмжөө "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-д түрээслүүлсэн байна.

/"Кью Эс Си" ХХК-ийн түрээслүүлсэн техник, тоног төхөөрөмжийн 2014-2016 онуудын 1 сарын түрээсийн төлбөр/

| Д/д | Техникийн нэр | 2014 он, 1 техникийн үнэ | | 2015 он, 1 техникийн үнэ | | 2016 он, 1 техникийн үнэ, төгрөгөөр | 2017 он, 1 техникийн үнэ, төгрөгөөр |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | доллароор | төгрөгөөр | доллароор | төгрөгөөр | | |
| 1 | Sandvik DI550 тэсэлгээний өрмийн машин | 11,806.70 | 21,467,886.48 | 11,806.70 | 23,266,991.42 | 29,000,000.0 | 58,000,000.0 |
| 2 | Sandvik DI580 тэсэлгээний өрмийн машин | | | | | 63,000,000.0 | 126,000,000.0 |
| 3 | Luigong CLG628H замын индүү | 2,148.18 | 3,905,992.73 | 2,148.18 | 4,233,332.40 | 4,610,000.0 | 9,220,000.0 |
| 4 | Белаз машин 75131 | 8,504.98 | 15,464,435.03 | 8,504.98 | 16,760,423.89 | 56,000,000.0 | 112,000,000.0 |
| 5 | Гэрэлт цамхаг NLPRO II | | 431,690.76 | | 431,690.76 | 230,000.0 | 460,000.0 |
| 6 | Грейдер CAT 16M | 4,785.97 | 8,702,233.53 | 4,785.97 | 9,431,519.64 | 30,000,000.0 | 60,000,000.0 |
| 7 | Гинжит бульдозер CAT D10T | 4,785.97 | 8,702,233.53 | 4,785.97 | 9,431,519.64 | 54,000,000.0 | 108,000,000.0 |
| 8 | Дугуйт ачигч CAT 988H | 4,785.97 | 8,702,233.53 | 4,785.97 | 9,431,519.64 | 35,000,000.0 | 70,000,000.0 |
| 9 | Волксвоган Амарок | | 2,371,994.52 | | 2,371,994.52 | 1,280,000.0 | 2,560,000.0 |
| 10 | Trimple R10 маркийн маркшейдерийн иж бүрэн багаж | 1,294.92 | 2,354,527.14 | 1,294.92 | 2,551,847.05 | 1,400,000.0 | 2,800,000.0 |
| 11 | Экскаватор EX2600-6BH | 67,033.91 | 121,886,417.87 | 67,033.91 | 132,101,045.08 | 155,000,000.0 | 310,000,000.0 |
| 12 | Бульдозер CAT D10T | 22,073.52 | 40,135,839.95 | 22,073.52 | 43,499,402.92 | 56,000,000.0 | 112,000,000.0 |
| 13 | Хово sinotruck | 1,156.64 | 2,103,095.38 | 1,156.64 | 2,279,344.18 | 3,100,000.0 | 6,200,000.0 |
| 14 | Белаз машин 75131 | 14,280.34 | 25,965,656.62 | 14,280.34 | 28,141,694.82 | 56,000,000.0 | |
| 15 | Дугуйт ачигч ZL50CN | 817.46 | 1,486,371.17 | 817.46 | 1,610,935.72 | 1,760,000.0 | 3,520,000.0 |
| 16 | Дугуйт ачигч ZL50CN | 806.32 | 1,466,115.53 | 806.32 | 1,588,982.57 | | |
| 17 | Хьюндай Старекс | | | | | | 500,000.0 |
| | Нийт дүн | 144,280.88 | 265,146,723.77 | 144,280.88 | 287,132,244.26 | 546,380,000.00 | 981,280,000.00 |

2014, 2015 онуудын 1 сарын түрээсийн төлбөрийг төгрөгт шилжүүлэхдээ тухайн жилүүдийн дундаж ханшаар тооцов. (2014 онд 1$=1,818.28₮, 2015 онд 1$= 1,970.66₮)

/"Кью Эс Си" ХХК-ийн түрээслүүлсэн техник, тоног төхөөрөмжийн 2017-2022 онуудын 1 сарын түрээсийн төлбөр/



"Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн 2014-2021 оны үйл ажиллагаанд хийсэн шалгалтын тайлан

| Д/д | Техникийн нэр | 2018 он, 1 техникийн үнэ, төгрөгөөр | 2019 он, 1 техникийн үнэ, төгрөгөөр | 2020 он, 1 техникийн үнэ, төгрөгөөр | 2021 он, 1 техникийн үнэ, төгрөгөөр | 2022 он, 1 техникийн үнэ, төгрөгөөр |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Sandvik DI550 тэсэлгээний өрмийн машин | 49,000,000.0 | 49,000,000.0 | 49,000,000.0 | 38,170,000.0 | 38,170,000.0 |
| 2 | Sandvik DI580 тэсэлгээний өрмийн машин | 88,000,000.0 | 88,000,000.0 | 88,000,000.0 | 84,150,000.0 | 84,150,000.0 |
| 3 | Luigong CLG628H замын индүү | 9,220,000.0 | 9,220,000.0 | 9,220,000.0 | 6,490,000.0 | 6,490,000.0 |
| 4 | Белаз машин 75131 | 112,000,000.0 | 112,000,000.0 | 112,000,000.0 | 109,230,000.0 | 109,230,000.0 |
| 5 | Гэрэлт цамхаг NLPRO II | 460,000.0 | 460,000.0 | 460,000.0 | 330,000.0 | 330,000.0 |
| 6 | Грейдер CAT 16M | 60,000,000.0 | 60,000,000.0 | 60,000,000.0 | 52,030,000.0 | 52,030,000.0 |
| 7 | Гинжит бульдозер CAT D10T | 108,000,000.0 | 108,000,000.0 | 108,000,000.0 | 89,210,000.0 | 89,210,000.0 |
| 8 | Дугуйт ачигч CAT 988H | 70,000,000.0 | 70,000,000.0 | 70,000,000.0 | 59,290,000.0 | 59,290,000.0 |
| 9 | Волксвоган Амарок | 2,560,000.0 | 2,560,000.0 | 2,560,000.0 | 770,000.0 | 770,000.0 |
| 10 | Trimple R10 маркийн маркшейдерийн иж бүрэн багаж | 2,800,000.0 | 2,800,000.0 | 2,800,000.0 | 2,090,000.0 | 2,090,000.0 |
| 11 | Экскаватор EX2600-6BH | 296,000,000.0 | 296,000,000.0 | 296,000,000.0 | 275,000,000.0 | 275,000,000.0 |
| 12 | Бульдозер CAT D10T | | | | | |
| 13 | Хово sinotruck | 6,200,000.0 | 6,200,000.0 | 6,200,000.0 | 6,820,000.0 | 6,820,000.0 |
| 14 | Белаз машин 75131 | | | | | |
| 15 | Дугуйт ачигч ZL50CN | 3,520,000.0 | 3,520,000.0 | 3,520,000.0 | 3,850,000.0 | 3,850,000.0 |
| 16 | Дугуйт ачигч ZL50CN | | | | | |
| 17 | Хьюндай Старекс | 500,000.0 | 500,000.0 | 500,000.0 | 550,000.0 | 550,000.0 |
| | Нийт дүн | 808,260,000.00 | 808,260,000.00 | 808,260,000.00 | 727,980,000.00 | 727,980,000.00 |

Дээрх хүснэгтээс харвал 2014-2015 онуудад "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХХК нь Белаз 75131 /4 ширхэг/, бульдозер CAT D10T /2 ширхэг/, дугуйт ачигч ZL50CN /3 ширхэг/ маркийн машин механизмыг өөр өөр үнээр түрээсэлдэг байсан бол 2016 онд бульдозер CAT D10T /2 ширхэг/ маркийн машин механизмыг өөр үнээр түрээсэлсэн байна. 2014-2022 он хүртэл 12 нэр төрлийн /давхардсан тоогоор 15 нэр төрөл/ техник, тоног төхөөрөмж, 2016-2022 он хүртэл 1 нэр төрлийн техник, тоног төхөөрөмж, 2017 оноос 1 нэр төрлийн тээврийн хэрэгслийг тус тус түрээсэлсэн байна.

/"Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн түрээслэсэн техник, тоног төхөөрөмжийн 1 сарын түрээсийн төлбөрийн өсөлтийг хувь/

| Д/д | Техникийн нэр | 2014 он | 2015 он | 2016 он | 2017 он | 2018 он | 2019 он | 2020 он | 2021 он | 2022 он |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Sandvik DI550 тэсэлгээний өрмийн машин | Суурь он | 8.38% | 35.09% | 170.17% | 128.25% | 128.25% | 128.25% | 77.80% | 77.80% |
| 2 | Sandvik DI580 тэсэлгээний өрмийн машин | | | Суурь он | 100.00% | 39.68% | 39.68% | 39.68% | 33.57% | 33.57% |
| 3 | Luigong CLG628H замын индүү | | 8.38% | 18.02% | 136.05% | 136.05% | 136.05% | 136.05% | 66.15% | 66.15% |
| 4 | Белаз машин 75131 | | 8.38% | 262.12% | 624.24% | 624.24% | 624.24% | 624.24% | 606.33% | 606.33% |
| 5 | Гэрэлт цамхаг NLPRO II | | 0.00% | -46.72% | 6.56% | 6.56% | 6.56% | 6.56% | -23.56% | -23.56% |
| 6 | Грейдер CAT 16M | | 8.38% | 244.74% | 589.48% | 589.48% | 589.48% | 589.48% | 497.89% | 497.89% |
| 7 | Гинжит бульдозер CAT D10T | | 8.38% | 520.53% | 1141.06% | 1141.06% | 1141.06% | 1141.06% | 925.14% | 925.14% |
| 8 | Дугуйт ачигч CAT 988H | | 8.38% | 302.20% | 704.39% | 704.39% | 704.39% | 704.39% | 581.32% | 581.32% |
| 9 | Волксвоган Амарок | | 0.00% | -46.04% | 7.93% | 7.93% | 7.93% | 7.93% | -67.54% | -67.54% |
| 10 | Trimple R10 маркийн маркшейдерийн иж бүрэн багаж | | 8.38% | -40.54% | 18.92% | 18.92% | 18.92% | 18.92% | -11.23% | -11.23% |
| 11 | Экскаватор EX2600-6BH | | 8.38% | 27.17% | 154.34% | 142.85% | 142.85% | 142.85% | 125.62% | 125.62% |
| 12 | Бульдозер CAT D10T | | 8.38% | 39.53% | 179.05% | -100.00% | -100.00% | -100.00% | -100.00% | -100.00% |
| 13 | Хово sinotruck | | 8.38% | 47.40% | 194.80% | 194.80% | 194.80% | 194.80% | 224.28% | 224.28% |
| 14 | Белаз машин 75131 | | 8.38% | 115.67% | | | | | | |
| 15 | Дугуйт ачигч ZL50CN | | 8.38% | 18.41% | 136.82% | 136.82% | 136.82% | 136.82% | 159.02% | 159.02% |
| 16 | Дугуйт ачигч ZL50CN | | 8.38% | 0.00% | 0.00% | 0.00% | 0.00% | 0.00% | 0.00% | 0.00% |
| 17 | Хьюндай Старекс | | | | Суурь он | 0.00% | 0.00% | 0.00% | 10.00% | 10.00% |

"Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн 2014 оноос эхлэн түрээсэлсэн 15 нэр төрлийн /давхардсан тоогоор/ техник, тоног төхөөрөмжийн түрээсийн төлбөрийг суурь төлбөрөөр авч үзэн 2015-2022 онуудтай харьцуулахад гэрэлт цамхаг NLPRO II, Trimple R10 маркийн маркшейдерийн иж бүрэн багаж, Волксвоган Амарок тээврийн хэрэгслийн 2021-2022 оны 1 сарын түрээсийн төлбөр нь 2014 оны түрээсийн төлбөрөөс буурсан үзүүлэлттэй ба машин

механизмуудын 1 сарын түрээсийн төлбөр 8.38-1141.06 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

2016 оноос эхлэн Sandvik DI580 тэсэлгээний өрмийн машиныг "Кью Эс Си" ХХК-иас түрээсэлсэн бөгөөд 2017-2022 онуудад 1 сарын түрээсийн төлбөр 33.57-100 хувиар өссөн байна.

2017 оноос эхлэн Хьюндай Старекс автомашиныг "Кью Эс Си" ХХК-иас түрээсэлсэн бөгөөд 2021-2022 онуудад 1 сарын түрээсийн төлбөр 10 хувиар өссөн байна.

Үүнээс дүгнэж үзвэл 2014, 2016, 2017 оноос ашиглалтад орсон машин механизм, тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж зэргүүд нь ашиглалтын хугацаа, элэгдэл хорогдол, эвдрэл гэмтлээс шалтгаалан түрээсийн төлбөрийн хэмжээ буурах байтал өссөн байна.

**15.3. Баяжуулах үйлдвэрийн түрээсийн төлбөрийн талаар:** "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК нь 2017 оноос Санмэ брэндийн хуурай баяжуулах үйлдвэрийг түрээсэлж эхэлсэн ба 2017-2020 онуудад 1 сар бүр тогтмол дүнгээр, 2021 оноос эхлэн баяжуулах үйлдвэрт ачаалсан 1 тонн хүдэр тутамд 5,900.00 төгрөг, тухайн сарын ачаалсан хүдрийн хэмжээ 39.0 мянган тонноос бага тохиолдолд түрээсийн төлбөр 1 сарын 230.10 сая төгрөг, 168.0-196.0 мянган тонн бол түрээсийн төлбөр 1 сарын 5,310.00 төгрөг, 196.0-224.0 мянган тонн бол түрээсийн төлбөр 1 сарын 4,720.00 төгрөг, 224.0 мянган тонноос дээш бол 4,130.00 төгрөг байхаар гэрээ байгуулсан байна.

2021 оны 9 дүгээр сараас эхлэн Ампко, Эриез брэндийн хуурай баяжуулах үйлдвэрийг түрээсэлж эхэлсэн ба баяжуулах үйлдвэрт ачаалсан 1 тонн хүдэр тутамд 5,900.00 төгрөг, тухайн сарын ачаалсан хүдрийн хэмжээ 25.0 мянган тонноос бага тохиолдолд түрээсийн төлбөр 1 сарын 147.50 сая төгрөг байхаар гэрээ байгуулсан байна.

/"Кью Эс Си" ХХК-ийн түрээслүүлсэн хуурай баяжуулах үйлдвэрийн 1 сарын түрээсийн төлбөрийн өсөлтийг хувь/

| Д/д | Техникийн нэр | 2017 оны сарын түрээсийн төлбөр | 2018 оны сарын түрээсийн төлбөр | 2019 оны сарын түрээсийн төлбөр | 2020 оны сарын түрээсийн төлбөр | 2021 оны сарын түрээсийн төлбөр | 2022 оны сарын түрээсийн төлбөр |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Санмэ брэндийн хуурай баяжуулах үйлдвэр | 340,000,000.00 | 230,000,000.00 | 230,000,000.00 | 230,000,000.00 | Үйлдвэрт ачаалласан 1 тн хүдрийг 5,900.00₮ | |
| 2 | Ампко, Эриез брэндийн хуурай баяжуулах үйлдвэр | | | | | Үйлдвэрт ачаалласан 1 тн хүдрийг 5,900.00₮ | |

Дээрх баяжуулах үйлдвэрүүдийн ачаалсан хүдрийн төлбөрт НӨАТ багтаагүй байна.

**15.4. "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-иас "Кью Эс Си" ХХК-руу шилжүүлсэн техник, тоног төхөөрөмж, баяжуулах үйлдвэрийн түрээсийн төлбөр болон гэрээний дагуу шилжүүлсэн түрээсийн төлбөр тооцооллын талаар:** "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК нь 2014-2021 онд техник, тоног төхөөрөмжийн түрээсийн төлбөрт 87.73 тэрбум төгрөг, баяжуулах үйлдвэр 1, 2-ын түрээсийн төлбөрт 21.15 тэрбум төгрөг нийт 108.88 тэрбум төгрөгийг "Кью Эс Си" ХХК-д төлсөн байна.

"Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-иас 2014-2015 оны эвдрэлтэй, зогссон, консервацид орсон машин механизм, техник хэрэгслийн мэдээлэл ирээгүй тул ирүүлсэн онуудын материалд тулгуурлан шалгалтыг явууллаа.





Хяналт шалгалтын явцад "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК нь 2014-2021 онд "Кью Эс Си" ХХК-д 18.50 тэрбум төгрөгийн түрээсийн төлбөрийг илүү төлсөн байна. Илүү төлсөн төлбөр нь дараах тооцооллыг хийлгүйгээр төлбөр олгосонтой холбоотой байна.

1. Төмөртэй, Төмөртолгойн төмрийн хүдрийн уурхай ажиллаагүй сарууд болон эвдрэлтэй, консервацид зогссон машин механизм, тээврийн хэрэгсэлд ногдох түрээсийн төлбөрийг хасаж тооцоогүй байна.

2. "Кью Эс Си" ХХК нь 2014 онд Төмөртэйн төмрийн хүдрийн уурхай 12 сард, 2015 онд Төмөртэйн төмрийн хүдрийн уурхай 1-11 дүгээр сард, Төмөртолгойн төмрийн хүдрийн уурхай 3-12 дугаар сард, 2017 онд Төмөртэйн төмрийн хүдрийн уурхай 1-2 сард, Төмөртолгойн төмрийн хүдрийн уурхайн 1-4 сард, 2018 онд Төмөртэйн төмрийн хүдрийн уурхай 1-2 сард, 2019 онд Төмөртэйн төмрийн хүдрийн уурхай 1 сард, 2022 онд Төмөртэйн төмрийн хүдрийн уурхайн 1 саруудад уурхай ажиллаагүй байхад түрээсийн төлбөр тооцож авсан байна.

Үүнд: 2018 онд 17 машин механизм, тээврийн хэрэгсэлд, 2019 онд 18 машин механизм, тээврийн хэрэгсэлд, 2020 онд 13 машин механизм, тээврийн хэрэгсэлд, 2021 онд 6 машин механизм, тээврийн хэрэгсэлд, 2022 онд 16 техник, тээврийн хэрэгсэл байна.

Дараах онуудад эврэлтэй, зогссон машин механизм, тээврийн хэрэгсэлд түрээсийн төлбөр тооцоолсон байна. Үүнд:

/Түрээсийн төлбөрийн тооцоолсон дүн болон "Кью Эс Си" ХХК-д үүсгэсэн түрээсийн төлбөрийн өглөгийн зөрүү/

| Он | Түрээсийн төлбөрийн бодит: Тээврийн хэрэгсэл, механизм, тоног төхөөрөмжийн — Тоо | Тээврийн хэрэгсэл, механизм, тоног төхөөрөмжийн — Үнэ | Төмөртолгойн төмрийн хүдрийн уурхай дахь — Баяжуулах үйлдвэр - 1 | Төмөртолгойн төмрийн хүдрийн уурхай дахь — Баяжуулах үйлдвэр - 2 | Он түс бүрээр нийт дүн | Дарханы төмөрлөгийн үйлдвэрээс Кью Эс Си ХХК-д шилжүүлсэн түрээсийн төлбөр: Тээврийн хэрэгсэл, механизм, тоног төхөөрөмжийн үнэ | Төмөртолгойн төмрийн хүдрийн уурхай дахь баяжуулах үйлдвэр - 1, 2 | Нийт дүн | Зөрүү |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2014 | 51 | 1,319,250,233.24 | | | 1,318,250,233.24 | 1,560,196,544.98 | | 1,560,196,544.98 | 240,946,311.74 |
| 2015 | 51 | 724,478,714.85 | | | 724,478,714.85 | 5,410,280,651.80 | | 5,410,280,651.80 | 4,685,801,936.95 |
| 2016 | 56 | 1,768,000,000.00 | | | 1,768,000,000.00 | 1,766,000,000.00 | | 1,766,000,000.00 | -2,000,000.00 |
| 2017 | 54 | 14,379,880,000.00 | 2,720,000,000.00 | | 17,099,880,000.00 | 17,470,800,000.00 | 2,720,000,000.00 | 20,190,800,000.00 | 3,090,920,000.00 |
| 2018 | 54 | 11,229,380,000.00 | 2,760,000,000.00 | | 13,989,360,000.00 | 16,131,360,000.00 | 2,760,000,000.00 | 18,891,360,000.00 | 4,902,000,000.00 |
| 2019 | 54 | 13,618,560,000.00 | 2,760,000,000.00 | | 16,378,560,000.00 | 16,131,360,000.00 | 2,760,000,000.00 | 18,891,360,000.00 | 2,512,800,000.00 |
| 2020 | 54 | 14,258,400,000.00 | 2,760,000,000.00 | | 17,018,400,000.00 | 16,131,360,000.00 | 2,760,000,000.00 | 18,891,360,000.00 | 1,872,960,000.00 |
| 2021 | 45 | 11,931,480,000.00 | 8,967,900,885.90 | 1,186,836,943.60 | 22,086,217,829.50 | 13,126,930,666.66 | 10,154,737,829.50 | 23,281,668,496.16 | 1,195,450,666.66 |
| Нийт төлбөр | | 68,229,408,948.10 | 19,967,900,885.90 | 1,186,836,943.60 | 90,384,146,777.60 | 87,728,297,863.44 | 21,154,737,829.50 | 108,883,036,682.94 | 18,498,879,915.34 |

Техник, тоног төхөөрөмж, баяжуулах үйлдвэр 1, 2-ын түрээсийн төлбөрийн тооцооллыг он, сар тус бүрээр хавсралтаар хавсаргав.

**15.5. Вагон түрээсийн гэрээ №1-ийн талаар:** "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК нь "Төмөр замын зураг төслийн институт" ХХК-иас АГ-2017/78 дугаартай "Вагон түрээслүүлэх, түрээслэх түрээсийн гэрээ" байгуулан, 300 ширхэг вагоныг түрээслэн ажилласан байна.

Гэрээний огноо: 2017-09-13

Гэрээний хугацаа: 1 жил

Гэрээний төлбөр: 1 ширхэг вагоны өдрийн төлбөр 35000 /НӨАТ-тай/ төгрөг.

"Төмөр замын зураг төслийн институт" ХХК нь "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-д 300 ширхэг вагоныг 2017.12.15-ны өдрөөс 2018.11.27-ны хооронд хүлээлгэн өгч дууссан байна. Гэрээнд 2017-2021 оны хооронд нийт 6 удаа

нэмэлт өөрчлөлт орсноос гэрээний хугацаанд 1 удаа, түрээслэх вагоны тоо хэмжээнд 1 удаа, 1 вагоны, өдрийн түрээсийн үнэд 4 удаа өөрчлөлт орсон байна.
**Гэрээний өөрчлөлт-1:** 2017 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр, АГ-2017/78 дугаар гэрээнд АГ-2017/78-01 дугаар "Вагон түрээслүүлэх, түрээслэх түрээсийн гэрээ нэмэлт" оруулан гэрээний хугацааг 5 жилээр болгосон.

**Гэрээний өөрчлөлт-2:** 2018 оны 2 дугаар сарын 21-ний өдөр гэрээнд 2 дахь удаагаа нэмэлт өөрчлөлт оруулан, АГ-2017/78-01 дугаартай "Вагон түрээслүүлэх, түрээслэх түрээсийн гэрээ нэмэлт-2"-г байгуулан 120 ширхэг вагоныг нэмж түрээслэхээр гэрээлж нийт вагоны тоог 420 болгож өөрчилсөн.

**Гэрээний өөрчлөлт-3:** 2018 оны 7 дугаар сарын 01-ний өдөр, АГ-2017/78 дугаар гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулан, АГ-2018/41 дүгээр "Вагон түрээслүүлэх, түрээслэх түрээсийн гэрээ нэмэлт -3" гэрээг байгуулж, 1 ширхэг вагоны өдрийн түрээсийн төлбөрийг 44.0 мянган төгрөг болгосон.

**Гэрээний өөрчлөлт-4:** 2019 оны 7 дугаар сарын 31-ний өдөр, АГ-2017/78 дугаар гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулан, 19/04 дугаартай "Вагон түрээслүүлэх, түрээслэх түрээсийн гэрээний нэмэлт-4" гэрээ байгуулж, 1 вагоны 1 өдрийн түрээсийн төлбөрийг 49.5 мянган төгрөг болгосон байна.

**Гэрээний өөрчлөлт-5:** 2020 оны 1 дүгээр сарын 02-ны өдөр, АГ-2017/78 дугаар гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулан, ТГ-НГ-20/01 дугаартай, "Вагон түрээслүүлэх, түрээслэх түрээсийн гэрээний нэмэлт-5" гэрээ байгуулж, 1 вагоны, өдрийн түрээсийн төлбөрийг 69.3 мянган төгрөг болгосон.

**Гэрээний өөрчлөлт-6:** 2020 оны 1 дүгээр сарын 02-ны өдөр, АГ-2017/78 дугаар гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулан, ТГ-НГ-20/01а дугаартай "Вагон түрээслүүлэх, түрээслэх түрээсийн гэрээний нэмэлт-5" гэрээ байгуулж, 1 вагоны, өдрийн түрээсийн төлбөрийг 89.98 мянган төгрөг болгосон.

Нэмэлт гэрээгээр түрээслэх 120 вагоноос 2018.12.05-ны өдрөөс 2020.03.28-ны өдрийн хооронд 86 ширхэг вагоныг нийлүүлснээр 386 вагон болж 34 вагоныг дутуу нийлүүлсэн.

**15.6. Вагон түрээсийн гэрээ №2-ийн талаар:** "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК нь "Төмөр замын зураг төслийн институт" ХХК-тай 2021 оны 1 дүгээр сарын 28-ны өдрөөс 300 ширхэг вагон түрээслэх, IRDP-21/02 дугаартай, "Вагон түрээсийн гэрээ"-г байгуулсан.

Гэрээний огноо: 2021-01-28

Гэрээний хугацаа: 5 жил

Гэрээний төлбөр: 1 ширхэг вагоны өдрийн төлбөр 94,050.0 /НӨАТ-тай/ төгрөг.

"Төмөр замын зураг төслийн институт" ХХК нь "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-д 300 ширхэг вагоныг, 2021.09.19-ний өдрөөс 2021.11.03-ны хооронд хүлээлгэн өгч дууссан байна.

**Гэрээний өөрчлөлт-1:** 2021 оны 3 дугаар сарын 30-ны өдөр, IRDP-21/02 дугаартай гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулан 1250 ширхэг вагоноор нэмэгдүүлэн, хугацааг 10 жил болгосон. Гэрээний нэмэлт өөрчлөлт хэрэгжээгүй байна.

**13.6. Вагон түрээсийн төлбөр тооцооны талаар:** "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК нь 2017 оноос эхлэн "Төмөр замын зураг төслийн институт" ХХК-тай





вагон түрээсийн 2 үндсэн гэрээ байгуулж, 7 нэмэлт өөрчлөлтийг нэмж тусгасан байна.

"Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК нь түрээсийн төлбөр тооцохдоо засвартай, эвдрэлтэй вагон, вагон ашиглаагүй байсан хоног, бусад иргэн, хуулийн этгээдэд түрээсэлсэн вагоны хоногуудыг хасаж тооцон, түрээсийн төлбөрийг шилжүүлдэг байна.

"Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн 2020-2022 оны эхний 3 сарын байдлаарх түрээсийн төлбөр тооцоог шалгалаа. Шалгахдаа түрээсийн вагоноос засварт орсон, эвдрэлтэй байсан хоног, бусад иргэн, хуулийн этгээдэд түрээсэлсэн хоног зэргийг хасаж тооцсон болно.

2017-2019 онуудад түрээсэлсэн вагоноос засварт орсон, эвдрэлтэй байсан хоног, түрээслүүлэгчээс бусад иргэн, хуулийн этгээдэд түрээсэлсэн вагоны хоногийн мэдээлэл, холбоотой анхан шатны баримтууд "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-д байхгүй байна.

2021 онд "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК, "Төмөр замын зураг төслийн институт" ХХК-ийн хооронд байгуулсан "Вагон түрээсийн гэрээний нэмэлт өөрчлөлтийн гэрээ" 01 дугаартай гэрээний:

2.3. дахь хэсэгт "Түрээслүүлэгч нь 2021 оны сүүлийн улирал болон 2022 оны 1 дүгээр улиралд багтаан ОХУ-ын Алтай вагон завод, эсхүл өөр үйлдвэрээс нийт 1250 вагон худалдан авах ажлыг зохион байгуулна. (Нэмэлт вагон) Алтай вагон заводоос худалдан авах тохиолдолд 12-2153-01 моделийн 70 тонны даацтай ачааны вагон байна".

2.5 дахь хэсэгт "Нэмэлт вагоныг энэхүү гэрээнд заасан нөхцөлөөр түрээслэгчид түрээслүүлэх бөгөөд 2022 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн бүрэн ашиглалтад оруулна".

5.1 дэх хэсэгт "Вагон түрээсийн төлбөр вагон тутамд хоногийн 94,050.00 төгрөг байна".

5.8 дахь хэсэгт "Энэхүү гэрээний 2.3 дахь хэсэгт заасан тооны вагоны үйлдвэр дээрх үнэ нь 3,312,500 рубль бөгөөд Монгол руу тээвэрлэх зардал, гааль, НӨАТ багтаагүй болно".

5.9 дахь хэсэгт "Нэг вагоныг түрээслэгчийн талбайд авчрах нэгж үнэ энэхүү гэрээ байгуулагдах өдрийн байдлаар 48,000.00 ам доллар болохыг талууд харилцан тохиролцов. Үүнээс түрээслэгч нь вагон худалдан авах хөрөнгө оруулалтад зориулж нийт 15,056,250 ам доллартой тэнцэх урьдчилгаа төлбөрийг түрээслүүлэгчид 2021 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө төлнө. Түрээслэгч нь энэхүү урьдчилгааг ОХУ-аас вагон худалдан авахад зарцуулах бөгөөд нэмэлт шаардлагатай санхүүжилтийг бие даан шийдвэрлэнэ".

5.10 дахь хэсэгт "Нэмэлт вагоныг энэхүү гэрээний 5.1 дэх хэсэгт заасан тарифаар түрээслэх бөгөөд түрээслэгчээс төлсөн урьдчилгаа төлбөрийг вагон түрээсийн төлбөрт суутган тооцно. Урьдчилгаа төлбөрт суутган тооцож дууссаны дараа Түрээслэгч нь энэхүү гэрээний дагуу түрээсийн төлбөрийг тогтоосон журмаар Түрээслүүлэгчид төлнө".

5.11 дэх хэсэгт "Түрээслүүлэгч нь энэхүү гэрээний 2.5-д заасан хугацаанд Түрээслэгчийг ямар нэг нэмэлт вагоноор хангаагүй тохиолдолд урьдчилгаа төлбөрийг буцаан төлнө. Түрээслүүлэгч нь урьдчилгаа төлбөрийг буцаан төлөөгүй бөгөөд талууд зөвшилцөлд хүрээгүй бол түрээслэгч нь урьдчилгаа төлбөрт түрээслүүлэгчийн өмчлөлийн Монгол Улсад ашиглаж буй 400 вагоны өмчлөх эрхийг шаардах эрхтэй байна" гэж тус тус заасан байна.

Түрээслүүлэгч "Төмөр замын зураг төслийн институт" ХХК нь 2022 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар 2021 оны 01 дүгээр гэрээнд заасан 1250 ширхэг вагоныг "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-д түрээсээр нийлүүлэх байсан боловч гэрээний үүргээ хэрэгжүүлээгүй байна.

| Огноо | Гүйлгээний утга | Шилжүүлсэн төлбөр | | Үндэслэл |
|---|---|---|---|---|
| | | Доллар | Төгрөг | |
| 2021.03.31 | Вагон түрээсийн урьдчилгаа | 15,058,204.92 | 42,910,312,486.18 | 2021 оны 01 дүгээр гэрээний 5.9 дахь заалт |
| 2021.06.24 | Вагон түрээсийн төлбөр /урьдчилгаа/ | | 10,775,000,000.00 | 2021 оны 01 дүгээр гэрээний 5.10 дахь заалт |
| Нийт дүн | | 15,058,204.92 | 53,685,312,486.18 | |

Иймд дээрх гэрээний 5.11 дэх хэсэгт заасны дагуу вагон түрээсийн урьдчилгаа төлбөр болох 42.91 тэрбум төгрөгийг "Төмөр замын зураг төслийн институт" ХХК-иас нэхэмжлэх эсхүл 400 ширхэг вагоны өмчлөх эрхийг шаардах, мөн вагон түрээсийн урьдчилгаа төлбөр гэж шилжүүлсэн 10.78 тэрбум төгрөгийг нэхэмжлэн авах шаардлагатай гэж үзэж байна.

/Түрээсийн төлбөрийн тооцоолсон дүн болон "Төмөр замын зураг төслийн институт" ХХК-д төлсөн түрээсийн төлбөрийн зөрүү/

| Түрээсийн төлбөр | 2017 он, түрээсийн төлбөр | 2018 он, түрээсийн төлбөр | 2019 он, түрээсийн төлбөр | 2020 он, түрээсийн төлбөр | 2021 он, түрээсийн төлбөр | 2022.03 сар, түрээсийн төлбөр | Нийт төлбөрийн дүн |
|---|---|---|---|---|---|---|---|
| "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХХК | 5,600,000.0 | 2,521,294,623.6 | 5,032,214,172.4 | 7,055,979,330.8 | 10,936,064,360.0 | 5,047,551,759.8 | 30,598,704,246.6 |
| Түрээсийн төлбөрийн бодолт, хуучин вагон | | | | 6,041,707,100.0 | 9,297,093,520.0 | 2,773,273,580.0 | 18,112,074,200.0 |
| Түрээсийн төлбөрийн бодолт, шинэ вагон | | | | | 1,418,368,050.0 | 2,214,877,500.0 | 3,633,245,550.0 |
| Нийт түрээсийн төлбөр | 0.0 | 0.0 | 0.0 | 6,041,707,100.0 | 10,715,461,570.0 | 4,988,151,080.0 | 21,745,319,750.0 |
| Вагон түрээсийн төлбөрийн зөрүү | | | | -1,014,272,230.8 | -220,602,790.0 | -59,400,679.8 | -1,294,275,700.6 |

Шалгалтаар "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-иас 2020-2022 оны 3 дугаар сарын байдлаар 1.29 тэрбум төгрөгийн түрээсийн төлбөрийг "Төмөр замын зураг төслийн институт" ХХК-д илүү шилжүүлсэн байна.

**15.7. Тоног төхөөрөмжийн түрээсийн гэрээний хэрэгжилтийн талаар:** Монгол Улсын Иргэний хуулийн 318 дугаар зүйлийн 318.1 дэх хэсэг болон холбогдох бусад хууль тогтоомжийг үндэслэн "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн ерөнхий захирал Т.Отгонбаяр, "Кьюу Эс Си" ХХК-ийн гүйцэтгэх захирал Э.Шижир нар 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр QSC 20/32 тоот, 2021 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр QSC 21/01 тоот, 2021 оны 09 дүгээр сарын 01-ний өдөр QSC 21/47 тоот "Тоног төхөөрөмжийн түрээсийн гэрээ" -г тус тус баталсан байна.

Дээрх гэрээний 1.1-д "Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт байрлах 3Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн "Төмөр толгой" төмрийн хүдрийн уурхайн талбайд суурилагдсан үндсэн тоног төхөөрөмжүүд болох Ампко, Эрпез, ("Ампко", Eriez) брэндийн хуурай баяжуулах үйлдвэрийн иж бүрэн шинэ тоног





төхөөрөмжүүдийг аж ахуйн зориулалтаар түрээслэх, түрээслэгч нь уг тоног төхөөрөмжийг түрээсийн дагуу ашиглан үр шимийг нь хүртэх, гэрээнд заасан төлбөр төлөхтэй холбогдох харилцааг зохицуулахаар заасан байна.

Уг гэрээний дагуу түрээслэх үйлдвэрийн тоног төхөөрөмжийн түрээсийн төлбөр нь түрээсийн зүйл болох баяжуулах үйлдвэрт ачаалсан 1 тн төмрийн хүдэр тус бүрд 5900.0 мянгаас доошгүй байхаар заасан бөгөөд энэ дүнд /НӨАТ/ ороогүй байна.

Ачаалсан төмрийн хүдэр буюу түрээсийн зүйл болох бутлан ангилах, баяжуулах үйлдвэрт тухайн сард баяжуулахаар оруулсан нийт төмрийн хүдрийн тоо хэмжээг үндэслэн түрээсийн тоног төхөөрөмжийн төлбөрийг тогтоохоор анхны гэрээг байгуулснаас хойш уг гэрээний хавсралтад 2 удаа өөрчлөлт оруулж хамгийн сүүлийн өөрчлөлтөөр "...түрээслэгч нь түрээсийн зүйл болох баяжуулах үйлдвэрт сар тутам ачаалах төмрийн хүдрийн доод хэмжээ 25000 төгрөг байх ба тухайн сарын ачаалсан төмрийн хүдэр энэ тоо хэмжээнээс бага байгаа тохиолдолд нэг сарын түрээсийн төлбөрийг 147,500,000 төгрөгөөр тооцно" гэж талууд харилцан тохиролцож гэрээг өөрчилсөн зэргээр Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1 дэх хэсэг " Дарханы төмөрлөгийн үйлдвэр ХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.12.4 дэх заалт, ТУЗ-ийн 2020 оны 12 сарын 10-ны өдрийн 20/23 тоот тогтоолын холбогдох заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Тайлангийн хугацаанд 2021 оны жилийн эцсийн байдлаар гүйцэтгэлийг дүгнэж 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр байгуулсан QSC 20/32 тоот гэрээний дагуу 8,967,903,481,10 төгрөг , 2021 оны 09 дүгээр сарын 01-ний өдөр QSC 21/47 тоот гэрээний түрээсийн төлбөрт нийт 1,186,837,733.00 төгрөгийг тус тус төлснөөр баталгаажуулсан байна.

**15.8. Оффисын байрны түрээсийн талаар:** "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК нь 2021 оны 06 дугаар сарын 24-ний өдөр "Нэйшнл Ньюс корпорейшн" ХХК-иас 1455.75 м.кв талбай бүхий оффисын байр худалдан авсан ба дээрх оффисын байрыг компанийн хэрэгцээнд ашиглаагүй байна.

2021 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс энэхүү байрыг "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК нь QSC21/54 дугаартай "Түрээсийн гэрээ"-г "Кьюу Эс Си" ХХК-тай байгуулан, Блю Скай тауэрын 8 дугаар давхарт, 200 м.кв талбайг, 1 м.кв талбайг 55.0 мян.төгрөг, сарын 11.0 сая төгрөгөөр, 2 жилийн хугацаатайгаар түрээслүүлсэн байна.

"Кьюу Эс Си" ХХК-тай байгуулсан түрээсийн гэрээг 2022 оны 3 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон ба байр ашиглалттай холбоотой зардлыг "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК хариуцдаг байсан байна.

"Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК нь дээрх оффисын байрыг худалдан авснаас хойш хөрөнгийн ашиглалтыг сайжруулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна. Иймд ашиглалтгүй байсан талбайн зөрүүг гэрээ дуусгавар болсон өдрөөр тооцож "Кьюу Эс Си" ХХК-иас түрээсийн төлбөрийн алдагдсан боломжийн өртөг 414.4 сая төгрөгийг нэхэмжлэн авах нь зүйтэй.

**15.9.** **<u>Түрээсийн автомашины ашиглалтын талаар:</u>** "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК нь "Кьюу Эс Си" ХХК-иас нийт 35 техник тоног төхөөрөмжийг 2014 оноос хойш түрээсийн гэрээгээр ашиглуулж байгаагаар тооцож хүлээлгэн өгснөөр данс бүртгэлдээ тусгаж ирсэн байна. Шалгалтын явцад түрээсийн тоног төхөөрөмжийн ашиглалтын байдалтай танилцахад Сэлэнгэ

аймгийн Ерөө сум дах Төмөртэйн хүдрийн уурхайд нийт 22 тоног төхөөрөмж бүртгэлтэй байгаагаас уулын өрмийн машин, экскаватор, бульдозер, автогрейдер, автосамосвал, белаз 73-38, индүү зэрэг 6 нэр төрлийн техникээс их засварт 1, акталсан 9, урсгал засварт 5 байгаа бөгөөд хэвийн ажиллагаатай 7 техник байгаа нь эдгээр машин техникийг цаашид ашиглах боломжгүйг харуулж байна.

## АРВАН ЗУРГАА. ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ ДУТАГДЛЫН ТАЛААР

"Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-д хийсэн хяналт шалгалтаар нийт 1,233,781.64 сая төгрөгийн зөрчил дутагдал илэрсэн.

16.1. Концессын гэрээ, хуульд заасан хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийн ашиглалт хангалтгүй, хүчин чадалдаа хүрч ажиллаагүй. Концессын гэрээнд тусгаагүй хөрөнгө оруулалтын ажил хийсэн байна.

"Жилд 500.0 мянгаас доошгүй тонн хүчин чадал бүхий шууд ангижруулах төмрийн үйлдвэр", Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн хүчин чадлыг жилийн 300.0 мянган тоннд хүргэх өргөтгөл, шинэчлэл хийх, Төмрийн хүдэр боловсруулж эцсийн бүтээгдэхүүн гаргах" төслийг 4 жилийн хугацаанд хийхээр концессын гэрээнд заасан боловч хэрэгжүүлээгүй байна.

2012 онд барьж ашиглалт оруулсан "Сэлэнгэ аймгийн Ерөө сумаас Хүдэр сумын Төмөртэйн уурхай хүртэл 110 кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугам 50 км, өргөтгөл, дэд станц"-ын төлбөрийг 2016 онд концессын зүйлийн төлбөрөөр Улсын төсвөөс "Кью Эс Си" ХХК-д буцаан олгосон боловч хөрөнгийг "Кью Эс Си" ХХК-ийн өмчлөлөөс одоог хүртэл төрийн өмчлөлд шилжүүлж, аваагүй байна.

Концессын төсөлд огт хамааралгүй "Сэлэнгэ аймгийн Хүдэр сумаас Дулаанхааны 4 замын уулзвар чиглэлийн 95 км авто зам"-ын төслийг концессын гэрээнд тусгаж Улсын төсвөөс 57.2 тэрбум төгрөгийг, Төмөртэйн ордоос Хандгайт өртөө хүртэлх 33.4 км, 1520 км царигтай төмөр зам, ачиж буулгах терминал барих ажлыг концессын гэрээнд тусгаж, Улсын төсвөөс 210,966.4 сая /Үндсэн төлбөр 183,608.6, хүүгийн төлбөр 27,357.4/ "Кью Эс Си" ХХК буцаан авсан. Концессын зорилгод хамаарахгүй зүйлийг концессын гэрээнд тусгаж, төсвийн хөрөнгийг төлөвлөлтгүй, үр ашиггүй зарцуулах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Засгийн газрын тогтоолыг үндэслэн концессын зүйлийн нэр, төрөлд өөрчлөлт оруулж концессын зүйлийн төлбөрийг буцаан авсан нь Улсын төсвийн хөрөнгийг үр ашиггүй, төлөвлөлтгүй зарцуулах, векселийн хүүгийн нэмэлт зардал Улсын төсвөөс төлөх нөхцөлийг бий болгосон байна.

Концессын гэрээний дагуу 2014 оны 12 сард ашиглалтад орсон Нойтон баяжуулах үйлдвэр 5 жилийн хугацаанд ажиллаагүй байна. 2019-2021 онд 387.8 мян.тн нунтаг завсрын бүтээгдэхүүн боловсруулж 270.4 мян.тн нойтон баяжмал үйлдвэрлэсэн нь жилдээ нийт хүчин чадлынхаа 10 гаруй хувийг ашигласан дүнтэй байна. Нойтон Баяжуулах үйлдвэр нь 2021 оны 11 сараас хойш бүрэн зогссон байна.

Ган бөмбөлгийн үйлдвэрийг ашиглалтад оруулсан боловч Концесс эзэмшигч гэрээний үүргээ зөрчин "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн хөрөнгөөр хийсэн. Түүхий эдийн чанар, гарч буй бүтээгдэхүүний шаардлагаас шалтгаалан ажиллахгүй байна.





16.2. Төслийн зорилго, үндсэн үйл ажиллагаанд шууд хамаарахгүй хөрөнгө, зардлыг санхүүжүүлэн компанид их хэмжээний өрийн дарамт үүсгэсэн байна.

Улаанбаатар хотод оффисын барилга худалдан авч шаардлагагүй хөрөнгө оруулалтыг санхүүжүүлсэн, хөрөнгийн ашиглалт хангалтгүй байна. "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 21/12 тоот хурлын тогтоолыг үндэслэн Улаанбаатар хотын Блью Скай Тауэрын 8 давхарт байрлах 1455.75 м.кв барилгыг худалдан авсан байна. "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК нь 2021 оны 06 дугаар сарын 24-ний өдөр "Нэйшнл Ньюс корпорэйшн" ХХК-тай №ҮХЭХХХАГ-21/001 дугаартай "Үл хөдлөх эд хөрөнгө худалдах, худалдан авах" гэрээгээр Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 1-р хороо, Соёл амралтын хүрээлэн, Энхтайвны өргөн чөлөө гудамж, 17-тоот барилгын 8 давхарт байрлах Үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийн 000591588 дугаар гэрчилгээ бүхий, 1455.75 м.кв талбайтай, оффисын зориулалттай үл хөдлөх эд хөрөнгийг 1 м.кв-ийн үнийг 7.65 сая төгрөгөөр тооцон нийт 11,136.5 сая төгрөгөөр худалдан авсан байна.

Хөрөнгө худалдан авахдаа Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 21/13 тоот хурлын тогтоолыг үндэслэн Худалдаа хөгжлийн банкнаас №ЗГ/CC210625004-12 дугаартай "Үл хөдлөх эд хөрөнгийн зээлийн гэрээ" байгуулж 10,870.0 сая төгрөгийг, жилийн 13.20 хувийн хүүтэй, 180 сарын хугацаатай зээл авч шийдвэрлэсэн байна.

Тус зээлийн төлбөрт 2021 онд 362.3 сая төгрөг, зээлийн хүүгийн төлбөрт 117.8 сая төгрөг, 2022 оны 05 дугаар сарын 31-ний байдлаар үндсэн зээлээс 60.4 сая төгрөг, зээлийн хүүд 117.8 сая төгрөгийг тус тус төлж барагдуулсан байна.

Тухайн зээлийг бүрэн төлж дуусахад үндсэн зээлийн 10,447.3 сая төгрөгийн, зээлийн хүүгийн 454.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь компани санхүүгийн хувьд хүндрэлтэй, их хэмжээний өрийн дарамтад байгаа нөхцөлд ямар ч үр ашиггүй хөрөнгө оруулалт болсон харагдаж байна.

"Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК нь дээрх оффисын байрыг компанийн хэрэгцээнд ашигладаггүй бөгөөд 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс энэхүү байрыг "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК нь QSC21/54 дугаартай "Түрээсийн гэрээ"-г "Кью Эс Си" ХХК-тай байгуулан, Блю Скай тауэрын 8 дугаар давхарт, 200 м.кв талбайг, 1 м.кв талбайг 55.0 мян.төгрөг, сарын 11.0 сая төгрөгөөр, 2 жилийн хугацаатайгаар түрээслүүлсэн байна.

"Кью Эс Си" ХХК-тай байгуулсан түрээсийн гэрээг 2022 оны 3 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон ба байр ашиглалттай холбоотой зардлыг "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК хариуцдаг байсан байна.

"Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК нь дээрх оффисын байрыг худалдан авснаас хойш хөрөнгийн ашиглалтыг сайжруулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна. Иймд ашиглалтгүй байсан талбайн зөрүүг гэрээ дуусгавар болсон өдрөөр тооцож "Кью Эс Си" ХХК-иас түрээсийн төлбөрийн алдагдсан боломжийн өртөг 414.4 сая төгрөгийг нэхэмжлэн авах нь зүйтэй.

2012 онд барьж ашиглалт оруулсан, 2016 онд концессын зүйлийн төлбөрөөр улсын төсвөөс санхүүжилтээ буцаан авсан "Сэлэнгэ аймгийн Ерөө сумаас Хүдэр сумын Төмөртэйн уурхай хүртэл 110 кВт-ын цахилгаан дамжуулах

агарын шугам/50 км, өргөтгөл, дэд станц"-ыг өнөөг хүртэл "Кью Эс Си" ХХК-иас төрийн өмчлөлд шилжүүлж, бүртгүүлээгүй байгаа нь Концессын тухай хууль, гэрээг зөрчсөн байна.

Засгийн газрын тогтоолыг үндэслэн Концессын зүйлийн нэр, төрөлд өөрчлөлт оруулж концессын зүйлийн төлбөрийг буцаан авсан нь Улсын төсвийн хөрөнгийг үр ашиггүй, төлөвлөлтгүй зарцуулах, векселийн хүүгийн нэмэлт зардал Улсын төсвөөс төлөх нөхцөлийг бий болгосон байна. Зөвхөн төмөр замын төслийн концессын эргэн төлөлтийн векселийн хүүгийн төлбөрт 17.0 тэрбум төгрөгийн хүүгийн нэмэлт зардал Улсын төсвөөс төлсөн байна.

16.3. Концессын гэрээнд тусгагдаагүй менежментийн төлбөрт 100.0 тэрбум төгрөг шилжүүлсэн байна.

Концессын тухай хуульд "Шинэчлэн сайжруулах-ашиглах-шилжүүлэх"-концесс эзэмшигч концессын зүйлийг өөрийн болон өөрийн боломжоор олсон хөрөнгөөр шинэчлэн сайжруулж гэрээнд заасан хугацаанд ашиглан, гэрээнд заасан нөхцөлөөр концессын зүйлийг шинэчлэн сайжруулсан зүйлийн хамт төрийн болон орон нутгийн өмчлөлд шилжүүлэх гэж заасан байна. Гэтэл "Кью Эс Си" ХХК өөрийн хөрөнгөөр концессын зүйлийг шинэчлэн сайжруулахаас илүү "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-иас төрөл бүрийн арга замаар хөрөнгө мөнгө шилжүүлэн авсан байна.

2017 оны 01 сарын 02-ны өдөр "Кью Эс Си" ХХК, "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн хооронд QSC 17/01 дугаар бүхий "Мэргэжлийн зөвлөгөө болон техникийн туслалцаа үзүүлэх гэрээ" байгуулсан ба Концессын гэрээнд Мэргэжлийн зөвлөгөө үзүүлэх, түүний төлбөрийг тооцож авах талаарх заалт тусгагдаагүй байна.

Тухайн гэрээний зорилго нь талууд харилцан ашигтай хамтын ажиллагаанд тулгуурлан төслийг үр ашигтай, амжилттай хэрэгжүүлэх, Дарханы төмөрлөгийн үйлдвэрийн үйл ажиллагааг тогтмол, үр ашигтай байлгахад дэмжлэг үзүүлэхэд оршино. Гэрээгээр "Кью Эс Си" ХХК нь Төслийг хэрэгжүүлэх шатанд техник технологи, тоног төхөөрөмж, эдийн засаг, бизнес зэрэг асуудлаар "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-д тогтмол мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, туслалцаа үзүүлэхээр тохирсон байна.

Гэрээний 8.1-д "Үзүүлэх үйлчилгээний хөлс нь нэг улирлын 2,500.0 мянган ам.доллар буюу 1 жилийн 10,000.0 мянган ам.доллар байна" гэж заажээ.

Гэрээний 8.3-т "Кью Эс Си" ХХК нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ өөрийн болон Дарханы төмөрлөгийн үйлдвэрийн зардлаар бүрэн хариуцах бөгөөд энэхүү гэрээний 8.1-д заасан үнэ нь материал, тоног төхөөрөмж, тээвэр, ажиллах хүчний цалин хөлс зэрэг бүх зардлууд багтсан эцсийн үнэ болно" гэж заасан байна.

Мэргэжлийн зөвлөгөө болон техникийн туслалцаа үзүүлэх гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 2020.10.01-ний өдрийн /дугааргүй/ нэмэлт өөрчлөлтийн 9.2.3 дах заалтын дагуу хийгдсэн 2021-2027 оныг дуусталх хугацааны төлбөрийг 9.2.2-д" энэхүү гэрээний төлбөрийг төлөх хугацаанаас 6 сараас дээш хугацааны өмнө урьдчилан төлсөн тохиолдолд тухайн төлбөр төлөх үеийн Монгол банкнаас зарласан бодлогын хүүгийн хувь хэмжээгээр төлбөрийг бууруулан тооцож төлнө" гэж заасны дагуу "Кью Эс Си" ХХК-аас авах авлагаас бууруулан тооцож урьдчилж төлсөн тооцоо дансанд 185,815.3 сая төгрөгийн бичилт хийсэн байна.

9.2.3-д "Энэхүү гэрээ хүчин төгөлдөр болсны дараа Дарханы төмөрлөгийн үйлдвэр нь 2021-2027 оныг дуусталх хугацааны төлбөрийг 2021 оны эхний улиралд багтаан урьдчилан төлөх бөгөөд 2022-2027 оны төлбөрийг уг гэрээний 9.2.2-т заасны дагуу хямдруулан тооцож төлнө" гэсний дагуу менежментийн





нэмэлт гэрээний зохицуулалтаар 1 жилийн төлбөрт НӨАТ-гүй дүнгээр 28,547.2 сая төгрөг, НӨАТ-тай дүнгээр 31,401.9 сая төгрөг төлөх тооцоо хийж 2021-2027 онд нийт 219,813.4 сая /НӨАТ-гүй / төгрөгийг урьдчилан төлөх тооцоо хийж хөнгөлөлт тооцсон дүнгээр 185,815.3 сая төгрөг төлөхөөр тусгасан байна.

Дээрх тооцоогоор гаргасан 185,815.3 сая төгрөгөөс 2021 оны зардалд 31,401.9 төгрөгийг хасаж, үлдэх 154,413.4 сая төгрөгийг авлагаар тооцож бүртгэсэн боловч тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй байна.

"Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК нь концессын гэрээнд тусгагдаагүй Мэргэжлийн зөвлөгөө болон техникийн туслалцаа үзүүлэх зардалд гэрээний дагуу 2018 онд 19,248.1 сая төгрөг, 2019 онд 24,185.9 сая төгрөг, 2020 онд 28,256.1 сая төгрөг, 2021 онд 28,547.2 сая төгрөг, нийт 100,237.3 сая төгрөгийг зарцуулсан байна. Энэ зардал нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлангийн удирдлагын зардалд бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний хөлс дансанд тайлагнагдсан нь албан татвар ногдох орлогыг мөн хэмжээгээр бууруулсан байна.

16.4. Концесс эзэмшигч, хөрөнгө оруулагч тал болох "Кью Эс Си" ХХК өөрийн техник, тоног төхөөрөмжөө "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-д түрээслүүлж их хэмжээний орлого олсон, "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК түрээсийн төлбөр төлж үр ашиггүй зардал гаргасан, өртөг зардлыг нэмэгдүүлсэн байна.

Мэргэжлийн зөвлөгөө болон техникийн туслалцаа үзүүлэх гэрээний 8.3-д "Кью Эс Си" ХХК нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ өөрийн болон "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн зардлаар бүрэн хариуцах бөгөөд энэхүү гэрээний 8.1-д заасан үнэ нь материал, тоног төхөөрөмж, тээвэр, ажиллах хүчний цалин хөлс зэрэг бүх зардлууд багтсан эцсийн үнэ болно." гэж заасан байна.

Гэтэл дээрх мэргэжлийн зөвлөгөө үзүүлсний төлбөрөөс гадна "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК нь "Кью Эс Си" ХХК-аас уул уурхайн машин техник, тоног төхөөрөмж түрээсэлж 2017-2021 онд нийт 111.5 тэрбум төгрөг түрээсийн төлбөрт төлсөн байна. Тухайн түрээсэлж буй техник, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, шатах тослох материал зэрэг бүх зардлыг "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК төлөхөөр тохирсон байна.

"Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК нь "Кью Эс Си" ХХК-иас 56 нэгж машин техник, Санмэ хуурай соронзон баяжуулах үйлдвэр, Баяжуулах үйлдвэр 2-г түрээслэн ашиглаж байна. Үүнд, жилд 4 ширхэг Сендвик өрөм түрээслэн авч түрээсийн төлбөрт 3,141.0 сая төгрөг, 1 ширхэг экскаватор EX2600-ийг 3,552.0 сая төгрөгөөр, 26 ширхэг HOWO A-60 автомашиныг 1,934.4 сая төгрөгөөр,
1 ширхэг гинжит бульдозер CAT 10T-ийг 1,296.0 сая төгрөгөөр түрээсэлж байна.
Төмөртэй уурхайд Санмэ хуурай соронзон баяжуулах үйлдвэрийг жилд 2,760.0 сая төгрөгөөр түрээсэлж байсан бол 2021 онд түрээсийн үнийг нэмж 8,967.9 сая төгрөгөөр түрээсэлсэн байна.

"Кью Эс Си" ХХК 2014 оны 09 сарын 27-нд гаальд 31 HOWO маркийн машин импортлохоор мэдүүлсний нэг бүрийн суурь үнэлгээ 159.9 сая төгрөг, гааль, НӨАТ нэмэгдсэн дүнгээр 184.7 сая төгрөг байна.

"Кью Эс Си" ХХК нь "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-д 1 ширхэг Sinotruk Howo маркийн машиныг, 2014 онд 6.5 сая төгрөгөөр, 2015 онд 27.7 сая төгрөгөөр, 2016 онд түрээс тооцоогүй, 2017-2020 онд 74.4 сая төгрөгөөр, 2021-2022 онд

102.3 сая төгрөгөөр түрээслэсэн ба өссөн дүнгээр түрээсийн төлбөрт 2014-2022 оны 1 дүгээр улирлын байдлаар 434.1 сая төгрөгийг төлсөн байна.

Түрээсийн Sinotruk Howo маркийн машины худалдан авсан үнэ /Даатгал дээрх балансын дүнг ашиглав/ 168.8 сая төгрөг бөгөөд дээрх үзүүлэлтээс түрээсийн төлбөрт түрээсийн автомашины үнээс 2.6 дахин их төлбөр төлсөн байна.

Өнгөрсөн хугацаанд Sinotruk Howo машины түрээсийн төлбөрт нийт 9,220.8 сая төгрөг төлжээ, Гэтэл "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн үндсэн хөрөнгөд 2014 онд 100 ширхэг HOWO маркийн машин бүртгэлтэй байна.

Дээрхээс харахад Концесс эзэмшигч "Кью Эс Си" ХХК нь Концессын гэрээнд тусгасны дагуу Дарханы төмөрлөгийн үйлдвэрийг үнэхээр үр ашигтай ажиллуулах зорилго агуулсан бол техник тоног төхөөрөмжийг түрээслэх бус хөрөнгө оруулалт болгон оруулж өнгөрсөн хугацаанд 108.88 тэрбум төгрөгийн зардал хэмнэх боломжтой байжээ.

"Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХХК нь 2014-2021 онд техник, тоног төхөөрөмжийн түрээсийн төлбөрт 87.73 тэрбум төгрөг, баяжуулах үйлдвэр 1, 2-ын түрээсийн төлбөрт 21.15 тэрбум төгрөг нийт 108.88 тэрбум төгрөгийг "Кью Эс Си" ХХК-д төлсөн байна.

Төмөртэй, Төмөртолгойн төмрийн хүдрийн уурхай ажиллаагүй сарууд болон эвдрэлтэй, консервацид зогссон машин механизм, тээврийн хэрэгсэлд ногдох түрээсийн төлбөрийг хасаж тооцоогүй, 2014 онд Төмөртэйн төмрийн хүдрийн уурхай 12 сард, 2015 онд Төмөртэйн төмрийн хүдрийн уурхай 1-11 дүгээр сард, Төмөртолгойн төмрийн хүдрийн уурхай 3-12 дугаар сард, 2017 онд Төмөртэйн төмрийн хүдрийн уурхай 1-2 сард, Төмөртолгойн төмрийн хүдрийн уурхайн 1-4 сард, 2018 онд Төмөртэйн төмрийн хүдрийн уурхай 1-2 сард, 2019 онд Төмөртэйн төмрийн хүдрийн уурхай 1 сард, 2022 онд Төмөртэйн төмрийн хүдрийн уурхайн 1 сарууддад уурхай ажиллаагүй байхад түрээсийн төлбөр тооцож авснаас "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХХК нь 2014-2021 онд "Кью Эс Си" ХХК-д 18.50 тэрбум төгрөгийн түрээсийн төлбөрийг илүү төлсөн байна.

"Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК нь "Төмөр замын зураг төслийн институт" ХХК-тай түрээсийн төлбөр тооцог хийхдээ зарим төлбөрийг ам доллароор хийж байгаа нь санхүүгийн хувьд алдагдал хүлээх эрсдэлтэй байна. 2021 оны байдлаар урьдчилж төлсөн түрээсийн төлбөр 50.36 тэрбум төгрөг байсан бол 2022 оны эхний 3 сарын байдлаар 43.89 тэрбум төгрөг болсон байна.

2021 оны 03 дугаар сарын 31-нд "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн Худалдаа хөгжлийн банкны 403197498 тоот данснаас 15.1 сая ам.доллар буюу тухайн үеийн ханшаар 42,910.3 сая төгрөгийг "Төмөр замын зураг төслийн институт" ХХК-д Вагон түрээсийн урьдчилгаа гэж шилжүүлэн авлагаар бүртгэсэн байна. Хэдийгээр данс бүртгэлд авлагаар бүртгэсэн боловч урт хугацааны түрээсийн төлбөрийг урьдчилан төлөхөөс илүүтэй өдөр тутам тооцогдож буй банкны зээлийг дээрх хэмжээгээр бууруулсан бол ирээдүйд төлөх зээл, хүүгийн зардлыг тодорхой хэмжээгээр бууруулах боломжийг алдсан байна.

Түрээслүүлэгч "Төмөр замын зураг төслийн институт" ХХК нь 2022 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар 2021 оны 01 дүгээр гэрээнд заасан 1250 ширхэг вагоныг "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-д түрээсээр нийлүүлэх байсан боловч гэрээний үүргээ хэрэгжүүлээгүй байна.





| Огноо | Гүйлгээний утга | Шилжүүлсэн төлбөр | | Үндэслэл |
|---|---|---|---|---|
| | | Доллар | Төгрөг | |
| 2021.03.31 | Вагон түрээсийн урьдчилгаа | 15,058,204.92 | 42,910,312,486.18 | 2021 оны 01 дүгээр гэрээний 5.9 дахь заалт |
| 2021.06.24 | Вагон түрээсийн төлбөр /урьдчилгаа/ | | 10,775,000,000.00 | 2021 оны 01 дүгээр гэрээний 5.10 дахь заалт |
| Нийт дүн | | 15,058,204.92 | 53,685,312,486.18 | |

Иймд дээрх гэрээний 5.11 дэх хэсэгт заасны дагуу вагон түрээсийн урьдчилгаа төлбөр болох 42.91 тэрбум төгрөгийг "Төмөр замын зураг төслийн институт" ХХК-иас нэхэмжлэх эсхүл 400 ширхэг вагоны өмчлөх эрхийг шаардах, мөн вагон түрээсийн урьдчилгаа төлбөр гэж шилжүүлсэн 10.78 тэрбум төгрөгийг нэхэмжлэн авах шаардлагатай гэж үзэж байна.

/Түрээсийн төлбөрийн тооцоолсон дүн болон "Төмөр замын зураг төслийн институт" ХХК-д төлсөн түрээсийн төлбөрийн зөрүү/

| Түрээсийн төлбөр | 2017 он, түрээсийн төлбөр | 2018 он, түрээсийн төлбөр | 2019 он, түрээсийн төлбөр | 2020 он, түрээсийн төлбөр | 2021 он, түрээсийн төлбөр | 2022.03 сар, түрээсийн төлбөр | Нийт төлбөрийн дүн |
|---|---|---|---|---|---|---|---|
| "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХХК | 5,600,000.0 | 2,521,294,623.6 | 5,032,214,172.4 | 7,055,979,330.8 | 10,936,064,360.0 | 5,047,551,759.8 | 30,598,704,246.6 |
| Түрээсийн төлбөрийн бодолт, хуучин вагон | | | | 6,041,707,100.0 | 9,297,093,520.0 | 2,773,273,580.0 | 18,112,074,200.0 |
| Түрээсийн төлбөрийн бодолт, шинэ вагон | | | | | 1,418,368,050.0 | 2,214,877,500.0 | 3,633,245,550.0 |
| Нийт түрээсийн төлбөр | 0.0 | 0.0 | 0.0 | 6,041,707,100.0 | 10,715,461,570.0 | 4,988,151,080.0 | 21,745,319,750.0 |
| Вагон түрээсийн төлбөрийн зөрүү | | | | -1,014,272,230.8 | -220,602,790.0 | -59,400,679.8 | -1,294,275,700.6 |

Шалгалтаар "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-иас 2020-2022 оны 3 дугаар сарын байдлаар 1.29 тэрбум төгрөгийн түрээсийн төлбөрийг "Төмөр замын зураг төслийн институт" ХХК-д илүү шилжүүлсэн байна.

<u>16.5. Банкнаас их хэмжээний зээл авч хийсэн зарим хөрөнгө оруулалт үр ашиггүй, авсан зээлээ компанийн үйл ажиллагаанд бус "Кью Эс Си" ХХК руу шилжүүлэн компанийг зээлийн өрийн дарамтад оруулсан байна.</u>

Шалгалтад хамрагдах хугацаанд Улаанбаатар хотын банк, Худалдаа хөгжлийн банкнуудаас зээл авах болон зээлийн шугамын эрх нээлгэхдээ Монгол Улсын Эдийн Засгийн Хөгжлийн яам, "Кью Эс Си" ХХК-ийн хооронд 2014 онд байгуулсан "Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төслийг хэрэгжүүлэх концесс"-ын гэрээний 2.8-д "Концесс эзэмшигч нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ Эрх бүхий этгээдэд урьдчилан мэдэгдэнэ", 2.8.1-д "Төслийг санхүүжүүлэх зорилгоор Концессын зүйлийг барьцаалах, баталгаа гаргах" гэснийг, мөн 2.9-д "Эрх бүхий этгээд нь мэдэгдэл хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор Концессын тухай хуулийн 27.1 дэх заалттай нийцэж байгаа эсэх талаар хянаж үзнэ" гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

"Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК нь 2017 оны 05 дугаар сарын 16-ны өдөр Улаанбаатар хотын банктай "Зээлийн шугамын эрх нээх" №ЗШЭНГ9101/170516 дугаартай гэрээ байгуулж, тус банкнаас "Дарханы

төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн Улаанбаатар хотын банк дахь ам долларын 2600062653 тоот дансанд 2017 оны 05 дугаар сарын 25-ны өдөр 13,000.0 мянган ам.доллар шилжин орж ирснийг тухайн өдөрт нь "Кью Эс Си" ХХК-ийн Улаанбаатар хотын банк дахь 2600060178 тоот данс руу хоорондын тооцоо гэсэн гүйлгээний утгатай шилжүүлсэн байна. Өөрөөр хэлбэл, тус зээлийг "Дархан төмөрлөгийн үйлдвэр" ХК нь өөрийн үйл ажиллагаандаа ашиглаагүй байна. "Дархан төмөрлөгийн үйлдвэр" ХХК нь 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар зээлийн хүүд 2,054.3 мянган ам.долларыг төлж, үндсэн зээлийн 13,000.0 мянган ам.доллар, зээлийн хүүгийн 2,274.9 мянган ам.долларын, нийт 15,274.9 мянган ам.долларын зээл, зээлийн хүүгийн үлдэгдэлтэй байна. Тухайн зээл, зээлийн хүүг авлагаар бүртгэсэн байна.

"Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК нь 2017 оны 05 сарын 04-ний өдөр Улаанбаатар хотын банктай №ЗШЭНГ9101/170516 дугаартай эргэлтийн хөрөнгийн зориулалтаар ашиглах зээлийн гэрээ байгуулж, тус банкнаас "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн Улаанбаатар хотын банк дахь ам долларын 2691002040 тоот дансанд 2017 оны 05 дугаар сарын 05-ны өдөр 5,460.0 мянган ам доллар шилжин орж ирснийг төгрөгт шилжүүлэн тухайн өдөрт нь "Кью Эс Си" ХХК-ийн Улаанбаатар хотын банк дахь 2600043404 тоот данс руу хоорондын тооцоо гэсэн гүйлгээний утгатай 12,969.3 сая төгрөгийг шилжүүлсэн байна. Тус зээлийг "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК өөрийн үйл ажиллагаандаа ашиглаагүй байна. Ам долларын зээлийг 2018 онд төгрөгийн зээл рүүшилжүүлсэн ба авлагын бүртгэлд зээл, зээлийн хүүг тусган тооцсон байна.

"Дархан төмөрлөгийн үйлдвэр" ХК нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар үндсэн зээлийн төлбөрт 14,398.0 сая төгрөг, зээлийн хүүгийн төлбөрт 4,150.3 сая төгрөг, 224.4 мянган ам.доллар, нийт 18,548.3 сая төгрөг, 224.4 мянган ам.долларыг зээл, зээлийн хүүд төлж зээлийг хаасан байна.

"Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК нь 2017 оны 12 дугаар сарын 27-ны өдөр Улаанбаатар хотын банктай "Эргэлтийн хөрөнгө санхүүжүүлэх болон хөрөнгө оруулалтын зориулалтаар" 38.0 сая ам долларын №ЗГ/СС171227003-11 дугаартай зээлийн гэрээ байгуулж, тус банкнаас "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн Худалдаа хөгжлийн банк дахь ам долларын 499247110 тоот дансанд 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдөр 34.9 сая ам доллар шилжин орж ирснийг тухайн өдөр нь "Кью Эс Си" ХХК-ийн Худалдаа хөгжлийн банкан дахь 499180051 тоот данс руу хоорондын тооцоо гэсэн гүйлгээний утгатай шилжүүлсэн ба үлдэгдэл 3.1 сая ам долларыг 2018 оны 02 сарын 07-ны өдөр мөн хоорондын тооцоо гэж тус тус шилжүүлсэн.

Тус зээлийг "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК өөрийн үйл ажиллагаандаа зарцуулаагүй байна. "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК нь 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар үндсэн зээлийн төлбөрт 22,980.2 мянган ам.долларыг, зээлийн хүүд 6,116.4 мянган ам.долларыг, нийт 29,096.6 мянган ам.долларыг төлж, үндсэн зээлийн 15,019.8 мянган ам.доллар, зээлийн хүүгийн 6,947.5 мянган ам.долларын, нийт 21,967.3 мянган ам.долларын зээл, зээлийн хүүгийн үлдэгдэлтэй байна. "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-иас "Кью Эс Си" ХХК руу шилжүүлсэн 38.0 сая ам.долларыг авлагаар бүртгэсэн боловч зээлийн хүүгийн зардлыг авлагаар тусгаагүй байна.

Авлагаар тусгалгүй зээлийн хүүгийн зардалд төлсөн 6,116.4 мянган ам.доллар болон зээлийн хүүд төлөхөөр тооцогдсон 6,947.5 мянган ам.доллар, нийт 13,063.9 мянган ам.долларыг "Кью Эс Си" ХХК-иас нэхэмжлэн авах нь зүйтэй.





<u>16.6. "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-иас худалдан авагч болон бусад этгээдэд шилжүүлсэн мөнгийг "Кью Эс Си" ХХК-иас авах авлагаар бүртгэж тооцоог хаасан, авлага, өглөгийг их хэмжээгээр нэмэгдүүлсэн бичилт хийсэн байна.</u>

2010 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн "Уул уурхайн металлургийн цогцолбор байгуулах төсөл"-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 24,724.8 сая төгрөгийн болон 49.4 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийгдсэнийг баталгаажуулж ТӨХ-ны 2013 оны 7 сарын 05-ны өдрийн 471 дүгээр тогтоолоор Кью Эс Си ХХК-ийн хөрөнгө оруулалтыг **81,301.4 сая** төгрөгөөр баталгаажуулж (ам.долларыг тухайн үеийн ханшаар тооцон төгрөгөөр) хөрөнгө оруулалтыг хүлээн зөвшөөрсөн байна.

Төрийн өмчийн хорооны 2013 оны тогтоол гарснаас хойш нийт 8,720.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалт нэмж хийснээр тооцож балансад тусгасан боловч холбогдох баримтаар баталгаажуулж тооцоо нийлсэн акт үйлдээгүй байна.

2014 оны 4 сараас хойш хийгдсэн гэх 8,720.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын зардал баримтаар нотлогдохгүй байх тул хийгдсэн хөрөнгө оруулалтын жагсаалтыг гаргаж, хөрөнгө тус бүрээр нь тулган шалгаж баталгаажуулах шаардлагатай гэж үзэж байна.

"Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн ерөнхий захирал М. Отгонбаярт Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76,1 дэх хэсэг 76.1.16, 76.1.17, 76.1.18 дах заалт болон Иргэний хуулийн 186 дугаар зүйлийн 186.1дэх хэсэг, "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн дүрмийн холбогдох хэсэг болон Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн мөн өдрийн 20/23 дугаар тогтоолоор дараах зөвшөөрлийг олгосон байна. Үүнд:

- Компанийн 2010 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн "Уул уурхайн металлургийн цогцолбор байгуулах төсөл"-ийг хамтран хэрэгжүүлэх талаар "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК, "Кью Эс Си" ХХК-ийн хооронд 49 сая ам доллароос доошгүй хэмжээний санхүүжилт хийх гэрээ байгуулах;
- Энэхүү тогтоолын 1-д заасан гэрээнүүдийн хүрээнд хөрөнгө оруулагч "Кью Эс Си" ХХК-иас компанид төгрөгөөр бүртгэгдсэн 24,724,811,447.31 төгрөгийн болон ам доллароор бүртгэгдсэн 49,403,008.94 ам долларын буцаан төлөгдөх шинжтэй санхүүжилт хийж урт хугацааны өглөгөөр бүртгэсэн байх;
- Дээрх тогтоолын 1-д заасан гэрээнүүдийн хүрээнд хийгдсэн төмөр зам болон авто замын төслүүдийн хөрөнгө оруулалтуудыг 2014 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр байгуулагдсан "Уул уурхайн металлургийн цогцолбор байгуулах төсөл"-ийг хэрэгжүүлэх концессын гэрээний хүрээнд хөрөнгө оруулагч "Кью Эс Си" ХХК-ийн дансанд бүртгэж хэрэгжүүлэх;
- Хөрөнгө оруулагч "Кью Эс Си" ХХК-ийн гэрээний дагуу оруулсан санхүүжилт нь компанийн эздийн өмчийн хэсэгт бус буцаан төлөгдөх нөхцөлтэйгөөр урт хугацаат өглөгөөр бүртгэгдсэн гэрээний дагуу хувьцаанд хөрвөх нөхцөлгүй байхаар;
- Хөрөнгө оруулалтын гэрээний дагуу хийгдсэн санхүүжилт болох урт хугацаат өглөгийн ам долларын дунд ханшийн тэгшитгэл хийж 2 талаас тооцоо нийлж уг тооцоог барагдуулах гэрээ байгуулах;
- Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан "Кью Эс Си" ХХК-д төлөх урт хугацаат өглөгийн тооцоог барагдуулах гэрээ байгуулах, гэрээний бусад

нөхцөлийг харилцан тохиролцох, гэрээнд гарын үсэг зурах бүрэн эрхийг тус тус олгосон.

"Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд урт хугацаат хөрөнгө оруулалт 90,021.8 сая төгрөг бүртгэгдсэн байна.

"Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн ТУЗ-ийн 2020 оны 12 сарын 10-ны өдрийн 20/253 тоот тогтоол, Ерөнхий захирлын 2020 оны 12 сарын 31-ний өдрийн А/152 тоот тушаалын дагуу Хөрөнгө оруулалтын гэрээний дагуу хийгдсэн санхүүжилт болох урт хугацаат өглөгийн 49,403.0 мянган ам.долларт 2020.12.31-ний өдрийн ханшаар тооцон 75,477.4 сая төгрөгийн ханшийн тэгшитгэл хийж жилийн эцсийн тайланд өмнөх оны үлдэгдэл болох 90,021.8 сая төгрөгийг нэмэгдүүлэн 165,499.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын өглөг бүртгэсэн байна.

"Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн ерөнхий захирлын 2020 оны 12 сарын 31-ний өдрийн "Тооцоо нийлэх тухай" А/152 тоот тушаалаар Хөрөнгө оруулалтын гэрээний дагуу хийгдсэн санхүүжилт болох урт хугацаат өглөгийн 49,403.0 мянган ам.долларт ханшийн тэгшитгэл хийж тооцоо нийлэхийг Ерөнхий нягтлан бодогч С. Сарантуяад зөвшөөрсний дагуу ханшийн тэгшитгэл хийж санхүүгийн тайланд тусгасан боловч анхан шатны холбогдох баримтаар баталгаажуулж тооцоо нийлсэн акт үйлдээгүй байна.

2020 оны 12 сарын 31-ний өдөр QSC 20/33 тоот Хөрөнгө оруулалтын санхүүжилтийг барагдуулах гэрээ байгуулсан байна. Гэрээний 1.1-д Энэхүү гэрээгээр "Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төсөл"-ийг хамтран хэрэгжүүлэх талаар Дарханы төмөрлөгийн үйлдвэр ХК, Кью Эс Си ХХК-ийн хооронд 2010 оны 09 сарын 29-ний өдөр байгуулсан хөрөнгө оруулалтын гэрээ, "Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төсөл"-ийн хүрээнд шаардлагатай "Дэд бүтэц байгуулах төсөл"-ийг хамтран хэрэгжүүлэх талаар Дарханы төмөрлөгийн үйлдвэр ХК, Кью Эс Си ХХК-ийн хооронд 2011 оны 12 сарын 23-ны өдөр байгуулсан Хөрөнгө оруулалтын гэрээний дагуу Хөрөнгө оруулагчаас Компанид оруулсан хөрөнгө оруулалтын санхүүжилтийг барагдуулахтай холбогдсон харилцааг зохицуулна.

2.1 Компани нь Хөрөнгө оруулагчаас энэхүү гэрээний 1.1-т заасан Хөрөнгө оруулалтын гэрээнүүдийн дагуу оруулсан нийт 165,499.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг мөнгөөр буцаан барагдуулна.

2.3 Компани нь 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн энэхүү гэрээний 2.1-т заасан үнийн дүнгээс хөрөнгө оруулалтын санхүүжилтийг бүрэн барагдуулах хүртэл хугацаанд улирал тутам зах зээлийн хүүгийн хэмжээгээр хүү тооцон төлнө. гэж заасны дагуу 2021 онд ногдох хүүг 14.82 хувиар буюу 24,526.9 сая төгрөгийн хуримтлуулсан хүү тооцож Дархан төмөрлөгийн үйлдвэр ХХК-аас "Кью Эс Си" ХХК-д өгөх өглөгөөр бүртгэсэн нь Концессын тухай хууль, концессын гэрээнд тусгайлан зааж, зохицуулаагүй асуудлыг урт хугацааны өглөгөөр бүртгэж, "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн зардлыг нэмэгдүүлэх, татвар ногдох орлого бууруулах нөхцөл бий болгосон байна.

Концессын тухай хууль болон хөрөнгө оруулалт, концессын гэрээнүүдэд "Дархан Төмөрлөгийн Үйлдвэр" ХК-д хийсэн хөрөнгө оруулалтыг буцаан төлөх, хүү тооцох ямар ч зохицуулалт байхгүй байгаа нь концесс эзэмшигч "Кью Эс Си" ХХК нь хууль, гэрээг зөрчиж Дархан Төмөрлөгийн Үйлдвэр" ХК-ийн урт хугацаат өглөг, зардлын хэмжээг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.





Иймд ханшийн тэгшитгэл хийж хөрөнгө оруулалтын өглөгийг нэмэгдүүлсэн 75,477.4 сая төгрөг, хуримтлуулсан хүү тооцсон 24,526.9 сая төгрөг, нийт 100,004.3 сая төгрөгийн "Кью Эс Си" ХХК-д өгөх өглөгийг тайлан балансаас хасаж тооцох шаардлагатай гэж үзлээ.

<u>16.7. "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК нь Концессын гэрээнд тусгагдаагүй хувьчлалын процесс ажиллагааг зохион байгуулж компанийг хохироосон байна.</u>

Компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 39 ширхэг, 443.5 сая төгрөгийн балансын үнэ бүхий орон сууцыг хувьчилсан байна.

Монгол Улсын "Эдийн засгийн хөгжлийн яам" болон "Кью Эс Си" ХХК-ийн хооронд байгуулсан Концессын гэрээний 4.5-д "Энэхүү гэрээний хугацаанд "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК нь төрийн өмч хэвээр байна" гэж заасан.

Гэтэл "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль"-ийн 9 дүгээр зүйлд Төрийн өмчийн талаарх Засгийн газрын бүрэн эрхэд хуулийн 9.3 дах хэсэгт заасны дагуу "Төрийн өөрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг хувьчлалаас гадуур худалдах, шилжүүлэх тухай шийдвэр гаргах" гэж заасан байна. Концесс эзэмшигч "Кью Эс Си" ХХК түүний томилсон удирдлагын баг эрхээ хэтрүүлэн Засгийн газрын бүрэн эрхийг зөрчиж Өмч хувьчлалын процесс ажиллагааг зохион байгуулж, төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгө болох тус компанид бүртгэлтэй 443,525,268.33 төгрөгийн балансын үнэ бүхий, 39 ширхэг орон сууцыг хувьчлах шийдвэр гаргасан тул нөхөн төлүүлэх шаардлагатай.

<u>16.8. "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК болон "Пик девелопмент" ХХК-ийн хооронд 2018-2019 онд үүссэн авлагын үлдэгдэл 135.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй. Талууд гэрээ байгуулсан боловч гэрээний дугаар, он, сар өдрийг бичиж баталгаажуулаагүй байна.</u>

"Пик девелопмент" ХХК тай холбогдон үүссэн өр, авлагын асуудлыг шийдвэрлэх хүрээнд 2020.09.30-ны өдөр баталсан Акт-ХХ 2020/119 тоот актад "Цувимал бүтээгдэхүүн худалдан авах гэрээ"-ний 4.1-дэх хэсэг болон холбогдох хууль тогтоомжийг үндэслэн:

- Нэг талаас Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан РД 2051303 Дарханы төмөрлөгийн үйлдвэр ХК, / А тал гэх /
- Нөгөө талаас Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан РД 5268079 "Кью Эс Си" ХХК, / Б тал гэх /
- Нөгөө талаас Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан "Пик девелопмент" ХХК / В тал гэх /

Компаниудын хооронд гурвалсан гэрээ байгуулж 2020.09.30-ны өдөр байгуулагдсан ХХ2020/119 тоот актад "Цувимал бүтээгдэхүүн худалдан авах" гэрээний төлбөрийг талуудын хооронд үүссэн өглөг, авлагаас тооцож барагдуулахтай холбогдуулан энэхүү актын 1.1-д заасан гэрээний төлбөр болох 1,015.0 сая төгрөгийг дараах журмаар төлсөнд тооцохоор заасан байна. Үүнд:

- 2.1.1. В талын А талд төлөх өглөгийг Б тал нь А талын хоорондын тооцоогоор актын 2.1-д заасан дүнгээр барагдуулна.
- 2.1.2. В тал нь В талд актын 2.1.1-д заасан үнийн дүнгийн өглөгийг В талын А талд төлөх хоорондын тооцоогоор барагдуулна.
- Энэхүү актын 2.1, 2.1.1 -д заасан үнийн актын 1.1-д заасан гэрээний гүйцэтгэлээр өөрчлөгдөж болно.

Актад тусгагдаагүй бусад харилцааг талууд тохиролцохоор заасан боловч гэрээний дугаар, он, сар өдрийг бичиж баталгаажуулаагүй, хүчин төгөлдөр бус гэж үзэж болохоор байна.

16.9. Төмрийн хүдрийн баяжмал, арматур, цувимал бүтээгдэхүүний үнийг өөрийн өртгөөс багаар тооцох, аж ахуйн нэгжүүдэд ялгавартай үнэ ханшаар борлуулж байгаа нь компанид их хэмжээний алдагдал учруулсан байх магадлалтай.

"Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК нь 2014-2018 онд 626,869.7 мянган тонн төмрийн хүдрийн баяжмалыг өөрийн өртгөөс нь 2,623.7 сая төгрөгөөр багаар үнэлэн борлуулсан байна. Тухайлбал, 2014 онд "Канетик" ХХК-д 99,472.8 тонн баяжмалыг өөрийн өртөг 2,897.6 сая төгрөг байхад 2,179.3 сая төгрөгөөр буюу өртгөөс 718.3 сая төгрөгөөр, "Кью Эс Си" ХХК-д 56,925.2 тонн баяжмалыг 1,263.8 сая төгрөгөөр буюу өөрийн өртгөөс 311.8 сая төгрөгөөр тус тус багаар тооцон борлуулсан. 2015 онд "Канетик" ХХК-д 51,533.6 тонн баяжмалыг 1,151.2 сая төгрөг буюу өөрийн өртгөөс 389.5 сая төгрөгөөр багаар үнэлсэн борлуулсан байна.

"Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК нь дотоодын аж ахуй нэгжүүдэд төмрийн хүдэр худалдах, худалдан авах гэрээний дагуу борлуулалт хийдэг болович гэрээнд 1 тн хүдрийн үнийг тогтоохдоо харилцан адилгүй үнээр борлуулдаг байна. Тухайлбал, Төмөртолгойн уурхайгаас олборлосон бүхэл 50%-54%-ийн агууламжтай заврын бүтээгдэхүүнийг 2021 онд хамгийн бага үнээр "Цемент шохой" ХК-д 1 тн тутмыг 57,511.82 төгрөгөөр /2924.35тн*57,511.82=168,184,685.50/ төгрөгөөр борлуулсан бол хамгийн өндөр үнээр Феррум Металл Монголия ХХК-д 1тн бүтээгдэхүүнийг 140,791.01 төг /14095тн*140,791.01төг=1,984,449,250.77/ төгрөгөөр борлуулж тайлагнасан байна.

2014 онд Гаалийн байгууллагад мэдээлсэн төмрийн хүдрийн баяжмалын мэдээнээс харахад Suifenhe Danggyida Trade Co LTD компани Дарханы төмөрлөгийн үйлдвэртэй байгуулсан гэрээний дагуу 99,864.8 тонн баяжмалыг 3,994.6 мянган ам.доллароор мэдүүлэн экспортлосон байхад борлуулалтын мэдээ тооцоонд тухайн компанийн талаар тусгаагүй, худалдах, худалдан авах гэрээ байгаагүй тул хууль хүчний байгууллагаас тодруулан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

Компани 2014-2020 онуудад 19 харилцагчид 548.3 мянган тонн жинтэй, баяжмалыг өөрийн өртгөөс нь 2.8 тэрбум төгрөгөөр доогуур үнээр борлуулж тайлант жилийн ашгийн үзүүлэлтийг бууруулсан байна.

2014 оноос 2021 оны 1 дүгээр улирлын хугацаанд 11.9 сая тонн жинтэй, 361.6 тэрбум төгрөгийн өртөг бүхий баяжмалыг 1 их наяд 125.8 тэрбум төгрөгөөр худалдан борлуулснаас гэрээнд заасны дагуу агуулга чийгшлийн зөрүүгээр 17.5 тэрбум төгрөгийн бууралт тооцож хассан байна.

2015-01-01-ний санхүүгийн тайлангаар бүхэл баяжмалын үлдэгдэл 2014 оны жилийн эцсийн үлдэгдлээс 9135.99 тн, 273.1 сая төгрөгийн бүхэл баяжмалаар зөрүүтэй байгааг тодруулахад 2015 онд бэлэн бүтээгдэхүүний код өөрчлөхдөө түүхий эд материалын дансанд андууран бүртгэсэн ба дээрх баяжмалыг "Канетик" ХХК-д өөрийн өртгөөс нь 7,916.0 төгрөгөөр доогуур үнээр борлуулан ажил гүйлгээнээс 72.3 сая төгрөгийн алдагдал хүлээсэн байна.

2014-2017 онд нийт 3.4 тэрбум төгрөгийн борлуулалтын хөнгөлөлт тооцсон болович зарим хөнгөлөлтийг үндэслэлгүй, компанийн үйл ажиллагаанд илт хохирол учруулсан байдлаар үзүүлсэн байна. Тухайлбал 2014 онд "Кью Эс Си" ХХК-нд нунтаг баяжмалыг өөрийн өртгөөс доогуур үнээр худалдан борлуулсан атлаа тухайн борлуулалтад 597.6 сая төгрөгийн үнийн зөрүүний хөнгөлөлт тооцсон мөн ханшийн зөрүүнээс үүссэн 41.6 сая төгрөгийг авах





авлагыг бууруулсан. "Канетик" ХХК-д төмрийн хүдрийн баяжмал өөрийн өртгөөс доогуур худалдан борлуулсан болович үнийн зөрүүний 99.2 сая төгрөгийн хөнгөлөлтийг үзүүлсэн байна.

Компани 2014-2021 онд санхүүгийн тайланд бүртгэсэн баяжмалуудын агуулга, нэр төрөлд өөрчлөлт оруулж 1 сая 452.1 мянган тн, 30,3 тэрбум төгрөгийн өртөг бүхий баяжмалыг зарлага болгож, 1 сая 452.1 мянган тонн, 24.8 тэрбум төгрөгийн баяжмалыг орлого авч бүтээгдэхүүний ангилал хооронд нягтлан бодох бүртгэлийн дансны шилжүүлэг хийсэн. Энэ бүртгэлийн дүнгээр бүтээгдэхүүний өөрийн өртгийг 5.5 тэрбум төгрөгөөр бууруулан бүртгэлд тусгасан байна. Дээрх бүртгэлийг 2016 оны Аудитын дүгнэлтийг үндэслэн бичилт хийсэн гэх болович баяжмалын ангилал хооронд шилжүүлэх залруулгыг тухайн онд нь хийгээгүй, нягтлан бодох бүртгэлийн бичилт хийх талаар гарсан тушаал шийдвэр, анхан шатны баримт нотолгоо байхгүй байна.

Компани 2014 онд арматурын худалдан борлуулах үнийг гүйцэтгэх захирлын тушаалаар 2021-2022 онд нийт 4 удаа, цувимал бүтээгдэхүүн борлуулах үнийг гүйцэтгэх захирлын тушаалаар 2014-2020 онд нийт 9 удаа шинээр тогтоон өгсөн байна. Үүнд, 1 тонн цувимал бүтээгдэхүүн худалдах үнийг 2014 онд марк, уртын хэмжээнээс нь хамааруулан 1,090,000.0-1,130,000.0-1,250,000.0 төгрөгөөр тогтоож байсан бол, 2017 оноос 1,485,000-2,013,000.0 төгрөгөөр, 2021 оноос 1 тонн арматурын үнийг 2,160,000.0-2,970,000.0 төгрөгөөр тогтоосон байна.

Дээрх тушаалаар 2014 онд үйлдвэрийн бүтээгдэхүүн үнийг өөрийн өртгөөс нь доогуур үнээр тогтоож шийдвэрлэснээс 140 харилцагчид, 20.4 мянган тонн бүтээгдэхүүн борлуулан энэхүү борлуулалтаас 3.1 тэрбум төгрөгийн алдагдал хүлээсэн.

- Тушаалаар 12м-ийн урттай, Д13, 16, 19, 22, 25, 29 маркийн, 1 тн нь 1,021,165.12-1,466,419.57 төгрөгийн өөрийн өртөгтэй бүтээгдэхүүнийг, 1,009,090.9-1,136,363.64 төгрөгөөр худалдан борлуулж тухайн ажил гүйлгээнээс 2.3 тэрбум төгрөгийн алдагдалтай борлуулалт хийсэн.
- Тушаалаар 6-11.5м-ийн урттай, Д13, 19, 22, 25, 29 маркийн, 1 тн нь 1,025,446.6-1,466,419.63 төгрөгийн өөрийн өртөгтэй бүтээгдэхүүнийг, 1,000,000.0-1,136,363.64 төгрөгөөр худалдан борлуулж тухайн ажил гүйлгээнээс 749.5 сая төгрөгийн алдагдалтай борлуулалт хийсэн.
- Тушаалаар 6-11.5м-ийн урттай, Д19, 22, 25 маркийн, 1 тн нь 1,008,591.12-1,400,590.55 төгрөгийн өөрийн өртөгтэй бүтээгдэхүүнийг, 1,000,000.0-1,118,181.81 төгрөгөөр худалдан борлуулж тухайн ажил гүйлгээнээс 22.6 сая төгрөгийн алдагдалтай борлуулалт хийсэн.
- Тушаалгүйгээр 125.8 мянган тонн арматурыг өөрийн өртгөөс нь доогуур үнээр худалдан 16.3 сая төгрөгийн алдагдалтай борлуулалт хийсэн.
- Тушаалаар тогтоосон үнээс доогуур 177.3 тонн арматурыг өөрийн өртгөөс нь доогуур үнээр худалдан 23.7 сая төгрөгийн алдагдалтай борлуулалт хийсэн.

16.10. Татварын тухай хууль тогтоомжийг зөрчиж, татварыг тухай бүр суутган тооцдоггүй, төлбөл зохих татварыг хугацаанд нь төвлөрүүлээгүйгээс их хэмжээний татварын өр хуримтлагдсан байна.

2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 117.4 тэрбум төгрөгийн татварын өр хуримтлагдсан нь Татварын ерөнхий хуулийн 29.2.Татварын тайлан тушаах, татвар төлөх хугацааг тухайн төрлийн татварын хуулиар тогтоох бөгөөд

хуульд өөрөөр заагаагүй бол татвар төлөх, тайлагнах хугацаа адил байна. гэснийг зөрчсөн байна.

Татварын хяналт шалгалтаар урьдчилсан байдлаар дараах алдаа илэрснийг нягтлан шалгаж байна. Үүнд:

16.10.1. ААНОАТ-ын тухай хуулиар ашигладаггүй тээврийн хэрэгсэлд түрээсийн зардал тооцсон, ашиглаагүй хөрөнгөд элэгдэл тооцож, Баяр ёслолын зардлыг татвар ногдох орлогоос хасаж тооцсон, Хөрөнгө оруулалтад зээлийн хүү тооцож татвар ногдуулах орлогыг тус тус бууруулсан.

16.10.2. НӨАТ-ын тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн хяналт шалгалтаар төлөх ёстой татварыг хуулийн хугацаанд төлөөгүй, үндсэн хөрөнгөтэй холбоотой НӨАТ-ын худалдан авалтыг хувь тэнцүүлэн тайланд залруулга хийгээгүй байна.

16.10.3. Байгууллагын өмчид бүртгэлтэй үл хөдлөх эд хөрөнгийг Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын хуульд заасны дагуу татвар ногдуулаагүй байна.

16.10.4. АМНАТ-ын тайлангаар экспортын борлуулалтыг Ашигт малтмалын тухай хууль, Засгийн газрын 2019 оны 342 дугаар тогтоол, бусад журмын дагуу олон улсын жишиг үнээр бүрэн тайлагнадаггүй, зарим борлуулалтыг бүтээгдэхүүн худалдах худалдан авах гэрээний үнийн дүнгээр тайлагнасан байна.

16.10.5. Мөн бусад ажил гүйлгээний баримтаас Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тайлангаарх удирдлагын зардалд Мэргэжлийн зөвлөгөө болон техникийн туслалцаа үзүүлэх гэрээний 2018 онд 19,248.1 сая төгрөг, 2019 онд 24,185.9 сая төгрөг, 2020 онд 28,256.1 сая төгрөг, 2021 онд 28,547.2 сая төгрөгийн нийт 100,237.3 сая төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний хөлс дансанд бичилт хийж, татвар ногдуулах орлогыг бууруулсан байна. Дээрх ажил гүйлгээг нягтлахад компани өөрийн үйл ажиллагаанд шаардлагатай ажил үйлчилгээг гэрээний үндсэн дээр авсан бөгөөд гэрээгээр ямар ажил үйлчилгээг, ямар хугацаанд, хэдий хэмжээний төлбөртэйгөөр авах, ажил үйлчилгээний үр дүнгээс хамаарсан хариуцлагыг хэрхэн хүлээх тухай нарийвчлан зохицуулсан байдаг. Гэтэл менежментийн төлбөрийн гэрээгээр менежментийн баг ямар үйлчилгээ үзүүлэх тухай ерөнхий тусгасан байх бөгөөд Менежментийн үйлчилгээнд компанийн үйл ажиллагаанд хамааралтай бүхий л үйлчилгээг багтаахаар заасан байна. Энэ нь ямар үйлчилгээг хэрхэн яаж үзүүлэх тухай нарийвчлан заагаагүй үйлчилгээний төлбөрийг жил тутамд 10 сая ам.доллар байхаар гэрээ байгуулсан нь хууль зүйн хувьд үндэслэлгүй байна.

16.10.6. Мөн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр байгуулсан QSC20/33 тоот гэрээнд 2010, 2011 оны нийт 165,499.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтад 24,526.9 сая төгрөгийн хуримтлагдсан хүү тооцож 2021 оны санхүү, татварын тайланд зээлийн хүүгийн зардал дансанд бичилт хийн албан татвар ногдох орлогоос хасаж татвар ногдуулах орлогыг бууруулсан байна. Дээрх Хөрөнгө оруулалтад хүү тооцож, татварын тайлан /маягт ТТ-13/-аар бусдад олгосон хүүгийн орлогоор тайлагнаж 2,452.7 сая төгрөгийг ногдуулан суутган авч төсөвт төлөхөөр тайлагнасан байна.

16.10.7. 2021 оны санхүүгийн тайланд найдваргүй авлагын хасагдуулгын зардлаар 78,540.5 сая төгрөгийг, бараа материалын үнэлгээний зардлаар 3,569.4 сая төгрөгийг тус тус санхүүгийн тайлангийн зардалд тайлагнаж, аж ахуй нэгжийн орлогын албан татварын тайлангийн "Санхүүгийн болон орлогын албан татварын





тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах тайлан" /татвар төлөхийн өмнөх ашгийг нэмэгдүүлэх дүн/-нд тайлагнасан байна.

"Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн 2018-2021 оны албан татварын ногдуулалт, төлөлтийн байдалд Татварын ерөнхий хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, болон татварын бусад хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан дүрэм журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахад анхан шатны баримтын бүрдэл дутуу, санхүү нягтлан бодох бүртгэл хөтлөлт хангалтгүй ТУЗ-ын шийдвэрийн дагуу ажил гүйлгээг хийдэг байна.

Татвар төлөгчийн анхан шатны баримтад хийсэн шалгалтаар илэрсэн дээрх зөрүүг Татварын ерөнхий хуулийн 41 дүгээр зүйлийн 41.10.3-т *"татварын болон нягтлан бодох бүртгэлийн тайлан, данс бүртгэл, санхүүгийн бусад баримт болон татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн мэдээлэлтэй холбоотой тайлбар, лавлагаа гаргуулан авах"* -гэж заасны дагуу нэмж тодруулах, тулган баталгаажуулах ажил үргэлжлэн хийгдэж байна.

Тулган баталгаажуулалт хийгдэж дууссаны дараа татварын албаны 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдөр үүсгэсэн албан татварын ногдуулалт, төлөлтийн байдалд хяналт шалгалт хийх томилолтын дагуу гүйцэтгэсэн ажлын үр дүнг Татварын ерөнхий хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1-д заасан баримт бичиг үйлдэн баталгаажуулна.

<u>16.11. Гаалийн тухай хууль тогтоомжийг зөрчиж импортын барааны гаалийн үнэ, тоо хэмжээг дутуу мэдүүлсэн, барааг Гаалийн байгууллагад мэдүүлээгүй, хэлцлийн үнэд нэмэгдэх зардлуудыг мэдүүлээгүй, гадаад тээврийн зардлыг дутуу мэдүүлсэн байна.</u>

Гаалийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийсэн хяналт шалгалтаар санхүүгийн болон гадаад худалдааны анхан шатны баримтууд, санхүү бүртгэл зэргийг импортын барааны гаалийн мэдүүлэгтэй тулгаж үзэхэд 2013-2021 онуудад нийт 8.2 тэрбум төгрөгийн импортын барааны гаалийн үнийг дутуу мэдүүлсэн, мөн барааг гаалийн байгууллагад мэдүүлээгүй, барааны тоо хэмжээг дутуу мэдүүлсэн, хэлцлийн үнэд нэмэгдэх зардлуудыг мэдүүлээгүй, гадаад тээврийн зардлыг дутуу мэдүүлсэн зэрэг зөрчлүүд илэрлээ.

Үндсэн хөрөнгө, сэлбэг хэрэгсэл, түүхий эд материалын гадаад харилцагчаар худалдан авалтын орлогыг гаалийн мэдүүлэгтэй тулган шалгахад нийт 8,226.2 сая төгрөгийн зөрчил илэрсэн.

Иймд дээрх илэрсэн зөрчилд ногдох нөхөн татвар, торгуулийн 1,788.7 сая төгрөгийн төлбөрийг гаргуулан төсөвт төвлөрүүлэхийн тулд харьяаллын дагуу хуулийн байгууллагаар шийдвэрлүүлэхээр саналыг ажлын хэсгийн удирдлагад хүргүүллээ.

/Гаалийн татвар, торгуулийн дүн, төгрөгөөр/

| Д/д | Хамаарах он | Илэрсэн зөрчлийн дүн | Нөхөн төлөгдөх дүн | Торгууль | Төлөх нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2018 | 101,716,958.53 | 15,766,128.57 | 4,729,838.57 | 20,495,967.14 |
| 2 | 2019 | 631,222,991.47 | 97,839,563.68 | 88,055,607.31 | 185,895,170.99 |
| 3 | 2020 | 1,002,234,926.37 | 155,346,413.59 | 77,673,206.79 | 233,019,620.38 |
| 4 | 2021 | 1,335,118,632.92 | 206,943,388.10 | 103,471,694.05 | 310,415,082.15 |
| | Дүн: | 3,070,293,509.29 | 475,895,493.94 | 273,930,346.72 | 749,825,840.67 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2013 | 7,235,550.00 | 1,121,510.25 | 336,453.08 | 1,457,963.33 |
| 2 | 2014 | 4,220,682,088.24 | 654,205,723.68 | 196,261,717.10 | 850,467,440.78 |
| 3 | 2015 | 109,418,563.79 | 16,959,877.39 | 5,087,963.22 | 22,047,840.60 |
| 4 | 2016 | 518,031,511.15 | 80,294,884.23 | 24,088,465.27 | 104,383,349.50 |
| 5 | 2017 | 300,515,512.19 | 46,579,904.39 | 13,973,971.32 | 60,553,875.71 |
| Дүн: | | 5,155,883,225.37 | 799,161,899.94 | 239,748,569.99 | 1,038,910,469.91 |
| НИЙТ ДҮН: | | 8,226,176,734.66 | 1,275,057,393.88 | 513,678,916.71 | 1,788,736,310.58 |

Мөн шалгалтаар 2014 онд тус компанийн "Кью Эс Си" ХХК болон гадаад харилцагчтай хийсэн гурвалсан гэрээтэй үндсэн хөрөнгөд орлогод авсан барааны гаалийн мэдүүлгийг тулган шалгахад гаалийн бүрдүүлэлт байхгүй байсан бөгөөд нотлох баримтыг гарган өгөхийг С.Сарантуяа нягтланд жагсаалтаар хүргүүлсэн боловч нотолгоог ирүүлээгүй байна.

## АРВАН ДОЛОО. ДҮГНЭЛТ

"Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн 2014-01-01-ний санхүүгийн тайлангаар нийт актив хөрөнгө 174.8 тэрбум төгрөг үүнээс, эргэлтийн хөрөнгө 84.0 тэрбум, эргэлтийн бус хөрөнгө 90.9 тэрбум төгрөг, нийт пассив хөрөнгө 174.8 тэрбум төгрөг, үүнээс 136.9 тэрбум төгрөг нь урт болон богино хугацаат өр, 21.9 тэрбум төгрөг нь өөрийн хөрөнгө, 15.9 тэрбум төгрөг нь хуримтлагдсан ашигтай ажиллаж байсан байна.

2014-2021 оноос хойших 8 жилийн хугацаанд компанийн хөрөнгө 625.3 тэрбум төгрөг болж 450.4 тэрбум төгрөгөөр, өр төлбөр 630.9 тэрбум төгрөг болж 494.0 тэрбум төгрөгөөр өссөн, өөрийн хөрөнгийн хэмжээ 21.4 тэрбум төгрөг, хуримтлагдсан алдагдал 27.0 тэрбум төгрөг болж 42.9 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Өнгөрсөн хугацаанд компанийн хөрөнгө өссөн боловч өр төлбөр мөн хэмжээгээр нэмэгдсэн, хөрөнгийн 34.1 хувь буюу 201.0 тэрбум төгрөгийг урьдчилж төлсөн зардал эзэлж, өр төлбөр нийт хөрөнгийн дүнгээс 5.6 тэрбум төгрөгөөр давсан үзүүлэлттэй байна. Энэ үзүүлэлт нь "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн хөрөнгө, өр төлбөрийн харьцаа алдагдсан, ээлийн дарамт ихэссэн, өөрийн хөрөнгийн эх үүсвэрээр үйл ажиллагаагаа явуулах чадамжгүй болсныг харуулж байна.

Арилжааны банкнаас авсан зээлийг бусад байгууллагад шилжүүлэн ашиглуулж хүүг нь төлөх, хэрэгцээгүй хөрөнгө худалдан авах, түрээсийн төлбөр төлөх зэргээр тооцоо судалгаагүй зарцуулсан байна.

Эдгээр байдал нь "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК нь концесс эзэмшигчид шилжээд үйл ажиллагаа нь сайжрах бус их хэмжээний урт болон богино хугацаат өр зээлтэй, уул уурхайн ажилд түрээсийн машин, техник, тоног төхөөрөмж ажиллуулж өртөг зардлыг нэмэгдүүлсэн төдийгүй үйл ажиллагаагаа хэвийн явуулахад хүндрэлтэй байдалд хүргэсэн байна.

"Кью Эс Си" ХХК нь 2014-2021 оны хугацаанд "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн удирдлага болон хөрөнгийн эрхийг хэрэгжүүлэхдээ концессын гэрээний үндсэн зорилго болох гангийн үйлдвэр байгуулах, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх замаар эцсийн ган бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилгыг бус дэд бүтэц, уул уурхайн олборлох, баяжуулах чиглэлд хөрөнгө оруулалт хийх замаар түүхий эдийг экспортод гарган борлуулж, ашиг олох зорилго агуулсан байна.





"Кью Эс Си" ХХК-ийн менежментийн дор "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-д хэрэгжүүлсэн төслүүд нь үр өгөөж багатай, эвдрэл гэмтэлтэй, ашиглалтгүй байгаа тул хохирлын үнэлгээ хийлгэх шаардлагатайгаас гадна, менежментийн төлбөрийг хөрөнгө оруулалтын зардлаас хасаж тооцох, шаардлагатай гэж үзэж байна.

Өнгөрсөн хугацааны мөнгөн хөрөнгийн зарцуулалт, төрийн өмчид бүртгэлээр тавих хяналт хангалтгүй, санхүүгийн тайлангийн орлого, зарлагын тоон үзүүлэлтийг зөрүүтэй илэрхийлсэн, анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг дутуу хөтөлсөн өр, авлагыг нэмэгдүүлсэн, санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийг олон улсын стандартын дагуу үнэн зөв гаргаагүй, хуулиар хүлээсэн чиг үүргийг бүрэн хэмжээгээр хэрэгжүүлж ажиллаагүй зэргээр Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4 "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 13.5."Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно",13.6."Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна",13.7."Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг зөрчсөн байна.

## АРВАН НАЙМ. ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛ

### 18.1. Нийтлэг асуудлаар

1. "Кью Эс Си" ХХК-тай хийх тооцоог нарийвчлан тооцож, үндэслэлгүй бүртгэсэн өглөг, авлагыг бууруулсан зэрэгтэй холбоотой тэрбум төгрөгийн тооцоог нийлж өглөг, авлагын залруулга хийх, буцаан нэхэмжлэн авч шийдвэрлэх;
2. "Төмөр замын зураг төслийн институт" ХХК-д урьдчилж шилжүүлсэн төлбөр тооцоог нягтлан хийж буцаан шилжүүлж авах;
3. Хүдрийн баяжмалын борлуулалттай холбогдон үүссэн тооцоо, өр төлбөрийн үлдэгдлийг байгууллага тус бүрээр баталгаажуулж он дамжин үүссэн өр авлагын асуудлыг хуулийн хүрээнд шийдвэрлэх;
4. Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтын бүрдлийг хангуулах, бүртгэлийг бодлогын бичиг баримтын дагуу хөтлөн гаргадаг байх;
5. Бараа, материал импортоосон тохиолдолд тухай бүр гаалийн бүрдүүлэлт хийх, гаалийн мэдүүлгийн дагуу барааг орлогод авах, барааны бүртгэлийг гаалийн мэдүүлгийн дугаараар гүйлгээний утга дээр бүртгэж хэвших;
6. Илэрсэн зөрчилд ногдох нөхөн татварын дүн нь Эрүүгийн хуулийг зөрчсөн байгаа тул харъяаллын дагуу шилжүүлж, хууль хяналтын байгууллагаар шалгуулан төлбөрийг гаргуулан улсын төсөвт төвлөрүүлэх;
7. Импортын барааг гаалийн байгууллагад мэдүүлдэггүй, дутуу мэдүүлдэг зэрэг өндөр эрсдэлтэй байх тул хяналтын ногоон төлөвт болон улбар шар төлөвт бүрдүүлэлтийг хамруулахгүй биет үзлэг шалгалтыг бүрэн хийжбайх;
8. "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК нь төрийн өмчит хувьцаат компани болсонтой холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 2022 онд зохион байгуулан, гүйцэтгэж буй "Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллого"-ын дагуу дээрх эзэмших, ашиглах эрхийн газрын мэдээллийг холбогдох байгууллагуудаас гаргуулан

авч, Засгийн газрын 2020 оны "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай" 10 дугаар тогтоолын дагуу эзэмших, ашиглах эрхийн газрыг үнэлж, 2022 оны санхүүгийн тайланд тусгах ажлыг зохион байгуулах;
9. Төрийн байгууллагуудын хяналт, шалгалт хариуцсан нэгжүүд Дарханы төмөрлөгийн үйлдвэр ТӨХК-д төлөвлөгөөт шалгалтыг 2 жил тутам хийж байх.

**18.2. Тухайлсан асуудлаар**

18.1.1. Компанид хэрэгжсэн гэх Концессын зүйлийн 2.1.3-т заасан төслийн хүрээнд хийгдсэн Ган бөмбөлгийн үйлдвэр нь хаягдал төмөр боловсруулах технологид үндэслэсэн, шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломж хязгаарлагдмал, төслийг Концесс эзэмшигч гэрээний үүргээ зөрчин "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн санхүүжилтээр хийснээс үүссэн хөрөнгө оруулалтын зардал 26,895.3 сая төгрөгийг, Концессын зүйлийн 2.1.1-д туссан Баяжуулах-/250тн.ц/ үйлдвэрийн хөрөнгө оруулалт 2,207.3 сая төгрөг, болон Баяжуулах-/750тн.ц/ үйлдвэрт хийгдсэн 6,865.4 сая төгрөгийн нэмэлт хөрөнгө оруулалт, Нойтон соронзон баяжуулах үйлдвэрт хийсэн 11,886.0 сая төгрөг, **нийт 47,854.0** сая төгрөгийг "Кью Эс Си" ХХК-д өгөх хөрөнгө оруулалтын өглөгөөс хасаж тооцох;

18.1.2. "Дархан төмөрлөгийн үйлдвэр" ХК-д хөрөнгө оруулалтаар бий болсон боловч ашиглалтын хугацаа дуусаагүй байхад акталж, худалдсан 2,711.4 сая төгрөгийн тээврийн хэрэгслийн дүнгээр хөрөнгө оруулалтын өглөгийг бууруулах;

18.1.3. "Дархан төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн үндсэн хөрөнгөөс хасагдсан, 12,576.20 сая төгрөгийн үнэтэй, Төмөртэй уурхайн 110 кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, өргөтгөл, дэд станцын хөрөнгийг даруй "Цахилгаан Дамжуулах Үндэсний Сүлжээ" ТӨХК-д хүлээлгэн өгч төрийн өмчид бүртгүүлэх.

**Жич:** Төмөртолгойн ордын нөөц багассан, дуусаж байгаа тул тус уурхайд "Кью Эс Си" ХХК-иас түрээсээр ашиглуулж байгаа 250 тн/ц, 500тн/ц баяжуулах үйлдвэрийг "Кью Эс Си" ХХК-иас нэхэмжлэх өр төлбөрт тооцон шилжүүлж авах шаардлагагүй болохыг дурдах нь зүйтэй.

18.2.1. Авлагаар тусгалгүй зээлийн хүүгийн зардалд төлсөн 6,116.4 мянган ам.доллар болон зээлийн хүүд төлөхөөр тооцогдсон 6,947.5 мянган ам.доллар, нийт 13,063.9 мянган ам.долларыг "Кью Эс Си" ХХК-иас нэхэмжлэн авах;

18.2.2. Мөнгөний шилжүүлгүүд зөвхөн хоорондын тооцоогоор гэсэн бичиглэлтэй, 56,460.0 мянган ам долларын ажил гүйлгээний санхүүгийн анхан шатны баримт тодорхой бус, чухам ямар ажил, үйлчилгээний төлбөр болох нь тодорхойгүй байх тул хууль, хүчний байгууллагаар нэг бүрчлэн тодруулан шалгуулах.

18.3. Банкны барьцаанд компанийн хөрөнгийг барьцаалсан гэрээнүүдийг эх хувиар нь олж авах, хөрөнгийг банкны барьцаанаас чөлөөлүүлэх талаар удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах.

18.4. Хувьчлах үйл ажиллагааг зохион байгуулсан, Концессын гэрээнд тусгагдаагүй хувьчлалын процесс ажиллагааг Төрийн өмчийн хуулиас гадуур





хэрэгжүүлэн хөрөнгийг захиран зарцуулсан тул хувьчилсан 443.53 сая төгрөгийн хөрөнгийн дүнгээр "Кью Эс Си" ХХК-иас нөхөн төлбөр нэхэмжлэх.

18.5.1. Өртгөөс нь доогуур үнээр худалдсан, үнийн зөрүү, хөнгөлөлт тооцсоноос үүссэн алдагдлыг "Кью Эс Си" ХХК-иар нөхөн төлүүлэх;

18.5.2. "Suifenhe Danggyida Trade" Co LTD компани "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-тай байгуулсан гэрээний дагуу экспортолсон 3,994.6 мянган ам долларын баяжмалын борлуулалтын мэдээ зөрүүтэй байгааг хууль хүчний байгууллагаар тодруулан шалгуулах.

18.6.1. "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК нь оффисын байр /УБ хот, Блю скай дахь/-ыг худалдан авснаас хойш хөрөнгийн ашиглалтыг сайжруулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй ба хөрөнгийн ашиглалтгүй байсан хугацаа болон талбайгаар тооцож "Кью Эс Си" ХХК-иас түрээсийн төлбөрийн алдагдсан боломжийн өртөг 414.4 сая төгрөгийг гаргуулах, нэхэмжлэн авах;

18.6.2. Мэргэжлийн зөвлөгөө болон техникийн туслалцаа үзүүлэх 2017 гэрээний дагуу 2017-2021 онд хийгдсэн төлбөрийн 154,413,4 сая төгрөгийгбуцаан авах буюу нэхэмжлэх, авлагаар тусгаж баталгаажуулах;

18.6.3. Ашиглалтын үеийн хайгуулын ажлын төлбөр 1,709.3 сая төгрөгийн өглөгийг "Кью Эс Си" ХХК-д өгөх өглөгөөс хасаж тооцоо хийх.

18.7.1. "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХХК-иас "Кью Эс Си" ХХК-д 2014-2021 оны түрээсийн төлбөрт илүү төлсөн 18.50 тэрбум төгрөгийг нэхэмжлэн авах, тус компанид өгөх өглөгөөс хасаж тооцох;

18.7.2. "Төмөр замын зураг төслийн институт" ХХК-иас Вагон түрээсийн урьдчилгаа төлбөр болох 42.91 тэрбум төгрөгийг нэхэмжлэх эсхүл 400 ширхэг вагоны өмчлөх эрхийг шаардах, мөн вагон түрээсийн урьдчилгаа төлбөр гэж шилжүүлсэн 10.78 тэрбум төгрөгийг нэхэмжлэн авах, тус компанид өгөх өглөгөөс хасаж тооцох.

18.8.1. 2014 оны 4 сараас хойш хийгдсэн гэх 8,265.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын зардал баримтаар нотлогдохгүй байх тул хийгдсэн хөрөнгө оруулалтын жагсаалтыг гарган, хөрөнгө тус бүрээр нь тулган шалгаж баталгаажуулах;

18.8.2. Ханшийн тэгшитгэл хийж хөрөнгө оруулалтын өглөгийг нэмэгдүүлсэн 75,477.4 сая төгрөг, хуримтлуулсан хүү тооцсон 24,526.9 сая төгрөг, нийт 100,004.3 сая төгрөгийг "Кью Эс Си" ХХК-д өгөх өглөгийг тайлан балансаас хасаж тооцох.

18.9.1. Тулган баталгаажуулалт хийгдэж дууссаны дараа татварын албаны 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдөр үүсгэсэн албан татварын ногдуулалт, төлөлтийн байдалд хяналт шалгалт хийх томилолтын дагуу гүйцэтгэсэн ажлын үр дүнг ТЕХ-ийн 79 дүгээр зүйлийн 79.1-д заасан баримт бичиг үйлдэн баталгаажуулах ажиллагаа хийгдэх тул Татварын акт тогтоосон дүнгээр холбогдох этгээдээс төлбөрийг нэхэмжлэн авах;

18.9.2. Гаалийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийсэн шалгалтаар илэрсэн зөрчилд ногдох нөхөн татвар, торгуулийн 1,788.7 сая төгрөгийн

төлбөрийг гаргуулан төсөвт төвлөрүүлэхийн тулд харьяаллын дагуу хуулийн байгууллагаар шийдвэрлүүлэх саналтай байна.





# "ДАРХАНЫ ТӨМӨРЛӨГИЙН ҮЙЛДВЭР" ХК-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, ДУТАГДЛЫН ЖАГСААЛТ

| Д/д | Зөрчлийн утга | Зөрчлийн мөнгөн дүн | | Авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал |
|---|---|---|---|---|
| | | Мянган ам.доллар | Сая төгрөг | |
| 1 | Концессын гэрээний Концессын зүйл туссан хөрөнгө оруулалтыг гэрээний үүргээ зөрчин "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-иар санхүүжүүлсэн. | - | 26,895.30 | "Кью Эс Си" ХХК-иас нэхэмжлэн авах, өглөгийг бууруулах. |
| | Концессын зүйлийн 2.1.1-д заасан Баяжуулах /250тн/ц/ үйлдвэрт хийсэн 2,207.3 сая, Баяжуулах /750тн/ц/ үйлдвэрт хийсэн нэмэлт хөрөнгө оруулалт 6,865.4 сая төгрөг, нойтон соронзон баяжуулах үйлдвэрт хийсэн 11,886.0 сая төгрөгийн үр ашиггүй хөрөнгө оруулалт. | | 20,958.70 | "Кью Эс Си" ХХК-д өгөх хөрөнгө оруулалтын өглөгийг бууруулах. |
| | Хөрөнгө оруулалтын гэрээний дагуу хийгдсэн боловч ашиглалтын хугацаа дуусаагүй байхад акталж, худалдсан тээврийн хэрэгсэл /23 ширхэг, Howo/ | | 2,711.40 | "Кью Эс Си" ХХК-д өгөх хөрөнгө оруулалтын өглөгийг бууруулах. |
| 2 | "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК нь өөрийн үйл ажиллагаандаа зарцуулаагүй, шууд "Кью Эс Си" ХХК- руу шилжүүлсэн хоорондын тооцоогоор гэсэн бичиглэлтэй, санхүүгийн анхан шатны баримт, ямар ажил, үйлчилгээний төлбөр болох нь тодорхойгүй мөнгөн шилжүүлэг. | 56,460.00 | - | Хууль, хүчний байгууллагаар нэг бүрчлэн тодруулан шалгуулах. |
| | Банкнаас авсан зээлийг шууд "Кью Эс Си" ХХК-д шилжүүлж, зээлийн хүүд төлсөн төлбөр. | 13,063.90 | - | "Кью Эс Си" ХХК-иас нэхэмжлэн авах. |
| 3 | Банкны зээл, зээлийн барьцаанд компанийн бүх орлого, хөрөнгө байна. | - | 494,428.20 | Барьцааны хөрөнгийг чөлөөлүүлэх арга хэмжээ авах, хууль хяналтын байгууллагад хандах. |
| 4 | Хувьчлалын үйл ажиллагаа хэрэгжүүлэн компанийн хөрөнгийг бусдад үнэ төлбөргүй шилжүүлсэн. | - | 443.53 | "Кью Эс Си" ХХК-иас төлбөрийг нэхэмжлэн авах, өглөгөөс хасах. |
| 5 | Өөрийн өртгөөс хямдавр борлуулсан баяжмал, цувимал бүтээгдэхүүн, арматур. | - | 5,967.20 | "Кью Эс Си" ХХК-иас төлбөрийг нэхэмжлэн авах эсхүл тус компанид өгөх өглөгийг бууруулах. |
| | Борлуулалтын үнийн зөрүү тооцсон. | - | 597.50 | |
| | Гаалийн байгууллагад мэдүүлсэн, борлуулалтын мэдээнээс зөрүүтэй баяжмал. | 3,994.60 | - | Хууль хүчний байгууллагаар тодруулан шалгуулах. |
| | Төслийн зорилго, үндсэн үйл ажиллагаанд шууд хамааралгүй оффисын барилга худалдан авч компанийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан. | - | 11,136.50 | Төрийн өмчийн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны байгууллагад санал оруулж, ашиглалтыг сайжруулах арга хэмжээ авах. |
| 6 | Оффисын барилгыг бусдад түрээслүүлэн ашиглалтыг сайжруулах арга хэмжээ аваагүйгээс компанийн алдагдсан боломжийн дүнгээр | - | 414.40 | "Кью Эс Си" ХХК-иас түрээсийн төлбөрийг нөхөн төлүүлэх, авлагаас нь хасаж тооцох. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | Урьдчилж төлсөн зардлаар бүртгэсэн менежментийн төлбөр /2022-2027 онд хамаарах/ | - | 154,413.40 | "Кью Эс Си" ХХК-иас төлбөрийг нэхэмжлэн авах, авлагаар бүртгэх. |
| | Концессын гэрээнд тусгагдаагүй зардлыг санхүүжүүлж, Менежментийн төлбөр төлсөн. /2018-2021 оны/ | - | 100,237.30 | |
| | Ашиглалтын үеийн хайгуулын ажлын төлбөрт зарцуулсан. | - | 1,709.28 | "Кью Эс Си" ХХК-д өгөх өглөгөөс хасаж тооцоо хийх |
| 7 | Уул уурхайн машин техник, тоног төхөөрөмж түрээсийн төлбөрт илүү төлсөн. | - | 18,500.00 | "Кью Эс Си" ХХК-иас төлбөрийг нэхэмжлэн авах |
| | Вагон түрээсийн төлбөрт илүү төлөгдсөн. | - | 1,290.00 | |
| | Вагон түрээсийн урьдчилгаа төлбөрт шилжүүлсэн төлбөр | 15.10 | 42,910.00 сая төгрөг эсхүл 400 ш вагон | "Төмөр замын зураг төслийн институт" ХХК иас нэхэмжлэн авах. |
| | | - | 10,780.00 | |
| 8 | Хөрөнгө оруулалтын өглөгт ханшийн тэгшитгэл хийж нэмэгдүүлсэнтэй холбоотой зөрчи | - | 75,477.40 | "Кью Эс Си" ХХК-д өгөх хөрөнгө оруулалтын өглөгийн дүнг бууруулах. |
| | Хөрөнгө оруулалтын өглөгт хуримтлуулсан хүү тооцсон | - | 24,526.90 | |
| | 2014 оноос хойш хийгдсэн, ТӨХ-ны 2013 оны 471 дүгээр тогтоолоор баталгаажуулсаны дараа нэмэлтээр хийсэн хөрөнгө оруулалтын ажил. | - | 8,265.90 | |
| 9 | Татварын тухай хууль тогтоомжийн хүрээнд | - | - | Хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх. |
| | Гаалийн тухай хууль тогтоомжийн хүрээнд | - | 1,788.70 | |
| | НИЙТ ЗӨРЧЛИЙН ДҮН: | $ 73,533.60 | 1,003,451.61 | 1,003,451.61 |
| | | | 1,233,781.64 | |

/Монголбанкны 2022 оны 06 сарын 29-ний өдрийн ам.долларын ханш 3,132.31 төгрөгөөр тооцов/.

ТАЙЛАН БОЛОВСРУУЛСАН:

Ажлын хэсгийн дэд дарга:

Ж.Цогтбаяр — Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газрын Санхүүгийн хяналт шалгалтын хэлтсийн дарга

Ц.Түвшинзаяа — Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтсийн дарга

Гишүүд:

Г.Янжинсүрэн — Сангийн яамны Санхүүгийн хяналт шалгалтын Улсын ахлах байцаагч

С.Баттөр — Сангийн яамны Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч

Е.Ёндонсамбуу — Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын төсвийн





хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн

Д.Сувдмаа — Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн, Санхүүгийн хяналт шалгалтын Улсын ахлах байцаагч

Э.Ганчимэг — Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн, Санхүүгийн хяналт шалгалтын Улсын ахлах байцаагч

А.Алтаншагай — Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтсийн мэргэжилтэн, Санхүүгийн хяналт шалгалтын Улсын байцаагч

Т.Лхагвасүрэн — Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтсийн мэргэжилтэн, Санхүүгийн хяналт шалгалтын Улсын байцаагч

Л.Гэрэлтуяа — Гаалийн ерөнхий газрын Бүрдүүлэлтийн дараах хяналт шалгалтын газрын гаалийн Улсын байцаагч

Ө.Зоригт — Гаалийн ерөнхий газрын Бүрдүүлэлтийн дараах хяналт шалгалтын газрын гаалийн Улсын байцаагч

Ч.Амаржаргал — Татварын ерөнхий газрын Том татвар төлөгчийн газрын Татварын хяналт шалгалтын хэлтсийн Татварын Улсын байцаагч

Р.Энхтуяа — Дархан -Уул аймгийн Татварын хэлтсийн Хяналт шалгалтын тасгийн Татварын Улсын байцаагч

ТАЙЛАНТАЙ ТАНИЛЦАЖ ЗӨВШӨӨРСӨН:

А.Ариунболд — "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК-ийн гүйцэтгэх захирал

С.Сарантуяа — "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК-ийн Ерөнхий нягтлан бодогч

------ o0o ------

# ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 04 сарын 14 өдөр Дугаар 123 Улаанбаатар хот

“Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-ийн
удирдлагын эрх болон хөрөнгийг “Кью Эс Си” ХХК-аас
буцаан шилжүүлэн авах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн “Концессын гэрээ цуцлах тухай” 148 дугаар тогтоолыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Концессын гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй “Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төсөл”-ийн концесс эзэмшигч “Кью Эс Си” ХХК-тай 2014 оны 04 дүгээр сарын 4-ний өдөр байгуулсан концессын гэрээг цуцалсантай холбогдуулан ““Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-ийн удирдлагын эрх болон хөрөнгийг шилжүүлэх тухай” Төрийн өмчийн хорооны 2014 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 207 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

2.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” төрийн өмчит хувьцаат компанийг концессын гэрээний хугацаанд Концесс эзэмшигчтэй нэгтгэсэн “Концессын гэрээний хэрэгжилтийг хангах тухай” Төрийн өмчийн хорооны 2015 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн 527 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

3.“Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-ийн удирдлагын эрх болон хөрөнгийг “Кью Эс Си” ХХК-аас буцаан авч байгаатай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Төрийн өмчийн удирдлага зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ), Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т тус тус даалгасугай.

3.1.“Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-ийн удирдлагын эрх болон хөрөнгийг “Кью Эс Си” ХХК-аас буцаан шилжүүлэн авах үйл ажиллагааг зохион байгуулах, компанийн дүрмийг шинэчлэн батлуулах, компанийн хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллах.

3.2.“Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-ийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх, хөрөнгийн тооллого хийж, компанийн хөрөнгийг төрийн өмчид бүртгэх ажлыг зохион байгуулах.

3.3.Компанийн үйл ажиллагааг хэвийн явуулах талаар цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллах.

ДАРГА Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА Ц.БАЯР-ЭРДЭНЭ

132001150

\Huraldaanii material\2022 on\2022.04.14 10-r huraldaan.docx

# ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
# ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
# ТОГТООЛ

2022 оны 04 сарын 14 өдөр Дугаар 124 Улаанбаатар хот

## Төрийн өмчийн төлөөлөгч томилох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6, 9 дэх хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн "Концессын гэрээ цуцлах тухай" 148 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн ""Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК-ийн удирдлагын эрх болон хөрөнгийг "Кью Эс Си" ХХК-аас буцаан шилжүүлэн авах тухай" 123 дугаар тогтоол гарсантай холбогдуулан "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" төрийн өмчит хувьцаат компанийн Гүйцэтгэх захирлыг эрх бүхий этгээд томилох хүртэл хугацаанд захирлын үүргийг түр гүйцэтгэх төрийн өмчийн төлөөлөгчөөр Ц.Шинэхүү (ТӨУЗХ-ийн Төлөвлөлт, хөрөнгө оруулалтын албаны дарга)-г томилсугай.

2. Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан, хууль журамд заасан чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллах, компанийн дүрэм, бүтэц болон эдийн засгийн үндсэн үзүүлэлт зорилтот түвшинг боловсруулан Төрийн өмчийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанаар шийдвэрлүүлэхийг Төрийн өмчийн төлөөлөгч Ц.Шинэхүүд даалгасугай.

3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг танилцуулан ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга (Ц.Баяр-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА Ц.БАЯР-ЭРДЭНЭ

132031192

\Huraldaanll material\2022 on\2022.04.14 10-r huraldaan.docx

**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,**
**ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН**
**ТОГТООЛ**

2022 оны 04 сарын 18 өдөр Дугаар 136 Улаанбаатар хот

Төрийн өмчийн төлөөлөгч томилох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6, 9 дэх хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн "Концессын гэрээ цуцлах тухай" 148 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК-ийн удирдлагын эрх болон хөрөнгийг "Кьюү Эс Си" ХХК-аас буцаан шилжүүлэн авах тухай" 123 дугаар тогтоол гарсантай холбогдуулан "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын үүргийг түр гүйцэтгэх төрийн өмчийн төлөөлөгчөөр А.Ариунболдыг томилсугай.

2.Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан, хууль журамд заасан чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллах, компанийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт зорилтот түвшинг боловсруулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанаар шийдвэрлүүлэхийг Төрийн өмчийн төлөөлөгч А.Ариунболдод даалгасугай.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 124 дүгээр тогтоолын 1 дүгээр заалтыг хүчингүй болгосугай.

4.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг танилцуулан ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга (Ц.Баяр-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА Ц.БАЯР-ЭРДЭНЭ

\Huraldaanii material\2022 on\2022.04.18 ... 13.000.1008

# ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 10 сарын 13 өдөр Дугаар 435 Улаанбаатар хот

Удирдамж болгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6, 21 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 65 дугаар зүйл, Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам"-ын 3.1.3 дахь заалт, Авлигатай тэмцэх газрын 2022 оны 05/13339 дүгээр албан бичгээр ирүүлсэн дүгнэлтийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг удирдамж болгосугай.

1.1 "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирлаар Ганпүрэвийн Дугаржавыг томилох асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх.

1.2. "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Ганпүрэвийн Дугаржавтай Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг хууль тогтоомжийн дагуу байгуулж ажиллах.

2.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА Ц.БАЯР-ЭРДЭНЭ

132003086

2022.10.13.23-t huralдaan.docx

МОНГОЛ УЛС
**АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР**
14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
И-мэйл: comcor@iaac.mn, Вэб сайт: http://iaac.mn

2022.10.11 № 05/13339
танай ____________-ны № ____________-т

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА
Б.ЦЭНГЭЛ ТАНАА

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг хянасан тухай

"Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн Ганпүрэвийн Дугаржавын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан 4сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянахад тухайн албан тушаалд томилоход ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Нэр дэвшигч нь тухайн албан тушаалд томилогдсон тохиолдолд Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3-т заасан хугацаанд хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг, тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөл байдалд дээрх хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж байх, мөн хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллахад анхаарна уу.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН,
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА
ЭРХЭЛСЭН КОМИССАР Т.ЭНХБОЛД

УХА0422 9120629

1422003018303

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2023.01.24 № ХЭГ/244

танай ______-ны №______-т

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Б.БАТТӨМӨР ТАНАА

Мэдээлэл хүргүүлэх тухай

"Дарханы төмөрлөгийн үйлдвэр" төрийн өмчит хувьцаат компанитай холбоотой асуудлаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан Таны асуулгатай холбогдуулан тус компанийг концессын гэрээгээр хувьчилсан сонгон шалгаруулалттай холбоотой мэдээллийг Эдийн засаг, хөгжлийн яамнаас ирүүлснийг Танд хүргүүлж байна.

Хавсралт 77 хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Д.АМАРБАЯСГАЛАН

000235002838

**МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД**

Засгийн газрын II байр, Нэгдсэн үндэстний гудамж 5/1,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 33 33,
Цахим шуудан: info@med.gov.mn

2023. 01. 18 № 01/98

танай ______________-ны №______________-т

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Д.АМАРБАЯСГАЛАН ТАНАА

"Дарханы төмөрлөгийн үйлдвэр" төрийн өмчит хувьцаат компанийг концессын гэрээгээр хувьчилсан сонгон шалгаруулалттай холбоотой мэдээллийг ирүүлэх тухай хүсэлтийг хүлээн авч танилцлаа.

Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төслийг хэрэгжүүлэх концессын гэрээний хувийн хэргээс "Кью Эс Си" ХХК-г хөрөнгө оруулагчаар шалгаруулсан болон хөрөнгө оруулалтын гэрээг концессын гэрээ болгож өөрчилсөн тухай холбогдох баримтуудыг, концессын гэрээний хэрэгжилтэд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн хамт хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 76 хуудастай.

Ч.ХҮРЭЛБААТАР

230103

Хавсралт

| № | Огноо | Баримтын нэр, агуулга | Хуудас |
|---|---|---|---|
| 1 | 2008.04.23 | Засгийн газрын тогтоол № 153,<br>ДТҮ-ийн талаар авах арга хэмжээний тухай | 1 |
| 2 | 2009.11.23 | ТӨХ-ний даргын тушаал, № 333,<br>Ажлын хэсэг томилох тухай | 1 |
| 3 | 2009.12.04 | Ажлын хэсгийн танилцуулга | 3 |
| 4 | 2012.08.01 | ТӨХ-ны тогтоол, товч танилцуулга № 326,<br>Хөрөнгө оруулалтын тухай | 3 |
| 5 | 2012.08.01 | ТӨХ-ны тогтоол, товч танилцуулга № 327 | 4 |
| 6 | 2013.07.05 | ТӨХ-ны тогтоол, товч танилцуулга № 471 | 2 |
| 7 | 2013.03.21 | "Кьюр Эс Си" ХХК-ийн албан бичиг, № 1/23 тоот | 3 |
| 8 | 2013.03.21 | "ДТҮ" ТӨХК-ийн албан бичиг, № 1-343 | 1 |
| 9 | 2013.05.02 | ҮАГ-ын албан бичиг, № 2/744 | 1 |
| 10 | 2013.05.07 | "Кьюр Эс Си" ХХК-ийн албан бичиг, № 1/39 | 2 |
| 11 | 2013.08.22 | "Кьюр Эс Си" ХХК-ийн албан бичиг, № 1/56 | 2 |
| 12 | 2014.01.24 | ЭЗХЯ-ны ТНБД-ын тушаал, № 11 | 1 |
| 13 | 2014.01.21 | "Кьюр Эс Си" ХХК-ийн албан бичиг, № 1/04 | 1 |
| 14 | 2014.02.04 | Ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэл | 2 |
| 15 | 2014.02.06 | Ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэл | 3 |
| 16 | 2014.02.12 | Ажлын хэсгийн дүгнэлт | 2 |
| 17 | 2014.02.20 | ЭЗХСайдын албан бичиг № 1/305,<br>Танилцуулга, Дүгнэлт | 5 |
| 18 | 2014.04.08 | ЭЗХСайдын албан бичиг № 1/671 | 1 |
| 19 | 2014.04.15 | ТӨХ-ны тогтоол № 155 | 2 |
| 20 | 2014.04.24 | ТӨХ-ны тогтоол № 207 | 2 |
| Дугаар (1-с 20-т) "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" төрийн өмчит хувьцаат компанийг концессын гэрээгээр хувьчилсан сонгон шалгаруулалттай холбоотой мэдээлэл, нотлох баримтууд | | | /Нийт/ 42 |
| 21 | 2021.10.13 | Үндэсний аудитын газрын гүйцэтгэлийн аудитын тайлан | 33 |
| **Нийт хуудас** | | | **75** |

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
# ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 2008 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр | Дугаар 153 | Улаанбаата хот |

"Дарханы төмөрлөгийн үйлдвэр' төрийн өмчит хувьцаат компанийн талаар авах зарим арга хэмжээний тухай

Ашигт малтмалын тухай хуулийн 9.1.8 дахь заалт үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Дархан-Сэлэнгийн бүсэд орших төрийн эзэмшли төмрийн хүдрийн орд газруудыг ашиглах, "Дарханы төмөрлөги үйлдвэр" төрийн өмчит хувьцаат компанийн үйл ажиллагаа өргөтгөн техник, технологийн шинэчлэл хийж, үйлдвэрийн хүчи чадлыг нэмэгдүүлэх, үр ашгийг дээшлүүлэх техник-эди засгийн үндэслэлийг боловсруулж, төслийг хэрэгжүүлэх зохис байгуулалтын арга хэмжээ авахыг Үйлдвэр, худалдааны сай Х.Наранхүү, Төрийн өмчийн хороо (Д.СУГАР)-нд үүрэ болгосугай.

2. Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан төслийн нөхцөл шаардлагыг хэрэгжүүлэх болон санхүүжилтийг үйл ажиллагаан ашгаас эргэн төлөгдөх нөхцөлтэй зохион байгуула менежментийн гэрээг "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" төрий өмчит хувьцаат компанийн удирдлагатай байгуулж ажиллахы Үйлдвэр, худалдааны сайд Х.Наранхүү, Төрийн өмчийн хоро (Д.СУГАР)-нд даалгасугай.

| | |
|---|---|
| Монгол Улсын Ерөнхий сайд | С.БАЯР |
| Үйлдвэр, худалдааны сайд | Х.НАРАНХҮҮ |

# МОНГОЛ УЛСЫН
# ТӨРИЙН ӨМЧИЙН ХОРООНЫ ДАРГЫН
# ТУШААЛ

2009 оны 11 сарын 23 өдөр Дугаар 333 Улаанбаатар хот

Ажлын хэсэг томилох тухай

"Дарханы төмөрлөгийн үйлдвэр ТӨХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай" Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн 153 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" төрийн өмчит хувьцаат компанийн үйл ажиллагааг өргөтгөн техник, технологийн шинэчлэл хийж, үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, үр ашгийг дээшлүүлэх талаар гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдаас ирсэн саналд үнэлэлт дүгнэлт өгөх Ажлын хэсгийг дор дурдсан бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

| | |
|---|---|
| Ц.Нанзаддорж | /Төрийн өмчийн хорооны Төрийн өмчийн удирдлага, хувьчлалын газрын дарга/ |
| Гишүүд: | |
| В.Дарханбаатар | /Төрийн өмчийн хорооны Төрийн өмчийн удирдлага, хувьчлалын газрын мэргэжилтэн/ |
| М.Баттөгс | /Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК-ийн орлогч захирал/ |
| Д.Баасанжав | / Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК-ийн Менежер/ |

2. Ажлын хэсэг тайлан, дүгнэлтээ Төрийн өмчийн хорооны удирдлагад танилцуулахыг Ажлын хэсэг /Ц.Нанзаддорж/-т даалгасугай.

ДАРГА Д.СУГАР

0000245

# ТАНИЛЦУУЛГА

2009 оны 12 дугаар сарын 04-ний өдөр Улаанбаатар хот

ХОЛБОГДОХ ШИЙДВЭРҮҮДИЙН ТАЛААР:

Засгийн газрын 2008 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн 153 дугаар тогтоолоор Дархан-Сэлэнгийн бүсэд орших төрийн эзэмшлийн төмрийн хүдрийн орд газруудыг ашиглах, "Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр"ТӨХК-ийн үйл ажиллагааг өргөтгөн техник, технологийн шинэчлэл хийж, үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, үр ашгийг дээшлүүлэх, техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулж, төслийг хэрэгжүүлэх, зохион байгуулалтын арга хэмжээ авахаар шийдвэрлэсэн.

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН ТАЛААР ТОВЧ МЭДЭЭЛЭЛ:

1. CPMIE / China National Precision Machinery I/E corporation/ нь "Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр" ТӨХК-ийн эзэмшлийн Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын нутаг дэвсгэрт орших 13319A лицензийн дугаартай Төмөртэйн орд, Ерөө сумын нутагт орших 13851A лицензийн дугаартай Хуст-Уулын орд, Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших 10738A лицензийн дугаартай Төмөртолгойн төмрийн хүдрийн ордуудыг ашиглан Металлургийн цогцолбор барьж байгуулах төслийг хэрэгжүүлэх санал ирүүлж, CPMIECorp-ийн захиалгаар Beris Engineering and Research Institute8 MCC2 Northerin Engineering & Technology Corporation судалгааны институтын төлөөлөл дарханы төмөрлөгийн үйлдвэрийн тухайн үеийн байдалтай, шинээр барих металлургийн цогцолборын хүчин чадал, технологи сонголт, дэд бүтцийн судалгаа хийсэн.

   Жилд 4,0 сая тонн төмрийн хүдэр олборлох үйлдвэр, 4,0 сая тонн төмрийн хүдэр баяжуулах үйлдвэр, 2,0 сая тонн бөөнцөгийн үйлдвэр, 540,0 мянган тонн цувимал бүтээгдэхүүн үйлдвэрлэх төмрийн үйлдвэр байгуулахаар тусгасан бөгөөд урьдчилсан тооцоогоор 889,3 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийхээр тооцсон байна. Төслийг БНХАУ-ын банкны төслийн зээлийн санхүүжилтээр хэрэгжүүлж, ойролцоогоор 6-7 жилд зээл, зээлийн хүүгийн хамт эргэн төлөгдөж бүрэн дуусмагц Монголын талд буюу Дарханы төмөрлөгийн үйлдвэрт шилжүүлж болох талаар төсөлд тусгасан.

2. Энэтхэг улсын "Меско Стийл" групп нь жилд 1,7 сая тонн бөөнцөг үйлдвэрлэхийн тулд 2,4 сая тонн хүдэр боловсруулах хүчин чадалтай баяжуулах үйлдвэр байгуулах санал тавьсан байна. Тус группийн гангийн үйлдвэр нь Орисса мужид байрладаг ба тэнд төмрийн өндөр агууламжтай уурхайнууд, Мадия Прадеш мужид коксждог нүүрсний уурхай эзэмшдэг байна. Дэлхийд гангийн болон уурхайн худалдаагаар 3-т ордог Английн Стемкор компани хувьцааных нь 10 хувийг эзэмшдэг байна.

"Меско Стийл" групп нь Гангийн үйлдвэрийг өргөтгөхийн тулд "Дарханы төмөрлөгийн үйлдвэр"ТӨХК-ийн нийт хувьцааны 51 хувь буюу удирдлагын багцыг эзэмшиж, технологийн үйл ажиллагааг хянахыг санал болгосон. Цаашид "Меско стийл" групп нь эзэмших хувиа 49 хувь хүртэл бууруулж болох боловч энэ тохиолдолд технологийн болон үйл ажиллагаанд бүрэн хяналт тавьж ажиллах саналтай байгаагаа илэрхийлсэн.

3. ICM (Industrial Corporation of Mongolia) ХХК нь жилд 1'000'000,0 тонн төмрийн хүдэр боловсруулж, 500'000,0 тонн төмөр үйлдвэрлэх үйлдвэрийн ТЭЗҮ-ийг Австрали улсын Ausmelt компанид захиалан хийлгэсэн бөгөөд 2 жилийн дотор барьж ашиглалтанд оруулах боломж байгаа гэсэн санал төлөвлөгөөгөө илэрхийлсэн.

4. Солонгос улсын Поско компанийн менежмент судалгааны посри төв "Монголын төмөрлөгийн үйлдвэрлэл болон түүнтэй холбоотой баялгийг олборлох стратеги бодлого"-ын талаар хамтарсан судалгаанд төсөл хэрэгжүүлэх хоёр талын харилцан ойлголцлын санамж бичгийг 2009 оны 11-р сарын 20-ны өдөр байгуулсан ба судалгааны эцсийн тайланг ирүүлээгүй болно.

5. "Кью Эс Си"ХХК 2009 оны 11-р сарын 05-ны өдөр Дархан-Сэлэнгийн бүсэд орших төрийн эзэмшлийн төмрийн хүдрийн орд газруудыг ашиглаж эдийн засгийн эргэлтэнд оруулах, "Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр" ТӨХК-ийн үйл ажиллагааг өргөтгөн техник, технологийн шинэчлэл хийж, үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулж, үр ашгийг дээшлүүлэх төслийг хэрэгжүүлэх саналаа ирүүлсэн.

Тус компани нь гангийн үйлдвэрлэл, технологиороо дэлхийд тэргүүлэгчид болохХБНГУ-ын SMS SIEMAG GROUP, OUTOTEC компаниудыг технологийн зөвлөгчөөр авч хамтран ажиллах бөгөөд Худалдаа хөгжлийн банк уг төслийг хэрэгжүүлэхэд санхүүгийн бүхий л үйлчилгээг үзүүлэхээр хамтран ажиллах хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан байна.

"Кью Эс Си"ХХК нь Дархан-Сэлэнгийн бүсэд орших төрийн эзэмшлийн төмрийн хүдрийн орд газруудыг ашиглаж, эдийн засгийн эргэлтэд оруулах, "Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр" ТӨХК-ийн үйл ажиллагааг өргөтгөн техник, технологийн шинэчлэл хийж, үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулж, үр ашгийг дээшлүүлэх төслийн санхүүжүүлтыг бүрэн шийдэж хэрэгжүүлж, хөрөнгө оруулалтын үр дүнд үйлдвэрлэн гаргасан бүтээгдэхүүний 70% /далан хувь/-ийг өөрийн өртөг шингэсэн үнээр худалдан авах эрх эдлэхээр тусгасан байна. Уг төсөлд Төмөртолгойн уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлж жилд 1,0 сая тонн хүдэр олборлох уул уурхайн цогцолбор барих, жилд 1,0 сая тонн хүдэр баяжуулах үйлдвэр байгуулах, жилд 300,0 мянган тонн шууд ангижруулсан төмөр боловсруулах үйлдвэр байгуулах, Төмөрлөгийн үйлдвэрийн хайлах, цувих технологийн шугамын өргөтгөл хийх ба шаваган зуухны тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтад 10,0 сая ам.доллар, цувих цехийн хөрөнгө оруулалтад 12,1 сая ам.доллар зарцуулахаар тусгасан байна.

6. БНХАУ-ын Бугат хотын төмөрлөгийн үйлдвэр болох "Бао ган" компани нь Монголд судалгаа хийсний үндсэн дээр Дархан-Сэлэнгийн бүс нутагт шинээр төмөрлөгийн цогцолбор үйлдвэр байгуулах төслийг боловсруулж санал болгосон байна. Жилд 5,0 сая тонн ган төмөр бүтээгдэхүүн боловсруулах хүчин чадалтай үйлдвэрийг 2 үе шаттайгаар хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн.

"Бао Ган" компани нь Монголд хийсэн судалгаандаа үндэслэн Дархан-Сэлэнгийн бүс нутагт шинээр төмөрлөгийн цогцолбор үйлдвэрийн төсөл шалгарсан тохиолдолд 20-30 жил тасралтгүй үйл ажиллагаа явуулах бөгөөд, үйлдвэрийг түүхий эдээр хангах төмрийн хүдрийн орд болон өнөөдөр хайгуулын шатанд байгаа төмрийн хүдрийн талбайг тус компанид эзэмших эрх олгох нөхцлийг тавьсан байна.

АЖЛЫН ХЭСГЭЭС ГАРГАСАН ДҮГНЭЛТ:

А. Монгол Улсын Засгийн Газрын үйлдвэрлэлийг хөгжүүлэх талаар гаргасан удаа дараагийн тогтоол шийдвэрүүд, "Оюу толгой", "Таван толгой" төсөл, Шивээ-Овоогийн болон Улаанбаатрын 5-р цахилгаан станц, "Утаагүй Улаанбаатар-100 мянган айлын орон сууц-авто зам" төсөл, Хөшигтийн хөндийн олон улсын нисэх буудал зэрэг төслүүдийн бүтээн байгуулалтад шаардагдах арматур болон бусад ган хийцийн бүтээгдэхүүнийг үндэсний үйлдвэрлэлээр бүрэн хангахын тулд Засгийн газрын 2008 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн 153 дугаар тогтоолоор Дархан-Сэлэнгийн бүсэд орших төрийн эзэмшлийн төмрийн хүдрийн орд газруудыг ашиглаж, эдийн засгийн эргэлтэд оруулж, "Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр" ТӨХК-ийн үйл ажиллагааг өргөтгөн техник, технологийн шинэчлэл хийж, үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулж, үр ашгийг дээшлүүлэх зайлшгүй шаардлага байна гэж үзсэн.

В. Дархан-Сэлэнгийн бүсэд орших төрийн эзэмшлийн төмрийн хүдрийн орд газруудыг ашиглаж, эдийн засгийн эргэлтэд оруулах, "Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр" ТӨХК-ийн үйл ажиллагааг өргөтгөн техник, технологийн шинэчлэл хийж, үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулж, үр ашгийг дээшлүүлэх төслийг хэрэгжүүлэх хөрөнгө оруулагчаар үндэсний компани болох "Кьюо Эс Си"ХХК-ийг санал болгож байна.

Уг компанийг санал болгож байгаа үндэслэл нь үйлдвэр болон ил уурхайд зэрэг хөрөнгө оруулалт хийж, үйлдвэрлэн гаргах бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах цаашлаад бусад төслүүдээс ялгарч буй хамгийн гол үзүүлэлт нь тус үйлдвэрийн эзэмшлийн төмрийн хүдрийн ордуудаас болон "Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр" ТӨХК-ийн хувьцаанаас ямар нэг хувь эзэмшихгүй, үндэсний компани гэдэгт оршино.

# МОНГОЛ УЛСЫН
# ТӨРИЙН ӨМЧИЙН ХОРООНЫ ТОГТООЛ

2012 оны 8 сарын 01 өдөр  Дугаар 326  Улаанбаатар хот

Хөрөнгө оруулалтын тухай

"Дарханы төмөрлөгийн үйлдвэр" төрийн өмчит хувьцаат компанийн талаар авах зарим арга хэмжээний тухай" Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн 153 дугаар тогтоол, "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" төрийн өмчит хувьцаат компанийн 2011 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, Үндэсний Аудитын Газрын 2012 оны дүгнэлтийг үндэслэн Төрийн өмчийн хорооноос ТОГТООХ нь:

1. "Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төсөл"-ийг хамтран хэрэгжүүлэх талаар "Дархан төмөрлөгийн үйлдвэр" төрийн өмчит хувьцаат компани, "Кьюю Эс Си" хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хооронд 2010 оны 09 дүгээр сарын 29-ны өдөр байгуулсан "Хөрөнгө оруулалтын гэрээ"-ний дагуу "Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төсөл"-ийн хүрээнд "Кьюю Эс Си" хязгаарлагдмал хариуцлагатай компани 48 сая ам долларын хөрөнгө оруулалт оруулсан болохыг зөвшөөрсүгэй.

2. Энэхүү төслийг цаашид гэрээний хугацаанд үргэлжлүүлэн хэрэгжүүлж дуусгахад бүх талын дэмжлэг үзүүлэн ажиллахыг "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөл болон Гүйцэтгэх удирдлагад даалгасугай.

ДАРГА  Ц.НАНЗАДДОРЖ

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА  Л.ГАНБАТ

# УУЛ УУРХАЙ, МЕТАЛЛУРГИЙН ЦОГЦОЛБОР БАЙГУУЛАХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН АЖЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

"Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай" Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн 153 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор "Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төсөл"-ийг хамтран хэрэгжүүлэх талаар "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХКомпани, "Кьюо Эс Си" Хязгаарлагдмал Хариуцлагатай Компанийн хооронд "Хөрөнгө оруулалтын гэрээ"-г 2010 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр байгуулж, Төрийн өмчийн хорооны дарга баталж үйл ажиллагаа эхлүүлсэн билээ.

"Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төсөл"-ийг хамтран хэрэгжүүлэх ажил амжилттай хэрэгжиж энэхүү гэрээний дагуу Дархан- Сэлэнгийн бүсэд орших төрийн эзэмшлийн төмрийн хүдрийн Хуст уул, Төмөр толгойн орд газруудыг үе шаттайгаар ашиглаж, эдийн засгийн эргэлтэд оруулах, "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК-ийн үйл ажиллагааг өргөтгөн техник, технологийн шинэчлэл хийж, үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор уурхайд шаардагдах шинэ техник, тоног төхөөрөмжүүдийг нийлүүлснээр ил уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлж жилд 1 сая тонн төмрийн хүдэр олборлодог болголоо.

Мөн Металлургийн цогцолбор байгуулах зорилгоор ХБНГУ-ын "SMS SIEMAG" Финландын "OUTOTEC" Японы "KOBE STEEL" компаниудтай хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурж баталгаажуулан хоёр тал ажлын хэсэг байгуулан ажиллаж байна. Энэхүү ажил ТЭЗҮ-ийн хүрээнд үндсэн тооцооллын шатанд явагдаж байна. Мөн төслийг хэрэгжүүлэх зорилгоор металлургийн чиглэлээр олон жилийн дадлага туршлагатай мэргэшсэн зөвлөх инженерийг ХБНГУ-аас урьж ирүүлэн төслийн зөвлөхөөр ажиллуулж байна.

Жилд 500000 тонн ганхайлуулах үйлдвэр байгуулах ажлын эхний үе шат болох хүдрийг баяжуулж ган үйлдвэрлэх стандартыг хангасан түүхий эд бэлтгэх хуурай, нойтон соронзон аргын үйлдвэрийн "Техник Эдийн Засгийн Үндэслэл"-ийг Эрдэс Баялгийн Мэргэжлийн Зөвлөлөөр батлуулсан. Хуурай аргаар жилд нэг сая тонн хүдэр баяжуулах үйлдвэр, мөн хуурай аргаар гарсан хүдрийг нойтон аргаар баяжуулж өндөр агуулгатай ган үйлдвэрлэх стандартын шаардлага хангасан үйлдвэр захиалж шаардлагатай тоног төхөөрөмжүүдийн хамт импортлон оруулж ирсэн бөгөөд одоо үйлдвэрийн тоног төхөөрөмжийн угсралтын ажил ид шатандаа явагдаж байна.

Ил уурхайн техник тоног төхөөрөмж, уурхайн төлөвлөлт, дизайныг мэргэжлийн байгууллагаар хийлгэж Монгол улсын Эрдэс Баялагын Мэргэжлийн Зөвлөлөөр батлуулж хөрөнгө оруулалтыг иж бүрэн хийсэн.

104

"Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК-ийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулж, үр ашгийг дээшлүүлэх зорилгоор шинэ бүтээгдэхүүн нэмж үйлдвэрлэх бүтээгдхүүний өртөг, зах зээлийн судалгаа тооцоо хийгдэж байна.

ПБА ... гарын

12 8 01

"Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төсөл"-ийг хамтран хэрэгжүүлэх талаар 2010 оны 09 дугаар сарын 29-ны өдөр байгуулсан Хөрөнгө оруулалтын гэрээний дагуу "Кью Эс Си" ХХКомпани 48 сая ам долларын хөрөнгө оруулалт оруулаад байна.

Иймд "Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төсөл"-ийг хамтран хэрэгжүүлэх талаар 2010 оны 09 дугаар сарын 29-ны өдөр байгуулсан Хөрөнгө оруулалтын гэрээний дагуу "Кью Эс Си" ХХК-аас "Дархан төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК-ийн хамтарсан төсөлд 48 сая ам долларын хөрөнгө оруулалт оруулсан болохыг зөвшөөрч, энэхүү төслийг цаашид гэрээний хугацаанд үргэлжлүүлэн хэрэгжүүлж дуусгахад бүх талын дэмжлэг үзүүлэн ажиллахыг "Дархан төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагад даалгах саналыг ТӨХ-ны хуралдаанд танилцуулж байна.

Төрийн өмчийн хороо

104

12 8 01

# МОНГОЛ УЛСЫН
# ТӨРИЙН ӨМЧИЙН ХОРООНЫ ТОГТООЛ

2012 оны 8 сарын 01 өдөр Дугаар 327 Улаанбаатар хот

"Дарханы төмөрлөгийн үйлдвэр" төрийн өмчит хувьцаат компанийн талаар авах зарим арга хэмжээний тухай"

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6 дахь заалт, 21 дүгээр зүйл, Компаний тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" төрийн өмчит хувьцаат компанийн талаар авах зарим арга хэмжээний тухай" Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн 153 дугаар тогтоол, "Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төсөл"-ийг хамтран хэрэгжүүлэх талаар "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" төрийн өмчит хувьцаат компани, "Кью Эс Си" хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хооронд байгуулсан "Хөрөнгө оруулалтын гэрээ"-г үндэслэн Төрийн өмчийн хорооноос ТОГТООХ нь:

1. Засгийн Газрын 2008 оны 153 дугаар тогтоолд заасан төслийн нөхцөл шаардлагын дагуу хөрөнгө оруулалт хийж, "Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төсөл"-ийг хамтран хэрэгжүүлэх Хөрөнгө оруулалтын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж байгааг харгалзан "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" төрийн өмчит хувьцаат компанийн менежментийг "Хөрөнгө оруулалтын гэрээ" хэрэгжих хугацаанд "Кью Эс Си"хязгаарлагдмал хариуцлагатай компанид шилжүүлсүгэй.

2. Төслийн үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор менежментийн гэрээг боловсруулж, Төрийн өмчийн хороогоор батлуулахыг "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.

3. "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд Төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүнээс Б.Хүрэлбаатар /ЭБЭХЯ-ны төрийн нарийн бичгийн дарга/, Ж.Бат-Эрдэнэ /ЗТБХБЯ-ны төрийн нарийн бичгийн дарга/, Б.Батбаяр /СЯ-ны санхүү эдийн засгийн бодлогын газрын дарга/, Ч.Цогтбаатар /ЭБЭХЯ-ны уул уурхай, хүнд үйлдвэрийн бодлогын газрын орлогч дарга/, Ж.Уранчимэг /ЗГ-ын ХЭГ-ын референт/, Х.Хэрлэн /Төрийн өмчийн хорооны газрын дарга/, Я.Цогтбаатар /ТӨХ-ны Хангамж, үйлчилгээний хэлтсийн дарга/ нарыг 2012 оны 7 дугаар сарын 5-ны өдрөөр тасалбар болгон чөлөөлсүгэй.

4. "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд Төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх гишүүнээр Б.Батхүү /ЭБЭХЯ-ны уул уурхай, хүнд үйлдвэрийн бодлогын газрын дарга/, Х.Хэрлэн /Төрийн өмчийн хорооны Төрийн өмчийн удирдлага, хувьчлалын газрын дарга/, В.Дарханбаатар /Төрийн өмчийн хорооны Төрийн өмчийн удирдлага, хувьчлалын газрын мэргэжилтэн/, Д.Эрдэнэбилэг /Төслийн санхүү стратегийн зөвлөх/, Д.Батжавхлан /Кью Эс Си ХХК-ийн гүйцэтгэх захирал/, Ж.Эрдэнэбилэг/Төслийн эдийн засгийн зөвлөх/, хараат бус гишүүнээр С.Оргодол /ХХБ-ны

гүйцэтгэх захирлын орлогч, эрх зүйч/, Д.Цэрэнбадам /Монголын Хуульчдын Холбооны тэргүүлэгч/, Ц.Мөнхжаргал /Монголын Металлургичдын холбоо ТББ-ын тэргүүн/ нарыг 2012 оны 7 дугаар сарын 5-ны өдрөөс эхлэн томилсугай.

ДАРГА Ц.НАНЗАДДОРЖ

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Л.ГАНБАТ

# ТАНИЛЦУУЛГА

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6 дахь заалт, 21 дүгээр зүйл, Компаний тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" төрийн өмчит хувьцаат компанийн талаар авах зарим арга хэмжээний тухай" Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн 153 дугаар тогтоол, "Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төсөл"-ийг хамтран хэрэгжүүлэх талаар "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" төрийн өмчит хувьцаат компани, "Кью Эс Си" хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хооронд байгуулсан "Хөрөнгө оруулалтын гэрээ"г үндэслэн Засгийн Газрын 2008 оны 153 дугаар тогтоолд заасан төслийн нөхцөл шаардлагыг дагуу хөрөнгө оруулалт хийж, "Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төсөл"-ийг хамтран хэрэгжүүлэх Хөрөнгө оруулалтын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж байгааг харгалзан "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" төрийн өмчит хувьцаат компанийн менежментийг "Хөрөнгө оруулалтын гэрээ" хэрэгжих хугацаанд "Кью Эс Си" хязгаарлагдмал хариуцлагатай компанид шилжүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

"Дарханы төмөрлөгийн үйлдвэр" төрийн өмчит хувьцаат компанийн менежментийг "Хөрөнгө оруулалтын гэрээ" хэрэгжих хугацаанд "Кью Эс Си" хязгаарлагдмал хариуцлагатай компанид шилжүүлж байгаатай холбогдуулан Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6 дахь заалт, 21 дүгээр зүйл, Компаний тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалтыг үндэслэн "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд Төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүнээс Б.Хүрэлбаатар /ЭБЭХЯ-ны төрийн нарийн бичгийн дарга/, Ж.Бат-Эрдэнэ /ЗТБХБЯ-ны төрийн нарийн бичгийн дарга/, Б.Батбаяр /СЯ-ны санхүү эдийн засгийн бодлогын газрын дарга/, Ч.Цогтбаатар /ЭБЭХЯ-ны уул уурхай, хүнд үйлдвэрийн бодлогын газрын орлогч дарга/, Ж.Уранчимэг /ЗГ-ын ХЭГ-ын референт/, [illegible].Хэрлэн /Төрийн өмчийн хорооны газрын дарга/, Я.Цогтбаатар /ТӨХ-ны Хангамж, үйлчилгээний хэлтсийн дарга/ нарыг 2012 оны 7 дугаар сарын 5-ны өдрөөр тасалбар болгон чөлөөлж, "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд Төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх гишүүнээр Б.Батхүү /ЭБЭХЯ-ны уул уурхай, хүнд үйлдвэрийн бодлогын газрын дарга/, [illegible].Хэрлэн /Төрийн өмчийн хорооны Төрийн өмчийн удирдлага, хувьчлалын газрын дарга/, [illegible].Дарханбаатар /Төрийн өмчийн хорооны Төрийн өмчийн удирдлага, хувьчлалын газрын мэргэжилтэн/, Д.Эрдэнэбилэг /Төслийн санхүү стратегийн зөвлөх/, Д.Батжавхлан / Кью Эс Си ХХК гүйцэтгэх захирал/, Ж.Эрдэнэбилэг /Төслийн эдийн засгийн зөвлөх/, хараат бус гишүүнээр С.Оргодол /ХХБ-ны гүйцэтгэх захирлын орлогч/, Д.Цэрэнбадам /Монголын Ажилчдын Холбооны тэргүүлэгч/, Ц.Мөнхжаргал /Монголын Металлургичдын холбооны ТББ-ын тэргүүн/ нарыг 2012 оны 7 дугаар сарын 5-ны өдрөөс эхлэн томилох саналтай байна.

104

12 8 01

Цаашид Засгийн Газрын 2008 оны 153 дугаар тогтоолд заасан төслийн нөхцөл шаардлагыг дагуу хөрөнгө оруулалт хийж, "Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төсөл"-ийг хамтран хэрэгжүүлэх Хөрөнгө оруулалтын гэрээний хүлээсэн үүргээ биелүүлж байгааг харгалзан"Дарханы төмөрлөгийн үйлдвэр" төрийн өмчит хувьцаат компанийн менежментийг "Кью Эс Си" ХХК-д гэрээ хэрэгжих хугацаанд шилжүүлэх нь зүйтэй гэж үзэж байгаа бөгөөд Төслийн үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор менежментийн гэрээг боловсруулж Төрийн өмчийн хороогоор батлуулахыг "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд түрэг болгох саналыг Төрийн өмчийн хорооны хуралдаанд танилцуулж байна. /

Төрийн өмчийн хороо

104

12 8 01

# МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН ӨМЧИЙН ХОРООНЫ ТОГТООЛ

2013 оны 07 сарын 05 өдөр Дугаар 471 Улаанбаатар

"Дарханы төмөрлөгийн үйлдвэр" төрийн өмчит хувьцаат компанийн талаар авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" төрийн өмчит хувьцаат компанийн 2012 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, Үндэсний аудитын газрын дүгнэлт, Төрийн өмчийн хорооны даргын 2013 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн А/123 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийн тайланг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" төрийн өмчит хувьцаат компани, "Кью Эс Си" ХХК-ийн хооронд 2010 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр байгуулсан "Уул уурхай металлургийн цогцолбор байгуулах төслийг хамтран хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын гэрээ", 2011 оны 12 дугаар сарын 23-ний өдөр байгуулсан "Дэд бүтэц байгуулах төслийг хамтран хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын гэрээ"-ний дагуу "Кью Эс Си" хязгаарлагдмал хариуцлагатай компани 81,301,393,800.4 /Наян нэгэн тэрбум гурван зуун нэг сая гурван зуун ерэн гурван мянга найман зуун/ төгрөгийн хөрөнгө оруулсныг тогтоосугай

2. Энэхүү тогтоолын нэгдүгээр заалтад дурдсан хөрөнгө оруулалтын гэрээнүүдийг зах зээл, эдийн засгийн нөхцөл байдал, өнөөгийн хүрсэн түвшинтэй уялдуулан Концессын тухай хуулийн дагуу Концессын гэрээ болгож өөрчлөх асуудлыг Эдийн засгийн хөгжлийн яаманд тавьж шийдвэрлүүлэхийг Төрийн өмчийн удирдлагын газар /Д.Болормаа/-т даалгасугай.

3. "Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төсөл"-ийн нэгдүгээр үе шатны барилга байгууламжийн ажлыг дуусгаж, төмрийн хүдэр баяжуулах үйлдвэрүүдийг 2013 онд багтаан ашиглалтад оруулах, төслийн хоёрдугаар үе шатны ажлын бэлтгэлийг хангах талаар удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч, "Уул уурхай, металлургийн

цогцолбор байгуулах төсөл"-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хийгдэх худалдан авалтыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж ажиллахыг "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал П.Эрдэнэцогтод үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ ЦОГТБААТАР

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА ОДМАА

QSC
Quality Steel Corp.

# 324, МҮЭХ-ний төв байр,1 хороо Сүхбаатарын талбай-7 гудамж, Бага-тойруу-15160, Чингэлтэй дүүрэг,Улаанбаатар хот, Монгол улс
Утас: 976-70126458,Факс: 976-330119
И-мэйл: qsc.mgl@gmail.com

15

**МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД Н. БАТБАЯР ТАНАА**

2013.08.21 № 1/23

танай _____________-ны №______________-т

Хүсэлт гаргах тухай

Дарханы Төмөрлөгийн үйлдвэрийг Монгол Улсын Засгийн Газрын 160-р тогтоолоор Дархан-Сэлэнгийн бүсийн Төмөртолгой, Төмөртэй, Баянгол, Хуст-Уулын төмрийн ордуудыг түшиглэн Хар төмөрлөгийн цогцолбор үйлдвэрийг барьж, үйлдвэрийн түүхий эдийн баазыг бүрдүүлэхээр төлөвлөж байгуулсан. Тус үйлдвэр нь байгуулагдсанаасаа хойш хаягдал төмрөөр үйлдвэрлэлээ явуулж хүчин чадлынхаа 30-60% ашиглаж ирсэн нь хаягдал төмрийн нөөцгүй, бүтээгдэхүүний дотоодын зах зээлийн эрэлт хэрэгцээ бага, төмрийн хүдрийн ордуудын лицензийг алдсанаас шалтгаалсан.

1997 онд гарсан Ашигт малтмалын тухай хуулийн дагуу Дарханы Төмөрлөгийн үйлдвэрийн эзэмшилд байх ёстой Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд орших Төмөртэйн төмрийн хүдрийн ордын лицензийг хууль бусаар хятадын "Төмөртэй хүдэр" ХХК авсан байсныг 2008 онд Монгол Улсын бүх шатны шүүхээр шийдвэрлүүлж эргүүлэн авсан. Гэвч өнөөдрийг хүртэл энэ асуудлаар Олон улсын шүүхэд маргаан үргэлжилж байна.

Монгол Улсын Засгийн Газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан Хар металлургийн цогцолбор байгуулах зорилтуудыг хэрэгжүүлэхийн тулд Эрдэс Баялаг, Эрчим хүчний Яамнаас Уул уурхай, хүнд үйлдвэрийг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулсан. Уул уурхай хүнд үйлдвэрийг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсын Засгийн Газрын 2008 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн 153-р тогтоолоор Дархан-Сэлэнгийн бүс нутгийн төмрийн орд газруудад түшиглэн Уул уурхай хар металлургын цогцолбор байгуулах, Дарханы төмөрлөгийн үйлдвэрт техник технологийн шинэчлэл хийхээр тусгагдсан болно. Уг тогтоол нь: "... Дарханы төмөрлөгийн үйлдвэр ТӨХК-ийн үйл ажиллагааг өргөтгөн техник, технологийн шинэчлэл хийж, дэд бүтэц, боловсруулах үйлдвэр байгуулах, үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, үр ашгийг дээшлүүлэх ТЭЗҮ боловсруулж, төслийг хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг Үйлдвэр, худалдааны сайд, Төрийн өмчийн хорооны дарга нарт үүрэг..." болгосон.

2010-2015 онд Дарханы Төмөрлөгийн үйлдвэр ТӨХК-ийг өргөтгөн Уул уурхай-металлургийн цогцолбор байгуулах концепцийг ТУЗ болон ТӨХ-р батлуулж, түүний дагуу хийгдэх ажлуудыг төлөвлөн, 2009 оноос ажлын хэсэг байгуулагдан ажилласан.

"Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК-ийг өргөтгөн, "Уул уурхай-хар төмөрлөгийн цогцолбор" байгуулах концепцийг дараах үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн: Үүнд:

- Төмрийн хүдрийн ордуудаа эдийн засгийн эргэлтэнд оруулах, Төмөртолгойн уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх, Төмөртэй, Хуст-Уулын орд дээр уурхай нээн ажиллуулах, боловсруулах үйлдвэр барих.
- Дарханы Төмөрлөгийн үйлдвэрийг өргөтгөн шинэчлэх, хүчин чадлыг нь нэмэгдүүлэх, Дархан-Сэлэнгийн бүс нутагт Уул уурхай хар төмөрлөгийн цогцолбор байгуулах.

Төрийн Өмчийн Хорооны даргын 333 тоот тушаалаар "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК-ийн үйл ажиллагааг өргөтгөн техник, технологийн шинэчлэл хийж, үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, төмөрлөгийн цогцолбор байгуулах талаар гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдаас ирүүлсэн саналд үнэлэлт дүгнэлт өгөх ажлын хэсгийг байгуулсан бөгөөд ажлын хэсэг нь гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдаас ирүүлсэн 6 саналаас дотоодын хөрөнгө оруулагч "Кью Эс Си" ХХК-ийг төслийн үндсэн хөрөнгө оруулагчаар шалгаруулж, 2009 оны 9-р сарын 29-нд хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан. Мөн "Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төсөл"-ийн хүрээнд шаардлагатай "Дэд бүтэц байгуулах төсөл"-ийг хамтран хэрэгжүүлэх талаар "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК, "Кью Эс Си" ХХК-ийн хооронд 2011 оны 12-р сарын 23-нд хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан.

Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төслийн хөрөнгө оруулалт нь "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК-ийн эзэмшлийн төмрийн хүдрийн ордуудыг хөгжүүлэх, гангийн үйлдвэрийг өргөтгөн шинэчлэхээр зураг, төсөл судалгааны ажил, хүнд машин механизм, тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, барилга байгууламж гэсэн 5 чиглэлээр хийгдэж байна.

2010-2012 онуудад нийтдээ 81,3 тэрбум төгрөгний хөрөнгө оруулалт хийгдсэний үр дүнд үйлдвэрийг хөгжүүлэх концепцийн эхний үе шат хэрэгжиж дууслаа. Уг шатанд хийгдсэн ажлуудаас тоймлон хүргэвэл. Үүнд:

Төмөртолгой, Төмөртэйн ордуудыг шинээр нээж ашиглалтанд оруулсан, ган хайлуулах стандартын түүхий эд бэлтгэх зорилгоор жилийн 5 сая тонн хүдэр боловсруулах хуурай баяжуулах үйлдвэр гурвыг байгуулсан, нэг сая тонны хүчин чадалтай нойтон баяжуулах үйлдвэрийн угсралтийн ажил 70%-н гүйцэтгэлтэй явж байгаа бөгөөд 2013 оны 9 сард ашиглалтад өгөхөөр төлөвлөсөн, 34 км салбар төмөр зам, ачиж буулгах терминалийн хамт барих ТЭЗҮ болон зураг төслийн ажил хийгдэж барилгын ажил эхлэх зөвшөөрлөө авсан ба 2014 оны 2-р улиралд барьж ашиглалтад өгнө, 50 км 110квт өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугам өргөтгөл дэд станцийн хамт барьж дуусгасан, 400 ажилчдын тохилог тосгон барьж ашиглалтанд оруулсан, орчин үеийн уул уурхайн засвар үйлчилгээний төв болон оффисийн барилга ашиглалтад оруулсан, төслийн 2-р үе шат болох ган хайлуулах үйлдвэрийн барилга угсралтын ажлыг энэ оны 5-р сард эхлүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Төслийн хугацаа 2,5 жил ба нийт хөрөнгө оруулалт 350 сая ам.доллар орчим бөгөөд 2015 онд хэрэгжүүлж дуусгахаар ажиллаж байна.

Энэхүү төслийн санхүүжилт нь 100% хөрөнгө оруулагч талаас бөгөөд Монгол Улсын Засгийн газар болон Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр ТӨХК-ийн талаас санхүүгийн ямар нэг үүрэг, хариуцлага, баталгаа шаардахгүйгээрээ давуу талтай юм.

Энэхүү төсөл хэрэгжсэнээр 2015 онд багтааж Монгол улс нь 300,000-500,000 тонн ган боловсруулж, дотоодын өөрийн хэрэглээгээ 100 % бүрэн хангах нөхцөл бүрэлдэнэ.

Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах, “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-ийг өргөтгөн шинэчлэх төслийн санхүүжилтын асуудал 2009 оноос хойш Төрийн өмчийн хороо, холбогдох яамдаар хэлэлцэгдэж байхад Концессийн хууль гүйцэд боловсруулагдаагүй байсан тул энэ асуудал тухайн үед хөрөнгө оруулалтын гэрээгээр шийдвэрлэгдсэн юм. Өнөөдрийг хүртэл Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төслийн хөрөнгө оруулалт Төрийн өмчийн хороо, “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК, Хөрөнгө оруулагч "Кью Эс Си" ХХК-ийн хооронд байгуулсан хөрөнгө оруулалтын гэрээний дагуу хийгдэж байгаа бөгөөд одоогийн хэрэгжиж буй хууль, тогтоомжид нийцүүлэн дараах 2 асуудлыг шийдвэрлэж өгнө үү. Үүнд:

**Нэгдүгээрт:** Хөрөнгө оруулалтын гэрээг 2010 оны 03-р сарын 01-нээс хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Концессын хуулийн 4-р зүйлийн 4.1.3 дэх заалтын дагуу “барих-өмчлөх-ашиглах” төрөлд нийцүүлэн зохицуулж, тус хуулийн 17-р зүйлийн 17.1.2 дахь заалтыг үндэслэн Концессийг шууд гэрээгээр шилжүүлэн өөрчлөх,

**Хоёрдугаарт:** “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-ийг өргөтгөн шинэчилж Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төслийн хөрөнгө оруулалтыг эрх зүйн хувьд баталгаажуулахын тулд Засгийн Газрын хуралдаанаар хэлэлцүүлж, тогтвортой байдлын гэрээ байгуулах.

Хүндэтгэсэн,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Д.БАТЖАВХЛАН

DMP

ДАРХАНЫ ТӨМӨРЛӨГИЙН ҮЙЛДВЭР
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ

213800 Дархан, Дархан-Уул аймаг
Утас:7037-4203, Факс: 7037-3946
E-mail: info@dmplant.mn

2013-03-27 № 1-343

Танай ____________-ны №____________ -т

**ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД**

**Н. БАТБАЯР ТАНАА**

Дарханы Төмөрлөгийн үйлдвэрийг Монгол Улсын Засгийн Газрын 160-р тогтоолоор Дархан-Сэлэнгийн бүсийн Төмөртолгой, Төмөртэй, Баянгол, Хуст-Уулын төмрийн ордуудыг түшиглэн Хар төмөрлөгийн цогцолбор үйлдвэрийг барьж, үйлдвэрийн түүхий эдийн баазыг бүрдүүлэхээр төлөвлөж байгуулсан.

2010-2015 онд Дарханы Төмөрлөгийн үйлдвэр ТӨХК-ийг өргөтгөн Уул уурхай-металлургийн цогцолбор байгуулах концепцийг ТУЗ болон ТӨХ-р батлуулж, түүний дагуу хийгдэх ажлуудыг төлөвлөн, 2010 оны 10-р сараас ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.

Хойд бүс нутагт төмөрлөгийн үйлдвэрийг хөгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай байгаа дэд бүтцийн доорхи төслүүдийг концессийн гэрээний жагсаалтад оруулж баталж өгнө үү:

1. Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд орших Төмөртэйн ордоос Ерөө суманд орших Болд Төмөр Ерөө Гол ХХК-ийн төмөр замын Хандгайт өртөө хүртэлх 33.4 км төмөр замыг ачиж буулгах терминалийн хамт барих төсөл
2. Хүдэр сумаас Ерөө сумын нутгаар дайран өнгөрч буй олон улсын чанартай М55 төв автозамтай холбох 95 км хүнд даацийн хатуу хучилттай автозам барих төсөл

Эдгээр төслүүд нь хойд бүс нутгийн эдийн засаг, аж үйлдвэржилт болон Монгол улсын экспортод /үр тариа, төмрийн хүдэр / онцгой ач холбогдолтой төслүүд болно.

Хүндэтгэсэн,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ П. ЭРДЭНЭЦОГТ

49

[illegible]

[illegible]ЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

2[illegible]46 Улаанбаатар хот Чингэлтэй дүүрэг

Бага тойруу. Засгийн газрын IV байр

Утас 26-04-37. Факс 32-32-66

2013.05.02 № 2/744

танай ____________-ны № ____________-т

"КЬЮ ЭС СИ" ХХК-Д

Үндэсний Аудитын газар Төрийн аудитын тухай хуулийн 18.5-д заасныг үндэслэн "Дархан Төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК-ийн 2012 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитыг "Би энд Си аудит" ХХК-иар гэрээгээр гүйцэтгүүлсэн болно.

Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 153 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх, төмөрлөгийн үйлдвэрийн үйл ажиллагааг дэмжих, үр ашгийг дээшлүүлэх зорилгоор Төрийн өмчийн хороо "Кью Эс Си" ХХК-тай 2012 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр гэрээ байгуулж, тус компанийг "Дархан Төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК-ийн хөрөнгө оруулагчаар сонгожээ.

Уг компани 2010-2012 оны хооронд 81,275.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн бөгөөд "Дархан Төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК-ийн 2011 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд "Кью Эс Си" ХХК-иас оруулсан хөрөнгө оруулалт 63,411.9 сая төгрөг, 2012 онд 17,864.0 сая төгрөг, нийт 81,275.9 төгрөгийг урт хугацаат өр төлбөрөөр бүртгэснийг аудитаар баталгаажуулсан байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ С.ЭНХЗАЯА

0[illegible]0482

albantootA5-Sankhuugiin auditiin gazar.doc

УХА0122

100

ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД
Н. БАТБАЯР ТАНАА

QSC
Quality Steel Corp.

# 324, МҮЭХ-ний төв байр, 1 хороо Сүхбаатарын
талбай-7 гудамж, Бага-тойруу-15160, Чингэлтэй
дүүрэг, Улаанбаатар хот, Монгол улс
Утас: 976-70126458, Факс: 976-330119
И-мэйл: qsc.mgl@gmail.com

2013.05.07 № 1/39

танай ______________-ны №________________-т

Хүсэлт тавих тухай

Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн Уул уурхай, хүнд үйлдвэрийг хөгжүүлэх дэд хөтөлбөрт "Хар металлургийн цогцолбор" байгуулах зорилт дэвшүүлсэн. Үлмаар Засгийн газрын 2008 оны 153-р тогтоолоор "... Дарханы төмөрлөгийн үйлдвэр ТӨХК-ийн үйл ажиллагааг өргөтгөн техник, технологийн шинэчлэл хийж, дэд бүтэц, боловсруулах үйлдвэр байгуулах, үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, үр ашгийг дээшлүүлэх ТЭЗҮ боловсруулж, төслийг хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг Үйлдвэр худалдааны сайд, Төрийн өмчийн хорооны дарга нарт үүрэг..." болгосон. Энэ тогтоол нь Дархан-Сэлэнгийн бүс нутгийн төмрийн ордуудыг түшиглэн уул уурхай, хар металлургын цогцолбор байгуулах, ДТҮ-т техник технологийн шинэчлэл хийх их ажлын эхлэлийг тавьсан болно.

"ДТҮ" ТӨХК-ийг өргөтгөн 2010-2015 онуудад Уул уурхай-металлургийн цогцолбор байгуулах концепцийг компанийн ТУЗ болон ТӨХ-оор баталж, түүний дагуу хийгдэх ажлуудыг төлөвлөн, 2010 оны 10-р сараас Ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Энэхүү концепцийг хоёр үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

- Төрийн Өмчийн Хорооны даргын 333 тоот тушаалаар "ДТҮ" ТӨХК-ийн үйл ажиллагааг өргөтгөн техник, технологийн шинэчлэл хийж, үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, төмөрлөгийн цогцолбор байгуулах талаар гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдаас ирүүлсэн саналд үнэлэлт дүгнэлт өгөх ажлын хэсгийг байгуулж, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдаас нийт 6 санал ирсэнээс дотоодын хөрөнгө оруулагч болох "Кьюб Эс Си" ХХК-ийг төслийн үндсэн хөрөнгө оруулагчаар шалгаруулж 2010 оны 9-р сарын 29-нд хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан. Мөн "Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төсөл"-ийн хүрээнд шаардлагатай "Дэд бүтэц байгуулах төсөл"-ийг хамтран хэрэгжүүлэх талаар ТӨХ, "ДТҮ" ТӨХК, "Кью Эс Си" ХХК-ийн хооронд 2011 оны 12-р сарын 23-нд хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан.

Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төслийн хөрөнгө оруулалт нь "ДТҮ" ТӨХК-ийн эзэмшлийн төмрийн хүдрийн ордуудыг хөгжүүлэх, гангийн үйлдвэрийг өргөтгөн шинэчлэхээр зураг, төсөл судалгааны ажил, хүнд машин механизм, тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, барилга байгууламж гэсэн 5 чиглэлээр хийгдэж байна. Компанийн зүгээс 2010-2012 онуудад нийтдээ 81,3 тэрбум төгрөгний хөрөнгө оруулалт хийгдсэний үр дүнд ДТҮ-ийг хөгжүүлэх концепцийн эхний үе шат хэрэгжиж дууслаа. Уг шатанд хийгдсэн ажлуудаас тоймловол:

- Төмөртолгой, Төмөртэйн ордуудыг шинээр нээж ашиглалтанд оруулсан,
- Уурхайнуудыг хүнд машин механизмаар иж бүрнээр хангасан,
- Ган хайлуулах стандартын түүхий эд бэлтгэх зорилгоор жилийн 5 сая тонн хүдэр боловсруулах хуурай баяжуулах үйлдвэр 3-ийг байгуулсан,
- Нэг сая тонны хүчин чадалтай нойтон баяжуулах үйлдвэрийн угсралтийн ажил 70%-н гүйцэтгэлтэй явж байгаа бөгөөд 10 сард ашиглалтад өгөхөөр төлөвлөсөн,

- 34 км салбар төмөр зам, ачиж буулгах терминалийн хамт барих ТЭЗҮ болон зураг төслийн ажил хийгдэж барилгын ажил эхлэх зөвшөөрлөө авсан ба 2014 оны 2-р улиралд барьж ашиглалтад өгнө,
- 50 км 110квт өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугам өргөтгөл дэд станцийн хамт барьж дуусгасан,
- 400 ажилчдын тохилог тосгон барьж ашиглалтанд оруулсан,
- Орчин үеийн уул уурхайн техникийн засвар үйлчилгээний төв болон оффисийн барилга ашиглалтад оруулсан,

Төслийн 2-р үе шат болох ган хайлуулах үйлдвэрийн барилга угсралтын ажлыг энэ оны 5-р сард …үүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Төслийн хугацаа 2,5 жил ба нийт хөрөнгө оруулалт 350 сая …доллар орчим бөгөөд 2015 онд хэрэгжүүлж дуусгахаар зорилт тавин ажиллаж байна. Энэхүү төслийн санхүүжилтийг 100% хөрөнгө оруулагч тал гаргах бөгөөд Засгийн газар, ДТҮ ТӨХК-ийн …ээс санхүүгийн аливаа үүрэг, хариуцлага, баталгаа гаргах шаардлагагүй давуу талтай юм.

Энэхүү төсөл амжилттай хэрэгжсэнээр 2015 онд Монгол Улс жилд 500,000 тонн ган …овсруулж, дотоодын хэрэглээгээ 100 % бүрэн хангах нөхцөл бүрэлдэнэ.

Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах, "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК-ийг …өтгөн шинэчлэх төслийн санхүүжилтын асуудал 2009 оноос хойш ТӨХ болон холбогдох яамдаар …лцэж байхад Концессийн хууль эцэслэн боловсрогдоогүй байсан тул энэ асуудал тухайн үед …өрөнгө оруулалтын гэрээ хэлбэрээр шийдэж байсан болно. Өнөөдрийг хүртэл Уул уурхай, …таллургийн цогцолбор байгуулах төслийн хөрөнгө оруулалт Төрийн өмчийн хороо, "Дарханы …мөрлөгийн үйлдвэр" ТӨХК, Хөрөнгө оруулагч "Кью Эс Си" ХХК-ийн хооронд байгуулсан хөрөнгө …уулалтын гэрээний дагуу хийгдэж байна.

Иймээс одоогийн хэрэгжиж буй хууль, тогтоомжид нийцүүлэн Концессын тухай хуулийн …уу концесс олгох шийдвэр гаргаж өгнө үү.

Хавсаргасан материалууд:

1. Засгийн газрын "ДТҮ ТӨХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 2008 оны 153 тоот тогтоол, 1 хуудас.
2. ТӨХ-ны даргын "Ажлын хэсэг томилох" 2009 оны 333 тоот тушаал, сонгон шалгаруулалт хийсэн танилцуулгын хамт, нийт 4 хуудас.
3. ТӨХ-ны "Хөрөнгө оруулалтын тухай" 2012 оны 326 тоот тогтоол, холбогдох танилцуулга нийт 5 хуудас.
4. ТӨХ-ны "ДТҮ ТӨХК талаар авах зарим арга хэмжээний тухай" 2012 оны 327 тоот тогтоол, холбогдох танилцуулга нийт 7 хуудас.
5. ҮАГ-аас ДТҮ-т олгосон 2013 оны 2/526 тоот "Аудитын гэрчилгээ", нийт 2 хуудас
6. Ситико Аудит ХХК-аас Кью Эс Си ХХК ирүүлсэн "Баталгаажуулалтын тухай" 2013 оны т/69 тоот, 1 хуудас.
7. ҮАГ-аас "Кью Эс Си" ХХК-д ирүүлсэн 2013 оны 2/744 албан тоот, 1 хуудас.

Нийт 21 хуудас материал хавсаргав.

Хүндэтгэсэн,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ … Д.БАТЖАВХЛАН

ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН САЙД
Н.БАТБАЯР ТАНАА

Qinhuay Steel Corp

# 324, МҮЭХ-ний төв байр,1 хороо Сүхбаатарын
талбай-7 гудамж, Бага-тойруу-15160, Чингэлтэй
дүүрэг,Улаанбаатар хот, Монгол улс
Утас: 976-70126458,Факс: 976-330119
И-мэйл: qsc.mgl@gmail.com

2013.08.22 № 1156

танай ______________-ны №_______________-т

Хүсэлт гаргах тухай

Засгийн газрын 2008 оны "Дарханы төмөрлөгийн үйлдвэрт авах зарим арга хэмжээний тухай" 153 дугаар тогтоолоор Дархан-Сэлэнгийн бүсэд орших төмрийн хүдрийн орд газруудыг түшиглэн уул уурхай, металлургын цогцолбор болгон өргөтгөн шинэчлэх ажлыг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлэх үүргийг холбогдох яам болох ТӨХ-д даалгасан байдаг. Уг тогтоолын дагуу 2010 онд ТӨХ-нооссонгон шалгаруулалт явуулж, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдаас ирүүлсэн зургаан саналаас тус компанийн санал шалгарч, тухайн үед үйлчилж байсан хуулийн хүрээнд хөрөнгө оруулалтын гэрээнүүд байгуулан, төслийг хэрэгжүүлж байна.

Уул уурхай, металлургын цогцолбор байгуулах төслийн ажил 2010 онд эхэлж, одоогийн байдлаар дараах ажлыг гүйцэтгээд байна. Үүнд:

- Машин механизмын паркийг шинэчилж, уурхайн ажилтнуудын ажиллаж амьдрах, тав тухтай орчинг бүрдүүлсэн уурхайчдын тосгон, машин механизмын засвар үйлчилгээний баазын барилга, уурхайн удирдлага болон инженер техникийн ажилчдын оффисын барилга, цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц зэргийг барьж байгуулан цогц арга хэмжээ авч Төмөртэйн уурхай бүрэн хүчин чадлаараа ажиллах нөхцөл бүрдэж, Улсын комиссын дүгнэлтийг хүлээж байгаа;
- Төмрийн хүдрийг баяжуулах хуурай соронзон аргын үйлдвэр гурвыг, жилийн нэг сая тонны хүчин чадалтай нойтон баяжуулах үйлдвэрийн барилга тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалтын ажил энэ оны 10 дугаар сард ашиглалтанд оруулахаар ажиллаж байгаа;

Цаашид төслийн хүрээнд жилд 500.0 мян.тн хүчин чадал бүхий гангын үйлдвэрийг 2.6 жилийн хугацаанд барьж, Дарханы төмөрлөгийн үйлдвэрийн ган хайлах зуух, цувих цехийг өргөтгөж, дотоодын зах зээлийг зуун хувь хангах зорилт тавин ажиллаж байна. Цогцолбор барих технологийн сонголт нь Япон Улсын "Kobe Steel" компанийн технологи бөгөөд Монгол Улсын Ерөнхий сайдын Япон Улсад 2013 оны 9 дүгээр сарын 12-14-ний өдрүүдэд хийх албан ёсны айлчлалын үеэр Санамж бичиг үйлдэхээр төлөвлөж байна.

Төслийн хэрэгжилтийгТөрийн өмчийн хорооноос яам дундын Ажлын хэсэг байгуулан (Сангийн яам, ЭЗХЯ, ҮХААЯ, ТӨХ, МХЕГ, АМГ нарын төлөөлөл орсон ) энэ ондшалгасан бөгөөд Ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн ТӨХ-ны даргын 2013

оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 471 тоот тогтоолгарсан байна. Уг тогтоолоор хөрөнгө оруулалтын дүнг баталгаажуулахын хамт хөрөнгө оруулалтын гэрээнүүдийг Концессын хуулинд нийцүүлэн Концессын гэрээ болгон өөрчлөх асуудлыг давхар зөвлөсөн болно.

УИХ-аас баталсан Төр, хувийн хэвшлийн түншлэлийн бодлого, Засгийн газрын холбогдох тогтоолууд, Хөрөнгө оруулалтын гэрээнүүд, төслийн хэрэгжилт, цаашид хийгдэх хөрөнгө оруулалтын ажлуудыг харгалзан үзэж, одоо үйлчилж буй хөрөнгө оруулалтын гэрээнүүдийг Концессын тухай хуулийнд нийцүүлэн Концессын гэрээболгон өөрчлөх хүсэлтэй байгаа тул холбогдох хууль, журмын дагуу шийдвэрлэж өгнө үү.

Гүнээ хүндэтгэсэн,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Д.БАТЖАВХЛАН

# ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН ТУШААЛ

2014 оны 01 сарын 24 өдөр Дугаар 11 Улаанбаатар хот

Ажлын хэсэг томилох тухай

Концессын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоолоор батлагдсан “Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төсөл”-ийн концессын гэрээний нөхцөлийн талаар “Кью Эс Си” ХХК-тай хэлэлцээ хийх, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ахлагч:

| | |
|---|---|
| Ц.Батбаяр | /ЭЗХЯ-ны Концессын хэлтсийн дарга/ |

Гишүүд:

| | |
|---|---|
| Ё.Манлайбаяр | /ЗТЯ-ны Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга/ |
| Б.Чимэдлхам | /ЭЗХЯ-ны Хуулийн хэлтсийн мэргэжилтэн/ |
| Д.Цэвэлмаа | /ЭЗХЯ-ны Концессын хэлтсийн мэргэжилтэн/ |

Нарийн бичгийн дарга:

| | |
|---|---|
| Г.Содбаяр | /ЭЗХЯ-ны Концессын хэлтсийн мэргэжилтэн/ |

2. Концессын гэрээний төслийг дүгнэлтийн хамт боловсруулан танилцуулахыг ажлын хэсэг /Ц.Батбаяр/-т үүрэг болгосугай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Б.ШИНЭБААТАР

080028

25

Quality Steel Corp.

# 324, МҮЭХ-ний төв байр,1 хороо Сүхбаатарын
талбай-7 гудамж, Бага-тойруу-15160, Чингэлтэй
дүүрэг,Улаанбаатар хот, Монгол улс
Утас: 976-70126458,Факс: 976-330119
И-мэйл: qsc.mgl@gmail.com

2014.01.21 № 1/04

танай ______________-ны №________________-т

**ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Б.ШИНЭБААТАР ТАНАА**

Ажлын хэсгийн бүрэлдэхүүний тухай

Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төслийг Концессын гэрээний үндсэнд хэрэгжүүлэх Засгийн газрын холбогдох тогтоол гарсныг үндэслэн Концессын гэрээ байгуулах яам дундын Ажлын хэсэгтэй тус компанийг төлөөлөн хэлэлцээ хийх бүрэлдэхүүнийг үүгээр хүргүүлж байна.

Ажлын хэсгийн гишүүд:

Д.Батжавхлан

О.Банзрагч

М.Мөнхбаатар

Ж.Эрдэнэбилэг

Ц.Пүрэвтүвшин

Б.Гантулга

Хүндэтгэсэн,

ЗАХИРАЛ Д.БАТЖАВХЛАН

**Уул уурхай, металлургийн цогцолбор төслийн концессын гэрээний хэлэлцээ хийх үүрэг бүхий ажлын хэсгийн 2014 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн хуралдааны тэмдэглэл**

Ажлын хэсгийн ахлагч Ц.Батбаяр ирц, хэлэлцэх асуудлыг танилцуулж хуралдааныг даргалав.

*Хуралд ирвэл зохих 5 гишүүнээс бүгд ирж, 100 хувийн ирцтэйгээр эхлэв.*

**Ц.Батбаяр:** Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоолоор баталсан Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад Уул уурхай, металлургийн цогцолбор төслийг концессын шинэчлэн сайжруулах-барих-ашиглах-шилжүүлэх, барих-шилжүүлэх төрлөөр шууд гэрээ байгуулан хэрэгжүүлэхээр заасан. Уг төсөл дээр төсвийн хөрөнгөөр санхүүгийн дэмжлэг үзүүлэх болон баталгаа шаардагдахгүй. Манай яаман дээр ирсэн Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт батлах тухай Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоолын хавсралтад энэ төсөл дээр төсвийн хөрөнгөөр санхүүгийн дэмжлэг үзүүлэх, баталгаа гаргах эсэх гэсэн хэсэг дээр онгорхой байна. Энэ техникийн алдаа гарсан байх. Манай яамнаас явуулсан Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтын төсөл дээр энэ төсөл дээр шаардлагагүй гэж бичсэн байгаа.

Эдийн засгийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2014 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 11 дүгээр тушаалаар Уул уурхай, металлургийн цогцолбор төслийн концессын гэрээний нөхцөлийн талаар “Кью Эс Си” ХХК-тай хэлэлцээ хийх, дүгнэлт гаргах үүрэг бүхий бүхий ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулья. Ажлын хэсгийн ахлагчаар Ц.Батбаяр миний бие, ажлын хэсгийн гишүүдээр Зам, тээврийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Ё.Манлайбаяр, Эдийн засгийн хөгжлийн яамны хуулийн хэлтсийн мэргэжилтэн Б.Чимэдлхам, концессын хэлтсийн мэргэжилтэн Д.Цэвэлмаа, нарийн бичгийн даргаар концессын хэлтсийн мэргэжилтэн Г.Содбаяр гэсэн бүрэлдэхүүнтэй байна.

Уг төслийн талаар товчхон танилцуулья. Уг төслийн хүрээнд концессын шинэчлэн сайжруулах-барих-ашиглах-шилжүүлэх төрлөөр Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр ТӨХК-ийн үйл ажиллагааг өргөтгөн техник, технологийн шинэчлэл хийж, үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, төмөрлөгийн цогцолбор байгуулах, Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд орших Төмөртэйн ордоос Ерөө суманд орших “Болд Төмөр Ерөө Гол” ХХК-ийн төмөр замын Хандгайт өртөө хүртлэх 33.4 км төмөр замыг ачиж буулгах терминалын хамт барих, Сэлэнгэ аймгаар өнгөрөх олон улсын авто замтай холбох 95 км хүнд даацийн хатуу хучилттай авто зам барих, концессын барих-шилжүүлэх төрлөөр Сэлэнгэ аймгийн Ерөө сумаас Хүдэр сумын Төмөртэй уурхай хүртэл 110 кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, өргөтгөл, дэд станцын хамт барих зэрэг ажлууд хийгдэх ёстой байгаа.

**Ё.Манлайбаяр:** Манай яам төмөр замын төслүүдийг хариуцаад хэрэгжүүлээд явж байгаа. Төслүүд дээр зөвлөхүүд ажиллаж байгаа. Миний зүгээс энэ Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төслийн хүрээнд баригдах Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд орших Төмөртэйн ордоос Ерөө суманд орших “Болд Төмөр Ерөө Гол” ХХК-ийн төмөр замын Хандгайт өртөө хүртлэх 33.4 км төмөр замыг ачиж буулгах терминалын хамт барих хэсэг дээр заавар зөвлөгөө өгөх, манай дээр байгаа зөвлөхүүдтэй төслийг хэрэгжүүлэх компанийн хүмүүсийг холбож өгөхөд бэлэн байна. Миний зүгээс яамны ажил их байгаа учраас ажлын хэсгийн хурал дээр байнга ирээд байх боломж бага байгаа. Явцын дунд надаас

асуух тодруулах зүйл байвал асуугаарай би чадах ядахаараа туслах болно гэдгийн хэлэх гэсэн юм.

**Ц.Батбаяр**: Кью эс си компаниас концессын гэрээний төслийн саналаа манай ажлын хэсэгт ирүүлсэн байна. Г.Содбаяр ажлын хэсгийн гишүүдэд тараагаад өгөөрэй. Ажлын хэсэг ойрын хугацаанд концессын гэрээний хэлэлцээнд орьё. Хэлэлцээ болох өдрийн товийг та бүхэнд мэдэгдэх байх. За өнөөдрийн хурлыг өндөрлөе. Хүрэлцэн ирсэн та бүхэнд баярлалаа.

*Хурал 11 цаг 00 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

Ахлагч:

Ц.Батбаяр /ЭЗХЯ-ны Концессын хэлтсийн дарга/

Гишүүд:

Ё.Манлайбаяр /ЗТЯ-ны Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга/

Б.Чимэдлхам /ЭЗХЯ-ны Хуулийн хэлтсийн мэргэжилтэн/

Д.Цэвэлмаа /ЭЗХЯ-ны Концессын хэлтсийн мэргэжилтэн/

**Тэмдэглэл хөтөлсөн:**

Нарийн бичгийн дарга:

Г.Содбаяр /ЭЗХЯ-ны Концессын хэлтсийн мэргэжилтэн/

**Уул уурхай, металлургийн цогцолбор төслийн концессын гэрээний хэлэлцээ хийх үүрэг бүхий ажлын хэсгийн 2014 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн хуралдааны тэмдэглэл**

Ажлын хэсгийн ахлагч Ц.Батбаяр ирц, хэлэлцэх асуудлыг танилцуулж хуралдааныг даргалав.

*Хуралд ирвэл зохих 5 гишүүнээс 4 ирж, 80 хувийн ирцтэйгээр эхлэв.*

**Ц.Батбаяр**: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Өнөөдөр бид Уул уурхай, металлургийн цогцолбор төслийн концессын гэрээний хэлэлцээ хийнэ. Хэлэлцээний нөгөө тал болох Кью эс си ХХК-ийн төлөөлөл О.Банзрагч, М.Мөнхбаатар, Б.Гантулга, Түвшээ нар ирсэн байна. Төлөөлөх итгэмжлэлээ авчирсан байна. Манай ажлын хэсгийн гишүүд танилцана биз. Ажлын хэсгийн гишүүдээ та бүхэнд танилцуулах нь зөв байх. Ажлын хэсгийн ахлагчаар Ц.Батбаяр миний бие, ажлын хэсгийн гишүүдээр Зам, тээврийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Ё.Манлайбаяр, Эдийн засгийн хөгжлийн яамны хуулийн хэлтсийн мэргэжилтэн Б.Чимэдлхам, концессын хэлтсийн мэргэжилтэн Д.Цэвэлмаа, нарийн бичгийн даргаар концессын хэлтсийн мэргэжилтэн Г.Содбаяр гэсэн бүрэлдэхүүнтэй байгаа.

За одоо концессын гэрээний төсөл дээрээ бүгдээрээ ярилцаад явья. Надад нэг санал байна. Гэрээний төслийг ярихдаа эхлээд гол гол хэсгүүд дээрээ эхлээд фокуслаад явья дараа нь гарчиг, нэр томьёоны тайлбар гэдэг ч юм уу тэр хэсэг рүүгээ орьё гэсэн саналтай байна.

Бүгд саналыг дэмжив.

**Г.Содбаяр**: За бүгдээрээ концессын зүйл дараах бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ гэсэн гол хэсэг дээр эхлээд очьё. Энэ хэсэг дээр Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоолын хавсралт дахь Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр ТӨХК-ийн үйл ажиллагааг өргөтгөн техник, технологийн шинэчлэл хийж, үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, төмөрлөгийн цогцолбор байгуулах, Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд орших Төмөртэйн ордоос Ерөө суманд орших “Болд Төмөр Ерөө Гол” ХХК-ийн төмөр замын Хандгайт өртөө хүртлэх 33.4 км төмөр замыг ачиж буулгах терминалын хамт барих, Сэлэнгэ аймгаар өнгөрөх олон улсын авто замтай холбох 95 км хүнд даацийн хатуу хучилттай авто зам барих, Сэлэнгэ аймгийн Ерөө сумаас Хүдэр сумын Төмөртэй уурхай хүртэл 110 кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, өргөтгөл, дэд станцын хамт барих гэснийг үг үсгээр нь оруулах нь зөв байх.

**Кью эс си ХХК-ийн төлөөлөл**: Утгыг нь алдагдуулахгүйгээр жаахан үг үсгийн хувьд засвар оруулж болно биз дээ.

**Г.Содбаяр**: Болох байхаа гэж бодож байна. Саналаа хэлээрэй. Эрчим хүчний тухай хуулиараа цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц нь төрийн өмчид байдаг. Тэгэхээр төслийн хүрээнд хийгдэх Сэлэнгэ аймгийн Ерөө сумаас Хүдэр сумын Төмөртэй уурхай хүртэл 110 кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, өргөтгөл, дэд станцыг концессын барих-шилжүүлэх төрлөөр бусад концессын зүйлийг шинэчлэн сайжруулах-барих-ашиглах-шилжүүлэх төрлөөр хэрэгжүүлнэ гэж оруулья.

**Кью эс си ХХК-ийн төлөөлөл**: Бид үндсэндээ агаарын шугам, өргөтгөл, дэд станцыг бариад дууссан. Одоо улсын комисст хүлээлгэн өгөх ажил үлдсэн байгаа. Энэ ажилд оруулсан хөрөнгө оруулалтаа тэгэхээр бид хаанаас нөхөж авах ёстой болж байна.

**Ц.Батбаяр**: Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт батлах тухай тухай Засгийн газрын тогтоолын хавсралтад Уул уурхай, металлургийн цогцолбор төслийн төсвийн хөрөнгөөр санхүүгийн дэмжлэг үзүүлэх, баталгаа гаргах эсэх гэсэн дээр юу ч алга байна. Дэмжлэг шаардлагатай тохиолдолд судлан шийдвэрлэх, дэмжлэг шаардлагагүй тохиолдолд шаардлагагүй гэж бичигддэг байгаа. Энэ төсөл дээр Засгийн газрын тогтоолоо албажуулахдаа техникийн алдаа гаргасан байх.

**Б.Чимэдлхам**: Засгийн газрын тогтоолоор баталсан энэ төсөл дээр төсвийн хөрөнгөөр санхүүгийн дэмжлэг үзүүлэх, баталгаа гаргах эсэх дээр судлан шийдвэрлэх гэж бичсэн байвал бид агаарын шугамын өртөгийг ярих боломжтой байсан. Харин уг Засгийн газрын тогтоолоор ийм үүрэг өгөгдөөгүй учир бид өртөг ярих боломжгүй гэсэн үг.

**Д.Цэвэлмаа**: Концессын гэрээний хугацааг 30 жил байхаар санал ирүүлсэн байна. Үндэслэлээ тайлбарлаач.

**Кью эс си ХХК-ийн төлөөлөл**: Бид уг төсөл дээр тооцоо судалгаа хийсэн байгаа. Энэ төсөл дээр урьдчилсан байдлаар 725 сая ам долларын хөрөнгө оруулалт орохоор байгаа. Оруулсан хөрөнгө оруулалтаа нөхөөд ашигаа тооцоход бид гэрээний хугацааг 30 жил байх тооцоо гарсан. Бид санхүүгийн тооцоо схемээ та бүхэнд хүргүүлье.

**Б.Чимэдлхам**: Дарханы төмөрлөгийн үйлдвэр ТӨХК-ийн удирдлагын эрхийг концесс эзэмшигч гэрээний хугацаанд авахаар тусгасан байна. Энэ талаар тайлбарлаач.

**Кью эс си ХХК-ийн төлөөлөл**: Манай компани 2009 оноос хойш өнөөдрийг хүртэл нийт 81 тэрбум орчим төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийчээд байгаа. Өнөөдрийг хүртэл бид төмөрлөгийн үйлдвэрийн ТУЗ, гүйцэтгэх удирдлагад байхгүй байгаа. Тийм учраас бид цаашдаа их хэмжээний хөрөнгө оруулалт оруулах учраас төслийг амжилттай хэрэгжүүлэх, хяналттай байлгах үүднээс Дарханы төмөрлөгийн үйлдвэр ТӨХК-ийн ТУЗ, гүйцэтгэх удирдлагыг концесс эзэмшигч нь өөрсдөө авья гэсэн санаагаар оруулсан. Энэ нь төрийн өмчит компанийг авч байгаа хэрэг биш бөгөөд зөвхөн компанийн засаглалыг гэрээний хугацаанд хэрэгжүүлнэ гэж ойлгож болно.

**Ц.Батбаяр**: Энд концессын төлбөртэй холбоотой заалт байна. Үүнийг тайлбарлах уу.

**Кью эс си ХХК-ийн төлөөлөл**: Концессын тухай хуульд концесс олгогч нь концессын төлбөр авч болно гэж заасан байгаа. Дарханы төмөрлөгийн үйлдвэр ТӨХК-ийн 2009-2013 онд улсын төсөвт хамгийн өндөр ногдол ашиг төлсөн нэг жилийн ногдол ашгийн дүнг энэхүү гэрээний хугацаатай үржүүлсэнтэй тэнцэхүйц төгрөгийг улсад өгөх боломжтой гэсэн санааг оруулсан байгаа. 2009-2013 онд улсын төсөвт хамгийн өндөр ногдол ашиг төлсөн нь 2,1 тэрбум төгрөг байдаг юм байна лээ.

**Ц.Батбаяр**: За тэр тоог нь Төрийн өмчийн хорооноос авч нягтлая. Өнөөдрийн гэрээний хэлэлцээг өндөрлөе. Маргааш үргэлжүүлье. Хүрэлцэн ирсэн та бүхэнд баярлалаа.

**Тэмдэглэлтэй танилцсан:**

Ахлагч:

Ц.Батбаяр /ЭЗХЯ-ны Концессын хэлтсийн дарга/

Гишүүд:

Ё.Манлайбаяр /ЗТЯ-ны Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга/

Б.Чимэдлхам /ЭЗХЯ-ны Хуулийн хэлтсийн мэргэжилтэн/

Д.Цэвэлмаа /ЭЗХЯ-ны Концессын хэлтсийн мэргэжилтэн/

**Тэмдэглэл хөтөлсөн:**

Нарийн бичгийн дарга:

Г.Содбаяр /ЭЗХЯ-ны Концессын хэлтсийн мэргэжилтэн/

# ...Л УУРХАЙ, МЕТАЛЛУРГИЙН ЦОГЦОЛБОР ТӨСӨЛ"-ИЙН КОНЦЕССЫН ШУУД ГЭРЭЭНИЙ ХЭЛЭЛЦЭЭ ХИЙХ ҮҮРЭГ БҮХИЙ АЖЛЫН ХЭСГИЙН ДҮГНЭЛТ

...4 оны 2 дугаар ...ын 12-ны өдөр

Улаанбаатар хот

Засгийн газрын 2013 оны "Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт ...лах тухай" 317 дугаар тогтоол, Төрийн нарийн бичгийн даргын 2014 оны 01 ...эр сарын 24-ний өдрийн 11 дүгээр тушаалын дагуу "Уул уурхай, металлургийн ...цолбор төсөл"-ийн концессын гэрээний төслийг боловсруулав.

Энэхүү концессын гэрээний төслийг Ажлын хэсэг "Кью Эс Си" ХХК-ийн ...оролтой хэлэлцээ хийх замаар боловсруулсан бөгөөд төслийн хүрээнд ...рханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК-ийн үйл ажиллагааг өргөтгөн техник, ...нологийн шинэчлэл хийх, Төмөртэй, Төмөртолгой, Хуст уулын ордуудыг эдийн ...сгийн эргэлтэд оруулж, төмрийн хүдрийн баяжмал үйлдвэрлэх үйлдвэр, нойтон ...аар баяжуулах үйлдвэр, шууд ангижруулсан төмрийн үйлдвэр, Сэлэнгэ аймгийн ...эр суманд орших Төмөртэйн ордоос Хандгайт өртөө (Баянгол төмөр зам) ...лэлийн 33.4 км стандартын 1520 мм царигтай төмөр зам, ачиж буулгах ...минал, Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд орших Төмөртэйн ордоос Сэлэнгэ ...гийн Сүхбаатар сумаас Улаанбаатар чиглэлийн олон улсын авто замын ...лаанхааны дөрвөн замын уулзвар хүртэл 95 км хүнд даацын хатуу хучилттай ...то зам барих ажлуудыг "Шинэчлэн сайжруулах-барих-ашиглах-шилжүүлэх" ...рлөөр, Сэлэнгэ аймгийн Ерөө сумаас Хүдэр сумын Төмөртэйн уурхай хүртэл ...0кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, өргөтгөл, дэд станц барих ажлыг ...арих-шилжүүлэх" төрлөөр концесс эзэмшигч хэрэгжүүлэх юм.

Концессын гэрээний хугацаа 30 жил байхаар тооцсон бөгөөд гэрээнд гарын ...эг зурсан өдрөөс эхлэн хугацаа тоологдож эхлэнэ.

Энэхүү концессын төсөлд төсвийн хөрөнгөөр санхүүгийн дэмжлэг үзүүлэх, ...аталгаа шаардагдахгүй бөгөөд харин Дарханы төмөрлөгийн үйлдвэр ТӨХК-аас ...лсын төсөвт хамгийн өндөр ногдол ашиг төлсөн нэг жилийн ногдол ашгийн дүнг ...нэхүү гэрээний хугацаатай үржүүлсэнтэй тэнцүү хэмжээний концессын төлбөрийг ...онцесс эзэмшигчээс авч улсын төсөвт төвлөрүүлэхээр гэрээний төсөлд тусгалаа.

Иймд Ажлын хэсэг энэхүү гэрээний төслийг боловсруулж дууссан гэж үзэж бүхий этгээдэд хүргүүлэхээр шийдвэрлэв.

Ахлагч:

Ц.Батбаяр /ЭЗХЯ-ны Концессын хэлтсийн дарга/

Гишүүд:

Ё.Манлайбаяр /ЗТЯ-ны Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга/

Б.Чимэдлхам /ЭЗХЯ-ны Хуулийн хэлтсийн мэргэжилтэн/

Д.Цэвэлмаа /ЭЗХЯ-ны Концессын хэлтсийн мэргэжилтэн/

Нарийн бичгийн дарга:

Г.Содбаяр /ЭЗХЯ-ны Концессын хэлтсийн мэргэжилтэн/

---000---

МОНГОЛ УЛСЫН
...ИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН САЙД
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
...дсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр,
...с/Факс: (976-51) 26-33-33, E-mail: info@med.gov.mn,
http://www.med.gov.mn

2014.02.20 № 1/305

...ий ____________-ны №____________-т

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Ч.САЙХАНБИЛЭГ ТАНАА

Концессын гэрээ байгуулах зөвшөөрөл авах тухай

...Засгийн газрын 2013 оны "Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт батлах ...317 дугаар тогтоолын дагуу "Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах ...ийн концессын гэрээний төслийг боловсруулан Засгийн газрын тогтоолын ... болон гэрээ байгуулах дүгнэлтийн хамт хүргүүлж байна.

Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлүүлж өгөхийг Танаас хүсье.

Хавсралт: Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулга;
Концессын гэрээний төсөл, гэрээ байгуулах дүгнэлт;
Яамдаас ирүүлсэн санал, товьёо.

Н.БАТБАЯР

030167

# ТАНИЛЦУУЛГА

УИХ-ын 2010 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн "Төрийн өмчийг 2010-2012 хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай" 11 дүгээр тогтоол, ийн газрын 2008 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн "Дарханы төмөрлөгийн двэр төрийн өмчит хувьцаат компанийн талаар авах зарим арга хэмжээний тухай" дугаар тогтоолын дагуу Дарханы төмөрлөгийн үйлдвэрт хөрөнгө оруулт хийж ийн чадлыг нэмэгдүүлэх зорилгоор "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК болон Эс Си" ХХК-ын хооронд 2010 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр "Уул уурхай, аллургийн цогцолбор байгуулах төслийг хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын гэрээ", 1 оны 12 дугаар сарын 23-ны өдөр "Дэд бүтэц байгуулах төслийг хамтран рэгжүүлэх хөрөнгө оруулалтын гэрээ"-нүүдийг байгуулсан байдаг.

"Кью Эс Си" ХХК нь "Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төсөл"-ийг нцессын тухай хуулийн дагуу "Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт"-д үүлж өгөх санал гаргасны дагуу Засгийн газрын 2013 оны "Төрийн өмчийн нцессын зүйлийн жагсаалт батлах тухай" 317 дугаар тогтоол гарсан.

Дээрх тогтоолын дагуу Эдийн засгийн хөгжлийн яам нь "Кью Эс Си" ХХК-тай нцессын гэрээний нөхцөлийн талаар талаар хэлэлцээ хийж яамдаас ирүүлсэн алыг тусган гэрээний төслийг боловсруулан танилцуулж байна. Энэхүү концессын рээний хүрээнд "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК-ийн үйл ажиллагааг өргөтгөн хник, технологийн шинэчлэл хийх, Төмөртэй, Төмөртолгой, Хуст уулын ордуудыг дийн засгийн эргэлтэд оруулж, төмрийн хүдрийн баяжмал үйлдвэрлэх үйлдвэр, йтон аргаар баяжуулах үйлдвэр, шууд ангижруулсан төмрийн үйлдвэр, Сэлэнгэ ймгийн Хүдэр суманд орших Төмөртэйн ордоос Хандгайт өртөө (Баянгол төмөр зам) иглэлийн 33.4 км стандартын 1520 мм царигтай төмөр зам, ачиж буулгах терминал, элэнгэ аймгийн Хүдэр суманд орших Төмөртэйн ордоос Сэлэнгэ аймгийн Сүхбаатар умаас Улаанбаатар чиглэлийн олон улсын авто замын Дулаанхааны дөрвөн замын лзвар хүртэл 95 км хүнд даацын хатуу хучилттай авто зам барих ажлуудыг Шинэчлэн сайжруулах-барих-ашиглах-шилжүүлэх" төрлөөр, Сэлэнгэ аймгийн Ерөө умаас Хүдэр сумын Төмөртэйн уурхай хүртэл 110кВт-ын цахилгаан дамжуулах гаарын шугам, өргөтгөл, дэд станц барих ажлыг "Барих-шилжүүлэх" төрлөөр концесс эмшигч хэрэгжүүлэх юм.

Концессын гэрээний хугацаа 30 жил байхаар тооцсон бөгөөд гэрээнд гарын үсэг рсан өдрөөс эхлэн хугацаа тоологдож эхлэнэ.

Энэхүү концессын төсөлд Засгийн газраас төсвийн дэмжлэг, баталгаа ардагдахгүй бөгөөд харин Дарханы төмөрлөгийн үйлдвэр ТӨХК-аас улсын төсөвт игийн өндөр ногдол ашиг төлсөн нэг жилийн ногдол ашгийн дүнг энэхүү гэрээний цаатай үржүүлсэнтэй тэнцүү хэмжээний концессын төлбөрийг концесс мшигчээс авч улсын төсөвт төвлөрүүлэхээр гэрээний төсөлд тусгалаа.

Концессын гэрээний төслийг хэлэлцэн, гэрээ байгуулах зөвшөөрөл олгож хийг хүсье.

---000---

# КОНЦЕССЫН ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ДҮГНЭЛТ

УИХ-ын 2010 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн "Төрийн өмчийг 2010-2012 ... хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай" 11 дүгээр тогтоол, ...гийн газрын 2008 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн "Дарханы төмөрлөгийн ...двэр төрийн өмчит хувьцаат компанийн талаар авах зарим арга хэмжээний тухай" ... дугаар тогтоолын дагуу Дарханы төмөрлөгийн үйлдвэрт хөрөнгө оруулт хийж ...ын чадлыг нэмэгдүүлэх зорилгоор "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК болон ...ью Эс Си" ХХК-ын хооронд 2010 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр "Уул уурхай, ...таллургийн цогцолбор байгуулах төслийг хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын гэрээ", ...11 оны 12 дугаар сарын 23-ны өдөр "Дэд бүтэц байгуулах төслийг хамтран ...рэгжүүлэх хөрөнгө оруулалтын гэрээ"-нүүдийг байгуулсан байдаг.

"Кью Эс Си" ХХК нь "Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төсөл"-ийг ...нцессын тухай хуулийн дагуу "Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт"-д ...уулж өгөх санал гаргасны дагуу Засгийн газрын 2013 оны "Төрийн өмчийн ...нцессын зүйлийн жагсаалт батлах тухай" 317 дугаар тогтоол гарсан.

Дээрх тогтоолын дагуу Эдийн засгийн хөгжлийн яам нь "Кью Эс Си" ХХК-тай ...нцессын гэрээний нөхцөлийн талаар талаар хэлэлцээ хийж яамдаас ирүүлсэн ...налыг тусган гэрээний төслийг боловсруулан танилцуулж байна. Энэхүү концессын ...рээний хүрээнд "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК-ийн үйл ажиллагааг өргөтгөн ...хник, технологийн шинэчлэл хийх, Төмөртэй, Төмөртолгой, Хуст уулын ордуудыг ...ийн засгийн эргэлтэд оруулж, төмрийн хүдрийн баяжмал үйлдвэрлэх үйлдвэр, ...йтон аргаар баяжуулах үйлдвэр, шууд ангижруулсан төмрийн үйлдвэр, Сэлэнгэ ...ймгийн Хүдэр суманд орших Төмөртэйн ордоос Хандгайт өртөө (Баянгол төмөр зам) ...иглэлийн 33.4 км стандартын 1520 мм царигтай төмөр зам, ачиж буулгах терминал, ...элэнгэ аймгийн Хүдэр суманд орших Төмөртэйн ордоос Сэлэнгэ аймгийн Сүхбаатар ...умаас Улаанбаатар чиглэлийн олон улсын авто замын Дулаанхааны дөрвөн замын ...улзвар хүртэл 95 км хүнд даацын хатуу хучилттай авто зам барих ажлуудыг "Шинэчлэн сайжруулах-барих-ашиглах-шилжүүлэх" төрлөөр, Сэлэнгэ аймгийн Ерөө ...умаас Хүдэр сумын Төмөртэйн уурхай хүртэл 110кВт-ын цахилгаан дамжуулах ...агаарын шугам, өргөтгөл, дэд станц барих ажлыг "Барих-шилжүүлэх" төрлөөр концесс ...эзэмшигч хэрэгжүүлэх юм.

Концессын гэрээний хугацаа 30 жил байхаар тооцсон бөгөөд гэрээнд гарын үсэг зан өдрөөс эхлэн хугацаа тоологдож эхлэнэ.

Энэхүү концессын төсөлд Засгийн газраас төсвийн дэмжлэг, баталгаа рдагдахгүй бөгөөд харин Дарханы төмөрлөгийн үйлдвэр ТӨХК-аас улсын төсөвт гийн өндөр ногдол ашиг төлсөн нэг жилийн ногдол ашгийн дүнг энэхүү гэрээний цаатай үржүүлсэнтэй тэнцүү хэмжээний концессын төлбөрийг концесс шигчээс авч улсын төсөвт төвлөрүүлэхээр гэрээний төсөлд тусгалаа.

Иймд энэхүү концессын гэрээг "Кью Эс Си" ХХК-тай байгуулах нь зүйтэй гэж өж байна.

ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН
САЙД Н.БАТБАЯР

38

МОНГОЛ УЛСЫН
ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/Факс: (976-51) 26-33-33, E-mail: info@med.gov.mn
http://www.med.gov.mn

2014.4.8 № 1/691

танай ____________-ны №____________-т

ТӨРИЙН ӨМЧИЙН ХОРООНЫ
ДАРГА Д.ЦОГТБААТАР ТАНАА

Санал хүргүүлэх тухай

Засгийн газрын 2014 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн "Концессын гэрээ байгуулах эрх олгох тухай" 69 дүгээр тогтоолын дагуу "Кью Эс Си" ХХК-тай 2014 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр "Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төсөл"-ийн концессын гэрээг байгуулсан.

Засгийн газрын 2014 оны 69 дүгээр тогтоолын 2 дахь заалтын дагуу "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК-ийн удирдлагын эрх болон хөрөнгийг "Кью Эс Си ХХК"-д шилжүүлэх ажлыг яаралтай зохион байгуулна уу.

Ажил хүлээлцэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнд манай яамнаас оролцох хүмүүсийн жагсаалтыг хүргүүлэв.

Хавсралт: Засгийн газрын тогтоол, Концессын гэрээний хуулбар.

Н.БАТБАЯР

080329

# МОНГОЛ УЛСЫН
# ТӨРИЙН ӨМЧИЙН ХОРООНЫ ТОГТООЛ

2014 оны 04 сарын 15 өдөр Дугаар 155 Улаанбаатар хот

Дарханы төмөрлөгийн үйлдвэр ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай

Концессын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 27 дугаар зүйл, Төрийн өмчийн хорооны дүрмийн 3 дугаар бүлгийн 12 дахь хэсэг, Засгийн газрын 2013 оны 9 дүгээр сарын 06-ны өдрийн "Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт батлах тухай" 317 дугаар тогтоол, Засгийн газрын 2014 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн "Концессын гэрээ байгуулах эрх олгох тухай" 69 дүгээр тогтоол, Төрийн өмчийн хорооны даргын "Түр орлон гүйцэтгүүлэх тухай" 2014 оны А/76 тоот тушаал, Эдийн засгийн хөгжлийн яам болон "Кью Эс Си" ХХК-ийн хооронд 2014 оны 4 дүгээр сарын 04-ний өдөр байгуулсан "Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төсөл"-ийн Концессын гэрээг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" төрийн өмчит хувьцаат компанийн удирдлагын эрх болон мөнгөн хөрөнгийг тогтоол гарсан өдрөөр, хөрөнгийг 2014 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөр тасалбар болгон "Кью Эс Си" ХХК-д Концессын гэрээний хугацаанд шилжүүлсүгэй.

2. Төрийн өмчийн хорооны даргын 2014 оны А/75 тоот тушаалаар байгуулагдсан "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" төрийн өмчит хувьцаат компанийн удирдлагын эрх болон хөрөнгийг хүлээлгэн өгөх чиг үүрэг бүхий Ажлын хэсгийн баримтлах удирдамжийг хавсралтаар баталсугай.

3. Удирдлагын эрх шилжсэнтэй холбогдуулан "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн одоогийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүдийг 2014 оны 4 дүгээр сарын 15-ны өдрөөр тасалбар болгон үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.

4. "Кью Эс Си" ХХК нь "Дарханы төмөрлөгийн үйлдвэр ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөл дарга, гишүүдийг Концессын гэрээний хугацаанд сонгох, томилох, чөлөөлөх эрхтэй болохыг дурдсугай.

0000569

5. Энэхүү тогтоолын биелэлтэд Концессын гэрээ дуусгавар болох хүртэл хугацаанд хяналт тавьж, Төрийн өмчийн хорооны хуралдаанд жил бүр танилцуулахыг Бүтцийн өөрчлөлтийн бодлогыг хэрэгжүүлэх газар /М.Батгэрэл/-т үүрэг болгосугай.

ТӨРИЙН ӨМЧИЙН ХОРООНЫ ГИШҮҮН Д.ДЭЛГЭРЦОГТ

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Ц.ОДМАА

41

# МОНГОЛ УЛСЫН
# ТӨРИЙН ӨМЧИЙН ХОРООНЫ ТОГТООЛ

2014 оны 04 сарын 24 өдөр　　　　Дугаар 207　　　　Улаанбаатар хот

"Дарханы төмөрлөгийн үйлдвэр"
ТӨХК-ийн удирдлагын эрх болон
хөрөнгийг шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 10, 11 дүгээр зүйл,Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн "Концессын гэрээ байгуулах эрх олгох тухай" 69 дүгээр тогтоол, Монгол Улсын Эдийн засгийн хөгжлийн яам, "КЬЮ ЭС СИ" ХХК-ийн хооронд 2014 оны 04 дүгээр сарын 04-ны өдөр байгуулсан "Уул уурхай металлургийн цогцолбор байгуулах төслийг хэрэгжүүлэх концессын гэрээ"-ний 6.18 дахь заалт, Төрийн өмчийн хорооны 2014 оны 155 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Төрийн өмчийн хорооноос ТОГТООХ нь:

1. "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК-ийн эзэмшилд байгаа нэгдүгээр хавсралтад заасан 153 262 648 009 /Нэг зуун тавин гурван тэрбум хоёр зуун жаран хоёр сая зургаан зуун дөчин найман мянга есөн/ төгрөгийн балансын үнэтэй, 64 450 070 215 /Жаран дөрвөн тэрбум дөрвөн зуун тавин сая далан мянга хоёр зуун арван таван/ төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий 88 812 577 794 /наян найман тэрбум найман зуун арван хоёр сая таван зуун далан долоон мянга долоон зуун ерэн дөрвөн/ төгрөгийн үлдэгдэл үнэтэй үндсэн хөрөнгө, 85 348 739 858 /Наян таван тэрбум гурван зуун дөчин найман сая долоон зуун гучин есөн мянга найман зуун тавин найман/ төгрөгийн эргэлтийн хөрөнгө, нийт 174 161 317 652 /Нэг зуун далан дөрвөн тэрбум нэг зуун жаран нэгэн сая гурван зуун арван долоон мянга зургаан зуун тавин хоёр/ төгрөгийн хөрөнгийг "Кьюу Эс Си" ХХК-д Концессын гэрээний хугацаанд шилжүүлсүгэй.

2. "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК-ийн эзэмшилд байгаа хоёрдугаар хавсралтад заасан улсын бүртгэлийн гэрчилгээ, компанийн дүрэм, ашигт малтмалын тусгай зөвшөөрөл, газар эзэмших эрхийн гэрчилгээ, үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ, компанийн үйл ажиллагаатай холбоотой гэрээ зэрэг 34 ширхэг баримт бичгийг "Кьюу Эс Си" ХХК-ийн эзэмшилд шилжүүлсүгэй.

3. Дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн Гүйцэтгэх захирал Д.Батжавхланд даалгасугай:

а. Нэгдүгээр хавсралтад заасан үндсэн ба эргэлтийн хөрөнгийг хөрө хүлээлцсэн актыг үндэслэн нягтлан бодох бүртгэлд тусгах ажлыг зохион байгуулах;

б. Хоёрдугаар хавсралтад заасан эрхийн гэрчилгээ, тусгай зөвшөөрөл, бус холбогдох баримт бичгийг хууль тогтоомж, Концессын гэрээнд заасны да эзэмших, ашиглах;

в. Концессын гэрээний биелэлт, үр дүнг жил бүр тооцож Эдийн зас хөгжлийн яам, Төрийн өмчийн хороо, Концесс эзэмшигчид танилцуулж байх.

4. Энэ тогтоолын биелэлтэд Концессын гэрээ дуусгавар болох хүр хугацаанд хяналт тавьж, Төрийн өмчийн хорооны хуралдаанд жил бүр танилцу байхыг Төрийн өмчийн хорооны Бүтцийн өөрчлөлтийн бодлогыг хэрэгжүүлэх газ /М.Батгэрэл/-т даалгасугай.

ТӨРИЙН ӨМЧИЙН ХОРООНЫ ГИШҮҮН: Д.ДЭЛГЭРЦОГТ

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Ц.ОДМАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## ГЭРЭЭНД ТУСГАСАН ЗАРИМ АЖЛУУД ХУГАЦААНДАА БҮРЭН ХЭРЭГЖЭЭГҮЙ БАЙНА

**АУДИТЫН СЭДЭВ: ДАРХАН-СЭЛЭНГИЙН БҮСЭД УУЛ УУРХАЙ, МЕТАЛЛУРГИЙН ЦОГЦОЛБОР БАЙГУУЛАХ ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ КОНЦЕССЫН ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ**

**АУДИТЫН КОД: АГГ-2021/09-ШТА-ГА**

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Аудитын гуравдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд
Утас: 263755 Цахим хаяг: enkhboldd@audit.gov.mn
Аудитын менежер Н.Анхбаяр
Утас: 261456 Цахим хаяг: ankhbayarn@audit.gov.mn
Ахлах аудитор Б.Болормаа
Утас: 261456 Цахим хаяг: bolormaab@audit.gov.mn

Улаанбаатар хот
2021 он

# МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ

2021 оны 10 сарын 13 өдөр Дугаар А/95 Улаанбаатар хот

## Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4, 29 дүгээр зүйлийн 29.1.9, 29.1.10, 29.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Дархан-Сэлэнгийн бүсэд Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төслийг хэрэгжүүлэх концессын гэрээний хэрэгжилт"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр, аудитаар өгсөн албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Монгол Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хороо, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төрийн худалдан авах ажиллагааны газар, "Кью Эс Си" ХХК-д тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга /Ц.Нямдорж/, Төрийн худалдан авах ажиллагааны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Х.Улам-Өрнөх/ нарт тус тус зөвлөсүгэй.

4. Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч /Я.Сарансүх/-д даалгасугай.

5. Аудитын ажлын болон нотлох баримтыг 2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор архивын нэгж болгон Үндэсний аудитын газрын архивд хүлээлгэн өгөхийг аудитын багт үүрэг болгосугай.

Д.ЗАНДАНБАТ

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны
10 дугаар сарын 15-ны өдрийн А/95 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

Аудитаар өгсөн албан шаардлагын жагсаалт

| № | Төлбөр, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн (сая.төгрөг) | Зөрчил хариуцах | |
|---|---|---|---|---|
| | | Албан шаардлага | Байгууллага | Албан тушаалтан |
| 1 | "Дулаанхааны 4 замын уулзвараас Ерөө-Хүдэр сум чиглэлийн хатуу хучилттай 95 км хүчин чадал бүхий авто замын барилга байгууламжийг төрийн нийтийн өмчид хүлээн авах, бүртгэх, ашиглагч, өмчлөгч байгууллагыг хууль, журамд нийцүүлэн тодорхойлоогүй. | 95,272.2 | Зам, тээврийн хөгжлийн яам | Төрийн нарийн бичгийн дарга /С.Батболд/ |
| 2 | Дархан-Сэлэнгийн бүсэд Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төслийг хэрэгжүүлэх концессын гэрээний дагуу концесс эзэмшигчээс ирүүлсэн тайлан, мэдээг нягталж, гэрээний хэрэгжилтэд тавих чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй. | - | Төрийн худалдан авах ажиллагааны газар | Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Х.Улам-Өрнөх/ |
| **Нийт дүн** | | **95,272.2** | | |

## АГУУЛГА


Товчилсон үгийн тайлбар 4

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл 5

Аудит хийсэн үндэслэл 5

Аудитын зорилт 5

Аудитын арга зүй, стандартын талаарх мэдэгдэл, хамарсан хүрээ 5

Аудитын хүндрэл, бэрхшээл 6

Аудитын шалгуур үзүүлэлт 6-7

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ 8

АУДИТЫН ДҮН 9

БҮЛЭГ НЭГ. ТӨСЛИЙН ГҮЙЦЭТГЭГЧИЙГ УРАЛДААНТ ШАЛГАРУУЛАЛТААР СОНГОЖЭЭ. 7

Хөрөнгө оруулалтын гэрээг концессын гэрээ болгож өөрчлөхийг эрх бүхий байгууллагад даалгасан талаар 7

Концессын төслийн мэдээллийг төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад тусгасан талаар 8

Засгийн газрын тогтоолоор концессын гэрээ байгуулах шийдвэр 9-14

БҮЛЭГ ХОЁР. КОНЦЕССЫН ТӨСЛИЙН ГҮЙЦЭТГЭЛД ТАВИХ ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА. 14

Гэрээнд тусгасан дэд бүтцийн төслүүдийн талаарх мэдээлэл 14

Төмөр замын ажил нь батлагдсан зураг төсөл, норм дүрэм, стандартын шаардлагыг хангасан талаар 14-16

Авто зам барих ажлыг батлагдсан зураг төсөв зохих норм стандартын дагуу гүйцэтгэсэн талаар 17-20

Эрчим хүчний барилга, байгууламжийн зураг төсөл, барилга угсралт, тоног төхөөрөмжийн угсралтын ажил нь холбогдох журам, норм дүрэм, стандартын шаардлагыг хангасан талаар 20-22

Концессын зүйлийн эргэн төлөлтийн санхүүжилтийг төсөвт тусган концесс эзэмшигчид олгосон талаар 22-25

Эрх бүхий байгууллагаас концессын гэрээний хэрэгжилтэд үнэлгээ хийсэн талаар 25-26

Төмрийн хүдрийн хуурай болон нойтон аргын баяжмал үйлдвэрлэх үйлдвэрийг ашиглалтад оруулсан талаар 26-28

ГУРАВ. ДҮГНЭЛТ 29

ДӨРӨВ. ЗӨВЛӨМЖ 30

Холбогдох байгууллагын санал 31

Саналд өгөх тайлбар 32

## Товчилсон үгийн тайлбар

| | |
|---|---|
| МУ | Монгол Улс |
| БНХАУ | Бүгд Найрамдах Хятад Ард Улс |
| БНСУ | Бүгд Найрамдах Солонгос Улс |
| УИХ | Улсын Их Хурал |
| ҮАГ | Үндэсний аудитын газар |
| ТБОНӨТХ | Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль |
| ТБОНӨХБАҮХАТХ | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль |
| АДБОУС | Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт |
| ЗГХЭГ | Засгийн газрын Хэрэг эрхлэх газар |
| БОАЖЯ | Байгаль орчин, аялал жуулчлалын яам |
| БХБЯ | Барилга, хот байгуулалтын яам |
| ЗТХЯ | Зам, тээврийн хөгжлийн яам |
| УУХҮЯ | Уул, уурхай, хүнд үйлдвэрийн яам |
| ЭХЯ | Эрчим хүчний яам |
| ЭЗХЯ | Эдийн засгийн хөгжлийн яам |
| ҮХГ | Үндэсний хөгжлийн газар |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар |
| ТХААГ | Төрийн худалдан авах ажиллагааны газар |
| ХОГ | Хөрөнгө оруулалтын газар |
| АМГТГ | Ашигт малтмал, газрын тосны газар |
| ТЕГ | Татварын ерөнхий газар |
| ХШҮДАГ | Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар |
| АЗЗА | Авто замын засвар, арчлалт |
| БНБД | Барилгын норм ба дүрэм |
| ЗТХТ | Зам, тээврийн хөгжлийн төв |
| ЗЗБНБД | Зам, замын байгууламжийн норм ба дүрэм |
| ИТА | Инженер техникийн ажилтан |
| ТНБД | Төрийн нарийн бичгийн дарга |
| ААНБ | Аж ахуйн нэгж байгууллага |
| ТӨУГ | Төрийн өмчийн удирдлагын газар |
| ТӨХК | Төрийн өмчит хувьцаат компани |
| ЦДАШ | Цахилгаан дамжуулах агаарын шугам |
| ХХК | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |
| ХОГ | Хөрөнгө оруулалтын газар |
| ТХХТ | Төр, хувийн хэвшлийн түншлэл |
| ТЭЗҮ | Техник, эдийн засгийн үндэслэл |
| ТӨХ | Төрийн өмчийн хороо |
| ТУЗ | Төлөөлөн удирдах зөвлөл |
| АҮЯ | Аж үйлдвэрийн яам |


| № | Тайлбар | Хуудасны дугаар |
|---|---|---|
| Хүснэгт 1 | Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад тусгасан төслийн мэдээлэл | 11 |
| Хүснэгт 2 | Төслийн зорилго, хүчин чадлын мэдээлэл | 14 |
| Хүснэгт 3 | Төмөр замын хөрөнгө оруулалтын төсөв, гүйцэтгэл | 16 |
| Хүснэгт 4 | Эргэн төлөлтийн шинэчилсэн хуваарь | 19 |
| Хүснэгт 5 | Авто замын хөрөнгө оруулалтын төсөв, гүйцэтгэл | 19 |
| Хүснэгт 6 | Экспертизээр хянагдсан төсөвт өртгийн тооцоолол | 21 |
| Хүснэгт 7 | Концессын гэрээний дагуу улсын төсвөөс олгосон санхүүжилтийн мэдээлэл | 24 |

## Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдээлэл

### Аудит хийсэн үндэслэл:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2021 оны 02 дугаар тогтоолыг үндэслэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/27 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу гүйцэтгэлээ.

### Аудитын зорилт:

"Дархан-Сэлэнгийн бүсэд Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төслийг хэрэгжүүлэх концессын гэрээний хэрэгжилт"-д гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулан, Улсын Их Хурал болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэсэн болно.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэв. Үүнд:

- Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад хууль, эрх зүйн шаардлагыг хангасан төслийг тусгаж, концесс эзэмшигчийг хуулийн дагуу сонгон шалгаруулсан эсэх;
- Төслийн гүйцэтгэл, түүнд тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу үр дүнтэй хэрэгжүүлсэн эсэх.

### Аудитын хамарсан хүрээ

Аудитад ЗГХЭГ, Сангийн яам, УУХҮЯ, ЭХЯ, ЗТХЯ, БОАЖЯ, ТӨБЗГ, ТХААГ, АМГТГ, ТЕГ болон концесс эзэмшигчийн хэрэгжүүлсэн төслийн зураг төсвийг зохиогч, магадлал хийсэн хуулийн этгээд, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэгч, зөвлөх үйлчилгээ үзүүлэгч ААНБ, бусад холбогдох байгууллагын үйл ажиллагааг хамруулав.

### Аудитын арга зүй, стандартын талаарх мэдээлэл, хамарсан хүрээ

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС 100, 300, 3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817:2020 “Төрийн аудит, тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS 6817-6:2020 “Нийцлийн аудитын зарчим”, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох зүйлсийг цуглуулж баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт хийх арга зүйг ашиглав.

Аудитаар “Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төсөл”-ийн төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналтай холбоотой хууль эрх зүйн актыг судлах, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, мэдээлэл, тодруулга авах, төслийн асуудлыг хариуцсан байгууллага болон холбоотой талуудаас гаргуулсан баримт, мэдээлэл, тайланг судалж, аудитын төлөвлөгөө, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, тэдгээрийн дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Авто зам, төмөр зам, эрчим хүч, барилгын салбарын хөндлөнгийн шинжээчдийн “Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төсөл”-ийн гэрээний

концессын зүйлд хамаарах Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд орших Төмөртэйн ордоос Хандгайт өртөө чиглэлийн 1520 мм царигтай төмөр зам, ачиж буулгах терминал, Төмөртэйн ордоос Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сум-Улаанбаатар чиглэлийн олон улсын авто замын Дулаанхааны дөрвөн замын уулзвар хүртэл 95 км хатуу хучилттай авто зам болон Сэлэнгэ аймгийн Ерөө сумаас Хүдэр сумын Төмөртэйн уурхай хүртэл 110 кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугам (50 км), өргөтгөл, дэд станц зэрэг ажлын зураг төсөл, төсөв, ажлын гүйцэтгэл нь холбогдох хууль тогтоомж, норм дүрэм, журамд нийцэж буй эсэхийг нягтлан шалгаж гаргасан дүгнэлт болон бусад холбогдох нотлох баримтад тулгуурлан аудитыг хэрэгжүүллээ.

Концессын гэрээнд тусгасан концессын зүйлээс Улсын комисс хүлээж аваагүй болон шүүхийн хүчин төгөлдөр шийдвэртэй холбоотой асуудлуудыг аудитад хамруулаагүй хязгаарласан болно.

## Аудитын хүндрэл, бэрхшээл

"Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төслийг хэрэгжүүлэх концессын гэрээ"-г Эдийн Засгийн Хөгжлийн Яам /татан буугдсан/ болон "Кью Эс Си" ХХК-ийн хооронд 2014 онд байгуулагдсан. Концессын зүйлд хамаарах төсөл арга хэмжээнүүдийн зураг, төслийг 2012-2016 онд эрх бүхий байгууллагаас боловсруулж баталсан бөгөөд холбогдох баримт материал нь Улсын архив болон орон нутгийн архивд шилжсэн, аудитад шаардлагатай ажлын баримтуудыг захиалагч, ашиглагч байгууллагууд бүрэн архивлаагүй байсан тул аудитад шаардлагатай баримтуудыг хамаарал бүхий байгууллагуудаас тус тус гаргуулан авч ажиллалаа.

Концессын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын бүтэц, зохион байгуулалт удаа дараа өөрчлөгдсөнөөс концессын зүйлд хамаарах төслүүдийн батлагдсан зураг, төсөв, гүйцэтгэл, тайлагналтай холбоотой баримт материалууд холбогдох байгууллагуудад бүрэн хэмжээнд байхгүй, аудитад шаардлагатай баримтуудыг ҮХГ, ТХААГ, Сангийн яам, ЗТХЯ, ЗТХТөв, БХТ, ЭХХТ, ЦДҮС, "Монголын төмөр зам" ТӨҮГ, ТӨБЗГ, БОАЖЯ, Архивын Ерөнхий газар болон орон нутгийн архивын газар зэрэг байгууллагуудад албан бичиг илгээж гаргуулан авахад хугацаа алдсан. Мөн "Ковид 19" өвчний тархалт нэмэгдсэнтэй холбоотойгоор төслийн үйл ажиллагаатай газар дээр нь очиж танилцах, хэмжилт, тулган баталгаажуулалт хийхэд орон нутгийн замуудыг хаасан, холбогдох байгууллагууд үйл ажиллагаагаа зогсоосон, Дархан-Уул болон Сэлэнгэ аймгийн Онцгой комиссоос зөвшөөрөл авах, тухайн төслийг хэрэгжүүлсэн объект руу нэвтрэх боломжтой үеийг хүлээх зэргээс шалтгаалж аудитыг төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэхэд цаг хугацаа их шаардсан болно.

## Ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт:

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа. Үүнд:

- Монгол Улсын 2016, 2017 оны Төсвийн тухай хууль;
- Концессын тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Өрийн удирдлагын тухай хууль;
- Барилгын тухай хууль;
- Авто замын тухай хууль;
- Эрчим хүчний тухай хууль;
- Ашигт малтмалын тухай хууль;

- Байгаль орчныг хамгаалах тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Төрөөс төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар баримтлах бодлогын баримт бичиг,
- Төслийн батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт;
- Засгийн газрын 2012 оны 103 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан

"Концесс олгох уралдаант шалгаруулалтын журам";

- Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоолоор баталсан "Концессын зүйлийн жагсаалт", түүнд оруулсан өөрчлөлтүүд;
- Засгийн газар болон "Кью Эс Си" ХХК-ийн хооронд 2014 онд байгуулсан "Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төсөл"-ийг хэрэгжүүлэх концессын гэрээ;
- Дээрх хууль тогтоомж, бусад шийдвэрүүдийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан УИХ, Засгийн газраас гаргасан шийдвэр;
- Авто зам, эрчим хүчний болон барилгын салбарт мөрдөж буй норм, дүрэм, стандартууд;
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрх зүйн актууд.

## Ерөнхий мэдээлэл

УИХ-ын 2009 оны 64 дүгээр тогтоолоор баталсан "Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлого"-ын 1.2-т "... Засгийн газраас тэргүүлэх ач холбогдол өгч байгаа төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төр, хувийн хэвшил хамтран ажиллах, төрийн тодорхой чиг үүргийг хувийн хэвшлийн этгээдээр гүйцэтгүүлэх замаар ... төсвийн үр ашгийг дээшлүүлэхэд чиглэнэ" гэж заасан байна.

Дээрх бодлогын хэрэгжилтийг хангах зорилгоор 2010 онд баталсан Концессын тухай хуульд "Концесс эзэмшигч концессын зүйлийг өөрийн болон өөрийн боломжоор олсон хөрөнгөөр барьж ашиглалтад оруулан дор дурдсан төрлөөс аль нөхцөлөөр гэрээ байгуулснаас шалтгаалан тодорхой хугацааны дараа хөрөнгийг төрийн болон орон нутгийн өмчлөлд шилжүүлэх" гэж заасан.

Засгийн газрын "Концессын гэрээ байгуулах эрх олгох тухай" 2014 оны 69 дүгээр тогтоолыг үндэслэн Эдийн Засгийн Хөгжлийн Яам/хуучин нэрээр/ болон "Кью Эс Си" ХХК-ийн хооронд "Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төслийг хэрэгжүүлэх концессын гэрээ"-г шинэчлэн сайжруулах-барих-ашиглах-шилжүүлэх, барих-шилжүүлэх төрлөөр 2014 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр байгуулсан.

Уг концессын гэрээний зүйл нь дараах хэсгээс бүрдсэн байна. Үүнд:

1. *"Хуст уул, Төмөртолгой, Төмөртэйн ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулж, жилдээ 3.0 сая доошгүй тонн төмрийн хүдэр олборлох, жилд 1.5 саяас доошгүй тонн төмрийн хүдрийн хуурай болон нойтон аргын баяжмал үйлдвэрлэх үйлдвэр байгуулах";*

2. *"Жилд 500.0 мянгаас доошгүй тонн хүчин чадал бүхий шууд ангижруулсан төмрийн үйлдвэр байгуулах";*

3. *"Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК-ийн хүчин чадлыг жилийн 300 мянган тоннд хүргэх өргөтгөл, шинэчлэл хийх /төмрийн хүдэр боловсруулж эцсийн бүтээгдэхүүн гаргах/;*

4. *"Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд орших Төмөртэйн ордоос Хандгайт өртөө (Баянгол төмөр зам) чиглэлийн 33.4 км 1520 мм царигтай төмөр зам, ачиж буулгах терминал барих";*

5. *"Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд орших Төмөртэйн ордоос Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумаас Улаанбаатар чиглэлийн олон улсын авто замын Дулаанхааны дөрвөн замын уулзвар хүртэл 95 км хүнд даацын хатуу хучилттай авто зам;*

6. *"Сэлэнгэ аймгийн Ерөө сумаас Хүдэр сумын Төмөртэйн уурхай хүртэл 110 кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, /50 км/, өргөтгөл, дэд станц барих зэрэг ажлуудыг гэрээнд тусгажээ.*

Аудитаар "Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төсөл"-ийн хүрээнд концессын "барих-шилжүүлэх" төрлөөр хэрэгжиж, Улсын комисст хүлээлгэн өгсөн төслүүдийн зураг төсөл, барилга угсралтын ажлын хэрэгжилтэд мэргэжлийн шинжээчдийн багийг ажиллуулж, дүгнэлт гаргуулж, түүнд тулгуурлан аудитыг гүйцэтгэсэн болно.

Концессын тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд ТХХТ, концессын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг 2010-2012 онд Төрийн өмчийн хороо, 2012-2014 онд ЭЗХЯ, 2014 оны 10 дугаар сараас

2015 онд хүртэл Сангийн яам, 2015 оноос 2016 оны 8 дугаар сар хүртэл Хөрөнгө оруулалтын газар, 2016 оны 8 дугаар сараас 2020 оны 12 сар хүртэл Үндэсний хөгжлийн газар, 2021 оноос өнөөг хүртэл ТХААГ тус тус хэрэгжүүлсэн байна.

Засгийн газрын 2018 оны "Тогтоол хүчингүй болгох тухай" 6 дугаар тогтоолоор "Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд орших Төмөртэйн ордоос Ерөө суманд орших "Болд Төмөр Ерөө Гол" ХХК-ийн төмөр замын Хандгайт өртөө хүртэлх 33.4 км төмөр замыг ачиж буулгах терминалын хамт барих" төсөл болон "Сэлэнгэ аймгаар өнгөрөх олон улсын авто замтай холбох 95 км хатуу хучилттай авто зам барих" төслийн "барих-шилжүүлэх" төслөөр байгуулсан нэмэлт гэрээг цуцлахыг ҮХГ-ын даргад, мөн концесс эзэмшигчид улсын төсвөөс олгосон хөрөнгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлэхийг Сангийн сайд, ЗТХ-ийн сайд, ҮХГ-ын дарга нарт тус тус даалгажээ.

## АУДИТЫН ДҮН

## НЭГ. ТӨСЛИЙН ГҮЙЦЭТГЭГЧИЙГ УРАЛДААНТ ШАЛГАРУУЛАЛТААР СОНГОЖЭЭ.

**Хөрөнгө оруулалтын гэрээг концессын гэрээ болгож өөрчлөхийг эрх бүхий байгууллагад даалгасан байна.**

1.1. Засгийн газрын 2008 оны "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 153, Төрийн Өмчийн Хорооны /хуучин нэрээр/ 2008 оны "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 332 дугаар тогтоолоор Дархан-Сэлэнгийн бүсэд орших төрийн эзэмшлийн төмрийн хүдрийн орд газруудыг ашиглах, "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" төрийн өмчит хувьцаат компанийн үйл ажиллагааг өргөтгөн техник, технологийн шинэчлэл хийж, үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, үр ашгийг дээшлүүлэх ТЭЗҮ-ийг боловсруулж, төслийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Үйлдвэр, худалдааны сайд болон ТӨХ-д тус тус үүрэг болгожээ.

1.2. Төслийн нөхцөл шаардлагыг хэрэгжүүлэх, санхүүжилтийг үйл ажиллагааны ашгаас эргэн төлөгдөх нөхцөлтэй зохион байгуулах менежментийн гэрээг "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" төрийн өмчит хувьцаат компанийн удирдлагатай байгуулж ажиллахыг Үйлдвэр, худалдааны сайд, ТӨХ-д даалгасан байна.

1.3. ТӨХ-ны даргын 2009 оны "Ажлын хэсэг томилох тухай" 333 дугаар тогтоолоор "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК-ийн үйл ажиллагааг өргөтгөн техник, технологийн шинэчлэл хийж, үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, үр ашгийг дээшлүүлэх талаар гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдаас ирсэн саналд үнэлэлт дүгнэлт өгөх үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулсан байна.

1.4. "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК-ийн үйл ажиллагааг өргөтгөн техник, технологийн шинэчлэл хийж, үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулж, үр ашгийг дээшлүүлэх төслийн уралдаант шалгаруулалтад орох хүсэлтийг гадаад, дотоодын нийт 6 ААНБ буюу CPMIE /China National Precision Machinery I/E corporation/, Энэтхэг Улсын "Меско Стийл" групп, ICM (Industrial Corporation of Mongolia) ХХК, БНСУ-ын "Поско" компанийн менежмент судалгааны посри төв, "Кью Эс Си" ХХК, БНХАУ-ын төмөрлөгийн үйлдвэр болох "Бао Ган" компаниуд ирүүлжээ.

1.5. Ажлын хэсгээс "Оюу толгой", Таван толгой", Шивээ Овоогийн болон Улаанбаатар V цахилгаан станц, Хөшигтийн хөндийн олон улсын нисэх буудал зэрэг төслүүдийн бүтээн байгуулалтад шаардагдах арматур, бусад ган хийцийн бүтээгдэхүүнийг үндэсний үйлдвэрлэлээр бүрэн хангахын тулд уг төслийг хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай гэж үзсэн бөгөөд хөрөнгө оруулагчаар "Кьюо Эс Си" ХХК-ийг санал болгосон байна.

1.6. Ийнхүү 2010 онд "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК болон "Кью Эс Си" ХХК-ийн хооронд "Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төслийг хэрэгжүүлэх Хөрөнгө оруулалтын гэрээ", мөн 2011 онд "Дэд бүтэц байгуулах төслийг хамтран хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын гэрээ"-г тус тус байгуулсан байна.

1.7. ТӨХ-ны 2012 оны 08 дугаар сарын "Хөрөнгө оруулалтын тухай" 326 дугаар тогтоолоор "Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төсөл"-ийн хүрээнд "Кью Эс Си" ХХК 48.0 сая ам.долларын хөрөнгө оруулалт оруулсан болохыг зөвшөөрч, 2012 оны "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 327 дугаар тогтоолоор дээрх хөрөнгө оруулалтын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж байгааг харгалзан "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК-ийн менежментийг "Хөрөнгө оруулалтын гэрээ" хэрэгжих хугацаанд "Кью Эс Си" ХХК-д шилжүүлсэн байна.

1.8. Үндэсний аудитын газар "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК-ийн 2012 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитыг "Би Энд Си аудит" ХХК-иар гэрээгээр гүйцэтгүүлж, 2010-2012 оны хооронд 81,275.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн бөгөөд "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК-ийн 2011 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд "Кью Эс Си" ХХК-иас оруулсан хөрөнгө оруулалт 63,411.9 сая, 2012 онд 17,864.0 сая, нийт 81,275.9 сая төгрөгийг урт хугацаат өр төлбөрөөр бүртгэснийг баталгаажуулсан байна.[1]

1.9. Төрийн өмчийн хорооны 2012 оны "Хөрөнгө оруулалтын тухай" 326, 2013 оны "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 471 дүгээр тогтоолоор "Кью Эс Си" ХХК "Хөрөнгө оруулалтын гэрээ"-ний дагуу төслийн хүрээнд 81,301.4 сая төгрөгийн (48.0 сая ам.долларын) хөрөнгө оруулсан болохыг тогтоож, хөрөнгө оруулалтын гэрээг зах зээл, эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан Концессын тухай хуулийн дагуу концессын гэрээ болгож өөрчлөх асуудлыг ЭЗХЯ-д тавьж шийдвэрлүүлэхийг ТӨУГ-т даалгажээ.

1.10. "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК нь 2013 оны 1/343, 1/39, 1/56 дугаартай албан бичгээр хойд бүс нутагт төмөрлөгийн үйлдвэрийг хөгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай байгаа дээрх хөрөнгө оруулалтын гэрээний хүрээнд хэрэгжиж буй дэд бүтцийн төслүүдийг Концессын тухай хуульд нийцүүлэн концессын гэрээ болгон өөрчлөх хүсэлтийг Эдийн засгийн хөгжлийн сайдад удаа дараа хүргүүлсэн байна.

**Концессын төслийн мэдээллийг төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад тусгасан байна.**

1.11. Концессын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3[2] дахь хэсэгт "Засгийн газар концессын зүйлийн жагсаалтыг батлахдаа дараах зүйлийг тусгана" гэж заасны дагуу

---

*[1] Үндэсний аудитын газрын 2013 оны 5 дугаар сарын 02-ний өдрийн "Кью Эс Си" ХХК-д илгээсэн 2/744 дугаартай албан бичиг*

*[2] 10.3-т Концессын зүйлийн жагсаалтад дараах зүйлийг тусгана:*
*10.3.1-д концессын зүйлийн нэр, тодорхойлолт, концессын төрөл, гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээ;*
*10.3.2-т төсвийн хөрөнгөөр санхүүгийн дэмжлэг үзүүлэх, баталгаа гаргах эсэх;*

Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоолын "Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт"-ын 5 дахь хэсэгт "Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төсөл"-ийг тусгасан байна.

*Хүснэгт 1. Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад тусгасан төслийн мэдээлэл*

| Концессын зүйлийн нэр | Концессын зүйлийн тодорхойлолт | Концессын төрөл | Гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээ | Төсвийн хөрөнгөөр санхүүгийн дэмжлэг үзүүлэх, баталгаа гаргах эсэх | Уралдаант шалгаруулалт явуулах, шууд гэрээ байгуулах эсэх |
|---|---|---|---|---|---|
| Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төсөл | Дархан-Сэлэнгийн бүсэд орших төрийн эзэмшлийн төмрийн хүдрийн орд газруудыг ашиглан, эдийн засгийн эргэлтэд оруулах, "Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр" ТӨХК-ийн үйл ажиллагааг өргөтгөн техник, технологийн шинэчлэл хийж, үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх. | Шинэчлэн сайжруулах-барих -ашиглах-шилжүүлэх, Барих-шилжүүлэх | -"Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр" ТӨХК-ийн үйл ажиллагааг өргөтгөн техник, технологийн шинэчлэл хийж, үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, төмөрлөгийн цогцолбор байгуулах.<br>-Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд орших Төмөртэйн ордоос Ерөө суманд орших "Болд Төмөр Ерөө Гол" ХХК-ийн төмөр замын Хандгайт өртөө хүртэлх 33.4 км төмөр замыг ачиж буулгах терминалын хамт барих.<br>-Сэлэнгэ аймгаар өнгөрөх олон улсын авто замтай холбох 95 км хатуу хучилттай авто зам барих. /ЗГ-ын 2015 оны 364 дүгээр тогтоолоор "хүнд даацын" гэснийг хассан/<br>-Сэлэнгэ аймгийн Ерөө сумаас Хүдэр сумын Төмөртэй уурхай хүртэл 110 кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, өргөтгөл, дэд станцын хамт барих. | Судлан шийдвэрлэх<br><br>/ЗГ-ын 2015 оны 364 дүгээр тогтоолоор Шаардлагагүй гэснийг "Судлан шийдвэрлэх" гэж өөрчилсөн байна/ | Шууд гэрээ байгуулах |

*Эх сурвалж: Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоолын хавсралт*

1.12. Ийнхүү "Шинэчлэн сайжруулах-барих-ашиглах-шилжүүлэх", "барих-шилжүүлэх" төрлөөр хэрэгжүүлэх "Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төсөл"-ийн концесс эзэмшигчийг сонгохдоо төслийн хөрөнгө оруулагчаар шалгарсан компанитай шууд гэрээ байгуулахаар шийдвэрлэсэн байна.

1.13. ЭЗХЯ-ны ТНБД-ын 2014 оны 11 дүгээр тушаалаар "Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төсөл"-ийн концессын гэрээний нөхцөлийн талаар "Кью Эс Си" ХХК-тай хэлэлцээ хийх, дүгнэлт гаргах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулсан байна.

1.14. Ажлын хэсгээс концессын гэрээний төслийг боловсруулж, холбогдох дүгнэлтийн хамт эрх бүхий этгээдэд хүргүүлэхээр шийдвэрлэсэн бөгөөд уг асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх зорилгоор гэрээний төсөлд СЯ, ХЗЯ, ҮХААЯ, УУЯ, ЭХЯ, БХБЯ, БОНХЯ-аас ирүүлсэн саналыг тусгажээ.

1.15. "Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төсөл"-ийн концессын гэрээний төсөл" болон гэрээ байгуулах дүгнэлтийг ЭЗХЯ-аас 2014 оны 02 дугаар сарын 20-ны өдөр 1/305 дугаартай албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн байна.

**Засгийн газрын тогтоолоор концессын гэрээ байгуулах шийдвэрийг гаргажээ.**

1.16. Концессын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2[3] дахь заалт, Засгийн газрын 2013 оны "Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт батлах тухай" 317, 2014 оны

---

*10.3.3-д энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасан уралдаант шалгаруулалт явуулах, эсхүл шууд гэрээ байгуулах эсэх.*
*[3] Концесс олгох шийдвэр гаргаж, концессын гэрээ байгуулах эрхийг ... байгууллагад олгох.*

"Концессын гэрээ байгуулах эрх олгох тухай" 69 дүгээр тогтоолын дагуу "Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төслийг хэрэгжүүлэх концессын гэрээг "Кьюү Эс Си" ХХК-тай байгуулах эрхийг ЭЗХЯ /татан буугдсан/-д олгож, төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай ТЭЗҮ, зураг төслийг батлах болон тусгай зөвшөөрлийг хууль тогтоомжийн дагуу олгохыг холбогдох салбарын яамдад даалгажээ.

1.17. Эдийн Засгийн Хөгжлийн Яам /татан буугдсан/ болон "Кью Эс Си" ХХК-ийн хооронд 2014 оны 4 дүгээр сарын 04-ний өдөр "Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төслийг хэрэгжүүлэх концессын гэрээ"-г "шинэчлэн сайжруулах-барих-ашиглах-шилжүүлэх" болон "барих-шилжүүлэх" төрлөөр 30 жилийн хугацаагаар байгуулсан байна.

1.18. Концесс эзэмшигчээс концессын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах хүсэлтийг АҮЯ болон Хөрөнгө оруулалтын газарт 2015 онд 1/88, 1/99 дугаартай албан бичгээр тус тус хүргүүлжээ.

1.19. Дээрх хүсэлтийн дагуу АҮЯ-аас ЗГ-ын 317 дугаар тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай Засгийн газрын тогтоолын төсөлд санал авахаар бүх сайд нарт 2015 оны 01/2466 дугаартай албан бичиг илгээхэд Хууль зүйн сайдаас бусад сайд дэмжсэн хариу ирүүлсэн байна.

1.20. Концессын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1[4] дэх хэсэг, Засгийн газрын 2015 оны 364 дүгээр тогтоол[5], концессын гэрээний 12.2[6] дахь заалтыг үндэслэн "Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төслийг хэрэгжүүлэх концессын гэрээ"-нд хоёр удаа нэмэлт, өөрчлөлт оржээ.[7] Үүнд:

**2015 оны 10 дугаар сарын 2-ны өдрийн концессын нэмэлт гэрээгээр:**

Концессын гэрээний 1.1-д дараах нэр томьёо, утгыг нэмэлтээр оруулсан байна. Тухайлбал:

***"Бодит хөрөнгө оруулалт"** гэж тухайн концессын зүйлийг барьж, эрх бүхий байгууллагад хүлээлгэн өгөх хүртэл хугацаанд гарсан төслийн үндсэн төсөв, санхүүжилтийн зардал, өртөг болон бусад баримтаар нотлогдсон концессын зүйлтэй холбоотой бүхий л зардлуудыг багтаасныг;*

1.2. Концессын гэрээний 2 дугаар зүйлийн холбогдох хэсгийг дараах байдлаар өөрчилсөн байна. Үүнд:

***2.1.5-ыг** "Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд орших Төмөртэйн ордоос Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сум-Улаанбаатар чиглэлийн олон улсын авто замын Дулаанхааны дөрвөн замын уулзвар хүртэл **95 км хатуу хучилттай авто зам**" гэж;*

**2.5 дахь** заалтыг нэмэлтээр оруулсан байна. Үүнд:

*Концесс эзэмшигч нь энэхүү гэрээний 2.1.1-2.1.3 дахь заалтыг **"шинэчлэн сайжруулах-барих-ашиглах шилжүүлэх**, 2.1.4-2.1.6 дахь заалтыг **"барих-шилжүүлэх" төрлөөр хэрэгжүүлнэ** гэж, мөн хөрөнгө оруулалтын эргэн төлөлт, концессын зүйлийг эрх бүхий этгээдэд хэрхэн шилжүүлэх болон төслийн тайлан, мэдээ гаргахтай холбоотой бусад заалт;*

**2016 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн концессын нэмэлт гэрээгээр:**

---

*[4] "Гэрээний талууд харилцан тохиролцож концессын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно".*

*[5] Засгийн газрын 2015 оны "Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай" 364 дүгээр тогтоолоор Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт"-ын "Гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээ" гэсэн багана "хүнд даацын" гэснийг хасаж, "Төсвийн хөрөнгөөр санхүүгийн дэмжлэг үзүүлэх, баталгаа гаргах эсэх" гэсэн баганад "шаардлагагүй" гэснийг "Судлан шийдвэрлэх" гэж өөрчилсөн байна.*

*[6] Концессын тухай хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу талууд харилцан тохиролцож энэхүү гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно".*

*[7] Засгийн газрын 2018 оны 6 дугаар тогтоолоор нэмэлт гэрээг цуцалсан.*

Концессын гэрээний 2 дугаар зүйлийн холбогдох хэсгийг дараах байдлаар өөрчилжээ. Үүнд:

1.1 *"... гэрээний 2.1.5-д заасан концессын зүйлийг барьж гүйцэтгэн Улсын комисст хүлээлгэн өгсөн концесс эзэмшигчийн оруулсан бодит хөрөнгө оруулалтыг санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дараах хуваарийн дагуу Улсын төсөвт суулган, концесс эзэмшигчид нөхөн төлнө..." гэж өөрчлөлт оруулсан байна.*

1.21. Концессын гэрээний 2015 он болон 2016 оны нэмэлт, өөрчлөлтүүд нь концессын зүйлийн нэр томьёо, төрөл, хөрөнгө оруулалтын санхүүжилтийн эргэн төлөлтийн хуваарьтай холбоотой заалтууд байна.

1.22. Засгийн газрын 2014 оны 69 дүгээр тогтоолоор "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК-ийн удирдлагын эрх болон хөрөнгийг концессын гэрээний хугацаанд "Кью Эс Си" ХХК-д шилжүүлэх ажлыг зохион байгуулахыг ТӨХ-д үүрэг болгосон байна.

1.23. Төрийн өмчийн хорооны 2014 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн талаар авах арга хэмжээний тухай" 155 дугаар тогтоолоор "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн удирдлагын эрх болон мөнгөн хөрөнгийг тогтоол гарсан өдрөөр, хөрөнгийг 2014 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөр, ТУЗ-ийн дарга, гишүүдийг 2014 оны 4 дүгээр сарын 15-ны өдрөөр тус тус тасалбар үүрэгт ажлаас чөлөөлж, "Кью Эс Си" ХХК-д концессын гэрээний хугацаанд шилжүүлэхээр шийдвэрлэсэн байна.

1.24. Улмаар ТӨХ-ны 2014 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК-ийн удирдлагын эрх болон хөрөнгийг шилжүүлэх тухай" 207 дугаар тогтоолоор тус компанийн эзэмшилд байгаа 153,262.6 сая төгрөгийн балансын үнэтэй, 64,450.0 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий 88,812.6 сая төгрөгийн үлдэгдэл үнэтэй үндсэн хөрөнгө, 85,348.7 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгө, нийт 174,161.3 сая төгрөгийн хөрөнгийг "Кью Эс Си" ХХК-д концессын гэрээний хугацаанд шилжүүлжээ.

1.25. Мөн "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК-ийн эзэмшилд байгаа улсын бүртгэлийн гэрчилгээ, компанийн дүрэм, ашигт малтмалын тусгай зөвшөөрөл, газар эзэмших гэрчилгээ, үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ, компанийн үйл ажиллагаатай холбоотой гэрээ зэрэг 34 ширхэг баримт бичгийг концесс эзэмшигчид тус тус шилжүүлсэн байна.

1.26. Концессын гэрээний 2.12-т "Энэхүү гэрээний хугацаанд төлөх концессын төлбөрийн хэмжээ "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК-иас 2009-2013 оны хугацаанд улсын төсөвт хамгийн өндөр ногдол ашиг төлсөн нэг жилийн ногдол ашгийн дүнг гэрээний хугацаатай үржүүлсэнтэй тэнцүү буюу 63.8 тэрбум төгрөг бөгөөд концессын төлбөрийн дүн өөрчлөгдөхгүй" гэсний дагуу 2014 онд концесс эзэмшигч концессын төлбөрийн урьдчилгаа 31.9 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлснээр гэрээ хүчин төгөлдөр болсон байна[8].

1.27. Гэрээний 2.14-т "...концессын үлдэгдэл төлбөрийг гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш 5 дахь жилээс эхлэн төлөх бөгөөд үлдэгдэл төлбөрийг жил бүр төлж дуусгавар болгохоор гэрээнд заасан байна. Концессын гэрээний хугацаанд тэнцүү хэмжээгээр эрх бүхий этгээдийн заасан дансанд санхүүгийн жил дууссанаас хойш

---

*[8] Сангийн яам Төрийн сангийн 900000707 дугаартай дансанд 2014.04.10-ны өдөр "Кью Эс Си" ХХК-ийн 499180050 дугаартай данснаас шилжүүлсэн байна.*

60 /жар/ хоногийн дотор төлнө" гэсний дагуу 2019 онд 1.276 тэрбум төгрөг, 2020 онд 1.276 тэрбум төгрөгийг тус тус концессын төлбөрт төлсөн байна.

## БҮЛЭГ 2. ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГААС КОНЦЕССЫН ТӨСЛИЙН ГҮЙЦЭТГЭЛД ТАВИХ ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

**Дэд бүтцийн төслүүдийг баталсан зураг төслийн дагуу бүрэн гүйцэтгэсэн байна.**

2.1. Концессын "барих-шилжүүлэх" төрлөөр хэрэгжсэн дэд бүтцийн төслүүд нь Төмөртэй уурхайн бүтээгдэхүүнийг тээвэрлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх, уурхайн болон баяжуулах үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд шаардлагатай эрчим хүчний асуудлыг шийдвэрлэх, төмөрлөгийн үйлдвэрийн техник, технологийн шинэчлэлийг хийж, үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлж, үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн байна. Үүнд:

*Хүснэгт 2. Төслийн зорилго, хүчин чадлын мэдээлэл*

| Гэрээний заалт № | Концессын зүйлийн нэр | Төслийн зорилго |
|---|---|---|
| 2.1.4 | Төмөртэйн ордоос Хандгайт өртөө чиглэлийн 33.4 км 1520 мм царигтай төмөр зам, ачиж буулгах терминал | Төмөртэй уурхайн бүтээгдэхүүний тээврийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, өртөг бууруулах Жилд 7 - 8 сая тн |
| 2.1.5 | Төмөртэйн ордоос Сэлэнгэ аймгийн Сүхбаатар-Улаанбаатар чиглэлийн олон улсын авто замын Дулаанхааны дөрвөн замын уулзвар хүртэл 95 км хатуу хучилттай авто зам | Сум орон нутгийн хөгжил, нутгийн ард иргэдийн харилцаа холбоог хангах, суудлын тэрэгний хөдөлгөөн, тээврийн хэрэгслээр зорчих аюулгүй байдлыг хангах[9] |
| 2.1.6 | Сэлэнгэ аймгийн Ерөө сумаас Хүдэр сумын Төмөртэйн уурхай хүртэл 110 кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугам (50 км), өргөтгөл, дэд станц барих ажил | Сэлэнгэ аймгийн Ерөө, Хүдэр сум, Төмөртэй уурхайг цахилгаан эрчим хүчээр хангах |

*Эх сурвалж: Үндэсний аудитын газар*

2.2. Дээрх "барих-шилжүүлэх" төрлөөр хэрэгжсэн төслүүдийг баталсан ТЭЗҮ, зураг төслийн дагуу хийж, зохих хууль тогтоомж, норм дүрэм, стандартын шаардлагыг хангасан эсэх, мөн төслийн гүйцэтгэлийг бодитой тайлагнасан эсэхийг нягтлан шалгах зорилгоор аудитад авто зам, эрчим хүч, барилгын мэргэжлийн хараат бус шинжээчдийн багийг оролцуулж, төсөл хэрэгжсэн объект /талбар/ дээр очиж, холбогдох хэмжилт, тулган баталгаажуулалтыг хийлээ.

**Төмөр замын ажил нь баталсан зураг төсөл, норм дүрэм, стандартын шаардлагыг хангасан байна.**

2.3. Гэрээний 2.1.4-т тусгасан Төмөртэйн ордоос Хандгайт өртөө чиглэлийн (Баянгол төмөр зам) төмөр зам, ачиж буулгах терминал барих ажлын төслийн ерөнхий төлөвлөгөөг Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын Засаг даргын 2014 оны 171502891 дугаартай захирамжаар Хүдэр сумын дэвсгэрт олгосон 620100м2 газарт хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

2.4. Төмөр замын суурь бүтцийн ажлын барилга угсралтын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх 14/19 дугаартай зөвшөөрлийг ЗТХБГ 2014 оны 10 дугаар сарын 14-ний өдөр олгосон. Төмөртэйн өртөөнөөс Ерөө сумын Хандгайт өртөө хүртэлх төмөр замын зураг төслийг "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК-ийн захирлын "зураг төсөл боловсруулах даалгаврыг үндэслэн "Максимал" ХХК нь "MNS6229:2010" МУ-ын стандартаар 1520мм царигтай төмөр зам барихаар төлөвлөн боловсруулж, Сэлэнгэ аймгийн ерөнхий архитектор Б.Хангал 2015 онд баталгаажуулсан байна.

---

[9] *Авто замын тухай 1998 оны хуулийн /2017.5.11-ний өдрийн хуулиар хүчингүй болсон/ 3 дугаар зүйл 3.1.9-д "орон нутгийн чанартай авто зам" гэж нийслэл, аймгийн нутаг дэвсгэр дэх сум, дүүрэг, хот, суурин газрыг хооронд нь холбосон авто замыг" ойлгоно.*

2.5. БХТ-ийн 2015 оны 599/2015 дугаартай магадлалын ерөнхий дүгнэлтэд 1520 мм царигтай гол замын уртын хэмжээ 23.4 км, бүрэн уртын хэмжээ 36.6 км, олон улсын жишигт нийцсэн, жилд 8-10 сая тонн ачаа тээвэрлэх төслийг хэрэгжүүлснээр МУ-д хар төмөрлөгийн салбарыг хөгжүүлэх, Дарханы төмөрлөгийн үйлдвэрийг өргөтгөн шинэчлэх нийгмийн ач холбогдолтой төсөл бөгөөд барилгын зураг төсөл, архитектур төлөвлөлт нь зохих норм дүрэм, стандартын шаардлага хангасан байна.

2.6. Концесс эзэмшигч нь "Монголиан Рэйлвэй корпорэйшн" ХХК-тай 2014 онд байгуулсан Т314/01 дугаартай 106.8 сая ам.долларын үнийн дүнтэй "Төмөр замын ажил захиалгаар гүйцэтгэх гэрээ"-ний дагуу Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд орших Төмөртэйн ордоос Хандгайт өртөө чиглэлийн төмөр зам барих ажлыг гүйцэтгүүлсэн байна.

2.7. Төслийн зөвлөх үйлчилгээний захиалагчаар "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК, "Кью Эс Си" ХХК, гүйцэтгэгчээр "Монголиан Рейлвей Корпорейшн" ХХК, түүний туслан гүйцэтгэгч нь "Пик Девелопмент" ХХК байна.

2.8. "Монголиан Рейлвей Корпорейшн" ХХК нь Төмөртэйн ордоос Хандгайт өртөө хүртэлх гол зам болох 23.4 км шинээр тавих төмөр замын зурвас газрын дагуу байр зүйн зураглалыг "Аэрогеодези" ХХК-иар гүйцэтгүүлсэн байна.

2.9. Аудитаар гүйцэтгэсэн ажлыг газар дээр нь зам хэмжигч вагоноор хэмжилт хийж, гүйцэтгэлийн зурагтай харьцуулан үзэж ажлын тоо хэмжээ нийт гол зам болох 23.4 км замын зурагт магадлал хийсэн байна.

2.10. Хандгайт-Төмөртэйн замын Төмөртэй өртөөний барилгын Ерөнхий төлөвлөгөө, Архитектурын хэсгийн ажлын зураг нь Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм, БНбД30.01.04, Үйлдвэрийн барилга БНбД31-11-09 нормуудын шаардлагыг хангасан байна гэж дүгнэж байна.

2.11. Хандгайт-Төмөртэйн төмөр замын барилга угсралтын ажлын төсвийг Барилгын хөгжлийн төвийн 2016 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн магадлалын ерөнхий дүгнэлтээр тэргүүлэх төсөвчин Г.Пэлээсүрэн гүйцэттэж, эксперт А.Уранчимэг баталгаажуулсан хянасан байна.

2.12. Аудитаар Төмөр замын уртыг 2021 оны 3 дугаар сарын 18-ны өдөр зам хэмжигч вагоноор хийсэн хэмжилтийг гүйцэтгэлийн зурагтай харьцуулан үзэхэд төмөр замын зайн хэмжээсийг дараах байдлаар тогтоолоо. Үүнд:

- *Нийт гол төмөр замын урт нь Депогийн барилга өнгөртөл;*
- *Автомат гэрлэн дохиололтой гарам – 3 ширхэг*
- *6х4м-ийн төмөр бетон гүүр 3 ширхэг,*
- *3х4м-ийн төмөр бетон дөрвөлжин хоолой - 4 ширхэг*
- *Ус өнгөрүүлэх төмөр бетон дөрвөлжин хоолой -25 ширхэг*
- *Хандгайт өртөөний 9 дүгээр сумны өмнөх уулзвараас Төмөртэй өртөөний 2 дугаар сумны өмнө уулзвар хүртэлх – 21.6 км;*
- *Салаа замуудын нийт урт - 15.1 км;*
- *Төмөр замын нийт урт 36.7 км ажил*

2.13. "Хандгайт өртөөнөөс Төмөртэйн уурхай хүртэлх төмөр замын барилгын ажлын тоо хэмжээг дараах байдлаар тусгасан байна. Тухайлбал,

- *"Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төслийг хэрэгжүүлэх концессын гэрээнд Хандгайт өртөөнөөс Төмөртэйн уурхай чиглэлд 1520 мм царигтай төмөр зам, ачиж буулгах терминалын ажлыг барих ажил;*
- *Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын 2015 оны 12 дугаар 28-ны өдрийн 02/18/15 дугаарын актад төмөр замыг 22.9 км төмөр зам болон бусад салаа зам, Төмөртэйн өртөөний хүлээн авах, явуулах зам, салбар замууд, инженерийн хиймэл байгууламж, дохиолол холбооны байгууламж, өртөөний удирдлага хяналтын байгууламжуудыг байнгын ашиглалтад оруулах тухай тус тус тусгажээ.*

**Концесс эзэмшигч төслийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг зээлийн болон өөрийн хөрөнгөөр бүрдүүлсэн байна.**

2.14. Концессын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь хэсэгт "...концесс эзэмшигч концессын зүйлийг өөрийн болон өөрийн боломжоор олсон хөрөнгөөр барьж ашиглалтад оруулан, гэрээнд заасан нөхцөлөөр төрийн болон орон нутгийн өмчлөлд шилжүүлэх" гэж заасны дагуу концесс эзэмшигч төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг Монгол Улсын Хөгжлийн банк, Худалдаа хөгжлийн банк, Улаанбаатар хотын банк болон компанийн өөрийн хөрөнгөөр бүрдүүлжээ.

2.15. Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд орших Төмөртэйн ордоос Хандгайт өртөө чиглэлийн төмөр зам, ачиж буулгах терминалыг барихад 2014 оны 12 дугаар сарын 03-ны өдөр Монгол Улсын хөгжлийн банкнаас 71.3 сая ам. долларын жилийн 8 хувийн хүүтэй зээлийг 3 жилийн хугацаатай авсан байна.[10]

2.16. Монгол Улсын 2016 оны Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 4 дүгээр хавсралт буюу "Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлэх векселиэр төлбөр гүйцэтгэсэн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт"-ын XI.1.1.17-д "Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд орших Төмөртэйн ордоос Хандгайт өртөө /Баянгол төмөр зам/ чиглэлийн төмөр зам, ачиж буулгах терминалын төсөл арга хэмжээ"-ний төсөвт өртгийг 256,391.1 сая төгрөгөөр баталж, 2016 онд төслийн эргэн төлөлтөд 183,608.6 сая төгрөгийг вексель хэлбэрээр концесс эзэмшигчид олгожээ.

*Хүснэгт 3. Төмөр замын хөрөнгө оруулалтын төсөв, гүйцэтгэл /сая төгрөг/*

| Концессын гэрээний дүн | Батлагдсан төсөвт өртөг | Аудитаар хянасан | | | Гүйцэтгэгчид олгосон дүн /вексель хэлбэрээр/ |
|---|---|---|---|---|---|
| | | Барилга угсралтын ажлын гүйцэтгэл | Санхүүжилтийн зардал | Нийт гүйцэтгэл | |
| 1 | 2 | 3 | 4 | 5=3+4 | 6 |
| 256,391.1 | 256,391.1 | 217,729.5 | 11,780.4 | 229,509.9 | 183,608.6 |

*Эх сурвалж: Концессын гэрээ, Төсвийн тухай хууль, хөндлөнгийн шинжээчийн тайлан*

*Тайлбар:Аудитаар төслийн нийт гүйцэтгэлийг 112.6 сая ам. доллароор буюу Монголбанкны 2016 оны дундаж ханш 1 ам. 2037 төгрөгөөр тооцож баталгаажуулав*

2.17. Ийнхүү концесс эзэмшигч гэрээний 2.1.4 дүгээр зүйлд хамаарах Төмөртэйн ордоос Хандгайт өртөө чиглэлийн 36.7 км дэлгэмэл урттай 1520 мм царигтай төмөр зам, ачиж буулгах терминал барих ажил, төмөр замын барилга угсралтын өртөөний 1382м$^2$ барилга, 1080м$^2$ депогийн барилга, 75м$^2$ уурын зуух, цооног, гүний худаг болон Төмөртэйн өртөөний ажилчдын 24 айлын орон сууцны барилгын инженерийн байгууламж, дохиолол холбоо, өртөөний байгууламж барих ажлыг зохих стандартын дагуу гүйцэтгэсэн байна.

[10] *Монголбанкны 2014 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн ханш ам.долларын ханш 1872 төгрөг*

2.18. "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК-ийн 2015 оны 1-3/3265 болон "Кью Эс Си" ХХК 2015 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн 1/134 дугаартай албан бичгээр "Хандгайт өртөөнөөс Төмөртэйн уурхай хүртэлх 22.9 км гол зам, бусад салаа зам болон төмөр замын барилгын ажлыг гүйцэтгэж дуусган, Улсын комисс ажилласан тул байнгын ашиглалтад авах хүсэлтийг ЗТЯ-д хүргүүлжээ.

2.19. "Кью Эс Си" ХХК нь концессын гэрээний 2.1.4-т тусгасан "Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд орших Төмөртэйн ордоос тус аймгийн Ерөө суманд орших "Болд Төмөр Ерөө Гол" ХХК-ийн төмөр замын Хандгайт өртөө хүртэлх төмөр замын ачиж, буулгах терминалыг Улсын комисст 2015 оны 12 дугаар сарын 28-ны өдөр хүлээлгэн өгсөн байна.

2.20. Концесс эзэмшигч 2015 онд Эдийн засгийн хөгжлийн яаманд 1/139, Гадаадын хөрөнгө оруулалтын газарт /хуучин нэрээр/ 1/141, мөн Монголын төмөр зам" ТӨХК-д 2016 онд 1/41 дугаартай албан бичгээр дээрх концессын зүйлийг хүлээлцэх тухай хүсэлтийг тус тус хүргүүлжээ.

2.21. "Монголын төмөр зам" ТӨХК-ийн 2016 онд Сангийн яаманд илгээсэн 01/164 дугаар албан бичигт[11] "Энэхүү төмөр зам нь одоо хэрэгжүүлж байгаа төслүүдтэй чанар болон төсөвт өртгийн хувьд дүйцэж байгаа бөгөөд төмөр замын ажлын төсөв, төмөр замын барилгын ажлын гүйцэтгүүлэх гэрээ зэрэг баримт бичгүүдэд үндэслэн 112.66 сая ам.доллароор тооцон хүлээн авч байгаа болно" гэсэн байна.

2.22. Улсын комисс барилга, байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авсан актыг үндэслэн захиалагч байгууллага болон Төсвийн ерөнхийлөн захирагчаас тухайн үл хөдлөх хөрөнгийг төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд эзэмшүүлэх саналыг ТӨБЗГ-т хүргүүлж шийдвэрлүүлсэн хэдий ч эзэмшигч байгууллага буюу "Монголын төмөр зам" ТӨХК-ийн тайлан тэнцэлд бүртгэлгүй, үйл ажиллагаа явуулж байна.

**Авто зам барих ажлыг баталсан зураг төсвийн дагуу зохих норм стандартын дагуу гүйцэтгэсэн байна.**

2.23. "Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төслийг хэрэгжүүлэх концессын гэрээ" 2015 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн нэмэлт гэрээгээр дараах байдлаар өөрчилсөн байна[12]. Тухайлбал:

- *Гэрээний 2.1.1-2.1.3 дахь заалтыг "шинэчлэн сайжруулах-барих-ашиглах шилжүүлэх, 2.1.4-2.1.6 дахь заалтыг "барих-шилжүүлэх" төрлөөр хэрэгжүүлнэ" гэж;*
- *Гэрээний 2.1.5 дахь хэсгийг "Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд орших Төмөртэйн ордоос Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сум-Улаанбаатар чиглэлийн олон улсын авто замын Дулаанхааны дөрвөн замын уулзвар хүртэл 95 км хатуу хучилттай авто зам" гэж тус тус өөрчилжээ.*

2.24. Зам, тээврийн яамны 2015 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 25/15 дугаартай ажлын даалгавраар "Сэлэнгэ аймгийн Дулаанхааны 4-н замын уулзвар-Ерөө-Хүдэр чиглэлийн хатуу хучилттай авто замын ТЭЗҮ болон инженерийн нарийвчилсан зураг

[11] *"Монголын төмөр зам" ТӨХК-ийн 2016 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн "01/164 дугаар албан бичиг*

[12] *Концессын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-т "Гэрээний талууд харилцан тохиролцож концессын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно", "Засгийн газрын 2015 оны "Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай" 364 дүгээр тогтоолоор Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоолоор баталсан "Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт"-ын "Гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээ" гэсэн багананд "хүнд даацын" гэснийг хасаж, "Төсвийн хөрөнгөөр санхүүгийн дэмжлэг үзүүлэх, баталгаа гаргах эсэх" гэсэн багананд "шаардлагагүй" гэснийг "Судлан шийдвэрлэх" гэж өөрчилсөн байна. Концессын гэрээний 12.2-т "Концессын тухай хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу талууд харилцан тохиролцож энэхүү гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно".*

төсөл, ажлын тоо хэмжээг "Даваа зам" ХХК-ийн зөвлөх инженер Ж.Даваасүрэн, барилгын ажлын төсвийг Ж.Оюунжаргал нар 2015 онд боловсруулсан байна.

2.25. Авто замын барилгын ажлын зураг төслийг эксперт Р.Балжир зөвлөх Б.Минжбадам нар хянаж, "Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ-ын 2016 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 50/2016 дугаартай ерөнхий дүгнэлтээр баталгаажсан байна.

2.26. Авто замын зураг төслийг "Авто зам төсөвлөх" ЗЗБНбД 22-004-2016, "Хот тосгоны төлөвлөлт ба барилгажилт" БНбД 30-01-04, "Хот суурины гудамж зам төлөвлөлт" БНбД 32-01-04, "Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх" БНбД 22.01.01*/2006, "Барилга байгууламжийн инженерийн судалгааны нийтлэг үндэслэл" БНбД 11-07-04-ийн II хэсэг инженер геодезийн ажил, "Авто замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага" MNS4597:2014, "Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм" MNS4596:2014-н дагуу боловсруулсан байна.

2.27. Инженерийн нарийвчилсан зураг төслөөр замын зорчих хэсгийн өргөн 7.0 м, хайрган хөвөөний өргөн 1.5 м, далангийн өргөн 10.0 м болон хучилтын хийцийг хөлдөлтөөс хамгаалах үе 30 см, суурийн доод үе зохист ширхэглэлд буталсан чулуун суурь 20 см, асфальт бетон хучилт 0.05 м байхаар төлөвлөсөн байна.

2.28. Концесс эзэмшигч "Кью Эс Си" ХХК-ийн хүсэлтээр авто замын барилгын ажлын төсвийг "Арвай нутгийн зам" ХХК-ийн төсөвчин Д.Ганбат боловсруулж, мэргэшсэн төсөвчин Ч.Батмөнх хянаж, эксперт, тэргүүлэх төсөвчин Л.Баасанбат нар хянаж, Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ-ын 01/2018 дугаартай Магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажуулсан байна.

2.29. Авто замын шороон далан болон ухмал байгуулах, хиймэл байгууламж барих, суурь хучилтын болон хөвөөний ажил, замын тоноглол, тохижилт, тэмдэг, тэмдэглэгээний ажлыг гүйцэтгэгч өөрийн машин механизм, хүн хүч, үйлдвэр баазад тулгуурлан нийт 2 жилийн хугацаанд хийж гүйцэтгэсэн бөгөөд авто замын ажлын захиалагчийн нэрийн өмнөөс "Мөнхөд ашдын зам" ХХК гүйцэтгэж, авто замын барилгын ажлын үе шат бүрд зөвлөх өдөр тутмын хяналт хийж баталгаажуулсан.

2.30. Аудитаар шинжээчдийн баг Монгол Улсад мөрдөж буй стандарт, норм дүрэм, аргачлалын дагуу тус авто замын техник-ашиглалтын түвшин тодорхойлох хэмжилт, туршилтын ажил болон авто зам, замын байгууламжийн чанар байдлыг гүйцэтгэж, тулган баталгаажуулалтыг хийв.

2.31. Хэмжилт судалгааны ажлаар Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд орших Төмөртэйн ордоос Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сум-Улаанбаатар чиглэлийн олон улсын авто замын Дулаанхааны дөрвөн замын уулзвар хүртэл 95 км даацын хатуу хучилттай авто замын техник ашиглалтын үзүүлэлтэд хэмжилт хийж, холбогдох норм стандарт, зураг төслийн шаардлагад "нийцсэн" гэж үнэлсэн байна.

2.32. Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд орших Төмөртэйн ордоос Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сум-Улаанбаатар чиглэлийн олон улсын авто замын Дулаанхааны дөрвөн замын уулзвар хүртэл 95 км даацын хатуу хучилттай авто зам барих төслийг барихад Улаанбаатар хотын банкнаас 2015-2016 онд авсан 26,163.7 сая төгрөгийн 13 хувийн хүүтэй зээлийн болон компанийн хөрөнгийн эх үүсвэрээр гүйцэтгэсэн байна.

2.33. Засгийн газрын 2015 оны 364 дүгээр тогтоолын 3-т "*Энэ тогтоолын 2 дугаар зүйлд заасан ажлыг ашиглалтад хүлээлгэн өгсний дараа тус ажлыг хийж гүйцэтгэхтэй холбогдуулан концесс эзэмшигчийн оруулсан бодит хөрөнгө оруулалтыг концессын гэрээний дагуу 2016-2020 оны улсын төсөвт тусган санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд, Аж үйлдвэрийн сайд нарт тус тус даалгасугай*" гэжээ.

2.34. Дээрх шийдвэрт концессын гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулахыг ХОГ-т даалгасны дагуу концессын гэрээнд 2016 оны 7 дугаар сарын 08-ны өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр төслийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн эргэн төлөлтийг 2016-2018 онуудад олгохоор тусгасан байна. Үүнд:

*Хүснэгт 4. Эргэн төлөлтийн шинэчилсэн хуваарь*

| Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил | *Концесс эзэмшигчид төлөх* | | *Төсвийн тухай хуулиар батлагдсан дүн /сая төгрөг/* | |
|---|---|---|---|---|
| | *хугацаа* | *хувь* | *төсөвт өртөг* | *санхүүжих дүн* |
| I.1.1.3.Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд орших Төмөртэйн ордоос Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумаас Улаанбаатар чиглэлийн олон улсын авто замын Дулаанхааны дөрвөн замын уулзвар хүртэл 95 км даацын хатуу хучилттай авто зам барих төсөл | *2016 онд* | *60 хувь* | *95,272.2* | *57,163.3* |
| | *2017 онд* | *30 хувь* | | *28,581.1* |
| | *2018 онд* | *10 хувь* | | *9,527.1* |

*Эх сурвалж: ҮХГ болон концесс эзэмшигчийн хооронд байгуулсан концессын нэмэлт гэрээ*

2.35. Концессын гэрээнд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр гэрээний 2 дугаар зүйлийн 2.19-д "*.... гэрээний 2.1.5-д заасан концессын зүйлийг барьж гүйцэтгэн Улсын комисст хүлээлгэн өгсөн концесс эзэмшигчийн оруулсан бодит хөрөнгө оруулалтыг санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага ...Улсын төсөвт суулган, концесс эзэмшигчид нөхөн төлнө...*" гэжээ.

2.36. Авто замын барилгын ажлын гүйцэтгэлийг ЗТБХБ-ын сайдын 2011 оны 200 дугаар тушаалаар баталсан "Авто зам, замын байгууламжийн засварын ажлын төсвийн төсөв зохиох заавар", Авто замын барилгын ажлын төсвийн жишиг норм" БНбД81-25-07, "Төмөрбетон гүүр, хоолойн барилгын ажлын төсвийн жишиг норм" БНбД81-28-07, "Авто замын засвар арчлалтын төсвийн жишиг норм" БНбД81-26-07 суурь нормын дагуу тооцож үзэхэд авто замын барилга угсралтын ажлын бодит гүйцэтгэл төслийн үнийн дүнгээс 273.9 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байх тул ТХААГ санхүүжилтийг дахин нягтлах шаардлагатай байна. Үүнд:

*Хүснэгт 5. Авто замын хөрөнгө оруулалтын төсөв, гүйцэтгэл /сая төгрөг/*

| *Батлагдсан төсөвт өртөг* | *Концесс эзэмшигчийн тайлагнасан дүн* | *Концесс эзэмшигчид олгосон санхүүжилт* | *Аудитаар хянасан гүйцэтгэлийн дүн* | | | *Гүйцэтгэлийн зөрүү* | *Үлдэгдэл* |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | *Барилга угсралтын ажлын дүн* | *Санхүүжилтийн зардал* | *Нийт гүйцэтгэл* | | |
| *1* | *2* | *3* | *4* | *5* | *6=4+5* | *7=2-6* | *8=6-3* |
| *95,272.2* | *95,272.2* | *57,163.3* | *73,370.9* | *21,627.4* | *94,998.3* | *273.9* | *37,835.0* |

*Эх сурвалж: Концессын гэрээ, Төсвийн тухай хууль, хөндлөнгийн шинжээчийн тайлан*

2.37. "Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төсөл"-д хамааралгүй авто замын төслийг "Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт"-д баталж хэрэгжүүлсэн нь улсын төсвөөс санхүүжүүлэх нөхцөлийг бүрдүүлжээ.

2.38. "Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд орших Төмөртэйн ордоос Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сум-Улаанбаатар чиглэлийн олон улсын авто замын Дулаанхааны дөрвөн замын уулзвар хүртэл 95 км даацын хатуу хучилттай авто зам барих төсөл"-ийн батлагдсан төсөвт өртөг 95,272.2 сая төгрөгөөс 2016 онд улсын төсвөөс хөрөнгө оруулалтын эргэн төлөлтөд 57,163.63 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

2.39. Засгийн газрын 2012 оны 151 дүгээр тогтоолоор баталсан "Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах дүрэм"-ийг үндэслэн Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 215 дугаар тушаалаар байгуулсан Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс доорх байдлаар ашиглалтад хүлээн авсан байна. Үүнд:

- *Барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комиссын 2016 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 07/07/16 дугаар актад Сэлэнгэ аймгийн Дулаанхааны 4 замын уулзвараас Ерөө-Хүдэр сум чиглэлийн хатуу хучилттай 95 км авто замын барилгын эхний хэсгийн 25 км авто замын ашиглагч байгууллагыг "Сэлэнгэ АЗЗА" ТӨХК-ийг;*
- *Барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комиссын 2017 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн 07/10/17 дугаартай дүгнэлтэд дээрх авто замын II хэсгийн 40 км авто зам, замын байгууламжийн зориулалттай ашиглагч, өмчлөгчийг Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Засаг даргын Тамгын газрыг;*
- *Авто зам, замын байгууламжийг байнгын ашиглалтад оруулах 2017 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 07/17/17 дугаартай дүгнэлтэд дээрх авто замын III хэсгийн 30 км хүчин чадал бүхий авто замын ашиглагч, өмчлөгчөөр "Кью Эс Си ХХК"* байхаар *тус тус шийдвэрлэсэн байна.*

2.40. Уг хатуу хучилттай авто замыг Улсын комиссын актаар байнгын ашиглалтад оруулсан боловч ашиглагч байгууллагаар гурван өөр газрыг тодорхойлсон нь Авто замын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1[13] -т "...*нийслэл, орон нутгийн чанартай авто зам нь төрийн нийтийн өмч байна.", мөн хуулийн 17.3-т "Нийслэл, орон нутгийн чанартай авто зам, түүний зурвас газрыг эзэмшигч нь аймаг, нийслэлийн Засаг дарга, түүнээс эрх олгосон этгээд байна"* гэж заасантай нийцэхгүй байна.

2.41. Тус авто замыг төрийн нийтийн өмчид хүлээн авах, бүртгэх, ашиглагч, өмчлөгч байгууллагыг хууль, журамд нийцүүлэн тодорхойлж, зөрчлийг арилгах талаар ЗТХЯ-д хугацаатай албан шаардлага хүргүүлэхээр болсон.

2.42. Дулаанхааны дөрвөн замын уулзвараас Ерөө-Хүдэр сум чиглэлийн 95 км хатуу хучилттай авто зам баригдсанаар Сэлэнгэ аймгийн Ерөө, Хүдэр сумын иргэдийн газар тариалан, мал аж ахуй, уул уурхай, үйлдвэрлэл эрхлэлт, аялал жуулчлалын үйл ажиллагаанд стратегийн ач холбогдолтой бөгөөд улмаар ард иргэдийг ая тухтай зорчих, цаг хугацаа хэмнэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

**Эрчим хүчний барилга, байгууламжийн зураг төсөл, барилга угсралт, тоног төхөөрөмжийн угсралтын ажил нь холбогдох журам, норм дүрэм, стандартын шаардлагыг хангасан байна.**

2.43. Аудитаар концессын гэрээнд тусгасан "Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Төмөртэйн төмрийн хүдрийн уурхай хүртэлх 110 кВ-ын 50 км цахилгаан дамжуулах агаарын шугам, 110/6 кВ-ын 16000 кВА хүчин чадалтай дэд станц, 110/10 кВ-ын Ерөө дэд станцын өргөтгөлийн барилга угсралтын ажлын гүйцэтгэлийн ил, далд ажлын актыг нягтлан, тулган баталгаажууллаа.

2.44. Уг төслийн төсөвт өртгийг "Монцахэр" ХХК-ийн гүйцэтгэсэн МЦЭ12-07-I шифртэй ажлын зураг, холбогдох заавар, норм, жишиг тариф зэрэг тухайн үеийн зах зээлийн материалын үнэ ханшийг үндэслэн тэргүүлэх төсөвчин Б.Мөнхтуяа тооцоолж, зураг, төсвийг Барилгын хөгжлийн төвийн 2012 оны 11 дүгээр сарын 23-

---

[13] *Олон Улс, улсын чанартай болон тусгай зориулалтын болон нийслэл, орон нутгийн чанартай авто зам нь төрийн нийтийн өмч байна.", мөн хуулийн 17.3-т "Нийслэл, орон нутгийн чанартай авто зам, түүний зурвас газрыг эзэмшигч нь аймаг, нийслэлийн Засаг дарга, түүнээс эрх олгосон этгээд байна".*

ны өдрийн 647/2012 дугаартай магадлалын дүгнэлтээр 13,175.9 сая төгрөгөөр баталгаажуулсан байна.

*Хүснэгт 6. Экспертизээр хянагдсан төсөвт өртгийн тооцоолол /сая төгрөг/*

| Төсөв № | Төслийн нэр | Үнийн дүн. |
|---|---|---|
| 12 /45-50 | 110 кВ-ын Ерөө Хүдэрийн ЦДАШ | 9,235.8 |
| 12 /46 | Хүдэр баяжуулах үйлдвэрийн 110/6 кВ-ын хүчдэл, 16МВа чадалтай дэд өртөөний барилга угсралтын ажил | 1,865.8 |
| 12 /47 | 110/10 кВ-ын Ерөө дэд станцын өргөтгөл | 1,628.7 |
| 12 /48 | 110/10 кВ-ын Ерөө дэд станцын удирдлагын байрны барилгын өргөтгөл барилга угсралтын ажил | 163.9 |
| 12 /49 | Төмрийн хүдрийн баяжуулах үйлдвэрийн 110/6 кВ-ын дэд станцын удирдлагын байр ба ХХБ-ийн барилга барих ажил | 151.9 |
| 12 /50 | Төмрийн хүдрийн баяжуулах үйлдвэрийн 110 кВ-ын дэд станцын ариун цэврийн өрөөний барилгын ажил | 2.3 |
| | Зураг төслийн баримт бичигт шуулт хийсэн зардал | 127.5 |
| | Бүгд дүн | 13,175.9 |

*Эх сурвалж: Шинжээчийн дүгнэлт*

2.45. Цахилгаан хангамжийн системийн зураг төсөл нь техникийн шийдэл, тоног төхөөрөмжийн сонголт Цахилгаан байгууламжийн дүрэм БД43-101+03, Орон сууц олон нийтийн барилгын тоног төхөөрөмжийг төлөвлөх ба угсрах БД43-102 зэрэг дүрмийн шаардлага хангасан байна гэж БХТ-ийн 2016 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 162/2016 дугаартай магадлалын ерөнхий дүгнэлтэд дурдсан байна.

2.46. Сэлэнгэ аймгийн Ерөө сумын "Ерөө" дэд станцын өргөтгөл, Ерөө-Хүдэр сумын нутагт шинээр барих "Дархан Төмөрлөгийн Үйлдвэр" ТӨХК-ийн 110 кВ-ын ЦДАШ, 110/6 кВ-ын хүчдэл, 16000 кВА чадалтай "Төмөрийн хүдрийн баяжуулах үйлдвэр"-ийн дэд станц ажлын зураг төсөл нь бүх норм дүрэм, зургийн даалгавар, техникийн нөхцөлийг хангасан эрх бүхий байгууллагуудаар магадлал хийлгэж баталгаажсан зураг төсөл болсон гэж дүгнэсэн байна.

2.47. Сэлэнгэ аймгийн Ерөө сумын "Ерөө" дэд станцын өргөтгөл, Ерөө-Хүдэр сумын нутагт шинээр барих "Дархан Төмөрлөгийн Үйлдвэр" ТӨХК-ийн 110 кВ-ын ЦДАШ, 110/6 кВ-ын хүчдэл, 16000 кВА чадалтай "Төмрийн хүдрийн баяжуулах үйлдвэр"-ийн дэд станцын ажлыг гүйцэтгэхээр Захиалагч "Юнайтад Энержи Систем" ХХК-ийн захирал Д.Баатар, гүйцэтгэгч "Виваланд" ХХК-ийн захирал Т.Халиун нарын хооронд 2012 оны 5 дугаар сарын 25-ны өдөр 12/19 тоот гэрээг 10,255.7 сая төгрөгөөр, мөн дээрх захиалагч гүйцэтгэгч нарын хооронд 2012 оны 10 дугаар сарын 29-ний өдөр 12/10-1 дугаартай гэрээг 2,320.5 сая төгрөгөөр, нийт 12,576.1 сая төгрөгөөр тус тус байгуулсан байна.

2.48. Төслийн захиалагч "Юнайтэд энержи систем" ХХК-ийн ЭБЭХЯ-ны ЭХБГ-ын дарга П.Товуудоржийн 2012 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр баталсан зургийн даалгавраар "Сэлэнгэ аймгийн Ерөө-Хүдэр сумын нутагт шинээр барих Дархан төмөрлөгийн Үйлдвэр ТӨХК-ийн 110 кВ-ын ЦДАШ -46.1км,16000кВА чадалтай дэд станц,110/10-кв-ын Ерөө дэд станцын өргөтгөл, Төмрийн хүдэр олборлох, баяжуулах үйлдвэрийн 110/6 кВ-ын дэд станцын барилга угсралт, монтаж, туршилт тохируулгын ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

2.49. "Төвийн бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ" ТӨХК 2012 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн 09/2012 дугаар 110/10 кВ-ын Ерөө дэд станцаас "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК-ийн Хүдрийн баяжуулах үйлдвэрийн гадна цахилгаан хангамжид олгосон техникийн нөхцөлөөр шинэчлэлийн техникийн асуудлыг шийдвэрлэж, Эрдэс баялаг, ЭХЯ-ны Эрчим хүчний бодлогын газраас 2012 оны 04

дүгээр сарын 30-ны өдрийн 2012/46Ц дугаартай 110/10 кВ-ын Ерөө дэд станцын өртгөтөл, "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК-ийн Хүдрийн баяжуулах үйлдвэрийн 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам дэд станцын баталсан зураг төсөл боловсруулах даалгаврын дагуу хийсэн байна.

2.50. "Мон цахэр" ХХК-ийн Ерөнхий захирал И.Ганбаатар "Юнайтед энержи систем" ХХК-ийн Ерөнхий захирал Д.Баатар нарын хооронд байгуулсан зураг төсөл боловсруулах 2012 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 04/12 тоот гэрээнд үндэслэн боловсруулж, Барилгын хөгжлийн төвийн 2012 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 647/2012 дугаартай магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажуулсан байна.

2.51. Төмөртэйн өртөө нь уурхайн технологийн зориулалтай 110/6 кВа-гийн трансформаторын 6 кВт шугам татаж өртөөний хажууд 250 кВ-ын 2 ш трансформатор бүхий КТПН байгуулж үндсэн тэжээлээр хангасан, өртөөний барилгын нөөц эх үүсвэр 250 кВа чадалтай генераторыг суурилуулсан, мөн өртөөний дохиолол болон түүний зам, сумын төвлөрүүлэлтийн байгууламжуудын хэвийн ажиллагааг хангах зорилгоор UPS нөөц тэжээл суурилуулсан тухай Барилга байгууламж хүлээлгэн өгсөн актад тодорхойлжээ.

2.52. Концесс эзэмшигч "Сэлэнгэ аймгийн Ерөө сумаас Хүдэр сумын Төмөртэй уурхай хүртэл 110 кВт-ын 50 км цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын барилга байгууламжийг барих ажлыг Улаанбаатар хотын банкнаас 2013-2015 онд жилийн 10 хувийн хүүтэй 17,112.0 сая төгрөгийн зээл авч гүйцэтгэсэн байна.

2.53. Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуулийн 4 дүгээр хавсралтаар *"Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлэх векселиэр төлбөр гүйцэтгэсэн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт"*-ын XIV.1.31-т "Сэлэнгэ аймгийн Ерөө сумаас Хүдэр сумын Төмөртэй уурхай хүртэл 110 кВт-ын 50 км цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын нийт төсөвт өртөг 12,576.2 сая төгрөг, 2016 онд санхүүжих дүн 12,576.2 сая төгрөг гэж батлсны дагуу концесс эзэмшигчид эргэн төлөлтийг бүрэн олгосон байна.

2.54. Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Төмөртэйн төмрийн хүдрийн уурхай хүртэлх 110 кВ-ын 50 км цахилгаан дамжуулах агаарын шугам, 10/6 кВ-ын 16000 кВ хүчин чадалтай дэд станц, 110/10 кВ-ын Ерөө дэд станцын өргөтгөлийн эрчим хүчний барилга, байгууламж нь баталсан зураг төслийн хүрээнд Цахилгаан эрчим хүчийг дамжуулах зориулалтаар 2014 онд концессын зүйлийг бүрэн дуусгаж хүлээлгэн өгөхөөр концессын гэрээ байгуулж, Улсын комиссын 11/2014 дугаартай актаар 2014 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн цахилгаан эрчим хүч дамжуулах зориулалтаар "ЦДҮС" ТӨХК-д 2014 оны 5 дугаар сарын 15-ны өдрөөс ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн байна.

2.55. Эрчим хүчний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т "Эрчим хүч дамжуулах шугам, дэд станц нь төрийн өмчлөлд байна" гэж заасны дагуу Цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын барилга байгууламжийн ажлыг төрийн өмчид хүлээн авч, ашиглагч байгууллагад ("ЦДҮС" ТӨХК) шилжүүлээгүй байна.

**Концессын зүйлийн эргэн төлөлтийн санхүүжилтийг төсөвт тусган концесс эзэмшигчид олгожээ.**

2.56. Засгийн газрын 2016 оны "Зарим төсөл, арга хэмжээний төлбөрийг векселиэр баталгаажуулах тухай" 72 дугаар тогтоолоор Монгол Улсын 2016 оны төсвийн тухай

хуулийн 2 дугаар хавсралтад тусгасан "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байсан зарим төсөл, арга хэмжээний төлбөрийг векселиэр баталгаажуулах тухай" Засгийн газрын 2015 оны 282 дугаар тогтоолд векселиэр санхүүжүүлэхээр заасан төсөл арга хэмжээний төлбөрийн санхүүжилтийг үргэлжлүүлэн олгож дуусгахыг Сангийн сайд Б.Болорт даалгасан байна.

2.57. Засгийн газрын 2016 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн "Концессын зүйлийг төрийн өмчид шилжүүлэн авах тухай" 77 дугаар тогтоолын дагуу[14] "Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд орших Төмөртэйн ордоос тус аймгийн Ерөө суманд орших "Болд Төмөр Ерөө Гол" ХХК-ийн төмөр замын Хандгайт өртөө хүртэлх ... төмөр замыг ачиж, буулгах терминалын хамт төрийн өмчит "Монголын төмөр зам" ХХК-ийн өмчид шилжүүлэн авч, концесс эзэмшигчийн төсөлд оруулсан бодит хөрөнгө оруулалтыг улсын төсөвт тусгах, эсхүл векселиэр санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд, Аж үйлдвэрийн сайд, "Монголын төмөр зам" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд тус тус даалгасан байна.

2.58. Дээрх шийдвэрийг үндэслэн концесс эзэмшигч 2016 оны 02 дугаар сарын 19-ний өдөр Аж үйлдвэрийн сайдад "Концессын зүйлийн бодит хөрөнгө оруулалт тооцох тухай" 1/15 дугаартай албан бичиг илгээж, гэрээний 1.1-ийн заалтыг үндэслэн төслийн санхүүжилтийн зардал 5.7 сая ам.долларыг ажил гүйцэтгэх гэрээний үнэ 106.9 сая ам. доллар дээр нэмж тооцон, нийт 112.66 сая ам.долларыг концессын гэрээний дагуу оруулсан бодит хөрөнгө оруулалтад тооцон баталгаажуулж, концессын төлбөрийг санхүүжүүлж өгөх хүсэлт гаргасан байна.

2.59. Үүний дагуу Аж үйлдвэрийн сайдаас[15] "Кью Эс Си" ХХК-ийн концессын зүйлд оруулсан бодит хөрөнгө оруулалт 112.66 сая ам. долларыг улсын төсөвт тусгах, эсхүл хүүтэй векселээр санхүүжүүлэх замаар концессын төлбөрийг төлөх саналыг Сангийн сайдад хүргүүлжээ.

2.60. Концесс эзэмшигч "Кью Эс Си" ХХК-ийн 2016 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн Сангийн сайдад илгээсэн 1/17 дугаартай албан бичигт "...концесс эзэмшигчээс төсөлд зарцуулсан бодит хөрөнгө оруулалт болох 112.66 сая ам.долларын 80 хувь буюу 90.1 сая ам.долларыг Концессын гэрээний 2.20[16]дахь хэсгийн дагуу хүүтэй, шилжих векселээр санхүүжүүлэх замаар концессын төлбөрийг олгож өгнө үү" гэсэн хүсэлтийг хүргүүлсэн байна.

2.61. Сангийн сайдын 2016 оны "Тогтоол хэрэгжүүлэх арга хэмжээний тухай" 72 дугаар тушаалаар "Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төслийг хэрэгжүүлэх концессын гэрээ"-ний дагуу "барих-шилжүүлэх" төрлөөр хэрэгжүүлсэн концессын зүйлийг "Монголын төмөр зам" ХХК-ийн өмчид шилжүүлэн авсантай холбогдуулан гэрээний дагуу 2016 онд төлөх бодит хөрөнгө оруулалтын 80 хувь буюу 90.1 сая ам.доллартой тэнцэх төгрөгийг жилийн 14.941 хувийн хүүтэй шилжих вексель хэлбэрээр баталгаажуулан концесс эзэмшигчид олгох арга хэмжээ авахыг Сангийн яамны холбогдох албан тушаалтнуудад[17] үүрэг болгожээ.

---

[14] *ТБОНӨТХ-ийн 6 дугаар зүйлийн 1.6, УИХ-ын 2010 оны 32 дугаар тогтоолоор батлсан "Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого"-ын 6.3.1, 6.4.1-д заалт*

[15] *Аж үйлдвэрийн сайдын 2016 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн 01/519 дугаартай албан бичгээр Сангийн сайдад "Концессын зүйл хүлээн авах тухай" албан бичигт[15] "...Кью Эс Си" ХХК-ийн концессын зүйлд оруулсан бодит хөрөнгө оруулалт болох 112.66 сая ам. долларыг улсын төсөвт тусгах, эсхүл хүүтэй векселээр санхүүжүүлэх замаар концессын төлбөрийг төлөх саналтай байна" гэжээ.*

[16] *" ...концессын зүйлийг хүлээлгэн өгөх бүхий этгээдэд шилжүүлж болох..."*

[17] *Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын газрын дарга А.Мөнхбаясгалан, Санхүүгийн бодлогын газрын Б.Нямаа, Хөгжлийн санхүүжилт, өрийн удирдлагын газрын дарга Б.Гантулга*

2.62. Дээрх тушаалаар баталсан "Төлбөр гүйцэтгэх акт"-ын 1.7-[18]д "гэрээний дагуу 2016 онд онд төлөх бодит хөрөнгө оруулалтын 80 хувь болох 90.1 сая ам.доллартой тэнцэх төгрөгийг жилийн 14.941 хувийн хүүтэй шилжих вексель хэлбэрээр концесс эзэмшигчид олгож баталгаажуулах арга хэмжээ авах", мөн 2.1-д "... бодит хөрөнгө оруулалтын 80 хувь болох дараах төлбөрийг шилжих вексель хэлбэрээр эзэмшүүлэв" гэсэн байна.

2.63. Төлбөр гүйцэтгэх актын 2.2-т "Кью Эс Си" ХХК нь энэхүү актын 2.1-т заасан дүн болон энэхүү актын талаар аливаа гомдол, нэхэмжлэл гаргах, маргах эрхгүй болохыг хүлээн зөвшөөрөв" гэж талууд[19] гарын үсэг зурж баталгаажуулсан байна.

2.64. Концессын гэрээний 1.1-д төслийн "Бодит хөрөнгө оруулалт"-ыг тухайн концессын зүйлийг барьж, эрх бүхий байгууллагад хүлээлгэн өгөх хүртэл хугацаанд гарсан төслийн үндсэн төсөв, санхүүжилтийн зардал, өртөг болон бусад баримтаар нотлогдсон концессын зүйлтэй холбоотой бүхий л зардлуудыг багтаасныг хэлнэ" гэжээ.

2.65. Эрх бүхий байгууллагаас Концессын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.5-т "концесс эзэмшигчийн гүйцэтгэх ажил, эсхүл үзүүлэх үйлчилгээний төлөө эрх бүхий этгээд төлбөр төлөхөөр бол түүний хэмжээ" гэснийг мөрдөөгүй, "Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төслийг хэрэгжүүлэх концессын гэрээ"-нд төслийн үнийн дүнг тодорхой тусгаагүй байна.

2.66. Концессын "барих-шилжүүлэх" төрлөөр хэрэгжүүлсэн доорх төсөл арга хэмжээний эргэн төлөлтөд 2016 онд концесс эзэмшигчид улсын төсвөөс нийт 253.348.1 сая төгрөгийг олгосон байна. Үүнд:

Хүснэгт 7. Концессын гэрээний дагуу улсын төсвөөс олгосон санхүүжилтийн мэдээлэл */сая төгрөг/*

| Концессын "барих-шилжүүлэх" төрлөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний нэр | Батлагдсан төсөв | Концесс эзэмшигчид олгосон дүн | Огноо |
|---|---|---|---|
| 1.Сэлэнгэ аймаг Дулаанхааны 4-н замын уулзвар-Ерөө-Хүдэр чиглэлийн 95км хатуу хучилттай зам[20] | 95,272.2 | 57,163.3 | 2016-12-28 |
| 2."Болд төмөр Ерөө гол" ХХК-ийн Хандгайт өртөөнөөс "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК-ийн Төмөртэйн уурхай чиглэлийн 22.9 км /36.56/ төмөр зам, өртөөний хүлээн авах, явуулах зам, салбар замууд, инженерийн байгууламж, дохиолол холбоо, өртөөний байгууламж | 256,391,1 | 183,608.6 | 2016-02-26 |
| 3.Сэлэнгэ аймгийн Ерөө сумаас Хүдэр сумын Төмөртэйн уурхай хүртэл 110 кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугам (50км), өргөтгөл, дэд станцын хамт барих | 12,576.2 | 12,576.2 | 2016-12-28 |
| **Нийт дүн** | **364,239.5** | **253,348.1** | |

*Эх сурвалж:Сангийн яам, Үндэсний хөгжлийн газар*

2.67. Эрх бүхий байгууллагууд Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.3[21], 4.5[22], 4.5.7[23] дахь заалтуудыг тус тус мөрдөөгүй байна.

*[18] "... концесс эзэмшигчийн оруулсан бодит хөрөнгө оруулалтыг санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дараах хуваарийн дагуу улсын төсөвт суулгаж, концесс эзэмшигчид нөхөн төлнө": 2016 онд 80 хувь, 2017, 2018, 2019, 2020 онд тус бүр 5 хувь"*

*[19] Сангийн яамыг төлөөлж Төсвийн хөрөнгө оруулалтын газрын мэргэжилтэн болон "Кью Эс Си" ХХК-ийг төлөөлж гүйцэтгэх захирал болон нягтлан бодогч нар гарын үсэг зурсан байна.*

*[20] ҮХГ-ын 900008315 дугаартай данснаас 2016.12.28-ны өдөр "Кью Эс Си" ХХК-ийн дансруу гүйлгээ хийсэн байна.*

*[21] Захиалагч байгууллага төсвийн хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлийг барилгын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын батлан гаргасан норм, норматив, болон тухайн барилгын ажлын батлагдсан зураг төсөл, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээгээр тохирсон барилгын ажлын төлөвлөгөөг үндэслэн ажил нэг бүрээр нь тулган шалгаж, баталгаажуулна.*

*[22] Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгжийн мэргэжилтэн хянаж баталгаажуулсан гарын үсэг бүхий албан тоот, холбогдох материалыг ..."Хяналтын хүснэгт"-д тусгагдсан шалгуур үзүүлэлт, шаардлагуудыг хангаж байгаа эсэхийг ... үндэслэн 2 хоногийн дотор санхүүжүүлнэ.*

*[23] Захиалагчийг төлөөлсөн эрх бүхий албан тушаалтнуудын гарын үсэг, тамга, тэмдгээр баталгаажсан барилгын ажлын гүйцэтгэл /энэ журмын 4, 5-р хавсралтаар батлагдсан маягтын дагуу/ гаргана.*

2.68. Засгийн газрын 2018 оны 6 дугаар тогтоолоор[24] "Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай" Засгийн газрын 2015 оны 364 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцож, концессын "барих-шилжүүлэх" төрлөөр 2015 оны 10 дугаар сарын 02-ны өдөр байгуулсан нэмэлт гэрээг цуцлахыг ҮХГ-т, "Сэлэнгэ аймгаар дамжин өнгөрөх олон улсын авто замтай холбох 95 км авто замын ажил" болон "Төмөртэйн ордоос Хандгайт өртөө чиглэлийн 1520 мм царигтай төмөр зам, өртөө, ачиж буулгах терминал барих" төсөлд зориулан концесс эзэмшигчид олгосон хөрөнгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлэх арга хэмжээ авахыг Сангийн яам, ЗТХЯ-д тус тус даалгасан байх боловч аудит хийх үед дээрх шийдвэр хэрэгжээгүй байна.

2.69. ҮХГ-аас 2018 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр "Кью Эс Си" ХХК-д "Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төсөл"-ийн концессын 2015 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн нэмэлт гэрээ болон 2016 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн нэмэлт гэрээ-2-ийг тус тус цуцалж байгаа тухай, 2020 оны 6 дугаар сарын 12-ны өдөр "Санхүүжилтийг буцаан шилжүүлэх тухай" 01/1064 дугаартай албан бичгээр улсын төсвөөс олгосон вексель болон санхүүжилтийг ҮХГ-ын дансанд буцаан шилжүүлэх талаар тус тус мэдэгдэл хүргүүлсэн байна.

**Эрх бүхий байгууллагаас концессын гэрээний хэрэгжилтэд үнэлгээ хийгээгүй байна.**

2.70. "Кью Эс Си" ХХК концессын зүйлтэй холбоотой онцгой эрхийн дагуу "Дарханы төмөрлөгийн үйлдвэр"-ийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдлага зохион байгуулалтаар хангаж ажилладаг бөгөөд төслийн хөрөнгө оруулалтыг техник, тоног төхөөрөмж, түүхий эд, бараа материал зэрэг хөрөнгө, биет болон биет бус хөрөнгө хэлбэрээр бүрдүүлж төслийн үйл ажиллагаанд зарцуулж иржээ[25].

2.71. "Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төслийг хэрэгжүүлэх концессын гэрээ"-ний 8.3[26]-т заасны дагуу концесс эзэмшигч 2017-2019 онд төслийн хүрээнд хийсэн ажлын мэдээ, тайланг гарган Үндэсний хөгжлийн газарт ирүүлсэн бөгөөд төсөл хэрэгжиж эхэлснээс хойш нийт 630,841.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн гэж тайлагнасан байна.

2.72. Концессын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага гэрээний 8.4[27]-т заасны дагуу концесс эзэмшигчээс ирүүлсэн тайлан, мэдээг нягталж, гэрээний хэрэгжилтэд тавих чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.

2.73. Концессын гэрээний 8.4-т "Эрх бүхий этгээд нь холбогдох төрийн захиргааны байгууллагын төлөөллийг оролцуулан энэхүү гэрээний хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан ажиллуулж болно" гэсэн байна.

2.74. УУХҮ-ийн сайдын 2019 оны А/136 дугаар тушаалаар "Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төсөл хэрэгжүүлэх концессын гэрээ"-ний хэрэгжилттэй танилцах, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулж, төслийн хөрөнгө оруулалтын бодит гүйцэтгэл, санхүүгийн үйл

---

*[24]Концессын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2-т "Концессын гэрээг ... эрх бүхий этгээдийн санаачилгаар цуцална:*
*24.2.4.үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах болон нийтийн эрх ашгийн үүднээс концессын гэрээг цуцлахаар Засгийн газар шийдвэрлэсэн*

*[25] Концессын гэрээний 6.20-д "концесс эзэмшигч нь бэлэн мөнгө, техник, тоног төхөөрөмж, түүхий эд, бараа материал зэрэг хөрөнгө, оюуны болон аж үйлдвэрийн өмчийн эрхийн биет бус хөрөнгө зэрэг бүх хэлбэрээр хөрөнгө оруулалт хийх.*

*[26] "Концесс эзэмшигч нь жилийн эцэст гэрээний хэрэгжилтийн талаар тайлан мэдээг гарган Эрх бүхий этгээдэд ирүүлэх үүрэгтэй".*

*[27] Концессын гэрээний 8.4-т "Эрх бүхий этгээд ирүүлсэн тайлан, мэдээг нягтална..." .*

ажиллагаанд мэргэжлийн багаас бүрдсэн ажлын хэсгийг ажиллуулах нь зүйтэй гэж дүгнэсэн боловч тодорхой ажлууд хийгээгүй байна.

2.75. Засгийн газрын 2020 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн 51 дүгээр тэмдэглэлээр төслийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, гангийн үйлдвэрийн бүтээн байгуулалтын бэлтгэл ажлыг гүйцэтгэж, шаардлагатай цахилгаан, эрчим хүчний дэд бүтцийн асуудлыг судалж, үе шаттай шийдвэрлэх арга хэмжээ авахыг УУХҮЯ, ЭХЯ болон Дархан-Уул аймгийн Засаг даргад даалгасан байна.

2.76. Үүний дагуу УУХҮС-ын 2020 оны А/268 дугаар тушаалаар "Уул уурхайн металлургийн цогцолбор төсөл"-ийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, гангийн үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэх төлөвлөгөө боловсруулан батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулжээ.

2.77. "Уул уурхайн металлургийн цогцолбор төслийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, гангийн үйлдвэрийн бүтээн байгуулалтын бэлтгэл ажлыг гүйцэтгэх төлөвлөгөө"-г УУХҮС-ын 2020 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн А/314 дүгээр тушаалаар баталсан боловч хэрэгжилт удаашралтай байна. Энэ нь уг төлөвлөгөөний хэрэгжилт хангуулж, хяналт тавьж ажиллах холбогдох албан тушаалтны удирдлага, зохион байгуулалтын үйл ажиллагаа сул байгаатай холбоотой байна.

**Төмрийн хүдрийн хуурай болон нойтон аргын баяжмал үйлдвэрлэх үйлдвэрийг ашиглалтад оруулжээ.**

2.78. Төмөртэйн орд нь нийт 229.3 сая.тн төмрийн хүдрийн нөөцтэй байна. Ордын дундаж агуулга 51.49%, Зүүн болон Баруун 2 хэсгээс бүрдэх бөгөөд Зүүн хэсэг нь Баруун, Зүүн 2 биетээс бүрддэг бөгөөд 2011 онд Төмөртэйн зүүний баруун биетийн уурхайг ашиглаж эхэлсэн байна.

2.79. Концессын гэрээний 2.1.1-т "Хуст-Уул, Төмөртолгой, Төмөртэйн ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулж, жилд 3.0 саяас доошгүй тонн төмрийн хүдэр олборлох, жилд 1.5 саяас доошгүй тонн төмрийн хүдрийн хуурай болон нойтон аргын баяжмал үйлдвэрлэх үйлдвэр байгуулах" гэсний дагуу концесс эзэмшигч дараах ажлыг гүйцэтгэсэн байна. Үүнд:

- *Төмөртэй уурхайд төмрийн хүдэр олборлолтыг 2014 оноос өнөөдрийг хүртэл явуулж олборлох хүчин чадал жилийн 3 сая тонн, баяжмал үйлдвэрлэх хүчин чадал жилийн 2.1 сая тонн болсон;*
- *Төмөртэйн ордод жилд 2.0 саяас тонн хүдэр боловсруулж, жилд 1.4 тонн төмрийн баяжмал үйлдвэрлэх хүчин чадал бүхий АНУ-ын TRIO брэндийн хуурай соронзон аргын баяжуулах үйлдвэрийг 2013-2014 онд байгуулж, 2015 оны 9 дүгээр сарын 20-ны өдөр ашиглалтад оруулж Улсын комисст хүлээлгэн өгсөн бөгөөд уг үйлдвэр нь 750 тонн/цагийн хүчин чадалтай ба 55%-60%-ийн төмрийн агуулгатай баяжмал, 40%-55% төмрийн агуулгатай завсрын бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна;*
- *Баяжуулах үйлдвэр 2014-2019 оны хооронд нийт 6.5 сая тонн төмрийн хүдэр баяжуулан, 4 сая тонн чанарын шаардлага хангасан өндөр агуулгатай баяжмал үйлдвэрлэж, 2019 онд баяжуулах үйлдвэр дээр технологийн сайжруулалт хийж бүтээгдэхүүнийхээ чанарыг сайжруулж 62%-ийн төмрийн агуулга бүхий нунтаг баяжмалыг угааж, баяжмал дахь шавар болон хоосон чулуулгийг салгаж баяжмалын чанарыг сайжруулах зорилготой баяжмал угаах шугамын төслийг хэрэгжүүлж эхэлсэн;*
- *Тус үйлдвэр нь Combo Alpha A400 маркийн угаах төхөөрөмж бөгөөд цагт 100-120 тонн баяжмал угаах хүчин чадалтай, эргэлтийн усыг 95% хүртэл эргүүлэн ашигладаг бағц тоног төхөөрөмж бөгөөд жилд 431,200 тонн баяжмал угааж, 85%-ийн гарцтайгаар 366,520 тонн угаасан баяжмал үйлдвэрлэх хүчин чадалтай байна;Тээврийн хүрэлцээгүй байдал болон зах зээлийн үнээс шалтгаалан Хуст-Уул уурхайн үйл ажиллагааг эхлээгүй;*

- *Концесс эзэмшигчийн зүгээс шаардлагатай хөрөнгө оруулалтыг хийсэн болович баяжмал бүтээгдэхүүний зах зээлийн үнэ 2014-2019 он хүртэл төсөөллөөс 2-3 дахин доогуур байсан нь төслийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлсөн байна.*

2.80. Төмөртэйн ордод жилд 3.5 сая тонн хүдэр боловсруулж, жилд 2.4 сая тонн төмрийн баяжмал үйлдвэрлэх хүчин чадал бүхий хуурай соронзон аргын баяжуулах үйлдвэрийг 2014 оны 7 дугаар сарын 01-ний өдөр ашиглалтад оруулж Улсын комисст хүлээлгэн өгсөн байна.

2.81. Төмөртэйн ордын Зүүн хэсгийн зүүн биетэд 2014 оны 6 дугаар сараас хайгуулын ажлыг эхлүүлж, Зүүн хэсгийн баруун биетэд ил уурхай байгуулсан ба ТЭЗҮ-ийн дагуу жилд 1 сая тонн хүдэр олборлох хүчин чадалтай байна.

2.82. Төмөртэйн ордод жилд 1 сая тонн хүдэр боловсруулж, 700.0 мянган тонн 65 хувийн агууламжтай баяжмал үйлдвэрлэх хүчин чадалтай нойтон соронзон баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийг ашиглалтад оруулж, цехийн барилгыг 2014 оны 12 дугаар сарын 15-ны өдөр Улсын комисст хүлээлгэн өгчээ.

2.83. Хуурай аргын баяжуулалтын дараагийн шат болох нойтон баяжуулах үйлдвэрийг жилийн 1 сая тонн боловсруулах хүчин чадалтайгаар үйлдвэрийн түүхий эдээр хангах зориулалтаар Гангийн үйлдвэрийн дэргэд барьж байгуулсан байна.

2.84. Концессын гэрээний 2.1.2-т "Жилд 500.0 мянгаас доошгүй тонн хүчин чадал бүхий шууд ангижруулсан төмрийн үйлдвэр" гэсний дагуу концесс эзэмшигчийн гүйцэтгэсэн ажлыг дурдвал,

- *Шууд ангижруулсан төмрийн үйлдвэр барих талбайн инженер геологийн судалгааны ажлыг хийж, үйлдвэрийн ТЭЗҮ боловсруулах ажлыг 2016 оны 4 дүгээр сард эхлүүлж Канад Улсын "Хатч" компаниар хийлгэж дуусгасан;*

- *Шууд ангижруулсан төмрийн үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажил концессын гэрээний 2.6-д зааснаар 2018 оны 4 дүгээр сард дуусаж, ашиглалтад бүрэн орохоор төлөвлөсөн болович зөвхөн концессын зүйлийн зураг төсөл, судалгааны ажлууд хийгдсэн болович цахилгаан эрчим хүчний эх үүсгэврийн болон дэд бүтцийн асуудал шийдвэрлэгдээгүйгээс төслийн явц удаашралтай байна. Улмаар цахилгаан эрчим хүч бага зарцуулдаг технологийн шийдлийг гарган ТЭЗҮ дахин боловсруулж, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хүнд үйлдвэрийн салбар хуралдаанаар хэлэлцүүлэхээр УУХҮЯ-нд 2021 оны 7 дугаар сард хүргүүлсэн байна.*

2.85. "Концессын гэрээний 2.1.3-т "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК-ийн хүчин чадлыг жилийн 300 мянган тоннд хүргэх өргөтгөл, шинэчлэл хийх (төмрийн хүдэр боловсруулж эцсийн бүтээгдэхүүн гаргах) гэсний дагуу дараах ажлыг хийжээ. Үүнд:

- *Гангийн үйлдвэрийг өргөтгөх, шинэчлэх, бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах ажлын хүрээнд жилд 25.0 мянган тонн 100-140 мм-ийн голчтой тээрмийн ган бөмбөлөг үйлдвэрлэх хүчин чадалтай Евро стандартын давтах аргын ган бөмбөлгийн үйлдвэрийг 2016 онд, бэлдэц үйлдвэрлэх цех дэх 25 тонн багтаамжтай шанаган зуухны тоног төхөөрөмж, барилга байгууламжийг 2017 онд, бэлдэц үйлдвэрлэх цехийн 6/0.4 кв-ын 1600 Ква дэд станц, үйлдвэрийн 110/22/6.6 кВ-ын Төмөрлөгийн дэд станцыг 110/22 кв-ын 6.3 МВА дэд станцаар өргөтгөсөн үйлдвэрийн өргөтгөл, 22 кв-ын цахилгаан дамжуулах кабелийн шугамын барилгыг 2018 онд тус тус хийж гүйцэтгэн Улсын комисст хүлээлгэн өгсөн байна.*
- *Хаягдал төмрийг боловсруулах пресс хайчны тоног төхөөрөмжийн угсралт, барилга байгууламжийг 2018 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр Техникийн комисст хүлээлгэн өгсөн байна.*
- *Концесс эзэмшигч төслийн технологийн усны хэрэгцээг хангах зорилгоор усан хөргөлтийн цамхаг шинээр суурилуулсан байна. Энэ нь бүтээгдэхүүний өртөг зардал бууруулах, хөдөлмөрийн бүтээмж нэмэгдүүлэх, ажил хөнгөвчлөхөд ач холбогдолтой болсон байна. Мөн ган бүтээгдэхүүний чанарыг сайжруулах зорилгоор тасралтгүй цутгах машинд орчин үеийн технологи болох цахилгаан соронзон хуйлруулагчийг Danieli компаниар хийлгэн угсарч суурилуулан ашиглалтад оруулжээ.*
- *Төмрийн хүдрээс түүхий эд гарган авах Шууд ангижруулсан төмрийн үйлдвэр барихаар Outotec компанийн технологийн үндсэн инженерингийн дизайныг боловсруулж 2016 онд дуусган бэлэн болгожээ.*

2.86. Гангийн үйлдвэр байгуулахад шууд ангижруулсан төмрийн үйлдвэрийн технологийн сонголттойгоор явахад 170 МВА эрчим хүчний эх үүсвэр, ачааллын хэрэгцээ гарч байгаа тул *эрчим хүчний хэрэглээ багатай цогцолбор үйлдвэрийн ТЭЗҮ боловсруулж, Эрдэс баялгийн зөвлөлийн Хүнд үйлдвэрийн салбар зөвлөлөөр хэлэлцүүлэхээр Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд хүргүүлсэн болович уг* асуудал шийдэгдээгүй төслийн явц удааширсан байна.

2.87. *Гангийн үйлдвэрийг өргөтгөх, бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах ажлын хүрээнд жилд 25 мянган тонн 100-140 мм-ийн голчтой Ган бөмбөлгийн үйлдвэрийг ашиглалтад оруулж, шинээр шанаган зуухны тоног төхөөрөмж, пресс хайчны тоног төхөөрөмж, усан хөргөлтийн цамхаг, цахилгаан соронзон хуйлруулагч зэрэг тоног төхөөрөмжийн шинэчлэлийг хийсэн байна.*

2.88. Гангийн үйлдвэрийн хэрэглээг хангах цахилгаан эрчим хүчний эх үүсгэвэр бий болоогүй, эрх бүхий байгууллагаас тодорхой шийдвэр гараагүй, барилга угсралт эхлүүлэх газар олгоогүй зэрэг хүндрэлтэй асуудлууд гарсан байна.

2.89. Концесс эзэмшигч цахилгаан эрчим хүч бага зарцуулдаг баг оврын домен зуухны технологид суурилсан гангийн үйлдвэрийн техник эдийн засгийн үндэслэлийг "Кью Эм Си" ХХК-иар гүйцэтгүүлж, мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангасан байна.

2.90. Концесс эзэмшигчийн зүгээс гэрээний 2.1.3-т заасан 300 мянган тонн ган бүтээгдэхүүн үйлдвэрлэх Гангийн үйлдвэр байгуулахын тулд 2019 оноос цахилгаан эрчим хүч бага зарцуулдаг домен зуух бүхий кокс, ширэм, гангийн үйлдвэрлэлийн технологийг сонгож, уг ажлын ТЭЗҮ-ийг боловсруулах ажлыг БНХАУ-ын инженерийн зураг төслийн MCC CERI компаниар хийлгэжээ.

—o0o—

## ГУРАВ. ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Төр, хувийн хэвшлийн түншлэлийн асуудлыг хариуцан хэрэгжүүлэх байгууллагын бүтэц, зохион байгуулалт удаа дараа өөрчлөгдсөнөөс концессын зүйлийн хэрэгжилтэд тавих хяналт, хариуцлага суларч зарим төслийн хэрэгжилт удааширсан байна.

- Засгийн газрын 2013 оны "Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт батлах тухай" 317 дугаар тогтоолоор "Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төсөл"-ийн концесс эзэмшигчийг сонгохдоо төслийн хөрөнгө оруулагчаар шалгарсан компанитай шууд гэрээ байгуулахаар шийдвэрлэсэн байна.

- Концессын "барих-шилжүүлэх" төрлөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнүүдийн зураг төсөл нь эрх бүхий байгууллагаар хянагдаж магадлалын дүгнэлтээр баталгаажуулсан байна.

- Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд "барих-шилжүүлэх" төрлөөр хэрэгжүүлэх авто зам, төмөр зам, эрчим хүчний төслүүдийн төсөвт өртөг болон эргэн төлөлтийн санхүүжилтийг олгохоор батлсны дагуу улсын төсвөөс нийт 253.348.1 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

- ҮХГ болон Сангийн яам нь концессын зүйлийн хөрөнгө оруулалтын эргэн төлөлтийн санхүүжилтийг олгохдоо төслийн гүйцэтгэлийг хянаж, баталгаажуулаагүй, Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам"-ыг мөрдөж ажиллаагүй байна.

- Концессын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь концессын гэрээний хэрэгжилтэд үнэлгээ хийх, хяналт тавих, төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг хугацаанд нь гаргуулан авч тайлагнах үүргээ зохих ёсоор хэрэгжүүлээгүй байна.

- Улсын комиссын актаар байнгын ашиглалтад хүлээн авсан төслийн барилга, байгууламжийн өмчлөгчийн асуудлыг хууль, журмын дагуу шийдвэрлээгүй байна.

- Засгийн газраас "Уул уурхайн металлургийн цогцолбор төсөл"-ийн үйл ажиллагааг эрчимжүүлэх чиглэлийг УУХҮЯ болон ЭХЯ-д даалгасны дагуу гангийн үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэх төлөвлөгөө баталсан боловч хэрэгжилт нь удаашралтай байна.

## ДӨРӨВ. ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дараах албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

**Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргад:**

- Концессын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах, боловсон хүчнийг мэргэшүүлэх, дотоод хяналт, хариуцлагын тогтолцоо бий болгох;

- Улсын комиссын актаар байнгын ашиглалтад хүлээн авсан төслийн барилга, байгууламжийн өмчлөгчийн асуудлыг хууль, журмын дагуу шийдвэрлэх.

**Монгол Улсын Сангийн сайдад:**

- Төсөл, хөтөлбөрийн санхүүжилтийг олгохдоо Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам"-ыг мөрдөх.

**Төрийн худалдан авах ажиллагааны газрын даргад:**

- Концессын гэрээний хэрэгжилтэд Концессын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.8-д "Концессын гэрээний хэрэгжилтэд үнэлгээ хийх, хяналт тавих, концессын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх" гэж заасныг хэрэгжүүлж ажиллах;

- Концессын тухай хуульд заасны дагуу гэрээнд концесс эзэмшигчийн гүйцэтгэх ажил, эсхүл үзүүлэх үйлчилгээний төлбөрийн дүн, төслийн үнийн дүнг тодорхой тусгаж, төслийн гүйцэтгэлийг холбогдох хууль, журмын дагуу хянан баталгаажуулах.

- Концессын төслийн хөрөнгө оруулалтын эргэн төлөлтийг холбогдох хууль журамд нийцүүлэн санхүүжүүлэх.

**Уул, уурхай хүнд үйлдвэрийн сайдад:**

- Засгийн газраас өгсөн чиглэлийн дагуу "Уул уурхайн металлургийн цогцолбор төсөл"-ийн үйл ажиллагааг эрчимжүүлэхэд чиглэсэн гангийн үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэх төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах ажлыг эрчимжүүлэх.

**Эрчим хүчний сайдад:**

- "Уул уурхайн металлургийн цогцолбор төсөл"-д шаардлагатай цахилгаан, эрчим хүчний дэд бүтцийн асуудлыг судалж, шийдвэрлэх арга хэмжээ авах.

# ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР
[illegible]

2021.08.09 № А-11/1302

Санал хүргүүлэх тухай

Танай 2021 оны 08/1771 дугаар албан бичгээр ирүүлсэн "Дархан-Сэлэнгийн бүсэд уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төслийг хэрэгжүүлэх концессын гэрээний хэрэгжилт"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланд дараах саналуудыг хүргүүлж байна. Үүнд

Тайлбар 1-ийг үзнэ үү

"1/ Тайлангийн дүгнэлт хэсэгт "Төр, хувийн хэвшлийн түншлэлийн асуудлыг хариуцан хэрэгжүүлэх байгууллагын бүтэц, зохион байгуулалт удаа дараа өөрчлөгдсөнөөс концессын зүйлийн хэрэгжилтэд тавих хяналт, хариуцлагын механизм суларч зарим төслийн хэрэгжилт удааширсан байна." гэжээ. "Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төсөл"-ийн төмрийн хүдэр, төмрийн үйлдвэрүүд барих, хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлууд нь эрчим хүчний дэд бүтцийн асуудлаа шийдвэрлээгүйгээс төслийн хэрэгжилт удааширсан гэж үзэх үндэслэлтэй тул хасах,

Тайлбар 2-ийг үзнэ үү

2/ Засгийн газрын 2018 оны 6 дугаар тогтоолоор Засгийн газрын 2015 оны 364 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцож, тогтоолын дагуу концессын нэмэлт гэрээг Эрх бүхий этгээд цуцалсан. Энэ асуудлаарх захиргааны маргааныг 3 шатны шүүхээр хэлэлцэн, Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 774 дүгээр шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2019 оны 221/МА2019/0074 дүгээр магадлал, Монгол Улсын дээд шүүхийн 2019 оны 351 дүгээр тогтоолоор концесс эзэмшигч "Кью эс си" ХХК-ийн нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож эцэслэн шийдвэрлэсэн. Ингэснээр концессын нэмэлт гэрээнүүд хүчингүй болж, Засгийн газрын 2018 оны 6 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж концесс эзэмшигч "Кью эс си" хязгаарлагдмал хариуцлагатай компанид олгосон 240,771,925,200.00 төгрөгийг буцаан улсын төсөвт төвлөрүүлэхийг концесс эзэмшигчид үүрэг болгуулахаар тайланд тусгах,

Тайлбар 3-ыг үзнэ үү

3/ Тайлангийн дүгнэлт хэсэгт "Эрчим хүчний сайдад: "Уул уурхай, металлургийн цогцолбор төсөл"-д шаардлагатай цахилгаан, эрчим хүчний дэд бүтцийн асуудлыг судлаж, шийдвэрлэх арга хэмжээ авах." гэжээ. Гэтэл концессын гэрээгээр эрчим хүчний дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэх үүргийг Засгийн газар хүлээгээгүй бөгөөд төслийг хэрэгжүүлэх бүрэн үүрэг, хариуцлагыг концесс эзэмшигч хариуцах тул дүгнэлтийн энэ хэсгийг хасах,

Тайлбар 4-ийг үзнэ үү

4/ "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" компанийн өнөөгийн өмчлөлийн хэлбэр, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын талаарх нөхцөл байдлын талаар дүгнэлтэд тусгах,

Тайлбар 5-ыг үзнэ үү

5/ Концессын гэрээний хэрэгжилтийн явц нь концессын зүйл тус бүрээр болон нэгтгэсэн байдлаар хэдэн хувийн гүйцэтгэлтэй байгааг тодорхой тусгах,

Тайлбар 6-г үзнэ үү

6/ Концесс эзэмшигчийн үйл ажиллагаанд хамаарч буй Хуст уул /13851А/, Төмөр толгой /10738А/, Төмөртэй орд /13319А/-уудын ашиглалтын хэмжээ ба концессын гэрээний 30 гэсэн хугацааны хамаарал буюу концессын гэрээ байгуулагдсанаас хойш 7 жилийн хугацаанд ашигласан байдал, цаашид ашиглагдах нөөцийн талаар тус тус дүгнэлтэд тусгах" зэрэг болно.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Х. УЛАМ-ӨРНӨХ

Төрийн худалдан авах ажиллагааны газрын саналд өгсөн тайлбар:

| | |
|---|---|
| Тайлбар 1 | "Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төсөл" нь зөвхөн эрчим хүчний дэд бүтцээс шалтгаалгүй, төр, хувийн хэвшлийн түншлэлийн асуудлыг хариуцан хэрэгжүүлэх байгууллагын бүтэц, зохион байгуулалт удаа дараа өөрчлөгдөж, концессын зүйлийн хэрэгжилтэд тавих хяналт, хариуцлага сул байсан тул хасах шаардлагагүй гэж үзсэн. |
| Тайлбар 2 | Тайлангийн 2.68 - 2.69-д уг асуудлыг тусгасан байна. |
| Тайлбар 3 | Тайлангийн 2.74 - 2.77-д уг асуудлыг тусгасан байна. |
| Тайлбар 4 | Тайлангийн 1.22 - 1.24-д энэ талаар тусгасан байна. |
| Тайлбар 5 | Концессын гэрээнд тусгасан концессын зүйлээс Улсын комисс хүлээж аваагүй болон шүүхийн хүчин төгөлдөр шийдвэртэй холбоотой асуудлуудыг аудитад хамруулаагүй хязгаарласан болно. |
| Тайлбар 6 | Аудитаар төслийн хүрээнд концессын "барих-шилжүүлэх" төрлөөр хэрэгжиж дууссан, Улсын комисст хүлээлгэн өгсөн төслүүдийг хамруулсан тул саналыг хүлээн авах боломжгүй. |

--o0o--